



МОНГОЛ
УЛСЫН
ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН
АУДИТЫН
ТАЙЛАН

**МОНГОЛ УЛСЫН 2025 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2026 оны 06 сарын 09 өдөр

Дугаар А/65

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1, 20.3, 20.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.9 дэх заалт, 29.3 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг Нэгдүгээр хавсралтаар, тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлагын жагсаалтыг Хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2.Аудитын тайланг Монгол Улсын Их Хурал, Засгийн газар, Сангийн яаманд тус тус хүргүүлэхийг Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор (Н.Цэвэлмаа), Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор (Д.Энхболд), Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор (Б.Баттуяа), Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор (Д.Баярсайхан) нарт тус тус даалгасугай.

3.Аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын Ерөнхий сайд (Н.Учрал), Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга (Б.Энхбаяр), Монгол Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд (З.Мэндсайхан) нарт тус тус зөвлөсүгэй.

4.Аудитын тайланг Монгол Улсын Их Хурал болон холбогдох Байнгын хороодоор хэлэлцүүлэх, бэлтгэл ажлыг хангах, аудитын үр дүнд хяналт тавьж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор (Н.Цэвэлмаа), Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор (Д.Энхболд), Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор (Б.Баттуяа), Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор (Д.Баярсайхан), Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газрын захирал, тэргүүлэх аудитор (Ч.Цэвэгдорж) нарт үүрэг болгосугай.



С.МАГНАЙСҮРЭН

АГУУЛГА

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	7
ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ	10
БҮЛЭГ 1. МОНГОЛ УЛСЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХДАА ТӨСВИЙН БОДЛОГЫГ ШИНЭЧЛЭЭГҮЙ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАСАН ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХАД БҮРЭН ЧИГЛЭЭГҮЙ НЬ НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДЛЫГ БУУРУУЛСАН БАЙНА.	12
<i>1.1 Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн суурь тэнцлийн тусгай шаардлагыг хангаагүй, жилийн төсвийн тухай хуулийн төслийг батлах, нэмэлт, өөрчлөлт оруулахдаа төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулдаг зөрчил давтагдан гарч байгаа нь тогтвортой төсвийн бодлого хэрэгжихгүй байх эрсдэлтэй байна.</i>	12
<i>1.2 Монгол Улсын 2025 оны төсвийн төслийг дахин боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулахдаа төсвийн бодлогыг шинэчлэн боловсруулаагүй, үр дүнг нэгтгээгүй, тайлант онд санхүүжүүлэхээр улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд батлагдсан, төсөл, арга хэмжээний 53.7 хувийг улсын төсөвт тусгаагүй байна.</i>	15
БҮЛЭГ 2. ТҮҮХИЙ ЭДИЙН МӨЧЛӨГ СӨРСӨН, ТӨСВИЙН ТЭЛЭЛТИЙГ ХЯЗГААРЛАСАН, ОРЛОГЫН БҮТЦИЙГ ТОГТВОРЖУУЛАХ БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХГҮЙГЭЭР, ЭКСПОРТЫН БИЕТ ХЭМЖЭЭНД НАЙДСАН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ ХИЙСЭЭР БАЙГАА НЬ НИЙЛҮҮЛЭЛТЭЭС ШАЛТГААЛСАН ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНЭ БУУРАХ, ТӨСВИЙН ОРЛОГО ХУВААРИЙН ДАГУУ БҮРДЭХГҮЙ БАЙХ ЭРСДЭЛТЭЙ БАЙНА.	19
<i>2.1 Нийлүүлэлтийн биет хэмжээ, гол нэр төрлийн эрдэс баялгийн экспортын орлогод найдсан төсвийн тэлэлт хийсээр байгаа нь төсвийн орлого тасрах, төсвийн төлөвлөлтийн ач холбогдлыг бууруулах, төсөвт тодотгол хийх эрсдэл бий болохоор байна.</i>	19
<i>2.2 Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн орлогыг 34,116.8 тэрбум төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 97.3 хувь буюу 33,179.2 тэрбум төгрөг байна. Үүнээс татварын орлого 6.9 хувиар тасарч, татварын бус орлого 24.1 хувиар давсан байна.</i>	20
<i>2.3 Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн татварын орлогыг 29,241.6 тэрбум төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 27,213.0 тэрбум төгрөг төвлөрүүлсний 57.4 хувь буюу 15,612.1 тэрбум төгрөг нь улсын төсвийн татварын орлого байна. Үүнээс ТӨХК-уудаас 2026 оны татварын урьдчилгаа 264.5 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлж, орлогын гүйцэтгэлийг нэмэгдүүлсэн байна.</i>	23
БҮЛЭГ 3. ТӨСВИЙН ОРЛОГО ТАСАРСАН, ТАЙЛАНТ ОНД ХЭРЭГЖСЭН ЗАРИМ ХӨТӨЛБӨР АРГА ХЭМЖЭЭНИЙ САНХҮҮЖИЛТИЙГ БҮРЭН ОЛГООГҮЙГЭЭС ДАРАА ОНЫ ТӨСӨВТ АЧААЛАЛ ҮҮСГЭЖ, ТӨЛӨВЛӨГДСӨН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ БҮРЭН ХЭРЭГЖИХГҮЙ БАЙХ ЭРСДЭЛИЙГ БИЙ БОЛГОЖ БАЙНА.	28
<i>3.1 Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хуулиар тогтоосон хугацаанд батлаагүйгээс төсвийн төсөл дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан хөтөлбөр арга хэмжээтэй уялдаагүй байна.</i>	28
<i>3.2 Зарим төсвийн ерөнхийлөн захирагчид үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлтийн бодлого баримталсан боловч уламжлалт төсөвлөлттэй байгаа нь хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг бодитой төлөвлөж, хэрэгжилтийг үнэн зөв тайлагнаж, үр дүнг үнэлэхгүй байх нөхцөлийг бүрдүүлж байна.</i>	34
<i>3.3 ТЕЗ бүрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнг баталсан боловч хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ тодорхой бус, зарим хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтүүд оновчгүй, хэмжих нэгж уялдаагүй, суурь түвшин алдаатай, хэмжигдэхүйц бус зэргээс хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн хэрэгжилтийг үнэлэх боломжгүй байна.</i>	45
БҮЛЭГ 4. ГОЛ НЭР ТӨРЛИЙН ЭРДЭС БАЯЛАГИЙН ҮНЭ ТӨЛӨВЛӨСӨН ХЭМЖЭЭНД ХҮРЭЭГҮЙ, ТӨСВИЙН ЗАРЛАГЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР ХУВААРИЙН ДАГУУ БҮРДЭЭГҮЙ, ТӨСВИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЗАРЧИМ АЛДАГДСАНААС ТӨСВИЙН ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ 1,027.9 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН АЛДАГДАЛТАЙ ГАРСАН БАЙНА. .	47

4.1 Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн тэнцэл 1,027.9 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна.	47
4.2 Улсын төсвийн нийт тэнцвэржүүлсэн тэнцэл 1,426.3 тэрбум төгрөгийн алдагдалтай гарч, ДНБ-ий 1.6 хувьтай тэнцэж байна.	48
БҮЛЭГ 5. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО ӨМНӨХ ОНООС 7.2 ХУВИАР, ЗАРЛАГА 12.6 ХУВИАР НЭМЭГДСЭН НЬ ОРЛОГЫН ӨСӨЛТӨӨС ДАВСАН ЗАРЛАГЫГ ХЯЗГААРЛАЖ, САНХҮҮГИЙН САХИЛГА БАТЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.	49
5.1 Орон нутаг нийт орлого ба тусламжаар 7,672.1 тэрбум төгрөг бүрдүүлж, 90.8 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь татварын орлогыг 783.8 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрүүлсэнтэй холбоотой байна.	49
5.2 Орон нутгийн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 8,172.4 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй гарч, батлагдсан төлөвлөгөөнөөс 2,548.6 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулсан ч өмнөх оноос 913.9 тэрбум төгрөг буюу 12.6 хувиар нэмэгдсэн байна.	50
5.3 Орон нутгийн нийт орлого өмнөх оноос 7.2 хувиар өссөн боловч нийт зарлага 12.6 хувиар нэмэгдэж, төсвийн тэнцэл 500.3 тэрбум төгрөгийн алдагдалтай гарчээ.	52
БҮЛЭГ 6. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЧӨЛӨӨТ ҮЛДЭГДЛИЙГ САНХҮҮГИЙН ХЭРЭГСЭЛД ХӨРӨНГӨ ОРУУЛАХААР ХУУЛЬЧИЛСАН БОЛОВЧ 40752 АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГААС АВАХ 590.4 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН НДШ-ИЙН АВЛАГЫГ БАРАГДУУЛААГҮЙ НЬ САНГИЙН ХӨРӨНГИЙГ НЭМЭГДҮҮЛЖ, ӨГӨӨЖ ХҮРТЭХ БОЛОМЖИЙГ АЛДАЖ БАЙНА.	53
6.1 Нийгмийн даатгалын ерөнхий хуульд заасны дагуу сангийн мөнгөн хөрөнгийн чөлөөт үлдэгдлийг арилжааны банканд байршуулж 77.6 тэрбум төгрөгийн хүүгийн орлого, ЗГ-ын үнэт цаас худалдан авч 27.0 тэрбум төгрөгийн хүүгийн өгөөж хүртсэн байна.	53
6.2 Төрийн байгууллагуудын мэдээллийн системийн уялдааг хангах замаар дотоод хяналтыг сайжруулж, мөнгөн хөрөнгийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.	54
БҮЛЭГ 7. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНД ХУВИАРАА ШИМТГЭЛ ТӨЛӨГЧДИЙН ТОО СҮҮЛИЙН 3 ЖИЛИЙН ДУНДЖААР 8.0 ХУВИАР БУУРЧ БАЙГАА ТУЛ ЦААШИД ДААТГУУЛАГЧДЫН ТООГ НЭМЭГДҮҮЛЭХ БОДЛОГЫН АРГА ХЭМЖЭЭ АВАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.	56
7.1 Даатгалын сангийн орлогын эх үүсвэртэй уялдуулан даатгалын үйлчилгээг төлөвлөх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нэхэмжлэлд даатгалын нэгдсэн цахим системээр тавих хяналтын үр нөлөө хангалтгүй байна.	56
7.2 Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийн даатгалд хамрагдалт хангалтгүй байгаагаас хувиараа шимтгэл төлөгчдийн тоо дунджаар 8.0 хувиар буурсан, даатгалын сангийн орлогын 55.4 хувийг төрөөс хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилт болон шимтгэлээр бүрдүүлж, улсын төсвөөс хамааралтай хэвээр байна.	56
БҮЛЭГ 8. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН ҮЛДЭГДЭЛД ГАДААД ӨРИЙН ЭЗЛЭХ ХУВЬ ӨНДӨР БАЙГАА НЬ ХАНШИЙН АЛДАГДАЛ, ХҮҮГИЙН ЗАРДЛААР ТӨСӨВТ ҮЗҮҮЛЭХ АЧААЛЛЫГ НЭМЭГДҮҮЛЖ БАЙНА.	59
8.1 Засгийн газрын өрийн үлдэгдэл нь хуульд заасан 60.0 хувийн босго дүнгээс доогуур буюу 39.4 хувьтай, төсвийн тусгай шаардлагыг хангасан боловч гадаад өрийн эзлэх хэмжээ 95.7 хувьд хүрч, ханшийн зөрүүгээс 1,739.9 тэрбум төгрөгийн алдагдал хүлээсэн байна.	59
8.2 Засгийн газрын түвшинд дотоод эх үүсвэрийн ашиглалт, төлбөр хуваарийн дагуу явагдаж байгаа боловч орон нутгийн зээллэгийн хуулийн нийцэл, үр ашиг, төлөвлөлтийн чанар зэрэг нь тулгамдсан асуудал хэвээр байна.	62
8.3 Засгийн газар гадаад өрийн дахин санхүүжилтийг амжилттай хийж, зээлжих зэрэглэлээ ахиулсан боловч төслийн бэлтгэл ажил хангагдаагүй, ашиглалт удаашралтай байгаагаас үүдэн ханшийн зөрүү болон ашиглаагүй зээлийн хүүгийн зардалд их хэмжээний алдагдал хүлээж байна.	64
БҮЛЭГ 9. ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧДЫН НЭМЭЛТ ТӨСВӨӨР 982.5 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН ОРЛОГО БҮРДҮҮЛЖ, ГҮЙЦЭТГЭЛЭЭР 876.7 ТЭРБУМ ТӨГРӨГ ЗАРЦУУЛСАН БАЙНА.	68
9.1 Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 318.9 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 23.1 хувиар өссөн байна.	68
9.2 Нэмэлт төсвийн зарлага 876.7 тэрбум төгрөг болж өмнөх оноос 24.4 хувиар буюу 283.8 тэрбум төгрөгөөр буурахад Сангийн яамнаас зарцуулалтын эрхийг хязгаарласан нь голлон нөлөөлсөн байна.	68

БҮЛЭГ 10. ӨМНӨХ ОНЫ АУДИТААР НИЙТ 29 ЗӨВЛӨМЖ ӨГСНӨӨС 68.5 ХУВИЙН ХЭРЭГЖИЛТТЭЙ БАЙНА.....	70
БҮЛЭГ 11. ШИЛЭН ДАНСНЫ НЭГДСЭН ЦАХИМ ХУУДАСНЫ ЗАРИМ МОДУЛЬ ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛЬ БОЛОН ХОЛБОГДОХ ЖУРМЫН ЗОХИЦУУЛАЛТТАЙ УЯЛДААГҮЙ, БАЙГУУЛЛАГУУД МЭДЭЭЛЛЭЭ ХУУЛЬД ЗААСАН ХУГАЦААНД БҮРЭН БАЙРШУУЛААГҮЙ БАЙНА.	71
11.1 Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны нэр томъёо нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т заасантай нийцэхгүй байна.	71
11.2 Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2 заасан байгууллагууд мэдээллээ хугацаа хоцроосон, 3.1.3, 3.1.4, 3.1.5-д заасан байгууллагууд мэдээллийн 55.1 хувийг байршуулаагүй байна.	71
БҮЛЭГ 12. УЛС ТӨРИЙН НАМУУДАД ОЛГОСОН ТӨРИЙН САНХҮҮЖИЛТИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ЗАРДЛЫН АНГИЛАЛ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ ТОДОРХОЙГҮЙ, ХУУЛЬ, ЖУРМЫН ЗААЛТ УЯЛДААГҮЙ, ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ ЧИГ ҮҮРЭГ ДАВХАРДАЖ БАЙНА.	73
12.1 Улс төрийн намд төрөөс олгосон санхүүжилтээс нийт 0.19 тэрбум төгрөгийг зориулалт бус зарцуулсан байна.....	73
12.2 Сонгуулийн ерөнхий хороо улс төрийн намд олгох төрийн санхүүжилтийг хуульд заасны дагуу зарцуулж, тайлагнасан эсэхийг дүгнээгүй, чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.	74
12.3 Сонгуулийн ерөнхий хорооны хяналтын шалгуур үзүүлэлт тодорхойгүй, авч хэрэгжүүлсэн арга хэмжээг үнэлэх боломжгүй байна.	75
БҮЛЭГ 13. НЭГДСЭН СУДАЛГААНЫ ҮР ДҮН.....	75
ДҮГНЭЛТ	77
ЗӨВЛӨМЖ	79
ХАВСРАЛТ ТАЙЛАН 1. УЛСЫН ТӨСВИЙН 2025 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН.....	88
ХАВСРАЛТ ТАЙЛАН 2. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2025 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН.....	149

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

1	ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
2	ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
3	АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
4	АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
5	Ам.доллар	Америк доллар
6	АХБ	Азийн хөгжлийн банк
7	АТГ	Авлигатай тэмцэх газар
8	АҮЭБС	Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд
9	БГД	Баянгол дүүрэг
10	БЗД	Баянзүрх дүүрэг
11	БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
12	БОУАӨС	Байгаль орчин, уур амьсгал өөрчлөлтийн сайд
13	БСҮХД	Боомтын сэргэлтийн үндэсний хорооны дарга
14	БХС	Батлан хамгаалахын сайд
15	БТКУС	Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем
16	БС	Боловсролын сайд
17	ГБХНХС	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
18	ГХС	Гадаад харилцааны сайд
19	ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
20	ДЦС	Дулааны цахилгаан станц
21	ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
22	ЕС	Ерөнхий сайд
23	ЗГ	Засгийн газар
24	ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
25	ЗДТГ	Засаг даргын тамгын газар
26	ЗТС	Зам, тээврийн сайд
27	ИЗНН	Иргэний зориг ногоон нам
28	ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
29	МАН	Монгол ардын нам
30	МУЗГ	Монгол улсын засгийн газар
31	МУЕС	Монгол улсын ерөнхий сайд
32	МНН	Монголын ногоон нам
33	МУНТГ	Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл
34	МУШС	Монгол улсын шадар сайд
35	МҮАН	Монголын үндэсний ардчилсан нам
36	НД	Налайх дүүрэг
37	НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
38	НДС	Нийгмийн даатгалын сан
39	НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
40	НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
41	НҮ	Нэрлэсэн үнэ
42	ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
43	ОНТЕЗ	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч
44	ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
45	ОУ	Олон улс
46	ОУВС	Олон улсын валютын сан
47	ӨҮЦ	Өнөөгийн үнэ цэнэ
48	ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
49	СБД	Сүхбаатар дүүрэг
50	СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
51	СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
52	СС	Сангийн сайд
53	ССАЖЗС	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд
54	СХД	Сонгинохайрхан дүүрэг
55	СЯ	Сангийн яам

56	ТАЗ	Төрийн албаны зөвлөл
57	ТАХ	Төсөл, арга хэмжээ
58	ТБОНӨХБАУХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
59	ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
60	ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
61	ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
62	ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
63	ТӨОХХК	Төрийн өмчийн оролцоотой хязгаарлагдмал хариуцлагатай компани
64	ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
65	ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
66	ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
67	ТХААГ	Төрийн худалдан авах ажиллагааны газар
68	ТХМ	Төсвийн хүрээний мэдэгдэл
69	ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
70	УИХ	Улсын Их Хурал
71	УТЕЗ	Улсын төсвийн ерөнхийлөн захирагч
72	УТНТ	Улс төрийн намын тухай
73	УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
74	УУХҮС	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд
75	УЦС	Усан цахилгаан станц
76	ҮБС	Үндэсний баялгийн сан
77	ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин
78	ҮСХ	Үндэсний статистикийн хороо
79	ХАА	Хөдөө аж ахуй
80	ХББОСС	Хот, байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд
81	ХЗДХС	Хууль зүй, дотоод хэргийн сайд
82	ХК	Хувьцаат компани
83	ХУД	Хан-уул дүүрэг
84	ХХААХҮС	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
85	ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
86	ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
87	ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
88	ХҮҮХД	Хяналт үнэлгээний үндэсний хорооны дарга
89	ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
90	ЦХИХХС	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд
91	ЧД	Чингэлтэй дүүрэг
92	ШН	Шинэ нам
93	ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
94	ЭЗХС	Эдийн засаг, хөгжлийн сайд
95	ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
96	ЭМДҮЗ	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл
97	ЭХС	Эрчим хүчний сайд

ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Монгол Улсын 2025 оны төсвийн хүрээний мэдэгдлийн өөрчлөлт	13
Хүснэгт 2. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн өөрчлөлт	14
Хүснэгт 3. Улсын хөгжлийн 2025 оны жилийн төлөвлөгөөний санхүүжилтийн эх үүсвэр, гүйцэтгэл	18
Хүснэгт 4. Улсын хөгжлийн 2025 оны жилийн төлөвлөгөө болон Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн уялдаа	18
Хүснэгт 5. Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламж	20
Хүснэгт 6. Уул уурхай, газрын тосны бүтээгдэхүүний орлого бүрдүүлэлт	22
Хүснэгт 7. Уул уурхай, газрын тосны бүтээгдэхүүний үнэ, биет хэмжээ	22
Хүснэгт 8. Төсвийн тогтворжуулалт, Үндэсний баялгийн сангийн орлого	23
Хүснэгт 9. Монгол Улсын 2025 оны улсын төсвийн татварын орлого	24

Хүснэгт 10. Монгол Улсын 2025 оны улсын төсвийн татварын бус орлого	25
Хүснэгт 11. Татварын хөнгөлөлт чөлөөлөлтийн судалгаа	26
Хүснэгт 12. Татварын өрийн мэдээлэл 1990-2024 он	26
Хүснэгт 13. Татварын ерөнхий газрын хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн зөрчлийн судалгаа	27
Хүснэгт 14. Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн төлөвлөлт	28
Хүснэгт 15. Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээл	31
Хүснэгт 16. Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээл	32
Хүснэгт 17. Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гадаад зээл, тусламжаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ	32
Хүснэгт 18. Нэгдсэн төсвийн эргэж төлөгдөх цэвэр зээл	33
Хүснэгт 19. Нэгдсэн төсвийн эргэж төлөгдөх цэвэр зээл	33
Хүснэгт 20. Монгол Улсын 2025 оны төсвийн зарлагын эдийн засгийн ангиллаар	35
Хүснэгт 21. Улсын төсвийн татаас, урсгал шилжүүлэг	39
Хүснэгт 22. Улсын төсвийн 2025 төсвийн хөрөнгө оруулалтын зардал	40
Хүснэгт 23. Гадаад зээл, тусламжийн эх үүсвэрээр санхүүжүүлэх төсөл	41
Хүснэгт 24. Улсын төсвийн 2025 оны хүүгийн зардал	45
Хүснэгт 25. Нэгдсэн төсвийн үзүүлэлтүүдийн ДНБ-д эзлэх хувь болон өсөлтийн хувь	47
Хүснэгт 26. Нэгдсэн төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр	47
Хүснэгт 27. Улсын төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр	48
Хүснэгт 28. Орон нутгийн орлогын гүйцэтгэл эдийн засгийн ангиллаар	49
Хүснэгт 29. Орон нутгийн зарлагын гүйцэтгэл эдийн засгийн ангиллаар	51
Хүснэгт 30. Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл төсвийн захирагчаар	51
Хүснэгт 31. Нийгмийн даатгалын сангийн зарлага	54
Хүснэгт 32. Засгийн газрын өрийн үлдэгдэл	59
Хүснэгт 33. Засгийн газрын 2025 оны өрийн үйлчилгээний үзүүлэлтийн гүйцэтгэл	60
Хүснэгт 34. Засгийн газрын 2025 оны өрийн үзүүлэлт	61
Хүснэгт 35. Засгийн газрын дотоод үнэт цаас	63
Хүснэгт 36. Орон нутгийн дотоод үнэт цаасны төрөл	63
Хүснэгт 37. Орон нутгийн гадаад үнэт цаасны үлдэгдэл	65
Хүснэгт 38. Засгийн газрын гадаад зээлийн үлдэгдэл	66
Хүснэгт 39. Нэмэлт төсвийн эх үүсвэрийг өмнөх онтой харьцуулахад	68
Хүснэгт 40. Шилэн дансны хөтлөлт, үнэлгээ	72
Хүснэгт 41. Улс төрийн намд олгосон төрийн санхүүжилт	73

ДҮРСЛЭЛИЙН ЖАГСААЛТ

Дүрслэл 1. Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн байгууллагын тоо	7
Дүрслэл 2. Нэгдсэн төсвийн 2021-2025 оны үзүүлэлт	15
Дүрслэл 3. Нэгдсэн төсвийн нийт орлого ба	21
Дүрслэл 4. Татварын орлогын судалгаа	24
Дүрслэл 5. Бараа үйлчилгээний бусад зардлын гүйцэтгэл	36
Дүрслэл 6. Улсын төсвийн нийт зарлага цэвэр зээлийн дүн ба хөрөнгийн зардал	41
Дүрслэл 7. Монгол Улсын нийт зарлага цэвэр зээлийн дүн ба хүүгийн зардал	45
Дүрслэл 8. ЭМДС-ийн орлогын гүйцэтгэл	57
Дүрслэл 9. Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг өөрөө хариуцан төлөх иргэдийн тоо	57
Дүрслэл 10. Тогтвортой байдлын хязгаар	60
Дүрслэл 11. Ханшийн алдагдлын статистик	62
Дүрслэл 12. Засгийн газрын дотоод үнэт цаасны статистик	62
Дүрслэл 13. Нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын зөвлөмжийн хэрэгжилт	70

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй**

Үндэсний аудитын газар Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1¹-д заасан бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.2² дахь заалтыг үндэслэн Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын зорилт

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн бодлогын зорилт үр нөлөөтэй хэрэгжсэн, төсвийн гүйцэтгэлийг үнэн зөв илэрхийлсэн эсэхэд аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж, дүнг УИХ-д танилцуулахад аудитын зорилт чиглэсэн.

Аудитын хамарсан хүрээ

Төсвийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.7³-д заасны дагуу Сангийн яамны бэлтгэсэн Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан, танилцуулгад үндэслэн нийт 3877 төсөвт байгууллага, сангуудын төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ. Үүнд:

- Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл;
- Улсын төсвийн 2025 оны гүйцэтгэл;
- Орон нутгийн 2025 оны төсвийн гүйцэтгэл;
- ЭМДС-ийн 2025 оны төсвийн гүйцэтгэл;
- НДС-ийн 2025 оны төсвийн гүйцэтгэл;
- Ирээдүйн өв сан;
- Үндэсний баялгийн сан;
- Төсвийн тогтворжуулалтын сан;
- Нэмэлт төсвийн 2025 оны гүйцэтгэлийн тайлан;
- Засгийн газрын өрийн үзүүлэлтүүд, гадаад зээлээр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр;
- Татварын зарлагын тайлан;
- Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2025 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн ажлын гүйцэтгэл;
- Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт;
- Төсвийн ерөнхийлөн захирагчдын 2025 онд хэрэгжүүлсэн хөтөлбөр, хөтөлбөрийн үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтүүд;
- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт;
- Улс төрийн намуудад төрөөс олгосон санхүүжилтийн гүйцэтгэл;
- Өмнөх оны зөвлөмжийн биелэлт.

Дүрслэл 1. Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн байгууллагын тоо



Тайлбар:

* Төсвийн ерөнхийлөн захирагч

** Төсвийн байгууллага, төсвийн гүйцэтгэлийн тайлан

*** Гүйцэтгэлээр санхүүжих байгууллага -2613

¹ Төрийн аудитын байгууллага Төсвийн тухай хуульд заасны дагуу улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн байгууллага, төсөв захирагчийн жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан, санхүүгийн нэгтгэсэн тайлан, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн жилийн санхүүгийн тайланд аудит хийнэ.

² Төрийн аудитын төв байгууллага нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэг сарын дотор аудит хийж, Засгийн газар, Улсын Их Хуралд хүргүүлэх

³ Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах

Аудитын арга зүй

Аудитыг АДБОУС 100, 300, 400, 3000, 4000-д нийцүүлэн боловсруулсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит, тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудит”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу гүйцэтгэлээ.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/69 дүгээр тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”, 2021 оны А/71 дүгээр тушаалаар баталсан “Нийцлийн аудитын заавар, аргачлал”-ын дагуу төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулан батлуулж, аудитын горим сорилыг хэрэгжүүлэв. Үүнд, Сангийн яам болон бусад холбогдох яам, байгууллагын албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, судалгаа, тоон мэдээлэл авах, түүвэрлэлт, тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ, харьцуулалт хийх зэрэг аудитын арга зүйг хэрэгжүүлж, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн зөвлөмжийг боловсрууллаа.

Аудитын тайланд улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн гүйцэтгэл, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, Улс төрийн намуудад төрөөс олгосон санхүүжилтийн тайланд хийсэн аудитын дүнг нэгтгэсэн болно. Аудитын холбогдох мэдээлэл, ажлын баримтыг хавсаргав.

Аудитын шалгуур үзүүлэлт

Аудитад дараах шалгуур үзүүлэлтийг ашигласан. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хууль;
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон уг хуульд өөрчлөлт оруулах тухай хууль;
- Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон уг хуульд өөрчлөлт оруулах тухай хууль;
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас хөнгөлөх, чөлөөлөх тухай хууль;
- Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль;
- Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль;
- Ирээдүйн өв сангийн тухай хууль;
- Нийгмийн даатгалын багц хуулиуд;
- Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хууль;
- Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хууль;
- Өрийн удирдлагын тухай хууль;
- Татварын багц хуулиуд;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Улс төрийн намын тухай хууль;
- Үндэсний баялгийн сангийн тухай хууль;
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль;
- Шилэн дансны тухай хууль;
- Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хууль;
- Бусад холбогдох хууль, тогтоомж, эрх зүйн актууд.

Монгол Улсын Их Хурлын болон Засгийн газрын дараах тогтоол, шийдвэрүүдийг 2025 оны төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөж ажилласан байна. Үүнд:

- Улсын Их Хурлын 2020 оны "Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай" 52 дугаар тогтоол;
- Улсын Их Хурлын 2020 оны "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай" 23 дугаар тогтоол;

- Улсын Их Хурлын 2024 оны “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 21 дүгээр тогтоол;
- Улсын Их Хурлын 2024 оны “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” 64 дүгээр тогтоол;
- Улсын Их хурлын 2024 оны “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 54 дүгээр тогтоол;
- Улсын Их Хурлын 2024 оны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 52 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2016 оны “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам” 29 дүгээр тогтоол;
- Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны “Төрийн албаны сахилга, дэг журам хариуцлагыг чангатгах, бүтээмжийг сайжруулах тухай” 01 дүгээр албан даалгавар;
- Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” 05 дугаар албан даалгавар;

Аудитын багийн бүрэлдэхүүн

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитыг Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Н.Цэвэлмаа, Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Баярсайхан, Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Баттуяа, Санхүүгийн аудитын газрын аудитын менежер В.Эрдэнэцогт, Б.Долгорсүрэн, Д.Энхдалай, П.Чанцалдулам, И.Эрдэнэцэг, Нийцлийн аудитын газрын Өгөгдлийн шинжилгээ хариуцсан менежер Д.Баттулга нар үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор М.Пагамдулам, П.Амарсанаа, Ц.Энхжаргал, Ж.Нямцэцэг, С.Отгонхорлоо, А.Даваадорж, Б.Долгоржав, Б.Ариунжаргал, Ш.Наран, аудитор Ж.Бямбацогт, М.Ганбаатар, Н.Нямсүрэн, Ж.Мөнхтуул, Т.Нямсүрэн, Ж.Мөнхбилгүүн, С.Шийлэгмаа, Т.Баасанцэнд, Я.Марал-Эрдэнэ, Б.Отгонцэцэг, С.Билгүтэй, Г.Тэлмүүн, Г.Батбилэг, Э.Цэлмэгбаяр нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэлээ.

Аудитад хөндлөнгийн мэргэжлийн шинжээчийг оролцуулж, ажлын даалгаврын дагуу тайлан гаргуулан, үр дүнг аудитын тайланд тусгасан болно.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн аудитын танилцуулгад дурдсан эдийн засгийн макро түвшний үзүүлэлтүүдийг Монгол банкнаас гаргасан 2025 оны жилийн тайлан, Эдийн засаг хөгжлийн яамны макро эдийн засгийн дөрөвдүгээр улирлын танилцуулга, Засгийн газраас өргөн барьсан Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангаас тоймлон авч ашигласан болно.

Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн өмнөх оноос 2.1 хувиар өсөж 30,303.1 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 2.4 хувиар өсөж 31,331.0 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1,027.9 тэрбум төгрөгийн алдагдалтай байна.

Эдийн засгийн суурийг тэлэх, төрөлжүүлэх бодлогын хүрээнд уул уурхайн болон хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх арга хэмжээнүүдийг үргэлжлүүлэн авч хэрэгжүүлснээр нэрлэсэн ДНБ-ий хэмжээ өмнөх оноос 12.5 хувиар нэмэгдэж, 89.9 их наяд төгрөгт хүрч, эдийн засаг 6.8 хувиар өссөн байна.

Эдийн засгийн өсөлтөд хөдөө аж ахуйн салбар голлон нөлөөлж нийт өсөлтийн 2.9 нэгж хувийг, уул уурхайн салбар 1.4 нэгж хувийг бүрдүүлсэн бол худалдаа үйлчилгээний салбар 0.6 нэгж хувиар буурсан байна.

Тариалангийн гол бүс нутгаар олон жилийн дунджаас бага хур тунадас унаснаар ургац хураалтын хэмжээ буурч, газар тариалангийн салбар агшсан ч мал аж ахуйн салбар эрчимтэй тэлж, бойжсон төлийн тоо толгой 21.7 саяд хүрч өмнөх оны мөн үеэс 5.5 сая толгой малаар нэмэгдсэн байна.

Газрын тос олборлолт 8 улирал дараалан буурч 3.8 сая баррель болсноор уул уурхайн салбарын өсөлтийг сааруулсан. Нүүрсний экспортын хэмжээ 4 дүгээр улиралд сэргэж, өмнөх оны мөн үеэс 0.4 хувиар өссөн, зэсийн баяжмал үйлдвэрлэл 36.2 хувиар, төмрийн хүдрийн үйлдвэрлэл 31.8 хувиар, алтны олборлолт 3.8 хувиар тус тус өсөж уул уурхайн салбарын өсөлтийг дэмжсэн байна.

Хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляц 2025 оны эцэст 7.5 хувьд хүрч, өмнөх оноос 1.5 нэгж хувиар буурснаар Монгол банкны зорилтот түвшнийг (6+/-2) хангаж байна.

Жилийн дундаж инфляц 8.6 хувьтай гарч өнгөрсөн оноос 1.8 хувиар нэмэгдэхэд импортын барааны үнийн өсөлт голлон нөлөөлсний зэрэгцээ махны үнийн өсөлт хүлээлтээс өндөр болсон, мөн газар тариалангийн салбар агшсантай холбоотой дотоодын хүнсний бүтээгдэхүүний үнэ өссөнөөс шалтгаалсан байна.

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2025 онд 47.1 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 10.6 хувь буюу 4.5 их наяд төгрөгөөр өссөн байна. Үүний 9.4 нэгж хувийг төгрөгийн хадгаламж, 2.1 нэгж хувийг гадаад валютын харилцах, 0.2 нэгж хувийг гадаад валютын хадгаламж бүрдүүлсэн боловч төгрөгийн харилцах 1.1 нэгж хувиар буурч сөрөг нөлөө үзүүлсэн байна.

Хөдөлмөрийн насны хүн амын тоо 2,352.8 мянгад хүрсэн байна. Үүнээс 15 ба түүнээс дээш насны нийт хүн амын 62.3 хувь буюу 1,466.3 мянга нь ажиллах хүч, 37.7 хувь буюу 886.5 мянга нь ажиллах хүчнээс гадуурх хүн ам байна.

Ажилгүй иргэдийн тоо өмнөх оноос 7.3 мянгаар өсөж 82.7 мянга болж, ажилгүйдлийн түвшин 0.3 нэгж хувиар өсөж, 5.6 хувьд хүрсэн байна. Ажиллах хүчний оролцооны түвшин өмнөх оноос 0.1 нэгж хувиар өсөж 62.3 хувьд хүрсэн ч хөдөлмөр эрхлэлтийн түвшин 58.8 хувь болж, өмнөх оноос 0.1 нэгж хувиар буурсан байна.

Тайлант онд өрхийн хэрэглээ 9.2 хувиар өссөн ч өрхийн бодит орлогын өсөлт удааширч 5.0 хувь болсон байна. Төрийн албан хаагчийн цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлсэн шийдвэрийн нөлөөгөөр өрхийн цалингийн орлогын өсөлт оны туршид тогтвортой хадгалагдсан нь голлох нөлөө үзүүлсэн байна.

Монгол Улс 2025 онд гадаад худалдааны нийт бараа эргэлт 27.0 тэрбум ам.долларт хүрч, гадаад худалдааны тэнцэл 4.4 тэрбум ам.долларын ашигтай гарсан байна. Экспортын хэмжээ өмнөх оны түвшинд хадгалагдаж 15.8 тэрбум ам.долларт хүрсэн бөгөөд нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдрийн экспортын биет хэмжээний өсөлт болон хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспортын өсөлт нь нүүрсний үнийн бууралтаас үүдсэн экспортын орлогын алдагдлыг нөхсөн байна.

Импорт өмнөх оноос 303.0 сая ам.доллараар буюу 2.6 хувиар буурч 11.3 тэрбум ам.долларт хүрсэн байна. Барааны бүлгээр авч үзвэл нийт бууралтын 1.8 нэгж хувийг хөрөнгө оруулалтын машин, тоног төхөөрөмж, 0.6 нэгж хувийг хэрэглээний бүтээгдэхүүн, 0.1 нэгж хувийг аж үйлдвэрийн орц тус тус бүрдүүлсэн байна.

Уул уурхайн тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийн импорт өмнөх онд өндөр байсан суурийн нөлөөгөөр 2025 онд уул уурхайн салбарт ашиглагддаг завсрын болон хөрөнгө оруулалтын барааны импорт саарсан.

Хэрэглээний бүтээгдэхүүний импортын хэмжээ буурахад нийслэл хотод 10-аас дээш жилийн насжилттай суудлын автомашинд тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаар олгохгүй гэж шийдвэрлэсэнтэй холбоотойгоор суудлын автомашины импорт 5.5 хувиар, эрэлтээс шалтгаалж А-80 авто бензиний хэрэглээ буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Урсгал ба хөрөнгийн данс 2,064.0 сая ам.долларын алдагдалтай, санхүүгийн данс 3,321.0 сая ам.долларын ашигтай гарснаар төлбөрийн тэнцэл өмнөх оноос 412 сая ам.доллараар нэмэгдэж, 1,034.0 сая ам.долларын ашигтай гарч, гадаад валютын улсын нөөц өмнөх оноос 1,495.0 сая ам.доллараар нэмэгдэж, 7,005.0 сая ам.долларт хүрсэн байна.

Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл өмнөх оноос 8.7 хувиар өсөж, 40,460.0 сая ам.долларт хүрсэн, Засгийн газрын гадаад өр нэрлэсэн үнээр 8,748.0 сая ам.доллар байна.

БҮЛЭГ 1. МОНГОЛ УЛСЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХДАА ТӨСВИЙН БОДЛОГЫГ ШИНЭЧЛЭЭГҮЙ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАСАН ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХАД БҮРЭН ЧИГЛЭЭГҮЙ НЬ НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДЛЫГ БУУРУУЛСАН БАЙНА.

1.1 Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн суурь тэнцлийн тусгай шаардлагыг хангаагүй, жилийн төсвийн тухай хуулийн төслийг батлах, нэмэлт, өөрчлөлт оруулахдаа төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулдаг зөрчил давтагдан гарч байгаа нь тогтвортой төсвийн бодлого хэрэгжихгүй байх эрсдэлтэй байна.

1.1.1 Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон Төсвийн тухай хуулиар нэгдсэн төсвийн тэнцлийн зорилтыг тодорхойлж тусгах, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, түүнд нийцүүлсэн тухайн жилийн төсвийн төслийг боловсруулах, УИХ-д өргөн мэдүүлэх, батлах, тэдгээрт нэмэлт, өөрчлөлт оруулах, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг батлах, хяналт тавих, санхүүгийн хуримтлалын удирдлагыг хэрэгжүүлэх харилцааг тус тус зохицуулж байна.

1.1.2 Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг анх баталснаас хойш 21 удаа нэмэлт өөрчлөлт оруулсан нь тус хуулийн үндсэн зорилт, үзэл баримтлал алдагдахад хүргэж байна.

1.1.3 Засгийн газраас 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг дагалдах нийт 14 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар УИХ-д өргөн мэдүүлснээс Төсвийн тухай хуулийн төсвийн удирдлага хэрэгжүүлэх болон хариуцлага хүлээлгэх, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн албан татварын хөнгөлөлт, тайлагнал, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн татвараас хөнгөлөх, чөлөөлөх, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төлөвлөлт, тайлагнал, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн нэмэгдэл урамшуулал, спортын уралдаан тэмцээн зэрэг үзүүлэлтүүдэд нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

1.1.4 УИХ-ын 2024 оны “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 54 дүгээр тогтоолоор баталсан нийт 19 арга хэмжээний хэрэгжилт 86.8 хувь, “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 52 дугаар тогтоолоор баталсан нийт 9 арга хэмжээний хэрэгжилт 77.7 хувьтай байна.

1.1.5 Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн хүрээнд 8 стратегийн бодлого, зорилтыг тодорхойлж, УИХ-ын чуулганы 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 29,400.1 тэрбум төгрөг, төсвийн нийт зарлагын дээд хэмжээг 31,300.4 тэрбум төгрөг, төсвийн тэнцлийг 1,900.3 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар баталсан.

1.1.6 Анх баталсан 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийг нийт 3 удаа өөрчилсөн бөгөөд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 30,209.9 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 33.6 хувь, нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээг 31,575.1 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 35.1 хувь, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 1,365.2 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 1.5 хувийн алдагдалтай байхаар нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

1.1.7 Төсвийн хүрээний мэдэгдэлд тусгасан төсвийн эдийн засгийн үзүүлэлтүүд нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

Хүснэгт 1. Монгол Улсын 2025 оны төсвийн хүрээний мэдээгдлийн өөрчлөлт

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт		Төсвийн хүрээний мэдэгдэл				Өөрчлөлт
		Анх баталсан	Өөрчлөн баталсан	Дахин өөрчилсөн	Тодотгол	Анх баталснаас
		/2024.06.05/	/2024.11.08/	/2024.12.12/	/2025.07.09/	
А		1	2	3	4	5=4-1
1	ДНБ-ий бодит өсөлтийн хэмжээ /хувь/	8.0	8.0	8.0	5.5	(2.5)
2	Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин	6.0	7.5	7.2	9.5	3.5
3	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/	29,400.1	33,864.7	33,470.0	30,209.9	809.8
	ДНБ-д эзлэх хувь	30.9	35.6	35.2	33.6	2.7
4	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	31,300.4	35,795.2	33,470.0	31,575.1	274.7
	ДНБ-д эзлэх хувь	32.9	37.7	35.2	35.1	2.2
5	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	(1,900.3)	(1,930.5)	-	(1,365.2)	535.1
	ДНБ-д эзлэх хувь	(2.0)	(2.0)	-	(1.5)	0.5
6	Нэгдсэн төсвийн суурь зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	Энэ үзүүлэлтийг 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмсэн	31,955.2	30,296.5	28,401.7	28,401.7
	ДНБ-д эзлэх хувь		33.6	31.9	31.6	31.6
7	Нэгдсэн төсвийн суурь тэнцэл /тэрбум төгрөг/		1,909.5	3,173.4	1,808.2	1,808.2
	ДНБ-д эзлэх хувь		2.0	3.3	2.0	2.0
8	Засгийн газрын өрийн нийт хэмжээ, нэрлэсэн дүнгээр /тэрбум төгрөг/	47,507.1	52,255.5	52,255.5	49,506.1	1,999.0
	ДНБ-д эзлэх хувь	50.0	55.0	55.0	55.0	5.0
9	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/	2,850.4	2,572.3	2,572.3	2,572.3	(278.1)

Эх сурвалж: Монгол Улсын Нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдээгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хууль

1.1.8 Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийг УИХ-аас 2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр баталсныг Монгол Улсын Ерөнхийлөгч 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр бүхэлд нь хориг тавьсан.

1.1.9 УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцэн, хүлээн авч “алдагдалгүй төсөв батлах” чиглэл өгсний дагуу 2025 оны төсвийн төсөлд зардал бууруулах зохицуулалт хийж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүнг 33,469.8 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийг 33,431.5 тэрбум төгрөг, төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 38.3 тэрбум төгрөгийн ашигтай байхаар баталсан.

Хүснэгт 2. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн өөрчлөлт

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2025 оны төсөв					
	Анх өргөн барьсан	Баталсан	Хоригийн дараа өргөн барьсан	Баталсан	Тод өргөн барьсан	Баталсан
	/2024.09.02/	/2024.11.12/	/2024.12.04/	/2024.12.12/	/2025.06.25/	/2025.07.09/
Тэнцвэржүүлсэн орлого ба тусламж	33,864.7	33,864.7	33,470.0	33,469.8	30,209.9	30,209.9
Нийт зарлага ба цэвэр зээл	35,795.2	35,771.9	33,470.0	33,431.5	31,575.1	31,573.9
Тэнцвэржүүлсэн тэнцэл	(1,930.5)	(1,907.2)	-	38.3	(1,365.2)	(1,364.0)

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

1.1.10 Монгол Улсын нэгдсэн төсвийн төсөл болон батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг боловсруулахдаа дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэхийн оронд хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар дунд хугацааны төсвийн хүрээний үндсэн үзүүлэлтүүдийг өөрчилдөг зөрчил давтагдсаар байна.

1.1.11 Экспортын орлогын бууралтаас шалтгаалан Монгол Улсын эдийн засаг 2025 оны нэгдүгээр улиралд 2.4 хувиар буурч, эдийн засгийн өсөлт саарснаар нэгдсэн төсвийн орлого тасрах нөхцөл үүссэн.

1.1.12 УИХ-ын чуулганы 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж, зарим төсвийн ерөнхийлөн захирагчийг Засгийн газрын бүрэлдэхүүнээс хасаж, зарим чиг үүргийг төсвийн ерөнхийлөн захирагч хооронд шилжүүлэх төсвийн зохицуулалт хийж, цомхон, чадварлаг бүтцээр төрийн үйлчилгээг үр ашигтай хүргэх цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулсан.

1.1.13 Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийг 3,260.0 тэрбум төгрөгөөр бууруулж, 30,209.9 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийг 1,857.6 тэрбум төгрөгөөр бууруулж, 31,573.9 тэрбум төгрөг, төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 1,364.0 тэрбум төгрөгийн алдагдалтай баталсан байна.

1.1.14 Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангаар нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 30,303.1 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 31,331.0 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1,027.9 тэрбум төгрөгийн алдагдалтай байна.

1.1.15 Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1,027.9 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу ДНБ-ий 1.1 хувьтай тэнцэж байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.9⁴-д заасан тусгай шаардлагыг хангасан.

1.1.16 Нэгдсэн төсвийн суурь тэнцэл 1,113.9 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 1.2 хувьтай тэнцэж байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2⁵-д заасан тусгай шаардлагыг хангаагүй байна.

1.1.17 Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн өмнөх оноос 2.1 хувь буюу 632.3 тэрбум төгрөгөөр өссөн боловч төлөвлөснөөс 4.5 хувь буюу 1,428.4 тэрбум төгрөгөөр дутуу биелсэн байна. Татварын байгууллагад тайлан тушаадаг аж ахуйн нэгжийн тоо 11.0 хувиар, бүртгэлтэй татвар төлөгчийн тоо 2.0 хувиар тус тус өсөж, эдийн засгийн өсөлтөд уул уурхайн бус салбарын оролцоо нэмэгдсэн нь төсвийн орлого өмнөх оноос өсөхөд голлох нөлөө үзүүлсэн.

⁴ Энэ хуульд заасан нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг 2017 онд 10.4 хувиас, 2018 онд 9.5 хувиас, 2019 онд 6.9 хувиас, 2020 онд 12.5 хувиас, 2021 онд 8.8 хувиас, 2022 онд 5.1 хувиас, 2023 онд 3.6 хувиас, 2024 онд 2.8 хувиас тус тус хэтрүүлэхгүй, 2025 оны төсвийн жилээс эхлэн нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байна.

⁵ Нэгдсэн төсвийн суурь тэнцэл нь тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр буюу түүнээс дээш хувийн ашигтай байх

1.1.18 Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн өмнөх оноос 2.4 хувь буюу 739.9 тэрбум төгрөгөөр өссөн, төлөвлөснөөс 11.4 хувь буюу 4,032.4 тэрбум төгрөгийн дутуу гүйцэтгэлтэй байна.

1.1.19 Тайлант оны нэгдсэн төсвийн нийт урсгал зарлагын хэмжээ 24,237.8 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 26.9 хувьтай тэнцэж байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3⁶-т заасан тусгай шаардлагыг хангасан.


1.1.20 Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдэл 35,407.7 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 39.4 хувьтай тэнцэж байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4⁷-т заасан тусгай шаардлагыг хангасан.

1.1.21 Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн бүрэлдэхүүн хоорондын орлого, зарлагын шилжүүлгийг 5,889.1 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 5,340.9 тэрбум төгрөгийн гүйлгээг цэвэрлэн тайлагнажээ.

1.1.22 Нэгдсэн төсвийн 2021–2025 оны жилийн дунджаар нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 25.1 хувь, нийт зарлага ба цэвэр зээл 19.6 хувиар тус тус өссөн байна.

Дүрслэл 2. Нэгдсэн төсвийн 2021-2025 оны үзүүлэлт

/тэрбум төгрөг/



Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

1.1.23 Нэгдсэн төсвийн алдагдал төлөвлөсөн түвшнээс буурсан хэдий ч төсвийн орлогын бүтэц уул уурхайн гол нэрийн бүтээгдэхүүний экспорт, түүний дэлхийн зах зээлийн үнэ ханшаас хэт хамааралтай хэвээр байна.

1.1.24 Нэгдсэн төсвийн нийт зарлагын хэт тэлэлт нь эдийн засгийн дотоод тэнцвэрт байдалд сөргөөр нөлөөлж, хувийн хэвшлийн үйл ажиллагааны орчин, хөрөнгө оруулалтын идэвхийг сааруулж болзошгүй байна.

1.2 Монгол Улсын 2025 оны төсвийн төслийг дахин боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулахдаа төсвийн бодлогыг шинэчлэн боловсруулаагүй, үр дүнг нэгтгээгүй, тайлант онд санхүүжүүлэхээр улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд батлагдсан, төсөл, арга хэмжээний 53.7 хувийг улсын төсөвт тусгаагүй байна.

1.2.1 Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг УИХ-д анх өргөн мэдүүлэхдээ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлж, хөгжлийн том төслүүдийг эхлүүлэн, төрийн оролцоог багасгаж, хувийн хэвшлийг дэмжихэд чиглэсэн үндсэн 5 бодлого, тэргүүлэх чиглэлийг тодорхойлсон.

⁶ нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээ тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 30 хувиас хэтрэхгүй байх;

⁷ Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрэхгүй байх;

1.2.3 **Бүсчилсэн хөгжлийн зорилттой уялдсан татварын бодлогын хүрээнд** бүсийн тэргүүлэх чиглэлд нийцсэн томоохон төсөл, арга хэмжээ, хөрөнгө оруулалт хийхийг сэдэлжүүлсэн, урамшуулсан татварын багц дэмжлэгийг үзүүлэх зорилтыг дэвшүүлсэн.

1.2.4 Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор элэгдэл тооцох үндсэн хөрөнгөд оруулсан хөрөнгө оруулалт болон харилцан хамааралгүй этгээдэд олгосон санхүүгийн дэмжлэг, хандивын зардлыг тухайн жилийн борлуулалтын орлогын 1.0 хувиас хэтрэхгүй дүнгээр татвараас хасаж, хөнгөлөх хуулийн зохицуулалтаар нийт 278 аж ахуйн нэгжийг 72.3 тэрбум төгрөгийн хөнгөлөлтөд хамруулсан байна.

1.2.5 **Төрийн өмчийн хөрөнгийн үр ашгийг өсгөх бодлогын хүрээнд** төрийн болон орон нутгийн өмчит компанийг нээлттэй, ил тод байдлыг хангуулж, зах зээлийн зарчмаар үйл ажиллагаа явуулах тогтолцоог бүрдүүлэх, удирдлагын манлайллыг хэрэгжүүлэх, сахилга батыг сайжруулж үр ашгийг дээшлүүлэх бодлогын зорилтыг дэвшүүлсэн.

1.2.6 Засгийн газрын 2025 оны “Эрчим хүчний салбарын төрийн өмчит зарим компанийн талаар авах арга хэмжээний тухай” 30 дугаар тогтоолоор “Баруун бүсийн эрчим хүчний систем” ХК, “Алтай-Улиастайн эрчим хүчний систем” ХК-ийг “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ХК-д, “Тайшир-Гуулингийн усан цахилгаан станц” ХХК, “Богдын голын усан цахилгаан станц” ХХК, “Тосонцэнгэлийн усан цахилгаан станц” ХХК-г нэгтгэж, “Тайшир-ногоон эрчим” ХК, Алтай-Улиастай Завхан салбар болон бусад түгээх сүлжээний салбаруудыг нэгтгэж “Алтай-Улиастайн цахилгаан түгээх сүлжээ” ХК байгуулсан.

1.2.7 Засгийн газрын 2025 оны “Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” 146 дугаар тогтоолоор Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ААТҮГ-ыг “Эрчис Ойл” ТӨХХК-д нэгтгэсэн.

1.2.8 Засгийн газрын 2025 оны “Төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаа, засаглалыг сайжруулах, шинэчлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 61 дүгээр тогтоолоор “Монгол-Кувейтын байгаль хамгаалах төв” ТӨААТҮГ-ыг “Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв” ТӨААТҮГ-т, “Монголын үнэт цаасны клирингийн төв” ХХК-г “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-д тус тус нэгтгэн “Аялал жуулчлалын хөгжлийн төв” ТӨААТҮГ-ыг татан буулгасан.

1.2.9 **Боловсруулах үйлдвэрийг татварын бодлогоор дэмжих бодлогын хүрээнд** Шинэ сэргэлтийн бодлогын Аж үйлдвэржилтийн сэргэлтийг ирэх оноос дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэн бүтээгдэхүүнээ хөгжүүлж байгаа боловсруулах үйлдвэрүүдийг салбар харгалзахгүйгээр татварын бодлогоор дэмжих зорилтыг дэвшүүлсэн.

1.2.10 Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр газар тариалан, боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмж, трактор, комбайныг гаалийн албан татвараас 100.0 хувь хөнгөлөх зохицуулалтыг баталж, 126 иргэн, аж ахуйн нэгжид нийт 230.9 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмж, трактор, комбайныг импортолж, гаалийн албан татварт төлсөн 11.6 тэрбум төгрөгийг 2026 онд буцаан олгохоор байна.

1.2.11 **Үндэсний баялгийн сангаар дамжуулан үндэсний орон сууцжуулалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх бодлогын хүрээнд** Үндэсний орон сууцны корпорацыг байгуулж иргэдийг орон сууцжуулах цогц арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

1.2.12 Орон сууцны ипотекийн хөнгөлөлттэй зээлийн хүрээнд тайлант онд нийт 1,260.8 тэрбум төгрөгийн зээлийг 9894 иргэнд олгосон байна. Үүнээс арилжааны банкны эх үүсвэрээр 214.6 тэрбум төгрөгийг 1566 иргэнд, Монгол банкны эх үүсвэрээр 583.9 тэрбум төгрөгийг 4664 иргэнд, Хуримтлалын сангийн эх үүсвэрээр 462.3 тэрбум төгрөгийг 3664 иргэнд тус тус олгосон. Нийт олгосон зээлийн 63.7 хувийг Улаанбаатар хотод буюу 840.6 тэрбум төгрөгийн зээлийг 6306 иргэнд, 36.3 хувийг орон нутагт буюу 420.3 тэрбум төгрөгийн зээлийг 3588 иргэнд тус тус олгосон.

1.2.13 Улаанбаатар хотоос орон нутагт шилжин ажиллах төрийн албан хаагчдыг төрийн албанд ажилласан жилтэй уялдуулан орон нутгийн 3.0 хувийн ипотекийн зээлд хамруулж орон сууцны урьдчилгаа төлбөрийн 60 хүртэлх хувьд батлан даалт гаргах үйл ажиллагааны хүрээнд

1,111 зээлдэгчид 131.8 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгож, 80 зээлдэгчийн 1.9 тэрбум төгрөгийн урьдчилгаа төлбөрийн батлан даалтад хамруулжээ.

1.2.14 Хөгжлийн хөрөнгө оруулалт, бүсийн томоохон дэд бүтцийн төслүүдийг санхүүжүүлэх бодлогын хүрээнд Засгийн газраас урт хугацааны тогтвортой хөгжлийн суурь дэд бүтцийг бий болгох 14 мега төслийг эхлүүлж, уул уурхайн бус салбарын өсөлтийг дэмжих замаар макро эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, төсвийн орлогыг нэмэгдүүлэх салбаруудын бодлогын цогц реформыг хэрэгжүүлэх зорилтыг дэвшүүлсэн.

1.2.15 Бүгд Найрамдах Хятад Ард Улсын ЭКСИМ банкны санхүүжилтээр хэрэгжиж буй "Эрдэнэбүрэнгийн УЦС" төсөлд 272.4 тэрбум төгрөг, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын ЭКСИМ банкны санхүүжилтээр хэрэгжиж буй "Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл"-д 446.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон.

1.2.16 Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 135 дугаар тогтоолын 1.3 дахь заалтад тусгасан Өмнөговь аймгийн Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 250 км тусгай зориулалтын авто зам барих бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх чиглэлийн хүрээнд далан, дэд суурь, цементээр бэхжүүлсэн суурийн 1, 2 дугаар үе, суурь хучилтын ажил хийгдэж, гүйцэтгэл 83.1 хувьтай байна.

1.2.17 "Америкийн Нэгдсэн Улсын Мянганы сорилтын сангийн санхүүжилтээр хэрэгжиж буй "Улаанбаатар хотын ундны ус хангамжийг нэмэгдүүлэх төсөл" болон "Хаягдал ус дахин боловсруулах төсөл"-д тусламжийн эх үүсвэрээр 244.5 тэрбум төгрөгийн санхүүжилт олгож, Ус гүн цэвэршүүлэх үйлдвэр, Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрийг шинээр ашиглалтад оруулсан.

1.2.18 БНХАУ-ын ЭКСИМ банкны санхүүжилтээр хэрэгжсэн "Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл"-ийн хүрээнд 29.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгож барилга угсралт болон дэд бүтцийн ажлуудыг бүрэн хийж дуусгасан байна.

1.2.19 Монгол Улсын 2025 оны төсвийн бодлогын үр дүнг нэгтгэн тайлагнаагүйгээс хэрэгжилтийг үнэлэх боломжгүй байна.

1.2.20 Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа төсвийн бодлогыг шинэчлэн боловсруулаагүйгээс зарим төсөл арга хэмжээний төсөв батлагдаагүй байна. Тухайлбал:

- Нийслэл Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, нийгмийн суурь үйлчилгээг 20 минутын дотор хүргэх шинэ орчин нөхцөлийг бүрдүүлэх, авто замын түгжрэлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн "Өөдөө тэмүүлэх Монгол" ган татлагат гүүрэн байгууламжийн урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсвийн 28.6 тэрбум төгрөгийн төсөл;
- "Хөшгийн хөндий туннел" төслийн урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсвийн 55.3 тэрбум төгрөгийн төсөл;
- Засгийн газрын нэг цэгийн үйлчилгээний цогцолборын барилга угсралтын 210.0 тэрбум төгрөгийн төсөл;
- Бүгд Найрамдах Франц Улсын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр хэлэлцэж байсан "Үндэсний хиймэл дагуулын төсөл"-ийн зээлийн ашиглалт 211.6 тэрбум төгрөг төсөл;
- Гэр хорооллын өрх эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц барихад зориулж, нийт 1000 өрхөд 30 тэрбум төгрөгийн урьдчилгаа төлбөрийн дэмжлэг үзүүлэх төсөв.

1.2.21 Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд тухайн бүс нутгийн онцлогт тулгуурласан хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалтын улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 38 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр 972.5 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээс 27 төсөл, арга хэмжээнд 404.6 тэрбум төгрөг батлагдаж, 11 төсөл, арга хэмжээний 567.9 тэрбум төгрөг хасагдсан байна.

1.2.22 Монгол Улсын 2025 оны төсөвт 2 удаа нэмэлт өөрчлөлт оруулахдаа нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 4,198.0 тэрбум төгрөгөөр бууруулж баталсан бөгөөд анх боловсруулсан

төсвийн бодлого, хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнг төсөвтэй уялдуулан шинэчлээгүй нь төсвийн бодлогын үр нөлөөг бууруулсан байна.

Төсвийн гүйцэтгэл нь Монгол Улсын 2025 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгасан төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд бүрэн чиглээгүй байна.

1.2.23 Монгол Улсын Их Хурлын 2024 оны 35 дугаар тогтоолоор “Монгол Улсын хөгжлийн 2025 оны жилийн төлөвлөгөө”-г 4 тэргүүлэх чиглэл, Төсвийн ерөнхийлөн захирагчдын хэрэгжүүлэх 373 шалгуур үзүүлэлт бүхий 328 төсөл, арга хэмжээг 19,359.1 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

1.2.24 Тус хөгжлийн төлөвлөгөөнд тусгасан төсөл, арга хэмжээний 5,276.7 тэрбум төгрөг буюу 27.3 хувийг улс, орон нутгийн төсвөөс, 4,151.5 тэрбум төгрөг буюу 21.4 хувийг гадаадын зээл тусламжаар, 9,930.9 тэрбум төгрөг буюу 51.3 хувийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ болон гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, бусад эх үүсвэрээр санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнээс улсын төсвөөс санхүүжих 18 төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг тусгаагүй байна.

Хүснэгт 3. Улсын хөгжлийн 2025 оны жилийн төлөвлөгөөний санхүүжилтийн эх үүсвэр, гүйцэтгэл

/тэрбум төгрөг/

№	Санхүүжилтийн эх үүсвэр	Төлөвлөгөө		Гүйцэтгэл		
		ТАХ тоо	Дүн	ТАХ тоо	Дүн	Хувь
1	Улсын болон орон нутгийн төсөв	188	5,276.7	118	1,449.3	27.5
2	Гадаадын зээл, тусламж	83	4,151.5	43	1,429.6	34.4
3	Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт	19	4,167.1	11	2,852.0	68.4
4	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ	32	4,463.6		-	-
5	Бусад эх үүсвэр	4	1,300.2	6	1,605.5	123.5
6	Эх үүсвэргүй	2			-	-
Нийт дүн		328	19,359.1	178	7,336.4	37.9

Эх сурвалж: “Улсын хөгжлийн 2025 оны жилийн төлөвлөгөөний хэрэгжилт”сэдэвт аудитын тайлан

1.2.25 Гүйцэтгэлээр хөгжлийн төлөвлөгөөнд тусгасан төсөл, арга хэмжээний 37.9 хувь буюу 7,336.4 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээг санхүүжүүлсэн, 62.1 хувь буюу 12,022.7 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээг санхүүжүүлээгүй байна.

Хүснэгт 4. Улсын хөгжлийн 2025 оны жилийн төлөвлөгөө болон Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн уялдаа

/тэрбум төгрөг/

Улсын төсвөөр хэрэгжүүлэх			Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд							
			Туссан				Тусаагүй			
ТАХ	Шалгуур үзүүлэлт	Мөнгөн дүн	ТАХ	Шалгуур үзүүлэлт	Мөнгөн дүн	Хувь	ТАХ	Шалгуур үзүүлэлт	Мөнгөн дүн	Хувь
160	182	4,630.9	74	85	1,499.1	46.3	86	97	3,131.8	53.7

Эх сурвалж: “Улсын хөгжлийн 2025 оны жилийн төлөвлөгөөний хэрэгжилт”сэдэвт аудитын тайлан

1.2.26 Тайлант онд Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд туссан нийт 160 төсөл, арга хэмжээний 4,630.9 тэрбум төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээс, 74 төсөл, арга хэмжээний 1,499.1 тэрбум төгрөг буюу 46.3 хувийн санхүүжилтийг Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд тусгаж баталсан, 86 төсөл, арга хэмжээний 3,131.8 тэрбум төгрөг буюу 53.7 хувийг тусгаагүй байна.

1.2.27 Энэ нь Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.3-т “Улсын төсөв нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх” гэж заасантай нийцэхгүй байна.

1.2.28 Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт хангалтгүй байгаа нь хөгжлийн бодлого тухайн оны батлагдсан төсөв хоорондоо уялдаагүй, төсвийн эх үүсвэртэй төсөл, арга хэмжээ Улсын төсөвт бүрэн тусгаагүй, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр санхүүжилт нь хасагдаж, зарим харилцагч татан буугдсан, төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч тодорхойгүй зэргээс шалтгаалсан байна.

БҮЛЭГ 2. ТҮҮХИЙ ЭДИЙН МӨЧЛӨГ СӨРСӨН, ТӨСВИЙН ТЭЛЭЛТИЙГ ХЯЗГААРЛАСАН, ОРЛОГЫН БҮТЦИЙГ ТОГТВОРЖУУЛАХ БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХГҮЙГЭЭР, ЭКСПОРТЫН БИЕТ ХЭМЖЭЭНД НАЙДСАН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ ХИЙСЭЭР БАЙГАА НЬ НИЙЛҮҮЛЭЛТЭЭС ШАЛТГААЛСАН ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНЭ БУУРАХ, ТӨСВИЙН ОРЛОГО ХУВААРИЙН ДАГУУ БҮРДЭХГҮЙ БАЙХ ЭРСДЭЛТЭЙ БАЙНА.

2.1 Нийлүүлэлтийн биет хэмжээ, гол нэр төрлийн эрдэс баялгийн экспортын орлогод найдсан төсвийн тэлэлт хийсээр байгаа нь төсвийн орлого тасрах, төсвийн төлөвлөлтийн ач холбогдлыг бууруулах, төсөвт тодотгол хийх эрсдэл бий болохоор байна.

2.1.1 Засгийн газраас 2025 онд төсвийн орлогын чиглэлээр баримтлах “Бүсчилсэн хөгжлийн зорилттой уялдсан татварын бодлого”, “Боловсруулах үйлдвэрийг дэмжих татварын бодлого”-ын 2 зорилтыг хэрэгжүүлэхээр төсвийн баримт бичгийг боловсруулж, УИХ-д өргөн барьсан байна.

2.1.2 Төсөвт баримталсан татварын бодлогын хэрэгжилтийг нэгтгэж, үр дүнг үнэлж, дүгнээгүй байна.

2.1.3 Түүхий эдийн мөчлөгийн үед уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх зорилгоор нүүрс, төмрөөс гадна зэсийн баяжмал, хайлуур жоншийг уул уурхайн бүтээгдэхүүний биржээр идэвхтэй арилжаалж эхэлсэн байна.

2.1.4 Хөрөнгийн биржээр 2025 онд нийт 1053 удаагийн уул уурхайн бүтээгдэхүүний цахим дуудлага арилжааг зохион байгуулжээ. Үүнээс 619 удаагийн арилжааны хэлцэл амжилттай хийгдэж, 21.8 сая тонн нүүрс, 5.9 сая тонн төмрийн хүдэр болон баяжмал, 51.5 мянган тонн жоншны хүдэр болон баяжмал, 50.0 мянган тонн зэсийн баяжмал, нийт 27.8 сая тонн уул уурхайн бүтээгдэхүүнийг арилжаалсан.

2.1.5 Тайлант онд нийт 369 удаагийн нүүрсний дуудлага арилжааг амжилттай зохион байгуулсан бөгөөд 7 сараас зах зээл идэвхжин 21.8 сая тонн нүүрсийг 5,583.0 тэрбум төгрөгөөр арилжжээ.

2.1.6 Төрийн өмчит компаниуд нийт арилжааны 62.6 хувь буюу 2,874.5 тэрбум төгрөгийг “Эрдэнэс тавантолгой” ХК, 23.1 хувь буюу 1,697.3 тэрбум төгрөгийг “Тавантолгой” ХК, 12.2 хувь буюу 936.8 тэрбум төгрөгийг “Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр” ХХК, 6.1 хувь буюу 451.4 тэрбум төгрөгийг “Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ, 4.1 хувь буюу 376.3 тэрбум төгрөгийг “Эрдэнэт Үйлдвэр” ТӨҮГ арилжаалсан байна.

2.1.7 Дэгдэмхий бодис дунд, коксжих нүүрсийг 4.9 сая тонн буюу 1,607.6 тэрбум төгрөгөөр, 1/3 коксжих нүүрсийг 5.6 сая тонн буюу 1,536.5 тэрбум төгрөгөөр, баяжуулсан коксжих нүүрсийг 1.9 сая тонн буюу 818.3 тэрбум төгрөгөөр, эрчим хүчний нүүрсийг 5.6 сая тонн буюу 811.8 тэрбум төгрөгөөр борлуулсан.

2.1.8 Зэсийн баяжмалын хувьд 10 удаагийн арилжааг амжилттай зохион байгуулж, “Эрдэнэт Үйлдвэр” ТӨҮГ нь 50.0 мянган тонн зэсийн баяжмалыг 376.3 тэрбум төгрөгөөр арилжаалж дотоодын зах зээлийн бенчмаркыг бий болгосон байна.

2.1.9 Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан, 2025 онд хэрэгжүүлэх татварын үйл ажиллагааг зохицуулсан 16 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, биелэлт 100.0 хувьтай гэж тайлагнажээ.

2.1.10 Засгийн газрын “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” 2024 оны 64 дүгээр тогтоолд тусгасан бүсчилсэн хөгжлийн тогтолцоонд чиглэсэн татварын бодлогоор 2025 онд Нийслэлээс алслагдсан аймаг, сумдад үйл ажиллагаа эрхэлж буй 361 хуулийн этгээд 34.6 тэрбум төгрөг, 180 иргэн 233 сая төгрөгийн шаталсан хөнгөлөлтөд хамрагдсан байна.

2.1.11 Орон нутагт шинээр барьсан нийтийн зориулалттай орон сууц борлуулсны орлогод ногдох албан татвараас 18 татвар төлөгч 1.6 тэрбум төгрөг, орон нутаг дахь түрээсийн орон

сууцны хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор амьдран суух зориулалтаар орон сууц түрээслүүлсний орлогод ногдох албан татвараас 1 иргэнд хөнгөлөлтийг эдлүүлсэн.

2.1.12 Татварын орчин, тайлагналыг хялбаршуулах замаар малын гаралтай түүхий эдийн бүртгэлийг сайжруулж, боловсруулах үйлдвэрүүдэд дэмжлэг үзүүлэх арга хэмжээний хүрээнд 14423 малчдын хоршоо, малчин, мал бүхий этгээдийн борлуулсан бүтээгдэхүүн /таван хошуу мал, анхан шатны боловсруулалтад ороогүй мах, сүү, арьс шир, ноолуур, хонь болон тэмээний ноос, сарлагийн хөөвөр/-ийн 1,307.1 тэрбум төгрөгийн борлуулалтын орлогод ногдох татварыг чөлөөлсөн байна.

2.2 Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн орлогыг 34,116.8 тэрбум төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 97.3 хувь буюу 33,179.2 тэрбум төгрөг байна. Үүнээс татварын орлого 6.9 хувиар тасарч, татварын бус орлого 24.1 хувиар давсан байна.

2.2.1 Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийг 34,116.8 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс 33,179.2 тэрбум төгрөгийн орлогыг бүрдүүлж, 97.3 хувийн гүйцэтгэлтэй, өмнөх оноос 5.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 5. Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламж

/тэрбум төгрөг/

Төсвийн орлого	Өмнөх он	2025 он				Өмнөх оноос өөрчлөлт
		Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь	
Нийт орлого ба тусламжийн дүн	31,456.6	34,116.8	33,179.2	(937.6)	97.3	1,722.6
Тогтворжуулалтын сан	443.9	429.1	562.5	133.4	131.1	118.6
Ирээдүйн өв сан	841.4	1,394.1	1,710.6	316.5	122.7	869.3
Хуримтлалын сан	500.6	562.1	603.0	40.8	107.3	102.4
Хөгжлийн сан	-	-	-	-	-	-
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн*	29,670.8	31,731.5	30,303.1	(1,428.4)	95.5	632.3
Татварын орлого	27,417.4	29,241.6	27,213.0	(2,028.7)	93.1	(204.4)
Татварын бус орлого	2,253.5	2,489.9	3,090.1	600.3	124.1	836.8
Үүнээс:						
Улсын төсвийн орлого	20,089.1	20,224.1	19,550.5	(673.6)	96.7	(538.6)
Орон нутгийн төсвийн орлого	7,121.8	8,453.2	7,672.1	(781.1)	90.8	550.3
НДС-ийн орлого	5,609.7	6,908.1	6,684.4	(223.6)	96.8	1,074.7
ЭМДС-ийн орлого	1,921.7	2,464.3	2,299.5	(164.8)	93.3	377.8
Үндэсний баялгийн сангийн орлого	1,341.9	1,956.2	2,313.6	357.4	118.3	971.7

Эх сурвалж: Сангийн яам, Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.2.2 Нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн 82.0 хувийг татварын орлого, 9.3 хувийг татварын бус орлого, 1.7 хувийг Тогтворжуулалтын санд, 5.2 хувийг Ирээдүйн өв санд, 1.8 хувийг Хуримтлалын санд төвлөрүүлэх орлого эзэлж байна.

2.2.3 Улсын төсвийн орлого 96.7 хувь, орон нутгийн төсвийн орлого 90.8 хувь, НДС-ийн орлого 96.8 хувь, ЭМДС-ийн орлого 93.3 хувь, ҮБС-ийн орлого 118.3 хувийн гүйцэтгэлтэй байна.


2.2.4 Тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүнг 31,731.5 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс 30,303.1 тэрбум төгрөгт хүрч, 95.5 хувийн гүйцэтгэлтэй байна.

2.2.5 Тайлант оны нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн ДНБ-ий 36.9 хувьтай тэнцэж, төлөвлөснөөс 4.5 хувиар дутуу биелж, өмнөх оноос 2.1 хувиар өссөн байна.

2.2.6 Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн өмнөх оноос 632.3 тэрбум төгрөгөөр өсөхөд татварын байгууллагад тайлан тушаадаг аж ахуйн нэгжийн тоо 11.0 хувиар, бүртгэлтэй татвар төлөгчийн тоо 2.0 хувиар тус тус өссөн, эдийн засгийн өсөлтөд уул уурхайн бус салбарын оролцоо нэмэгдсэнтэй холбоотой байна.

2.2.7 Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн 62.7 хувийг улсын, 25.3 хувийг орон нутгийн, 22.0 хувийг НДС, 7.6 хувийг ЭМДС-ийн орлогоос бүрдүүлжээ.

Дүрслэл 3. Нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн бүтэц /тэрбум төгрөг/



2.2.8 Нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламж уул уурхайн экспортын гол нэр төрлийн түүхий эдийн үнэ, нийт импорт төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй, ногдуулсан татвар, хураамж бүрэн төвлөрөөгүй, улс, орон нутгийн ТЕЗ нарын өөрийн болон төсөвт төвлөрүүлэх орлого, ногдол ашгийг үндэслэлтэй төлөвлөж, төвлөрүүлээгүй зэргээс шалтгаалан төлөвлөснөөс 2.7 хувь буюу 937.6 тэрбум төгрөгөөр тасарсан байна. Энэ нь орлогын албан татвар 810.5 тэрбум төгрөгөөр, НӨАТ 439.4 тэрбум төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэл, хураамж 357.4 тэрбум төгрөгөөр, гадаад үйл ажиллагааны орлого 271.8 тэрбум төгрөгөөр, тусгай зориулалтын орлого 6.0 тэрбум төгрөгөөр

тасарч, татварын бус орлого 600.3 тэрбум төгрөгөөр, бусад татвар (төлбөр, хураамж) 146.1 тэрбум төгрөгөөр, хөрөнгийн албан татвар 15.9 тэрбум төгрөгөөр, үндэсний баялагийн сан 357.4 тэрбум төгрөгөөр, тогтворжуулалтын сан 133.4 тэрбум төгрөгөөр давсан нь голлон нөлөөлсөн байна.

2.2.9 Нэгдсэн төсвийн нийт орлогыг бодитой, үндэслэлтэй төлөвлөөгүй, хэт өндөр төсөөлснөөс орлого тасарч, татвар төлөгчдөөс 1,247.9 тэрбум төгрөгийн татвар хураамжийг урьдчилан төлүүлж, тайлант оны гүйцэтгэлээр бүртгэж, тайлагнасан нь дараа оны төсвийн орлогын бүрдүүлэлтэд хүндрэл үүсгэхээр байна.

2.2.10 Орон нутгийн төсвийн нийт орлого ба тусламжийн 49.9 хувийг Улаанбаатар хот, 21.5 хувийг Өмнөговь аймаг, 4.4 хувийг Орхон аймаг, 2.0 хувийг Дорноговь аймаг, 22.2 хувийг бусад аймгууд бүрдүүлсэн байна.

2.2.11 Бүсчлэлээр орон нутгийн төсвийн нийт орлого ба тусламжийн 49.8 хувийг Улаанбаатарын бүс, 24.9 хувийг Говийн бүс, 7.0 хувийг Хойд бүс, 5.3 хувийг Баруун бүс, 5.4 хувийг Төвийн бүс, 3.6 хувийг Хангайн бүс, 4.0 хувийг Зүүн бүс эзэлж байна.

2.2.12 Аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас аймаг, нийслэлийн төсөвт 1,893.9 тэрбум төгрөгийг шилжүүлэн хуваарилсан байна. Тухайлбал, Өмнөговь аймаг 770.9 тэрбум төгрөг, Улаанбаатар хот 818.4 тэрбум төгрөг, Орхон аймаг 102.1 тэрбум төгрөг байна.

Нүүрсний экспортын үнэ төлөвлөсөн хэмжээнд хүрээгүйгээс 487.4 тэрбум төгрөгөөр тасарсан боловч биет хэмжээг нэмэгдүүлсэн, зэсийн баяжмал, алтны үнийн өсөлт, төмрийн хүдрийн нийлүүлэлтээс шалтгаалан уул уурхай, газрын тосны салбарын орлого 484.7 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна.

2.2.13 Уул уурхай, газрын тосны бүтээгдэхүүний орлого төлөвлөснөөс 5.0 хувиар давж, өмнөх оноос 12.6 хувиар буурч, эдийн засгийн 6.8 хувийн өсөлтийн 1.4 нэгж хувийг бүрдүүлж, нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжид уул уурхай, газрын тосны салбарын орлого 30.2 хувийг эзэлж байна.

2.2.14 Уул уурхай, газрын тосны бүтээгдэхүүний нийт орлогын 43.4 хувийг АМНАТ, 29.7 хувийг ААНОАТ, 13.4 хувийг бусад татвар, хураамж, 4.1 хувийг ногдол ашиг, 5.7 хувийг гаалийн татвар, хураамж, 3.7 хувийг НӨАТ тус тус эзэлж байна.

2.2.15 Тайлант онд АМНАТ-ийн орлогыг гүйцэтгэлээр 3,874.5 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, төсвийн тогтворжуулалтын санд 348.0 тэрбум төгрөг, ирээдүйн өв санд 1,255.9 тэрбум төгрөг, улсын төсөвт 2,270.6 тэрбум төгрөгийг хуваарилжээ.

Хүснэгт 6. Уул уурхай, газрын тосны бүтээгдэхүүний орлого бүрдүүлэлт

/тэрбум төгрөг/

№	Бүтээгдэхүүн нэр төрөл	2021	2022	2023	2024	2025
1	Алт, тушаасан (цэвэр жингээр)	227.1	258.2	311.7	375.4	579.9
2	Зэсийн баяжмал	2,448.2	2,425.6	2,742.6	2,699.6	3,697.5
3	Төмрийн хүдэр	189.2	56.5	117.5	200.1	457.8
4	Нүүрс	980.9	2,260.7	4,723.8	7,373.2	4,373.8
5	Боловсруулаагүй нефть	198.1	160.9	304.2	237.8	231.9
6	Бусад	280.7	354.2	416.8	583.8	680.9
	Дүн	4,324.2	5,516.1	8,616.6	11,469.9	10,021.8

Эх сурвалж: Сангийн яам, Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.2.16 Нэгдсэн төсвийн нийт орлогын 30.2 хувийг уул уурхай, газрын тосны салбарын орлого бүрдүүлж байгаагаас гол нэр төрлийн эрдэс баялаг болох нүүрс 13.2 хувийг, зэсийн баяжмал 11.1 хувийг эзэлж байна.

Хүснэгт 7. Уул уурхай, газрын тосны бүтээгдэхүүний үнэ, биет хэмжээ

/тэрбум төгрөг/

Бүтээг- дэхүүн нэр төрөл	х/н	Биет хэмжээ			Үнэ, ам доллар/нэгж			Орлого /тэрбум төгрөг/		
		2024 гүйц	2025		2024 гүйц	2025		2024 гүйц	2025	
			Төл	Гүйц		Төл	Гүйц		Төл	Гүйц
Нүүрс	сая.тн	83.8	85.0	90.0	103.9	70.0	64.1	7373.2	4,861.2	4,373.8
Зэсийн баяжмал	сая.тн	1.7	2	2.3	9,184.0	9,200.0	9,938.6	2,699.6	3,021.2	3,697.5
Алт, тушаасан (цэвэр жингээр)	тн, \$/унц	10.9	16.5	11.3	2,483.4	2,900.0	3,429.2	375.4	457.6	579.9
Төмрийн хүдэр	сая.тн	7.5	8.1	8.8	79.6	72.0	72.1	200.1	281.4	457.8
Боловсруулаагүй нефть	сая.бар	4.1	3.8	3.5	76.5	72.0	71.3	237.8	249.7	231.9
Бусад	-	-	-	-	-	-	-	583.8	666.0	680.9
Дүн	-	-	-	-	-	-	-	11,469.9	9,537.1	10,021.8

Эх сурвалж: Сангийн яам, Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.2.17 Экспортын гол нэр төрлийн түүхий эд, нүүрсний үнэ өмнөх оноос буурч, тонн тутамд 64.0 ам.долларт хүрч олборлогч компаниудын ашигт ажиллагаанаас хамааран татвар ногдох орлогын хэмжээ буурсан байна.

2.2.18 Уул уурхайн салбарын экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүний төлөвлөсөн үнэ буурсан боловч нүүрсний биет хэмжээ 90.0 сая тоннд хүрч 7.4 хувиар, зэсийн баяжмалын биет хэмжээ 2.3 сая тоннд хүрч 35.3 хувиар өсөж, 484.7 тэрбум төгрөгөөр орлого давж биелсэн байна.

2.2.19 Уул уурхайн салбарын голлох нэр төрлийн бүтээгдэхүүн болох нүүрсний борлуулалтын биет хэмжээ өмнөх оноос 7.4 хувь буюу 6.2 сая тонн, төлөвлөснөөс 5.8 хувь буюу 5.0 сая тоннд хүрч нэмэгдсэн байна.

2.2.20 Гадаадын шууд хөрөнгө оруулалтад уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт 75.1 хувь, гадаад худалдааны экспортод уул уурхай эрдэс баялгийн бүтээгдэхүүн 93.0 хувийг эзэлж байна.

Ирээдүйн өв сангийн корпорац байгуулах, хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх эрх олгосон мандатыг боловсруулж, түүхий эдийн мөчлөгийн үед бий болсон орлогыг хуримтлуулах замаар төсвийн тэлэлтийг хязгаарлах, бодлого хэрэгжүүлэх орон зайг бий болгох, гадаад валютын нөөцийг тогтворжуулах бодлого баримтлах шаардлагатай байна.

2.2.21 Тогтворжуулалтын санд 429.1 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээр баталж, гүйцэтгэлээр 131.1 хувь буюу 562.5 тэрбум төгрөгийг төвлөрүүлжээ. Үүнээс ААНОАТ-аас 119.0 тэрбум төгрөг, АМНАТ-өөс 443.5 тэрбум төгрөгийг бүрдүүлжээ.

2.2.22 Тогтворжуулалтын санд төвлөрүүлэх орлого төлөвлөснөөс 31.1 хувь буюу 133.4 тэрбум төгрөгөөр давж биелсэн нь нүүрсний биет хэмжээ 90.0 сая тоннд хүрч 7.4 хувиар, зэсийн баяжмалын биет хэмжээ 2.3 сая тоннд хүрч 35.3 хувиар өсч, зах зээлийн үнэ нүүрсний тэнцвэржүүлсэн үнээс өндөр байсан нь нөлөөлсөн байна.

Хүснэгт 8. Төсвийн тогтворжуулалт, Үндэсний баялгийн сангийн орлого

/тэрбум төгрөг/

Он	Нийт орлого ба тусламж	ДНБ	Хуримтлал					Эзлэх хувь	
			Ирээдүйн өв сан	Тогтворжуулалтын сан	Хуримтлалын сан	Хөгжлийн сан	Дүн	Нийт орлогод	ДНБ-д
2017	7,958.3	28,010.7	357.7	325.7	-	-	683.4	8.6	2.4
2018	10,172.8	32,582.6	620.7	207	-	-	827.7	8.1	2.5
2019	12,040.3	37,839.2	1,040.2	94.6	-	-	1134.8	9.4	3.0
2020	10,450.2	37,453.3	914.1	66.2	-	-	980.3	9.4	2.6
2021	14,306.4	43,555.5	967	627.9	-	-	1594.9	11.1	3.7
2022	18,521.6	53,851.5	1,626.3	1,394.6	-	-	3064.9	16.5	5.7
2023	24,387.1	70,441.5	416.2	675.9	-	-	1092.1	4.5	1.6
2024	31,456.6	79,956.3	841.4	443.9	500.6	*	1,785.7	5.7	2.2
2025	33,179.2	89,937.1	1,710.6	562.5	603.0	*	2,876.1	8.7	3.2

Эх сурвалж: Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.2.23 Засгийн газрын “Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сангийн хөрөнгийн удирдлагын бодлого батлах тухай” 2025 оны 72 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллахыг Сангийн яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд даалгаж, Монголбанканд зөвлөсөн байна.

2.2.24 Ирээдүйн өв сангийн болон Хуримтлалын сангийн хөрөнгийн удирдлагын бодлогыг баталсан боловч Ирээдүй өв сангийн тухай хуульд заасан тус сангийн хөрөнгийг мандатын дагуу удирдах, хянах тогтолцоо бүрдээгүй байна.

2.2.25 Ирээдүйн өв санд 1,394.0 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлэхээр баталж, гүйцэтгэлээр АМНАТ-аас 1,409.6 тэрбум төгрөг, хөрөнгө оруулалт, ханшийн өөрчлөлтөөс 301.0 тэрбум төгрөг, нийт 1,710.6 тэрбум төгрөгийн орлого төвлөрч, Монголбанканд гадаад валютаар нийт 4,751.7 тэрбум төгрөгийн хөрөнгийг арвижуулахаар хадгаламж хэлбэрээр байршуулсан байна.

2.2.26 Харин хуримтлалын санд 562.1 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 602.9 тэрбум төгрөгийн орлого төвлөрч, 964.4 тэрбум төгрөгийг Монголбанктэй гэрээ байгуулж, орон сууцны зээлээр баталгаажсан үнэт цаасыг худалдан авах замаар хөрөнгө оруулалт хийсэн байна.

2.2.27 Тогтворжуулалтын санд 2011-2025 онд нийт 4,823.1 тэрбум төгрөг, Ирээдүй өв санд 8,494.2 тэрбум төгрөг, Хуримтлалын санд 1,103.6 тэрбум төгрөгийн хуримтлал үүсгэн төсвийн алдагдлыг санхүүжүүлэх, Хүний хөгжил сангийн өглөг барагдуулах, хүүхдийн мөнгөн хуримтлал олгоход зарцуулсан байна.

2.3 Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн татварын орлогыг 29,241.6 тэрбум төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 27,213.0 тэрбум төгрөг төвлөрүүлсний 57.4 хувь буюу 15,612.1 тэрбум төгрөг нь улсын төсвийн татварын орлого байна. Үүнээс ТӨХК-уудаас 2026 оны татварын урьдчилгаа 264.5 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлж, орлогын гүйцэтгэлийг нэмэгдүүлсэн байна

2.3.1 Улсын төсөвт нийт 16,499.6 тэрбум төгрөгийн татварын орлогыг төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 15,612.1 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, баталсан төлөвлөгөө 887.5 тэрбум төгрөг буюу 5.4 хувиар тасарсан байна.

Хүснэгт 9. Монгол Улсын 2025 оны улсын төсвийн татварын орлого

/тэрбум төгрөг/


№	Үзүүлэлт	2024 оны Гүйц	2025 оны				Өмнөх оноос өөрчлөлт
			Төл	Гүй	Зөрүү	Хувь	
1	Татварын орлого	17,033.1	16,499.6	15,612.1	(887.5)	94.6	(1,421.2)
1.1	Орлогын албан татвар	4,307.6	3,835.6	3,771.1	(64.5)	98.3	(536.5)
1.4	Нэмэгдсэн өртгийн албан татвар	5,866.8	6,646.8	6,207.3	(439.4)	93.4	340.5
1.5	Онцгой албан татвар	1,107.4	1,254.5	949.0	(305.5)	75.6	(158.4)
1.6	Тусгай зориулалтын орлого	26.4	31.5	25.5	(6.0)	81.0	(0.9)
1.7	Гадаад үйл ажиллагааны орлого	1,792.3	2,114.0	1,842.2	(271.8)	87.1	49.9
1.8	Бусад татвар (төлбөр, хураамж)	3,932.6	2,617.2	2,816.9	199.7	107.6	(1,115.7)

Эх сурвалж: Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн үр дүнгийн үзүүлэлт

2.3.2 Улсын төсвийн татварын орлого 94.6 хувийн биелэлтэд онцгой албан татвар 24.4 хувь, тусгай зориулалтын орлого 19.0 хувь, гадаад үйл ажиллагааны орлого 12.9 хувь, нэмэгдсэн өртгийн албан татвар 6.6 хувь, орлогын албан татвар 1.7 хувиар тасарч, бусад татвар 7.6 хувиар давсан нь нөлөөлжээ.

Дүрслэл 4. Татварын орлогын судалгаа

/тэрбум төгрөг/



2.3.3 Улсын төсвийн татварын орлого гүйцэтгэлээр 887.5 тэрбум төгрөгөөр тасарч, өмнөх оноос 8.3 хувь буюу 1,421.2 тэрбум төгрөгөөр буурсан байна

2.3.4 Орлогын албан татварын орлогод 3,835.6 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 3,771.1 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлж, 64.5 тэрбум төгрөгөөр тасарсан. ААНБ-ийн тоо 11.0 хувь, нийт борлуулалтын орлого 2.3 хувиар нэмэгдсэн боловч нийт ногдуулсан татварын дүн 1,917.5 тэрбум төгрөгөөр, төлөлт 948.6 тэрбум төгрөгөөр буурснаас шалтгаалсан байна.

2.3.5 Нэмэгдсэн өртгийн албан татварын орлогод 6,646.8 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 6,207.4 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлж, 439.4 тэрбум төгрөгөөр тасарсан нь нийт импорт төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй, 241.6 тэрбум төгрөгийн импортын НӨАТ-ыг төлөх хугацааг хойшлуулсан, дотоодын барааны "0" хувь ногдуулалтын хэмжээ өссөн, НӨАТ-ын хуримтлагдсан өр 693.8 тэрбум төгрөг болсон зэргээс шалтгаалжээ.

2.3.6 Онцгой албан татварын орлогод 1,254.5 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 949.0 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлж, 305.5 тэрбум төгрөгөөр тасарсан нь импортолсон суудлын автомашины тоо өмнөх оноос 32693 ширхгээр буурч, дотоодын архи, дарс, спиртийн үйлдвэрлэлийн тоо хэмжээ өссөн ч борлуулалт хангалтгүй байгаа зэргээс шалтгаалсан байна.

2.3.7 Тусгай зориулалтын орлогод 31.5 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 25.5 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлж, 6.0 тэрбум төгрөгөөр тасарсан нь зах зээлд А-80 авто бензиний эрэлтээс шалтгаалсан импорт 5.4 мянган тонноор буурсан, Засгийн газрын "Авто бензин, дизелийн түлшний гааль, онцгой албан татварын тухай" 2024 оны 241 дүгээр тогтоолын хэрэгжилтийг сунгаж, 2025 он болгосноос шалтгаалсан байна.

2.3.8 Гадаад үйл ажиллагааны орлогод 2,114.0 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 1,842.2 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлж, 271.8 тэрбум төгрөгөөр тасарсан нь гадаад худалдааны нийт эргэлт төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй, БТКУС-ын сагсан дах импортын 7 нэр төрлийн бараа нийт дүнгээр 459.4 сая ам.доллараар, экспортын 11 нэр төрлийн бараа нийт дүнгээр 471.6 сая ам.доллараар буурсан байна.

2.3.9 Бусад татвар (төлбөр, хураамж)-д 2,617.2 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 2,816.0 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлж, 198.8 тэрбум төгрөгөөр давсан нь АМНАТ 225.7 тэрбум төгрөг, ашигт малтмалын хайгуул болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр 15.8 тэрбум төгрөг, улсын тэмдэгтийн хураамж 14.1 тэрбум төгрөгөөр тус тус давсантай холбоотой байна.

Хувьцааны ногдол ашгийг үндэслэлтэй төлөвлөж, бүрэн төвлөрүүлээгүй, экспортын биет хэмжээ төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй, зарим төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжээгүйгээс татварын бус орлогын зарим ангиллын төлөвлөгөө биелээгүй байна.

2.3.10 Монгол Улсын 2025 оны төсөвт нийт 3,295.4 тэрбум төгрөгийн татварын бус орлогыг төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 3,375.9 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, 80.5 тэрбум төгрөг буюу 2.4 хувиар давж биелсэн байна.

Хүснэгт 10. Монгол Улсын 2025 оны улсын төсвийн татварын бус орлого

/тэрбум төгрөг/

Д.д	Үзүүлэлт	2024 оны гүйц	2025 он				Өмнөх оноос өөрчлөлт
			Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь	
2	Татварын бус орлого	3,056.0	3,295.4	3,375.9	80.5	102.4	239.3
2.1	Нийтлэг татварын бус орлого	1,178.5	1,070.8	1,745.3	674.5	163.0	(107.8)
2.1.1	Хувьцааны ногдол ашиг	40.1	100.0	64.7	(35.3)	64.7	59.9
2.1.2	Хүү, торгуулийн орлого	189.4	127.9	111.9	(16.0)	87.5	(61.5)
2.1.3	Түрээсийн орлого	3.9	1.6	4.6	3.0	290.1	(2.3)
2.1.4	Газрын тосны орлого	237.8	249.7	231.9	(17.8)	92.9	11.9
2.1.5	Навигацийн орлого	80.0	80.0	80.0	-	100.0	-
2.1.6	Төсөв байгууллагын өөрийн орлого	413.3	339.7	685.0	345.2	201.6	(73.6)
2.1.7	Бусад орлого	214.1	171.9	567.3	395.4	330.0	(42.2)
2.3	Тусламжийн орлого	1,877.5	2,224.6	1,630.6	(594.0)	73.3	347.1

Эх сурвалж: Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн үр дүнгийн үзүүлэлт

2.3.11 Нийтлэг татварын бус орлогод 1,070.8 тэрбум төгрөгийг төлөвлөснөөс 1,745.3 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, 674.5 тэрбум төгрөгөөр давсан нь төсөвт байгууллагын өөрийн орлого 345.2 тэрбум төгрөг, бусад орлого 395.4 тэрбум төгрөгөөр давснаас шалтгаалсан байна.

2.3.12 Хувьцааны ногдол ашигт 100.0 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 64.7 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлж, 35.3 тэрбум төгрөгөөр тасарсан нь ТӨБЗГ-ын 2025 оны 312 дугаар тогтоолоор 78.2 тэрбум төгрөгийг 31 хуулийн этгээдээс бүрдүүлэхээр баталж, 21.8 тэрбум төгрөгийн орлогын эх үүсвэр тодорхойгүйгээс шалтгаалсан байна.

Эрчис ойл ХХК, Эрчим хүчний үндэсний төв ХХ, Биокомбинат ХХ, Хөдөө аж ахуйн корпорац ХХК, Төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэрлэл технологийн цогцолбор ТӨХХК, Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ, Засгийн газрын автобааз ТӨҮГ, Төр хувийн хэвшлийн түншлэл ТӨҮГ, Төрийн үнэт цаасны хэвлэл ТӨОХХК-ийн нийт 15.6 тэрбум төгрөгийг ногдол ашгаас төвлөрүүлээгүй байна.

2.3.13 Хүү, торгуулийн орлогод 127.9 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээс, гүйцэтгэлээр 111.9 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлж, 16.0 тэрбум төгрөгөөр тасарсан нь төрийн сангийн чөлөөт эх үүсвэр, хадгаламжийн хэмжээ буурч, харилцах, хадгаламжийн дансанд бодогдох хүүгийн орлого 30.3 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн.

2.3.14 Газрын тосны орлогод 249.7 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээс, гүйцэтгэлээр 237.9 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлж, 17.8 тэрбум төгрөгөөр тасарсан нь газрын тосны олборлолтын 94 хувийг бүрдүүлж буй “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн олборлолт, үйлдвэрлэлийн хэмжээ төлөвлөсөн хэмжээнд хүрээгүйгээс шалтгаалжээ.

2.3.15 Төсөвт байгууллагын өөрийн орлогод 339.7 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээс, гүйцэтгэлээр 685.0 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлж, баталсан төлөвлөгөөнөөс 345.2 тэрбум төгрөгөөр давсан нь улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын харьяа орлогын төлөвлөгөө батлагдсан 263 байгууллагын 336.9 тэрбум төгрөгийн орлого давж, 104 байгууллагын 31.5 тэрбум төгрөгийн төлөвлөгөөгүй орлогыг төвлөрүүлж, 128 байгууллага 23.2 тэрбум төгрөгөөр орлогын төлөвлөгөөг тасалсан байна.

2.3.16 Тусламжийн орлогод 2,224.6 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээс, гүйцэтгэлээр 1,630.6 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлж, 594.0 тэрбум төгрөгөөр тасарсан нь Өмнөговь аймаг 419.9 тэрбум төгрөг, Орхон аймаг 83.4 тэрбум төгрөг, Дорноговь аймаг 9.7 тэрбум төгрөгийн орлогыг тус тус үндэслэлтэй төлөвлөөгүй, уул уурхайн салбар дагасан зах зээл хумигдсан, татвар ногдох орлогын хэмжээ буурсан зэргээс шалтгаалсан байна.

Татварын зарлага буюу тайлант оны татварын хөнгөлөлт, чөлөөлөлт 1,698.7 тэрбум төгрөгт хүрч, татварын нийт орлогын 5.8 хувьтай тэнцэж байна.

Хүснэгт 11. Татварын хөнгөлөлт чөлөөлөлтийн судалгаа

/тэрбум төгрөг/

Нийт	Хөнгөлөлт		Чөлөөлөлт		Нийт /хөн+чөл/	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ААНОАТ	5,888	264.6	5,393	777.8	11,281	1,042.4
ХХОАТ	1,516,031	194.0	4,716	10.0	1,520,747	204.1
НӨАТ-ын чөлөөлөлт	-	-	23,465	324.5	23,465	324.5
Гаалийн албан татвар	-	-	-	78.7	-	78.7
Импортын НӨАТ	-	-	-	49.0	-	49.0
Нийт дүн	1,521,919	458.6	33,574	1,240.1	1,555,493	1,698.7

Эх сурвалж: Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн үр дүнгийн үзүүлэлт

2.3.17 Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн дагуу чөлөөлсөн 264.6 тэрбум төгрөг, хөнгөлөлт 777.8 тэрбум төгрөг, хувь хүний орлогын албан татварын тухай хуулиар чөлөөлсөн 10.0 тэрбум төгрөг, хөнгөлөлт 194.0 тэрбум төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хөнгөлөлт, чөлөөлөлт 324.5 тэрбум төгрөгт тус тус хүрчээ.

2.3.18 Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулиар нийт 9 арга хэмжээний 358.8 тэрбум төгрөгийг чөлөөлсөн байна.

Татварын системд бүртгэлтэй олон жилийн насжилттай хуримтлагдсан өрийн дүн нэмэгдсэн нь татварыг шударга төлөх зарчим алдагдах, улсын төсвийн орлого тасрах эрсдэлийг нэмэгдүүлж байна

2.3.19 Татварт бүртгэлтэй өрийн үлдэгдлийг 1990-2024 оны байдлаар авч үзвэл 5,948.7 тэрбум төгрөгийн үлдэгдэл байна. Үүнээс төлөгдөхгүй байгаа насжилт өндөртэй өр төлбөр 42.7 хувь буюу 2,540.0 тэрбум төгрөг, барагдуулах боломжтой төлөгдөх хугацаандаа байгаа 57.3 хувь буюу 3,408.7 тэрбум төгрөг байна.

Хүснэгт 12. Татварын өрийн мэдээлэл 1990-2024 он

/тэрбум төгрөг/

Татварын төсөв, төрлөөр	Нийт дүн	Он						Дүнд эзлэх хувь
		1990-2019	2020	2021	2022	2023	2024	
НИЙТ	5,948.7	981.7	229.2	363.0	935.1	980.2	2,459.6	100.0
Улсын төсөв	4,400.5	723.4	173.6	285.6	651.6	794.4	1,771.9	74.0
ААНОАТ	1,148.2	55.7	16.8	77.5	128.9	110.9	758.4	19.3
Агаарын бохирдол	16.8	4.7	0.6	1.0	1.0	3.6	5.9	0.3
АМНАТ	785.4	64.2	17.9	27.1	195.7	240.9	239.6	13.2
НӨАТ	2,416.4	580.2	137.9	179.9	325.8	438.6	754.0	40.6
Онцгой	18.6	3.6	0.3	0.1	0.3	0.4	13.9	0.3
Бусад	15.0	15.0	-	-	-	-	-	0.3
Орон нутаг	1,548.2	258.0	55.7	77.4	283.5	185.9	687.7	26.0
Аймаг, нийслэлийн төсөв	119.1	53.5	10.7	12.1	13.2	15.5	14.1	2.0
Сум, дүүргийн төсөв	1,429.3	204.7	45.0	65.3	270.3	170.4	673.6	24.0
Шалтгаан өр	2,540.0	638.1	55.1	68.7	450.9	246.1	1,081.1	42.7
Барагдах өрийн дүн	3,408.7	343.4	174.2	294.3	484.2	734.1	1,378.5	57.3

Эх сурвалж: Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн үр дүнгийн үзүүлэлт

2.3.20 Татварын байгууллагын программд бүртгэлтэй өрийн хэмжээ 1990-2024 оны байдлаар 2,540.0 тэрбум төгрөг болж өссөн байна. Үүнээс 2024 онд 1,081.1 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 835.0 тэрбум төгрөгөөр өссөн нь татварыг шударга төлөх зарчмыг алдагдуулж, татварын орлого тасрах, өр хуримтлах эрсдэл нэмэгдсэн байна.

2.3.21 Төлөгдөхгүй байгаа нийт 2,540.1 тэрбум төгрөгийн татварын өрийг төрлөөр нь авч үзвэл ААНОАТ 620.5 тэрбум төгрөг, НӨАТ 693.8 тэрбум төгрөг, АМНАТ 410.0 тэрбум төгрөг голлох нөлөө үзүүлж байна.

2.3.22 Өр барагдуулалт удааширсан шалтгааныг харахад 2024 онд 1,081.1 тэрбум төгрөгийн өр төлбөр нэмэгдсэнээс 84.9 хувь буюу 917.9 тэрбум төгрөг Татварын маргаан таслах зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой байгаа тул маргаан таслах зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулах, шийдвэр гаргах хугацааг богиносгох шаардлагатай байна.

2.3.23 Нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчийн бодит бус борлуулалт, хий бичилттэй холбоотой 249 татвар төлөгчийн 2,176.6 тэрбум төгрөг, бусад гэрээ, бараа, ажил, үйлчилгээ, мөнгө угаасан байж болзошгүй 109 татвар төлөгчийн 1,144.2 тэрбум төгрөг, нийт 358 татвар төлөгчийн 3,320.8 тэрбум төгрөгийн зөрчлийн танилцуулгыг цагдаа болон хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн байна.

Хүснэгт 13. Татварын ерөнхий газрын хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн зөрчлийн судалгаа

/тэрбум төгрөг/

Он	НӨАТ-ийн хий бичилт		Бусад гэрээ бараа, ажил, үйлчилгээ, мөнгө угаасан байж болзошгүй		Нийт	
	Тоо	Зөрчлийн дүн	Тоо	Зөрчлийн дүн	Тоо	Зөрчлийн дүн
2022	56	671.0	39	2,116.7	95	2,787.7
2023	101	853.4	40	439.5	141	1,292.9
2024	70	960.9	161	4,810.7	231	5,771.6
2025	249	2,176.6	109	1,144.2	358	3,320.8
Нийт	476	4,661.9	349	8,511.1	825	13,172.9

Эх сурвалж: Татварын удирдлагын нэгдсэн систем, 2025

2.3.24 Шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг аудитын явцад ЦЕГ-аас тодруулахад 2026 оны 106/5209 дүгээр албан бичгээр 2025 онд гааль, татварын байгууллагаас 101 зөрчлийн танилцуулга ирүүлснийг хүлээн авч, холбогдох мөрдөн шалгах ажиллагааг явуулснаас хэрэг бүртгэлтийн 49 хэргийг хааж, үлдэгдэл 52 танилцуулгад дурдагдсан асуудалд нийт 99 иргэн, аж ахуйн нэгжийг эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татан шүүхэд шилжүүлэх саналтай прокурорын байгууллагуудад тус тус шилжүүлсэн. Одоогийн байдлаар дээрх байгууллагуудаас 2024, 2025 онд ирүүлсэн танилцуулгын дагуу 55 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна гэсэн хариу ирүүлсэн.

2.3.25 Гааль, татварын байгууллагаас хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн мөнгө угаасан байж болзошгүй, татварын бүрдүүлэлт ногдуулалттай холбоотой гэмт хэргийн шинжтэй хэргүүдийг шийдвэрлэх ажиллагааны хууль эрх зүйн орчныг сайжруулах талаар өмнөх аудитаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, Цагдаагийн байгууллагад шилжүүлсэн зөрчлийн танилцуулгыг хүлээн авч, мөрдөн шалгах ажиллагааг явуулах, илрүүлэх, шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгуулах, зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагааг эрчимжүүлж, гэмт хэрэг, зөрчлийн талаарх нэгдсэн тоо бүртгэлийг бүрэн, үнэн зөв хөтлөөгүй зөрчлийг арилгуулахаар ХЗДХС-д албан шаардлага хүргүүлээ.

БҮЛЭГ 3. ТӨСВИЙН ОРЛОГО ТАСАРСАН, ТАЙЛАНТ ОНД ХЭРЭГЖСЭН ЗАРИМ ХӨТӨЛБӨР АРГА ХЭМЖЭЭНИЙ САНХҮҮЖИЛТИЙГ БҮРЭН ОЛГООГҮЙГЭЭС ДАРАА ОНЫ ТӨСӨВТ АЧААЛАЛ ҮҮСГЭЖ, ТӨЛӨВЛӨГДСӨН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ БҮРЭН ХЭРЭГЖИХГҮЙ БАЙХ ЭРСДЭЛИЙГ БИЙ БОЛГОЖ БАЙНА.

3.1 Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хуулиар тогтоосон хугацаанд батлаагүйгээс төсвийн төсөл дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан хөтөлбөр арга хэмжээтэй уялдаагүй байна.

3.1.1 Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийг анх 35,771.9 тэрбум төгрөгөөр баталснаас хөрөнгийн зардлыг 1,442.1 тэрбум төгрөг, урсгал зардлыг 730.0 тэрбум төгрөг, эргэж төлөгдөх цэвэр зээлийг 168.3 тэрбум төгрөг, нийт 2,340.4 тэрбум төгрөгөөр бууруулж, нийт зарлага ба цэвэр зээлийг 33,431.5 тэрбум төгрөг, төсвийн тэнцлийг 38.3 тэрбум төгрөгийн ашигтай байхаар баталсан байна.

3.1.2 Тайлант онд экспорт, төсвийн орлого буурч, эдийн засгийн өсөлт саарсны улмаас төсөвт өөрчлөлт оруулах шаардлага бий болж, нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийг 1,857.6 тэрбум төгрөгөөр бууруулж, 31,573.9 тэрбум төгрөгөөр баталсан нь Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны ТХМ-ийн нийт зарлагын дээд хэмжээнээс хэтрээгүй, төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл дотоодын нийт бүтээгдэхүүний 1.5 хувьтай тэнцүү хэмжээний алдагдалтай байхаар баталжээ⁸.

Хүснэгт 14. Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн төлөвлөлт

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Төсвийн жилийн хязгаар	ТЕЗ нарын санал	Анх баталсан 2024.11.08	Өөрчлөн баталсан		Төлөв	Зөрүү	
				2024.12.12	2025.07.09		Дүн	Хувь
А	1	2	3	4	5	6	7=6-3	8=6/3
НЭГДСЭН ТӨСӨВ*			35,771.9	33,431.5	31,573.9	35,363.4	(408.5)	105.8
Улсын төсөв	22,927.6	37,627.5	26,485.3	24,209.8	22,564.3	22,564.3	(3,921.0)	93.2
Орон нутгийн төсөв ⁹	7,000.1	9,465.3	7,756.1	7,635.1	6,938.9	10,721.1 ¹⁰	2,965.0	140.4
НДС-ийн төсөв	5,413.3	6,174.3	5,815.5	5,815.5	5,802.2	5,802.2	(13.3)	99.8
ЭМДС-гийн төсөв	1,886.3	2,801.5	2,216.3	2,216.3	2,164.8	2,164.8	(51.5)	97.7

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл /*цэвэр дүнгээр/

3.1.3 Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангаар нийт зарлага ба цэвэр зээлийн төлөвлөгөө ТХМ-ээр баталснаас 3,788.3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь орон нутгийн төсвийн Сангийн яамны хянасан дүнг ИТХ-аар баталсан төсвийн дүнгээр нэмэгдүүлсэнтэй холбоотой байна. Үүнд: Улаанбаатар хот 2,400.4 тэрбум төгрөгөөр, Өмнөговь аймаг 489.8 тэрбум төгрөгөөр, Орхон аймаг 214.4 тэрбум төгрөгөөр, бусад 19 аймаг 12.1–68.8 тэрбум төгрөгөөр тус тус нэмжээ.

3.1.4 Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 243 арга хэмжээнээс 128 буюу 52.7 хувь, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2025-2028 онд хэрэгжүүлэх 580 зорилтоос 169 зорилт буюу 29.1 хувь нь Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан байна¹¹.

3.1.5 УИХ-ын 2024 оны “Монгол Улсын хөгжлийн 2025 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл” 35 дугаар тогтоолоор Эдийн засаг, Бүсчилсэн хөгжил, Хүний хөгжил, Хүний эрхийг дээдэлсэн засаглалын үндсэн бодлогын хүрээнд өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж байгаа асуудлуудыг тодорхойлж, шаардлагатай салбарын реформыг шуурхай эхлүүлж, тэргүүлэх ач холбогдолтой хөгжлийн томоохон төслүүдийг эрчимжүүлэхийг зорьжээ.

⁸ Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.9-д “... 2025 оны төсвийн жилээс эхлэн нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байна”

⁹ Сангийн яамны хянасан дүн

¹⁰ ИТХ-ын баталсан дүн

¹¹ Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн Нийцлийн аудитын тайлан, 5 дугаар нүүр, 1.3, 1.4 дэх хэсэг

3.1.6 Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд улсын төсвөөс 182 төсөл, арга хэмжээнд 4,810.4 тэрбум төгрөг, орон нутгийн төсвөөс 9 төсөл, арга хэмжээнд 466.3 тэрбум төгрөг, гадаад зээл, тусламжаар 93 төсөл, арга хэмжээнд 4,151.5 тэрбум төгрөг, төр, хувийн хэвшлийн түншлэл, бусад хөрөнгөөр 44 төсөл, арга хэмжээнд 9,930.9 тэрбум төгрөг, нийт 19,359.1 тэрбум төгрөгийн санхүүжилт шаардагдах 328 төсөл, арга хэмжээг 19 ТЕЗ хэрэгжүүлэхээр тусгасан байна.

3.1.7 Дээрх бодлогын хүрээнд 20 хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч тухайн онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл, улсын хөгжлийн төлөвлөгөөг хуулиар тогтоосон хугацаанд батлаагүй¹², ТЕЗ нар төсвийн төслийг улсын жилийн төлөвлөгөөнд үндэслэн боловсруулаагүйгээс зарим төсөл, арга хэмжээ хэрэгжихгүй, санхүүжих эх үүсвэр шийдвэрлэгдэхгүй байх нөхцөлийг бий болгожээ.

3.1.8 Засгийн газраас дунд хугацааны ТХМ-д нийцүүлэн улсын төсвийн жилийн хязгаарыг 22,927.6 тэрбум төгрөгөөр, орон нутгийн төсвийн жилийн хязгаарыг 7,000.1 тэрбум төгрөгөөр¹³, нийгмийн даатгалын сангийн төсвийн жилийн хязгаарыг 5,413.3 тэрбум төгрөгөөр, эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн жилийн хязгаарыг 1,886.3 тэрбум төгрөгөөр тус тус баталсан байна.

3.1.9 ТЕЗ нар төсвийн төслийг Засгийн газрын баталсан жилийн төсвийн хязгаарт үндэслэж, боловсруулаагүй¹⁴, хязгаарт багтаагүй саналын холбогдох үндэслэл, тайлбарыг бодитой гаргаж ирүүлээгүй зөрчлүүд жил бүр давтагдсаар байна. Үүнд: Улсын ТЕЗ 14,699.9 тэрбум төгрөгөөр, орон нутгийн ТЕЗ 2,465.2 тэрбум төгрөгөөр, НДС 761.0 тэрбум төгрөгөөр, ЭМДС 915.2 тэрбум төгрөгөөр тус тус хэтрүүлэн ирүүлжээ.

3.1.10 Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийг тодотгож, 31,573.9 тэрбум төгрөгөөр баталсан нь өмнөх оны гүйцэтгэлээс 982.8 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн боловч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн зарим төсөл, арга хэмжээний санхүүжилт батлагдаагүй, хариуцагч байгууллагыг буруу тодорхойлсон, төсөл, арга хэмжээг давхардуулан төлөвлөсөн¹⁵ байна.

3.1.11 Улсын жилийн төлөвлөгөөнд улсын төсвөөс санхүүжих 18 төсөл, арга хэмжээний санхүүжилтийн хэмжээг батлаагүй, 1,499.1 тэрбум төгрөгийн 74¹⁶ төсөл, арга хэмжээ буюу 46.3 хувийг Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар баталж, ТЕЗ нарын хөтөлбөрийн зорилт хүрэх үр дүнд бүрэн тусгаагүй нь Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.8-д “улсын жилийн төлөвлөгөөнд суурилсан байх”, 27.1.9-д “төрийн мөнгөний бодлогын зорилтод нийцсэн байх” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

3.1.12 Монгол Улс урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд гадаадын тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөтөлбөрийн хүрээнд үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлтийн шинэчлэлийг 2020 оноос эхлүүлсэн боловч өнөөдрийн байдлаар боловсролын салбарыг үе шаттай шилжүүлж байна.

3.1.13 Сангийн яам “Монгол Улсад тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн хүрээнд 2021 оноос эхлэн төсвийн төслийг боловсруулах удирдамжид гүйцэтгэл болон үр дүнд суурилсан төлөвлөлтийг туршилтаар хэрэгжүүлж, заавар, аргачлалыг ТЕЗ нарт хүргүүлжээ.

3.1.14 ТЕЗ нарын төсвийн төсөл бэлтгэх удирдамжид¹⁷ Боловсролын сайд, ГБХНХС, ССАЖЗС, ХХААХҮС-ын төсвийг үр дүнд суурилан¹⁸ боловсруулж, хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнээс Боловсролын сайдын төсвийг бараа, үйлчилгээний бусад зардал, цалин хөлсний

¹² УИХ-ын 35 дугаар тогтоолоор 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдөр баталсан.

¹³ Сангийн яамны хянасан дүн

¹⁴ Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.4-т “жилийн төсвийн хязгаарт үндэслэсэн байх”, 31 дүгээр зүйлийн 31.1.3-т “жилийн төсвийн хязгаарт багтаасан байх”

¹⁵ Улсын хөгжлийн 2025 оны жилийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн Нийцлийн аудитын тайлан, 8 дугаар нүүр

¹⁶ Улсын хөгжлийн 2025 оны жилийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн Нийцлийн аудитын тайлан, 5 дугаар нүүр

¹⁷ Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.4-т “санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага ... жилийн төсвийн хязгаарыг төсвийн удирдамжийн хамт жил бүрийн 7 дугаар сарын 5-ны дотор төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх”

¹⁸ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.11-т “төлөвлөлт нь үр дүнд чиглэсэн байх”

зардлын эдийн засгийн ангиллаар үр дүнд суурилж, эрүүл мэндийн салбараас ЭМДС-аас олгодог санхүүжилтийг гүйцэтгэлд суурилж, бусад салбарын ТЕЗ нарын төсвийг уламжлалт аргаар бэлтгэсэн байна.

3.1.15 ССАЖЗС-ын эрхлэх асуудлын хүрээний Соёл, урлагийн газрын орон нутгийн харьяа байгууллагуудын өөрийн орлогыг төлөвлөхгүйгээр гүйцэтгэлд суурилах зарчмаар санхүүжүүлсэн байна. Тухайн байгууллагууд өөрийн орлогын 10.5 тэрбум төгрөгийг уран бүтээл туурвих, тоглолтын чанарыг дээшлүүлэх зэрэг гарцын гүйцэтгэлийг сайжруулахад зарцуулахгүйгээр үндсэн үйл ажиллагааны урсгал зардалд зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 4.1.56¹⁹ дахь хэсэгт заасантай нийцэхгүй байна.

3.1.16 Засгийн газраас анх баталсан төсвийн төслийг дахин боловсруулж, өргөн мэдүүлэхдээ эрүүл мэнд, нийгмийн халамж, тэтгэмж, тусламж үйлчилгээ болон төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын урсгал зардлыг бууруулахгүй байх, төсөвт байгууллагуудын үр ашиггүй зардлыг бууруулж, төрийн байгууллагуудын орон тооны давхардлыг арилгах, төрийн үйл ажиллагааг хүрэх үр дүн, гүйцэтгэлд суурилж санхүүжүүлэх, үйл ажиллагааны зарим зардлыг 10.0–100.0 хувиар бууруулах бодлогыг баримталж, урсгал зардлыг 786.1 тэрбум төгрөгөөр, 2 дахь удаагийн тодотголоор 1,889.4 тэрбум төгрөгөөр тус тус бууруулан боловсруулсан нь төсвийн төсөл бэлтгэх удирдамжтай нийцсэн байна.

Зарим хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний санхүүжигдээгүй зардлыг дараа жилийн төсвөөс олгосон нь төсөвт ачаалал үүсгэх, тухайн онд төлөвлөгдсөн хөтөлбөр, арга хэмжээ бүрэн хэрэгжихгүй байх эрсдэлтэй байна.

3.1.17 Төсвийн жилийн дундуур нүүрсний үнэ огцом унаж, уул уурхайн салбарын орлого тасарснаас шалтгаалан төсвийн хэмнэлтийн горимд шилжиж, нэн шаардлагатай цалин, НДШ, урсгал шилжүүлэг, татаас, хүүгийн зардал, төсвийн байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангах болон худалдан авах ажиллагаатай холбоотой зардлуудыг эрэмбэлэн санхүүжүүлсэн байна.

3.1.18 Зарим төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэл гарсан боловч, санхүүжигдээгүй, өр төлбөр үүссэнийг дараа жилийн төсвөөс барагдуулах эрсдэл үүссэн байна.

3.1.19 Улсын хөгжлийн төлөвлөлтийн бодлогын баримт бичигтэй уялдуулан Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газраас санаачилсан "Хүнсний хувьсгал" хөтөлбөр, "Цагаан алт" үндэсний хөтөлбөр, "Шинэ хоршоо-Чинээлэг малчин", "Атар-IV тариалангийн тогтвортой хөгжлийн аян"-ы хүрээнд 420.2 тэрбум төгрөг батлагдсанаас 217.0 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

3.1.20 ХХААХҮС-ын хэрэгжүүлэх Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 17.3 тэрбум төгрөг, улаан буудай, сүү, ноос, арьс шир, хүнсний ногооны урамшуулалд 25.1 тэрбум төгрөг, зээлийн хүүгийн хөнгөлөлтөд 104.1 тэрбум төгрөг, сайдын хөтөлбөр арга хэмжээний зардалд 13.2 тэрбум төгрөг, нийт 159.7 тэрбум төгрөгийн хөтөлбөр, арга хэмжээ санхүүжигдээгүй, ССАЖЗС-ын хэрэгжүүлэх "Монголд зочлох жил", "Залуучуудын жил" арга хэмжээнд 1.6 тэрбум төгрөг батлагдсанаас 1.1 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй гарч, 0.4 тэрбум төгрөгийн өр төлбөр үүссэн байна.

3.1.21 Монгол Улсын төсөв, өрийн удирдлага болон макро эдийн засгийн үзүүлэлтүүдийг Олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч S&P агентлагаас Монгол Улсын зээлжих зэрэглэл В+ эерэг байсныг ВВ- тогтвортой, Moody's агентлаг В2 тогтвортойгоос В1 тогтвортой түвшинд 1 шат ахиулж, Fitch агентлагаас В+ тогтвортой түвшинд хэвээр үнэлсэн байна. Гэвч Монгол Улсын эдийн засаг нь уул уурхайн экспорт, түүхий эдийн үнэ, гадаад эрэлтээс өндөр хамааралтай хэвээр байгаа тул уул уурхайн орлогын түр зуурын өсөлтөд тулгуурлан цалин, тэтгэвэр, халамж, бараа үйлчилгээ зэрэг байнгын шинжтэй урсгал зардлыг нэмэгдүүлэхээс зайлсхийж,

¹⁹ Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.56-д "гүйцэтгэлд суурилсан санхүүжилт" гэж хөтөлбөр, арга хэмжээний хүрэх үр дүн, төрийн үйлчилгээний чанар зэрэг гарцын гүйцэтгэлийг сайжруулах зорилгоор төсвийн байгууллагын үйл ажиллагааны зардлыг бүхэлд нь, эсхүл тодорхой хэсгийг нийт дүнгээр нь төлөвлөж, хуваарилахыг.

урсгал зардлыг тогтвортой орлогын эх үүсвэр, төсвийн сахилга баттай уялдуулан төлөвлөх шаардлага байна.

3.1.22 Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээл 31,331.0 тэрбум төгрөг буюу 88.6 хувийн гүйцэтгэлтэй, ДНБ-ий 34.8 хувьтай тэнцэж байна.

Хүснэгт 15. Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээл

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2024 оны гүйц	2025 он				Өмнөх оноос зөрүү
		Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь	
А	1	2	3	4=2-3	5=3/2	6=3-1
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	30,591.1	35,363.4	31,331.0	4,032.4	88.6	739.9
Урсгал зарлага	22,176.6	25,970.8	24,237.7	1,733.1	93.3	2,061.1
Бараа, үйлчилгээний зардал	9,556.9	11,218.9	10,124.8	1,094.1	90.2	567.9
Хүү	1,235.9	1,633.8	1,548.2	85.6	94.8	312.3
Татаас ба урсгал шилжүүлэг	11,383.8	13,118.1	12,564.7	553.4	95.8	1,180.9
Хөрөнгийн зардал	7,970.8	9,553.6	7,074.1	2,479.5	74.0	(896.7)
Эргэж төлөгдөх цэвэр зээл	443.7	(161.0)	19.2	(180.2)	(11.9)	(424.5)
Төсвийн бүрэлдэхүүнээр*						
Улсын төсөв	21,372.4	22,564.3	20,414.3	2,150.0	90.5	(958.1)
Орон нутгийн төсөв	7,258.6	10,721.1	8,172.4	2,548.7	76.2	913.8
НДС-гийн төсөв	5,104.7	5,802.2	5,846.9	(44.7)	100.8	742.2
ЭМДС-гийн төсөв	1,926.9	2,164.8	2,238.3	(73.5)	103.4	311.4

Эх сурвалж: Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /*цэвэр дүнгээр/

3.1.23 Төсвийн нийт зарлагын гүйцэтгэлийн 52.5 хувийг улсын, 21.7 хувийг орон нутгийн, 18.7 хувийг НДС-гийн, 7.1 хувийг ЭМДС-гийн төсөв тус тус эзэлж байна.

3.1.24 Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн 24,237.7 тэрбум төгрөг буюу 77.3 хувийг урсгал зарлага, 7,074.1 тэрбум төгрөг буюу 22.6 хувийг хөрөнгийн зардал, 19.2 тэрбум төгрөг буюу 0.1 хувийг эргэж төлөгдөх цэвэр зээл эзэлж байна.

3.1.25 Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээл 31,331.0 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 739.9 тэрбум төгрөгөөр өссөн нь улсын төсвийн урсгал зардал 4.6 хувиар, орон нутгийн төсвийн урсгал зардал 12.7 хувиар нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.1.26 Урсгал зардал нийт зарлага ба цэвэр зээлийн 77.3 хувийг эзэлж байгаа нь өмнөх оноос 4.8 нэгж буюу 2,061.2 тэрбум төгрөгөөр өссөн, хөрөнгийн зардал 3.4 нэгж буюу 896.8 тэрбум төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгийн үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэхэд анхаарах шаардлагатай байна.

3.1.27 Урсгал зардал өмнөх оноос 2,061.1 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь татаас, урсгал шилжүүлэг 1,180.9 тэрбум төгрөгөөр, бараа, үйлчилгээний зардал 567.9 тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

3.1.28 Хөрөнгийн зардал 7,074.1 тэрбум төгрөг буюу 74.0 хувийн гүйцэтгэлтэй гарсан нь орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт 31.6 хувь буюу 1,532.0 тэрбум төгрөгөөр, улсын төсвийн хөрөнгө оруулалт 28.4 хувь буюу 903.2 тэрбум төгрөгөөр, гадаад тусламжийн хөрөнгө оруулалт 13.3 хувь буюу 40.7 тэрбум төгрөгөөр, гадаад зээлийн хөрөнгийн зардал 0.3 хувь буюу 3.6 тэрбум төгрөгөөр тус тус дутуу санхүүжсэнээс шалтгаалсан байна.

3.1.29 Улсын ТЕЗ нарын хэрэгжүүлдэг нийгмийн хамгааллын хөтөлбөр өмнөх оноос 401.6 тэрбум төгрөгөөр, эрх зүй, нийгмийн хэв журам, аюулгүй байдлын хөтөлбөр 309.1 тэрбум төгрөгөөр, батлан хамгаалахын хөтөлбөр 168.1 тэрбум төгрөгөөр тус тус өссөн, хөдөө аж ахуй, газар тариалан, аж үйлдвэрийн хөтөлбөр 224.2 тэрбум төгрөгөөр, эрчим хүч, уул уурхайн хөтөлбөр 200.6 тэрбум төгрөгөөр, соёл урлаг, спорт, аялал жуулчлалын хөтөлбөр 108.1 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

Хүснэгт 16. Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээл хөтөлбөрөөр

/тэрбум төгрөг/

Хөтөлбөрийн нэр	2024 оны гүйц	2025 он				Өмнөх оноос зөрүү
		Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь	
А	1	2	3	4=2-3	5=3/2	6=3-1
Улсын төсвийн нийт дүн	21,372.4	22,564.3	20,414.3	2,150.0	90.5	(958.1)
Боловсрол, шинжлэх ухаан	4,049.8	4,372.4	4,012.9	359.5	91.8	(36.9)
Нийгмийн хамгаалал	3,667.3	4,181.5	4,068.9	112.6	97.3	401.6
Ерөнхий төлөвлөлт, санхүү төсвийн харилцаа	4,245.2	3,628.2	3,255.3	372.9	89.7	(989.9)
Эрх зүй, нийгмийн хэв журам, аюулгүй байдал	1,746.5	2,176.2	2,055.6	120.6	94.5	309.1
Эрүүл мэнд	1,553.5	1,719.8	1,621.9	97.9	94.3	68.4
Батлан хамгаалах	1,016.5	1,206.3	1,184.6	21.7	98.2	168.1
Зам тээвэр	808.8	1,023.5	772.0	251.5	75.4	(36.8)
Хөдөө аж ахуй, газар тариалан, аж үйлдвэр	648.9	652.9	424.7	228.2	65.0	(224.2)
Соёл урлаг, спорт, аялал жуулчлал	491.0	439.9	382.9	57.0	87.0	(108.1)
Эрчим хүч, уул уурхай	501.5	408.2	300.9	107.3	73.7	(200.6)
Бусад	2,643.4	2,755.4	2,334.4	421.0	84.7	(309.0)
Орон нутгийн төсвийн нийт дүн	7,258.6	10,721.1	8,172.5	2,548.6	76.2	913.9
Ерөнхийлөгч, хууль тогтоох болон гүйцэтгэх засаглалын удирдлага	3,316.3	2,227.4	1,714.5	512.9	77.0	(1,601.8)
Зам тээвэр	453.6	766.4	664.7	101.7	86.7	211.1
Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуй	441.5	604.5	545.8	58.7	90.3	104.3
Боловсрол, шинжлэх ухаан	266.2	347.5	292.8	54.7	84.3	26.6
Бусад	2,780.9	6,775.2	4,954.7	1,820.5	73.1	2,173.8

Эх сурвалж: Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

3.1.30 Орон нутгийн хэрэгжүүлэх ерөнхийлөгч, хууль тогтоох болон гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөрийн зардал 1,601.8 тэрбум төгрөгөөр буурч, зам, тээвэр 211.1 тэрбум төгрөгөөр, барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн хөтөлбөрийн зардал 104.3 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

3.1.31 Гадаад зээл, тусламжаар 1,959.4 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 1,874.8 тэрбум төгрөг буюу 95.7 хувийн гүйцэтгэлтэй, өмнөх оноос 631.7 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 17. Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гадаад зээл, тусламжаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2024 оны гүйц	2025 он				Өмнөх оноос зөрүү
		Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь	
А	1	2	3	4=2-3	5=3/2	6=3-1
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	2,506.5	1,959.4	1,874.8	84.6	95.7	(631.7)
Гадаад зээлээр хэрэгжүүлэх ажил, үйлчилгээ	2,068.6	1,542.4	1,530.6	11.8	99.2	(538.0)
Бараа, үйлчилгээний зардал	194.0	107.0	101.5	5.5	94.9	(92.5)
Хөрөнгийн зардал	1,415.7	1,226.7	1,223.2	3.5	99.7	(192.5)
Эргэж төлөгдөх цэвэр зээл	458.9	208.8	205.9	2.8	98.7	(253.0)
Гадаад тусламжаар гүйцэтгэх ажил, үйлчилгээ	437.9	417.0	344.2	72.8	82.5	(93.7)
Бараа, үйлчилгээний зардал	46.2	112.0	79.9	32.1	71.3	33.7
Хөрөнгийн зардал	391.7	305.0	264.3	40.7	86.7	(127.4)

Эх сурвалж: Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

3.1.32 Гадаад зээлээр хэрэгжүүлсэн хөтөлбөр 99.2 хувь буюу 1,530.6 тэрбум төгрөгийн, гадаад тусламжаар хэрэгжүүлсэн хөтөлбөр 82.5 хувь буюу 344.2 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

3.1.33 Гадаад зээл, тусламжийн 79.3 хувийг хөрөнгийн зардал, 11.0 хувийг эргэж төлөгдөх цэвэр зээл, 9.7 хувийг урсгал зардал эзэлж байна.

3.1.34 Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 19.2 тэрбум төгрөг буюу 111.9 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь төлөвлөснөөс 180.2 тэрбум төгрөг буюу 11.9 хувиар давж биелсэн байна.

Хүснэгт 18. Нэгдсэн төсвийн эргэж төлөгдөх цэвэр зээл

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2024 оны гүйц	2025 оны			
		Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь
Нэгдсэн төсвийн эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийн дүн	443.7	(161.0)	19.2	(180.2)	(111.9)
Эргэж төлөгдөх дотоод цэвэр зээл	(15.1)	(369.8)	(186.7)	(183.1)	50.5
Эргэж төлөгдөх гадаад цэвэр зээл	458.8	208.8	205.9	2.9	98.6
Улсын төсвийн эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	325.3	(127.0)	(52.3)	(74.7)	41.2
Эргэж төлөгдөх дотоод цэвэр зээл	(133.5)	(335.8)	(258.2)	(77.6)	76.9
Эргэж төлөгдөх гадаад цэвэр зээл	458.8	208.8	205.9	2.9	98.6
Орон нутгийн төсвийн эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	125.3	110.8	76.5	34.3	69.0
Эргэж төлөгдөх дотоод цэвэр зээл	125.3	110.8	76.5	34.3	69.0
Нийгмийн даатгалын сангийн төсвийн эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	(2.5)	(67.3)	(1.6)	(65.7)	2.4
Эргэж төлөгдөх дотоод цэвэр зээл	(2.5)	(67.3)	(1.6)	(65.7)	2.4
Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	(4.4)	(77.6)	(3.4)	(74.2)	4.4
Эргэж төлөгдөх дотоод цэвэр зээл	(4.4)	(77.6)	(3.4)	(74.2)	4.4

Эх сурвалж: Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

3.1.35 Эргэж төлөгдөх цэвэр зээл улсын төсөв 41.2 хувийн, орон нутгийн төсөв 69.0 хувийн, НДС-гийн төсөв 2.4 хувийн, ЭМДС-гийн төсөв 4.4 хувийн гүйцэтгэлтэй байна.

Эргэж төлөгдөх дотоод цэвэр зээл 50.5 хувийн, гадаад цэвэр зээл 98.6 хувийн гүйцэтгэлтэй байна.

3.1.36 Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн эргэж төлөгдөх дотоод цэвэр зээлийг 369.8 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс 186.7 тэрбум төгрөг буюу 50.5 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 19. Нэгдсэн төсвийн эргэж төлөгдөх цэвэр зээл

/тэрбум төгрөг/

ТЭЗ	Төсөл хөтөлбөрийн нэр	2025 оны			
		Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь
Олгосон зээл, үүнээс		316.3	158.2	158.1	50.0
Боловсролын сайд	Боловсролын зээлийн сан	27.9	16.2	11.7	58.1
ГБХНХС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	45.0	-	45.0	-
Сангийн сайд	Засгийн газрын зээл ба бонд	41.2	-	41.2	-
ХББОСС	Түрээсийн орон сууц хөтөлбөр	4.5	4.5	-	100.0
ХХААХҮС	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан	45.0	47.2	(2.2)	104.9
	Зээлийн батлан даалтын сан	5.0	-	5.0	-
	Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах хоёр үе шаттай зээлийн төсөл	24.7	13.8	10.9	55.9
	Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил нэгж	12.2	-	12.2	-
Орон нутаг	19 аймгийн ТЭЗ	110.8	76.5	34.3	69.0
Буцаан төлөгдсөн зээл, үүнээс		(686.1)	(344.9)	(341.2)	50.3
Боловсролын сайд	Боловсролын зээлийн сан	(30.0)	(17.9)	(12.1)	59.7
ГБХНХС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	(4.0)	(3.1)	(0.9)	77.5
Сангийн сайд	Аж ахуйн нэгж, байгууллага	(300.0)	(285.3)	(14.7)	95.1
	4.0 мянга, 100.0 мянга орон сууц хөтөлбөр	(6.2)	(6.1)	(0.1)	98.4
	Анод банкнаас авах авлага	(22.4)	-	(22.4)	-
	Зоос банкны хүлээн авагчаас авах авлага	(58.5)	-	(58.5)	-
ХЗДХС	Банк, хадгаламж зээлийн хоршооны ажлын алба	(20.6)	-	(20.6)	-
	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан	(0.2)	(0.7)	0.5	350.0
	Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сан	(40.7)	-	(40.7)	-

ХХААХҮС	Хөдөө аж ахуйг дэмжих сан	(13.6)	(3.6)	(10.0)	26.5
	Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах хоёр үе шаттай зээлийн төсөл	(27.6)	(6.2)	(21.4)	22.5
	Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил нэгж	(17.4)	(17.0)	(0.4)	97.7
НДС	Капитал банкнаас авах авлага	(67.3)	(1.6)	(65.7)	2.4
ЭМДС	Капитал банкнаас авах авлага	(77.6)	(3.4)	(74.2)	4.4
Эргэж төлөгдөх зээлийн дүн		(369.8)	(186.7)	(183.1)	50.5
Гадаад эх үүсвэрийн зээлийн дүн		208.8	205.9	2.9	98.6
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийн дүн		(161.0)	19.2	(180.2)	(111.9)

Эх сурвалж: Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

3.1.37 Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийн зардалд дотоод эх үүсвэрээс 316.3 тэрбум төгрөг, гадаад эх үүсвэрээс 208.8 тэрбум төгрөг олгохоор төлөвлөснөөс, өмнөх онуудад олгосон зээлээс 686.1 тэрбум төгрөгийг буцаан төвлөрүүлэхээр баталжээ.

3.1.38 Эргэж төлөгдөх дотоод цэвэр зээл 158.2 тэрбум төгрөг буюу 50.0 хувийн, гадаад цэвэр зээл 205.9 тэрбум төгрөг буюу 98.6 хувийн гүйцэтгэлтэй, буцааж төлөгдсөн зээл 344.9 тэрбум төгрөг буюу 50.3 хувийн гүйцэтгэлтэй байна.

3.1.39 Гадаад эх үүсвэрээс 11 төслийн нэгжээр дамжуулан 208.8 тэрбум төгрөгийн зээл олгохоор төлөвлөснөөс гүйцэтгэлээр 205.9 тэрбум төгрөгийн зээл олгосон байна.

3.1.40 Иргэн, ААНБ-уудад олгосон зээлээс 686.1 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр баталснаас 344.9 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, зээлийн хугацаа хэтэрсэн, муу зээлийн ангилалд шилжсэн, зээлдэгчдийн төлбөрийн чадвар буурсан зэргээс шалтгаалан 341.2 тэрбум төгрөгийн эргэн төлөлт хийгдээгүй байна.

3.1.41 Орон нутгийн 19 ТЕЗ-аар дамжуулан 110.8 тэрбум төгрөгийн зээл олгохоор төлөвлөснөөс 76.5 тэрбум төгрөг буюу 69.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

3.1.42 Татан буугдсан Капитал банкнаас авах НДС-гийн авлагаас 67.3 тэрбум төгрөг, ЭМДС-гийн авлагаас 77.6 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр НДС 1.6 тэрбум төгрөгийн, ЭМДС 3.4 тэрбум төгрөгийн авлагыг цуглуулж, 139.9 тэрбум төгрөгийг дутуу төвлөрүүлсэн байна.

3.2 Зарим төсвийн ерөнхийлөн захирагчид үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлтийн бодлого баримталсан боловч уламжлалт төсөвлөлттэй байгаа нь хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг бодитой төлөвлөж, хэрэгжилтийг үнэн зөв тайлагнаж, үр дүнг үнэлэхгүй байх нөхцөлийг бүрдүүлж байна.

3.2.1 Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар улсын төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийг 26,485.3 тэрбум төгрөгөөр баталжээ. Тус хуулийг 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулиар хүчингүй болгож, Засгийн газар төсвийн төслийг дахин боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлсэн байна.

3.2.2 УИХ-аас улсын төсвийн урсгал зардлыг 680.5 тэрбум төгрөг, хөрөнгийн зардлыг 1,426.6 тэрбум төгрөг, эргэж төлөгдөх цэвэр зээлийг 168.4 тэрбум төгрөг, нийт 2,275.5 тэрбум төгрөгөөр бууруулж, 24,209.8 тэрбум төгрөгөөр баталсан байна.

3.2.3 Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2²⁰ дахь хэсэгт заасны дагуу төсөвт “Хэмнэлтийн тодотгол” хийж, тэвчиж болох зардлыг хэмнэж, урсгал зардлыг 1,174.6 тэрбум төгрөг, хөрөнгийн зардлыг 412.6 тэрбум төгрөг, эргэж төлөгдөх цэвэр зээлийг 58.3 төгрөг, нийт 1,645.5 тэрбум төгрөгөөр бууруулж, 22,564.3 тэрбум төгрөг баталсан байна.

3.2.4 Тухайн жилийн төсвийн тухай хуулиар ТЕЗ-ийн урсгал болон хөрөнгийн зардлыг хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтээс тусад нь баталдаг боловч төсвийг эдийн засгийн ангиллаар төлөвлөж байна. ТЕЗ-ийн урсгал төсөв хооронд хийсэн төсвийн зохицуулалт нь батлагдсан төсвийг бодит гүйцэтгэлтэй уялдуулан хянах боломжгүй, төсвийн зарцуулалтын хяналтын журам мөрдөгдөхгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

²⁰ Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.2-т “урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, зарлага нэмэгдэж, нэгдсэн төсвийн алдагдал дотоодын нийт бүтээгдэхүүний гурван хувиар нэмэгдэх;”

3.2.5 Улсын төсвийн нийт зарлага ба цэвэр зээл 20,414.3 тэрбум төгрөг буюу 90.5 хувийн гүйцэтгэлтэй гарч, ДНБ-ий 22.7 хувьтай тэнцэж байна.

Хүснэгт 20. Монгол Улсын 2025 оны төсвийн зарлагын эдийн засгийн ангиллаар

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2024 он гүйц	2025 он				Өмнөх оноос зөрүү
		Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь	
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	21,372.4	22,564.3	20,414.3	2,150.0	90.5	(958.1)
А. Урсгал зарлага	15,965.0	17,983.9	16,706.7	1,277.2	92.9	741.7
Бараа, үйлчилгээний зардал	7,781.6	8,920.0	8,194.8	725.2	91.9	413.2
Цалин хөлс	4,739.4	5,662.1	5,482.1	180.0	96.8	742.7
Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	468.6	555.0	535.5	19.5	96.5	66.9
Бараа, үйлчилгээний бусад зардал	2,573.6	2,702.9	2,177.2	525.7	80.6	(396.4)
Хүү	1,165.9	1,293.0	1,208.9	84.1	93.5	43.0
Татаас ба урсгал шилжүүлэг	7,017.5	7,770.9	7,303.0	467.9	94.0	285.5
Татаас	1,776.1	2,027.3	1,826.2	201.1	90.1	50.1
Урсгал шилжүүлэг	5,241.4	5,743.6	5,476.8	266.8	95.4	235.4
Б. Хөрөнгийн зардал	5,082.1	4,707.4	3,759.9	947.5	79.9	(1,322.2)
Барилга байгууламж	4,101.3	3,937.1	3,087.3	849.8	78.4	(1,014.0)
Их засвар	77.6	119.8	110.4	9.4	92.2	32.8
Хөрөнгийн бусад зардал	903.2	650.5	562.2	88.3	86.4	(341.0)
В. Эргэж төлөгдөх цэвэр зээл	325.3	(127.0)	(52.3)	(74.7)	41.2	(377.6)
Эргэж төлөгдөх дотоод цэвэр зээл	(133.5)	(335.8)	(258.2)	(77.6)	76.9	(124.7)
Эргэж төлөгдөх гадаад цэвэр зээл	458.8	208.8	205.9	2.9	98.6	(252.9)

Эх сурвалж: Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

3.2.6 Улсын төсвийн 81.3 хувь буюу 16,706.7 тэрбум төгрөгийг урсгал зарлага, 18.4 хувь буюу 3,759.9 тэрбум төгрөгийг хөрөнгийн зардал, 0.3 хувь буюу 52.3 тэрбум төгрөгийг эргэж төлөгдөх цэвэр зээл эзэлж байна.

3.2.7 Улсын төсвийн нийт зарлага ба цэвэр зээл 90.5 хувийн гүйцэтгэлтэй, 2,150.0 тэрбум төгрөгөөр дутуу биелсэн нь хөрөнгийн зардлыг 947.5 тэрбум төгрөгөөр, бараа, үйлчилгээний зардлыг 725.2 тэрбум тэрбум төгрөгөөр, татаас ба урсгал шилжүүлгийг 467.9 тэрбум төгрөгөөр, хүүгийн зардлыг 84.1 тэрбум төгрөгөөр тус тус дутуу зарцуулж, эргэж төлөгдөх цэвэр зээлийг 74.7 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрүүлснээс шалтгаалжээ.

3.2.8 Нийт зарлага ба цэвэр зээл өмнөх оноос 958.1 тэрбум төгрөгөөр буурсан нь хөрөнгийн зардал 1,322.2 тэрбум төгрөгөөр, бараа, үйлчилгээний бусад зардал 396.4 тэрбум төгрөгөөр, эргэж төлөгдөх цэвэр зээл 377.6 тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлжээ.


3.2.9 Тайлант онд бараа, үйлчилгээний бусад зардал 525.7 тэрбум төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй байгаа нь дараах шалтгаантай байна. Тухайлбал:

- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 0.4 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн зохицуулж, мэргэжлийн үйлчилгээний зардал 200.0 тэрбум төгрөгийг дутуу зарцуулснаас 79.2 хувийн гүйцэтгэлтэй;
- Нормативт зардлыг 53.9 тэрбум төгрөгөөр бууруулан зохицуулж, хоол, хүнс 74.5 тэрбум төгрөг, эм бэлдмэл эмнэлгийн хэрэгслийн зардал 31.9 тэрбум төгрөг, нормын хувцас зөөлөн эдлэлийн зардал 6.4 тэрбум төгрөг, нийт 112.8 тэрбум төгрөгийг дутуу зарцуулснаас 72.8 хувийн гүйцэтгэлтэй;
- Бараа үйлчилгээний бусад зардлын бүлгийг 23.9 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн зохицуулж, бараа, үйлчилгээний бусад зардлын ангиллаас 93.6 тэрбум төгрөгийг дутуу зарцуулснаас 85.2 хувийн гүйцэтгэлтэй гарсан нь голлон нөлөөлсөн байна.

3.2.10 Улсын төсвийн бараа, үйлчилгээний бусад зардал 2,177.2 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй гарч, өмнөх оноос 396.4 тэрбум төгрөгөөр буурсан байна. Сүүлийн 10 жилийн судалгааны дунджаар жилд 90.5 - 161.6 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, тогтмол өссөн, сонгуультай 2016, 2020, 2024 онуудад өмнөх оноос 30.0-60.0 хувиар огцом нэмэгдэж, сонгуулийн дараагийн 3 жил буурах хандлагатай байна.

Дүрслэл 5. Бараа үйлчилгээний бусад зардлын гүйцэтгэл

/тэрбум төгрөг/



Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

Төсвийн ерөнхийлөн захирагчдын урсгал зардлын төлөвлөлт, хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнтэй уялдаагүй, төсвийн төлөвлөлт бодит бус байгаагаас жилийн дундуур урсгал төсөвт олон удаагийн зохицуулалт хийж, төсвийн зарцуулалтын хяналтыг алдагдуулж, хэрэгжилтийг үнэн зөв тайлагнахгүй байх нөхцөлийг үүсгэсэн байна.

3.2.12 Зарим ТЕЗ нар төсвийн төслийг боловсруулахдаа төсвийн зарлагыг эдийн засгийн ангилал, зориулалт, арга хэмжээгээр төлөвлөж, батлуулаагүй нь төсвийг хуваарийн дагуу санхүүжүүлэхгүй байх, хяналт хэрэгжихгүй, үр ашиггүй зардал гарах, буруу тайлагнах нөхцөлийг бүрдүүлж байна. Тухайлбал, байрны түрээсийг бараа, үйлчилгээний бусад зардалд, шуудан, холбоо, интернэтийн төлбөрийг бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжид төлөвлөсөн байна.

3.2.13 Сангийн сайд ТЕЗ нарын батлагдсан төсөвт зохицуулалт хийх саналыг үндэслэн урсгал зардал хооронд 12 удаа зохицуулалт хийсэн²¹ байна. Үүнд: татаасыг 36.5 тэрбум төгрөгөөр бууруулж, бараа, үйлчилгээний зардлыг 12.0 тэрбум төгрөгөөр, урсгал шилжүүлгийг 24.5 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн. Цалин НДШ-ийн зардлаас 43.7 тэрбум төгрөг, татаасаас 36.5 тэрбум төгрөг, нийт 80.2 тэрбум төгрөгөөр бууруулж, бараа, үйлчилгээний бусад зардлыг 55.7 тэрбум төгрөгөөр, урсгал шилжүүлгийг 24.5 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.

3.2.14 ТЕЗ нарын хэрэгжүүлэх 109 хөтөлбөр, арга хэмжээнд 17,983.8 тэрбум төгрөгийн урсгал зардал батлагдсанаас сар бүр хуваарьт өөрчлөлт оруулан 28 хөтөлбөрийн 67.1 тэрбум төгрөгийг бууруулж, 38 хөтөлбөрийн санхүүжилтийг нэмэгдүүлэн, нийт 66 хөтөлбөр хооронд зохицуулалт²² хийснийг холбогдох хууль тогтоомжийн дагуу тайлагнаагүй байна.

3.2.15 Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.7 дахь хэсэгт “Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно.” гэж заасан нь урсгал зардал хооронд зохицуулалт хийх нөхцөлийг үүсгэж, төсвийн зарцуулалтын хяналтын журам мөрдөгдөхгүй байх, жил бүр урсгал зардал тэлж байгаа энэ үед төсвийн зохицуулалтаас үүссэн эдийн засгийн ангилал зөрчигдөх, төсөвт төлөвлөөгүй, үр ашиггүй зардал гаргадаг зөрчил буурахгүй байна.

3.2.16 Урсгал зардалд дараах ТЕЗ нар голлох зохицуулалтуудыг хийсэн байна. Тухайлбал:

- ХХААХҮС: Шинээр гэрээ байгуулсан ажлуудын санхүүжилт төсвийн тодотголоор хасагдаж, татаасыг 20.4 тэрбум төгрөгөөр бууруулж, бараа, ажил үйлчилгээний зардлыг 18.3 тэрбум төгрөг, цалин, НДШ-ийг 1.8 тэрбум төгрөг, урсгал шилжүүлгийг 0.3 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн;

²¹ Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2 дахь хэсэг, Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”

²² Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.4-т “төсвийн захирагч нь төсвийн жилийн дундуур энэ хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд тухайн жилийн төсөвтөө өөрчлөлт оруулж, зохицуулалт хийсэн бол гүйцэтгэлийг нь анхны батлагдсан зорилт, хүрэх үр дүнтэй харьцуулж тайлагнадаг байх;”, 54 дүгээр зүйлийн 54.6-д “Энэ хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу төсөвт зохицуулалт хийсэн тохиолдолд хөтөлбөрийн гүйцэтгэлийг анх төлөвлөсөн хүрэх үр дүнгийн зорилттой нь харьцуулсан байдлаар тайлагнана.”

- ХЗДХС: Орон тоо, цалин хөлсний зардал хэмнэгдсэнээс цалин, НДШ-ийн зардлыг 42.1 тэрбум төгрөгөөр бууруулж, төрөөс үзүүлэх дэмжлэгийн дутагдсан зардлыг санхүүжүүлэхэд урсгал шилжүүлэгт 22.5 тэрбум төгрөг, татаасыг 0.4 тэрбум төгрөг, худалдан авах ажиллагааны гүйцэтгэлээр санхүүжилт олгоход 17.3 тэрбум төгрөг, бусад тогтмол зардлыг санхүүжүүлэхэд 1.9 тэрбум төгрөг, нийт 19.2 тэрбум төгрөгийн бараа үйлчилгээний зардлыг тус тус нэмэгдүүлсэн;
- ССАЖЗС: Урсгал шилжүүлэг буюу соёлын байгууллагын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтээс 2.8 тэрбум төгрөгийг соёл, урлагийн салбарын нийт байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангахад, цалин, НДШ-ийн зардлаас 1.6 тэрбум төгрөгийг бууруулж орон нутгийн театр, чуулга музейн цалин хөлс, НДШ-ийн дутагдалтай эх үүсвэрийг шийдвэрлэсэн;
- Боловсролын сайд: Урсгал шилжүүлгийг 9.5 тэрбум төгрөгөөр бууруулж, бараа, үйлчилгээний бусад зардлыг 8.2 тэрбум төгрөгөөр, цалин, НДШ-ийг 1.3 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн нь үдийн хоол хөтөлбөрөөс хэмнэгдсэн зардлыг салбарын хэвийн үйл ажиллагааг хангахад шаардагдах дутагдаж буй зардлуудад хуваарилснаас шалтгаалсан;
- ЭХС: бараа, үйлчилгээний зардлыг 3.7 тэрбум төгрөг, татаасыг 7.2 тэрбум төгрөг, нийт 10.9 тэрбум төгрөгөөр бууруулж, урсгал шилжүүлгийг 10.9 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

3.2.17 Аудитаар урсгал зардалтай холбоотой 35.6 тэрбум төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:

- Төсвийг үр ашиггүй зарцуулсан нийт 24.4 тэрбум төгрөг /БОУАӨС 13.3 тэрбум төгрөг, СС 5.3 тэрбум төгрөг, Боловсролын сайд 2.0 тэрбум төгрөг, ССАЖЗС 1.0 тэрбум төгрөг, ГБХНХС 0.9 тэрбум төгрөг, ЗГХЭГ 0.5 тэрбум төгрөг, ЭЗХС 0.3 тэрбум төгрөг, ЗТС 0.2 тэрбум төгрөг, ХЗДХС 0.2 тэрбум төгрөг, МУШС 0.1 тэрбум төгрөг, ҮСХ 0.1 тэрбум төгрөг, бусад 0.5 тэрбум төгрөг/;
- Төсөвт тусгаагүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлсэн нийт 8.3 тэрбум төгрөг /БОУАӨС 6.0 тэрбум төгрөг, Сангийн сайд 1.0 тэрбум төгрөг, ССАЖЗС 0.5 тэрбум төгрөг, ГХС 0.2 тэрбум төгрөг, ЗГХЭГ 0.2 тэрбум төгрөг, АҮЭБС 0.1 тэрбум төгрөг, ГБХНХС 0.1 тэрбум төгрөг, бусад 0.2 тэрбум төгрөг/;
- Эдийн засгийн ангилал зөрчиж зарцуулсан нийт 2.6 тэрбум төгрөг /ЭМС 0.8 тэрбум төгрөг, ГБХНХС 0.3 тэрбум төгрөг, Сангийн сайд 0.3 тэрбум төгрөг, ХХААХҮС 0.3 тэрбум төгрөг, ГХС 0.2 тэрбум төгрөг, Боловсролын сайд 0.1 тэрбум төгрөг, МУЕС 0.1 тэрбум төгрөг, ССАЖЗС 0.1 тэрбум төгрөг, бусад ТЕЗ 0.4 тэрбум төгрөг/;
- Урсгал төсвөөс хөрөнгө бэлтгэсэн нийт 0.3 тэрбум төгрөг /Боловсролын сайд 0.1 тэрбум төгрөг, Бусад ТЕЗ 0.2 тэрбум төгрөг/;

3.2.18 Өмнөх оны аудитаар бараа, үйлчилгээний бусад зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлуудыг төсвийн эдийн засгийн ангиллын дагуу төлөвлөж, зарцуулалтын ил тод хариуцлагатай байдлыг сайжруулах зөвлөмж өгсний дагуу Сангийн сайдын 2025 оны “Төсвийн зарим ангилал шинэчлэн батлах тухай” 112 дугаар тушаалаар бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг зардлын дэд ангилал үүсгэн задалж, бараа үйлчилгээний бусад зардлыг эдийн засгийн ангилалд давхардуулан дэд ангилал үүсгэсэн байсныг залруулаагүй байна. Тус журмыг 2026 оны төсвийн жилээс эхлэн мөрдөхөөр баталжээ.

3.2.19 Зарим ТЕЗ-д программ, хангамжийн зардлыг тухайлан зохицуулсан журамгүйгээс урсгал зардлаас 6.7 тэрбум төгрөгийн 33 биет бус хөрөнгө²³ буюу программ, хангамжийг бэлтгэсэн байна.

3.2.20 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж болон бараа, үйлчилгээний бусад зардлын ангиллаас 25 ТЕЗ 22.0 тэрбум төгрөгийн 78 лиценз, 6.7 тэрбум төгрөгийн 33 программ хангамж, нийт 28.7 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Үүнд:

²³ Зарим биет бус хөрөнгө нь компакт диск (CD) (компьютерийн программ хангамжийн хувьд), эрх зүйн баримт бичиг (лиценз эсвэл патентын хувьд), дэлгэцэнд гаргах хальс гэх мэт биет шинж чанартайгаар хадгалагдаж байх болно. Биет бус ба биет элементүүдийн аль алиныг агуулсан хөрөнгийг ҮСНББУС 17, Үндсэн Хөрөнгө-ийн дагуу биет хөрөнгө эсвэл энэ Стандартын дагуу биет бус хөрөнгө гэж үзэх эсэхийг тодорхойлоход, байгууллага нь аль элемент илүү чухал ач холбогдолтой байгааг үнэлэх үндэслэл шүүн тунгалт хийдэг. Жишээлбэл, байгууллагын усан онгоцны жолоодлогын программ хангамж нь уг усан онгоцны салшгүй нэг хэсэг бөгөөд түүнийг үндсэн хөрөнгө гэж үзнэ. Энэ зарчмыг компьютерийн үйлдлийн системийн хувьд мөрдөнө. Программ хангамж нь холбогдох техникийн хэрэгслийн салшгүй нэг бүрэлдэхүүн хэсэг биш байх тохиолдолд компьютерийн программ хангамжийг биет бус хөрөнгө гэж үзнэ.

- ЦХИХХС: лиценз 5.9 тэрбум төгрөг, программ 1.9 тэрбум төгрөг, нийт 7.8 тэрбум төгрөг;
- Сангийн сайд: лиценз 7.5 тэрбум төгрөг, программ 0.1 тэрбум төгрөг, нийт 7.6 тэрбум төгрөг;
- ГБХНХС: лиценз, программ 3.5 тэрбум төгрөг;
- ТАЭ: лиценз 2.6 тэрбум төгрөг, программ 0.9 тэрбум төгрөг, нийт 3.5 тэрбум төгрөг;
- Бусад ТЕЭ: лиценз 2.5 тэрбум төгрөг, программ 3.8 тэрбум төгрөг, нийт 6.3 тэрбум төгрөг.

3.2.21 ТЕЭ нар төсвийн төслийг боловсруулахдаа бодит тооцоо судалгаанд үндэслээгүй, нийгэм эдийн засгийн ач холбогдолгүй болсон хөтөлбөр, төсөл, арга хэмжээг зогсоох, эсвэл бууруулах саналын тооцооллоо ирүүлээгүй, хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, арга хэмжээтэй уялдуулаагүй байгаа нь төсвийн хуваарьт тогтмол өөрчлөлт оруулах, хэрэгжилтийг үнэн зөв тайлагнахгүй, төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл, бодит хэмнэлтийг салгаж үнэлэх боломжгүй байна.

3.2.22 Олон улсын байгууллагуудаас өгсөн²⁴ төсвийн сахилга бат, өрийн удирдлага, урсгал зардлын үр ашиг, дунд хугацааны тогтвортой байдлыг хангах зөвлөмжийн чиглэлтэй нийцсэн тодорхой ахиц гарсан байна. Гэвч төсвийн орлогын өсөлт нь уул уурхайн салбар, гадаад зах зээлийн нөхцөлөөс өндөр хамааралтай хэвээр байгаа тул орлогын өсөлтөд тулгуурлан байнгын шинжтэй урсгал зардлыг нэмэгдүүлэхгүй байх, төсвийн сахилга батыг хадгалах, халамжийн зардлыг илүү зорилтот бүлэгт чиглүүлж, үр ашгийг сайжруулах шаардлагатай байна.

3.2.23 АХБ болон Дэлхийн банкнаас өгсөн зөвлөмжүүд нь Монгол Улсын төсвийн бодлогыг илүү тогтвортой, үр ашигтай, мөчлөг сөрсөн шинжтэй болгоход чиглэж байна. Тухайлбал, АХБ-ны 2025–2028 оны түншлэлийн стратеги нь эдийн засгийн төрөлжилт, санхүүгийн салбарын тогтвортой байдал, тогтвортой санхүүжилтийн орчныг дэмжихэд чиглэж байгаа бол Дэлхийн банкны зөвлөмжүүд нь урсгал зардлын үр ашиг, халамжийн зорилтот байдал, өрийн удирдлага, төсвийн нөөц бүрдүүлэлтийг сайжруулах шаардлагатайг онцолжээ.

3.2.24 Харьцуулсан улс орнуудын туршлагаас харахад төсвийн дүрэм, хуримтлалын сан, өрийн хязгаар, татаасын шинэчлэл, халамжийн зорилтот тогтолцоо, төрийн өмчит байгууллагын засаглал зэрэг арга хэмжээ нь төсвийн тогтвортой байдал болон зээлжих зэрэглэлд эерэг нөлөө үзүүлдэг байна. Тухайлбал, Узбекистан улсын бүтцийн шинэчлэл, төсвийн сахилга бат, татаасын дарамтыг бууруулах бодлого нь зээлжих зэрэглэл ахихад нөлөөлж болохыг харуулж байна.

Цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 6,017.6 тэрбум төгрөг буюу нийт зарлагын 29.5 хувьтай тэнцэж, өмнөх оноос 809.6 тэрбум төгрөгөөр өссөн байна.

3.2.25 Цалин, НДШ-ийн зардлыг нийт 6,217.1 тэрбум төгрөгөөр баталснаас 96.8 хувь буюу 6,017.6 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Үүнд: цалин хөлс, нэмэгдэл, урамшууллын зардал 5,482.1 тэрбум төгрөг, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал 535.5 тэрбум төгрөг байна.

3.2.26 Улсын төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн 26.9 хувийг, урсгал зардлын 32.8 хувийг цалин, хөлсний зардал эзэлж байна.

3.2.27 Цалин, хөлс НДШ-ийн зардал өмнөх оноос 809.6 тэрбум төгрөгөөр өссөн нь Засгийн газрын 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 238 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалинг 6.0 хувиар нэмэгдүүлсэнтэй холбоотой байна. Үүнд: Боловсролын сайд 209.0 тэрбум төгрөгөөр, ХЗДХС 185.2 тэрбум төгрөгөөр, БХС 87.0 тэрбум төгрөгөөр, бусад ТЕЭ-д 0.1 - 50.5 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

3.2.28 Цалингийн зардлын 76.4 хувь нь гүйцэтгэх албан тушаалтан, 15.7 хувь нь туслах, 7.9 хувь нь удирдах албан тушаалтны цалин байна.

²⁴ Дэлхийн банк “Mongolia Public Finance Review: Making this Time Different – Fiscal Reforms for Stable, Sustainable, and Inclusive Development” буюу “Монгол Улсын төсвийн судалгаа: Тогтвортой, хүртээмжтэй хөгжлийн төлөөх төсвийн шинэчлэл” тайлан 2025 он, Азийн хөгжлийн банк, “Mongolia: Country Partnership Strategy 2025–2028” буюу “Монгол Улстай хамтран хэрэгжүүлэх түншлэлийн стратеги 2025–2028” баримт бичиг, 2025 он

3.2.29 Нийт төрийн албан хаагчдын тоо 2016-2025 оны хугацаанд 188.9 мянгаас 213.6 мянга болж, жилд 0.4 – 16.3 мянган хүнээр буюу 13.1 хувиар өссөн байна. Төрийн албан хаагчийн хүн амд эзлэх хувь 2016-2024 онд 6.0-6.5 хувийн хооронд тогтвортой байсан бол 2025 онд 5.9 хувь болж буурсан байна.

3.2.30 Нийт албан хаагчдын 139.6 мянга буюу 65.3 хувь нь төрийн үйлчилгээний албан хаагч, 49.9 мянга буюу 23.4 хувь нь төрийн тусгай албан хаагч, 20.5 мянга буюу 9.6 хувь нь төрийн захиргааны албан хаагч, 3.6 мянга буюу 1.7 хувь нь төрийн улс төрийн албан хаагч байна. Төрийн улс төрийн албан хаагч өмнөх оноос 179 буюу 4.7 хувиар, төрийн захиргааны албан хаагч 823 буюу 3.9 хувиар, төрийн үйлчилгээний албан хаагч 13.1 мянга буюу 8.6 хувиар тус тус буурсан бол төрийн тусгай албан хаагч 790 буюу 1.6 хувиар нэмэгдсэн байна.

Хүний нөөцийн удирдлага, дотоод хяналтын тогтолцоо, төсвийн сахилга бат сул байгаагаас цалин хөлс, урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэлтэй холбоотой 22.1 тэрбум төгрөгийн зөрчил илэрсэн байна.

3.2.31 ТЕЗ нарын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалтай холбоотой нийт 22.1 тэрбум төгрөгийн зөрчил илэрсэн байна. Үүнд:

- **Цалин, урамшуулалтай холбоотой:** Төрийн байгууллагууд урамшуулал, нэмээдлийг гүйцэтгэл, үр дүнтэй уялдуулах зарчмыг хангалттай хэрэгжүүлээгүй, давхардуулан болон үндэслэлгүйгээр олгосон 4.2 тэрбум төгрөгийн 374 зөрчил;
- **Цалингийн тооцоотой холбоотой:** Цалин хөлс, нэмээдэл, олгохдоо холбогдох хууль, тогтоомж, дотоод журмыг баримтлаагүй, илүү олгосон, буруу тооцоолсон, зориулалтын бус зарцуулсан нийт 8.8 тэрбум төгрөгийн 1,030 зөрчил;
- **Орон тоо, бүтэц зохион байгуулалттай холбоотой:** Бүтэц, орон тооны төлөвлөлт бодит хэрэгцээ, чиг үүрэгтэй нийцээгүй, батлагдсан орон тооны хязгаар, бүтэц зохион байгуулалтыг мөрдөөгүй 2.0 тэрбум төгрөгийн 117 зөрчил;
- **Томилгоо, сонгон шалгаруулалттай холбоотой:** Төрийн албаны томилгоо, албан хаагчийг сонгон шалгаруулахдаа холбогдох хууль, журмыг бүрэн хэрэгжүүлээгүй 0.6 тэрбум төгрөгийн 118 зөрчил;
- **Бодлого, зохицуулалтын давхардалтай холбоотой:** Цалин хөлс, урамшуулал, бүтэц, орон тооны зохицуулалттай холбоотой эрх зүйн баримт бичиг, журам, шийдвэрүүдийн уялдаа хангалтгүй, давхардалтай хэрэгжсэн 8 зөрчил;
- **НДШ-тэй холбоотой:** НДШ-ийг тооцох, суутгах, тайлагнах, төлбөр тооцоог холбогдох хууль, тогтоомжийг мөрдөөгүйгээс НДШ-ийг буруу тооцох, дутуу болон илүү төлөх, өглөг, авлага үүсгэх, хугацаанд нь шилжүүлээгүй нийт 6.5 тэрбум төгрөгийн 375 зөрчил тус тус илэрсэн.

3.2.32 Төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд 71 иргэн, албан тушаалтнаас нийт 0.5 тэрбум төгрөгийг төрийн сангийн дансанд төвлөрүүлж, улсын орлого болгосон байна. Аудитаар улсын төсвөөс эрх бүхий албан тушаалтны буруутай шийдвэрийн улмаас ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчийн нөхөн олговрыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлээгүй нийт 1.2 тэрбум төгрөгийн зөрчил илэрсэн байна.

Татаас ба урсгал шилжүүлэг 7,303.0 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

3.2.33 Улсын төсвийн татаас ба урсгал шилжүүлгийн зардал нийт 7,770.9 тэрбум төгрөгөөр батлагдсанаас 7,303.0 тэрбум төгрөг буюу 94.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 21. Улсын төсвийн татаас, урсгал шилжүүлэг

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2024 оны гүйцэтгэл	Улсын төсвийн 2025 оны төсвийн зарлага				Өмнөх оноос /+,-/
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	
А	1	2	3	4=2-3	5=3/2	6=3-1
ТАТААС БА САНХҮҮЖИЛТ	7,017.5	7,770.9	7,303.0	467.9	94.0	285.5
Татаас	1,776.1	2,027.3	1,826.2	201.1	90.1	50.1
Урсгал шилжүүлэг	5,241.4	5,743.6	5,476.8	266.8	95.4	235.4

Эх сурвалж: Монгол улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

3.2.34 Тайлант онд 12 ТЕЗ-д 1.0 – 1,453.4 тэрбум төгрөгийн 1,826.2 тэрбум төгрөгийн татаасыг олгосон нь өмнөх оноос 50.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.

3.2.35 Татаасын 1,453.4 тэрбум төгрөг буюу 71.7 хувийг ГБХНХС, 244.4 тэрбум төгрөг буюу 20.8 хувийг ХХААХҮС, 128.4 тэрбум төгрөг буюу 7.5 хувийг бусад 10 ТЕЗ эзэлж байна.

3.2.36 ГБХНХС-ын татаас өмнөх оноос 277.7 тэрбум төгрөгөөр өссөн нь НДС-гийн алдагдлыг нөхөхөд зориулж 355.7 тэрбум төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлсэн нь голлон нөлөөлсөн байна.

3.2.37 ХХААХҮС-ын арьс шир, ноосны урамшуулалд зориулан батлагдсан нийт 21.6 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээ нь санхүүжилт хийгдээгүйгээс хэрэгжээгүй бөгөөд салбарыг дэмжихэд чиглэсэн бодлогын арга хэмжээ бодит үр дүнд хүрээгүй байна.

3.2.38 Урсгал шилжүүлгийн зардлын 44.1 хувийг нийгмийн халамжийн зардал, 40.4 хувийг засгийн газрын дотоод шилжүүлэг, 15.5 хувийг бусад урсгал шилжүүлэг эзэлж байна. Бусад урсгал шилжүүлэг нь нийгмийн хамгааллын арга хэмжээ, санхүүгийн дэмжлэгт зарцуулагдаж байна.

3.2.39 Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026–2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулиар Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс хуваарилах зардлын дээд хэмжээг 2,572.3 тэрбум төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 2,419.9 тэрбум төгрөг гарч, батлагдсан зардлын дээд хэмжээнээс хэтрээгүй байна.

3.2.40 Ижил төрлийн халамжийн үйлчилгээ хуулийн хэд хэдэн заалтаар давхар зохицуулагдаж, нэг төрлийн зардлыг өөр өөр эх үүсвэрээр санхүүжүүлж байна. Тухайлбал, ахмад настанд чиглэсэн амралт, сувилал, замын зардлын хөнгөлөлтийг Ахмад настны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2²⁵, 10 дугаар зүйлийн 10.1.2²⁶, 10.1.3²⁷ дахь хэсэгт заасан 5 төрлийн үйлчилгээнд нийт 26.9 тэрбум төгрөгийг олгосон байна. Мөн төрөлжсөн асрамжийн үйлчилгээ, онцгой тохиолдлын тэтгэмж, холбогдох үйлчилгээний зардлыг орон нутгийн төсвөөс 1.0 тэрбум төгрөг, улсын төсвөөс 3.1 тэрбум төгрөгөөр санхүүжүүлсэн байна.

3.2.41 Халамжийн тогтолцоо нь иргэн төвтэй бус, харин хуулийн заалтад суурилсан салангид үйлчилгээний хэлбэрээр зохион байгуулагдаж байгаа нь нэг иргэн ижил зорилготой хэд хэдэн төрлийн халамжийг зэрэг хүртэх нөхцөлийг бүрдүүлснээс халамжийг нийт 302.2 мянган иргэн давхардуулан авсан байна.

Улсын төсвийн нийт зарлага ба цэвэр зээлд эзлэх хөрөнгийн зардал сүүлийн 2 жилийн хугацаанд буурч байгаа нь хөрөнгө оруулалтын үр өгөөж буурах, төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хугацаандаа хэрэгжихгүй байх эрсдэлтэй байна.

3.2.42 Хөрөнгийн зардлыг 4,707.4 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс 3,759.9 тэрбум төгрөг буюу 79.9 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 22. Улсын төсвийн 2025 төсвийн хөрөнгө оруулалтын зардал /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2024 оны гүйц	2025 он				Өмнөх оноос зөрүү	
		Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь		
Хөрөнгийн зардал	5,082.1	4,707.4	3,759.9	947.5	79.9	1,322.2	
Барилга байгууламж	4,101.3	3,937.1	3,087.3	849.8	78.4	1,014.0	
Их засвар	77.6	119.8	110.4	9.4	92.2	(32.8)	
Хөрөнгийн бусад зардал	903.2	650.5	562.2	88.3	86.4	341.0	
Үүнээс	Гадаад зээл, тусламж	1,807.4	1,531.8	1,487.5	44.3	97.1	319.9
	Концесс	-	107.1	11.0	96.1	10.3	(11.0)
	УТХО	3,093.5	2,914.9	2,124.5	790.4	72.9	969.0
	Бусад хөрөнгө	181.2	153.6	136.9	16.7	89.1	44.3

Эх сурвалж: Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

3.2.43 Хөрөнгийн зардал өмнөх оноос 26.0 хувиар буурсан нь улсын төсвийн хөрөнгийн зардал 969.0 тэрбум төгрөг, гадаад зээл, тусламжийн хөрөнгийн зардал 319.9 тэрбум төгрөг, бусад хөрөнгийн зардал 44.3 тэрбум төгрөгөөр тус тус буурч, концесс 11.0 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан нь нөлөөлсөн байна.

²⁵ Ахмад настны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2-т "ахмад настанд амралт, сувиллын газарт амрах эрхийн бичгийг жилд нэг удаа хөнгөлөлттэй үнээр олгох"

²⁶ Ахмад настны тухай хуулийн 10.1.2-т "эмчилгээ, сувилгаа зайлшгүй шаардлагатай ахмад настанд ... тээврийн хэрэгслийн нэг талын зардал, эрхийн бичгийн жишиг үнийн 50 хувийг, хүндэт донор ахмад настанд 100 хувийг жилд нэг удаа нөхөн олгох;"

²⁷ Ахмад настны тухай хуулийн 10.1.3-т "нийслэлээс 1000 километр ба түүнээс хол алслагдсан газарт байнга оршин суудаг ахмад настан ... , унааны нэг талын зардлыг жилд нэг удаа нөхөн олгох;"


3.2.44 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын зардал 72.9 хувь буюу 2,124.5 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй гарч, тендерээс 49.7 тэрбум төгрөг, гүйцэтгэлээс 13.7 тэрбум төгрөгийн хэмнэлт гарч, төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйгээс 727.0 тэрбум төгрөгийн санхүүжилт олгоогүй байна.

3.2.45 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар тайлант онд хэрэгжиж дуусах 287.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 33 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйгээс 74.8 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гараагүй байна. Үүнд 23.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 2013-2014 онд эхлүүлсэн дуусаагүй 2 төсөл, арга хэмжээний 2.2 тэрбум төгрөг байна.

3.2.46 Улсын төсвийн нийт зарлага ба цэвэр зээлд хөрөнгийн зардлын эзлэх хувь сүүлийн 3 жилд 24.6 – 18.4 хувь хүртэл буурсан байна.

Дүрслэл 6. Улсын төсвийн нийт зарлага цэвэр зээлийн дүн ба хөрөнгийн зардал

/тэрбум төгрөг/



Эх сурвалж: Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Гадаад зээлийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлээгүйгээс зээлийн үр өгөөж буурах, өрийн дарамт үүсэх эрсдэлийг бий болгож байна.

3.2.47 Гадаадын зээл, тусламжийн эх үүсвэрээр 1,959.4 тэрбум төгрөгийн 102 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 91 төсөл, арга хэмжээ 1,874.8 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 23. Гадаад зээл, тусламжийн эх үүсвэрээр санхүүжүүлэх төсөл

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Баталсан		Гүйцэтгэл		Зөрүү	
	Тоо	Төсөв	тоо	Олгосон	тоо	Олгоогүй
Гадаад зээл	75	1,542.4	70	1,530.6	5	11.8
Тусламж	27	417.0	21	344.2	6	72.8
Нийт дүн	102	1,959.4	91	1,874.8	11	84.6

Эх сурвалж: Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

3.2.48 Гадаад зээлийн 0.02 тэрбум төгрөгийн 5 төсөл, тусламжийн 12.1 тэрбум төгрөгийн 6 төсөл хэрэгжээгүй байна. Гадаад зээлийн эх үүсвэрээр хэрэгжих 5 төслийн үндсэн зээлийн төлбөрт 1.0 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 3.9 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

3.2.49 Гадаад зээл, тусламжийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 17 төсөлд Монголын талын хөрөнгөөр нийт 11.9 тэрбум төгрөгийн урсгал зардлыг санхүүжүүлсэн байна. Гадаад зээлийн эх үүсвэрээр хэрэгжүүлж буй төслийн хүрээнд Төрийн байгууллагуудад чиглэсэн хурал цуглаан, сургалт зохион байгуулж 0.5 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

Гадаад зээлээр хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн санхүүжилтийн 15.0 хувийг эдийн засгийн үр ашиггүй, эргэн төлөлт хийх чадамжгүй, бодит эдийн засгийн өсөлтийг дэмжихгүй зэрэг нийгмийн шинж чанартай төсөл, арга хэмжээнд олгосон байна.

3.2.50 Хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд бүрэн тусгаагүй 75 төслийг гадаадын зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна. Гадаад зээлийн эх үүсвэрээр үр дүнг үнэлэх боломжгүй 7.0 тэрбум төгрөгийн 2 төсөл, бодит эдийн засгийн өсөлтийг дэмжихгүй 12.7 тэрбум төгрөгийн 6 төсөл, эргэн төлөлт хийх чадамжгүй, улсын төсвийн хөрөнгө оруулалт болон бусад эх үүсвэрээр хэрэгжүүлэх боломжтой 209.2 тэрбум төгрөгийн 21 төслийг санхүүжүүлж тус тус гадаад зээлийг нэмэгдүүлсэн байна.

3.2.51 Гадаад зээл, тусламжаар санхүүжих нийт төслийн 62.7 хувь буюу 1,090.6 тэрбум төгрөгийн 64 төслийн гэрээг сунгасан, үүнээс 24.7 тэрбум төгрөгийн 5 төсөл 2012-2014 оноос эхлэн хэрэгжүүлж байгаа олон жил үргэлжилсэн төслүүд байна.

Гадаад зээл, тусламжаар хэрэгжүүлсэн төслийн үр дүнд бий болсон 61.4 тэрбум төгрөгийн хөрөнгийг ашиглагч байгууллагад шилжүүлээгүй, захиалагч байгууллагын хяналт хангалтгүйгээс төсөл хугацаандаа хэрэгжихгүй, төсөвт өртөг нэмэгдэх эрсдэлтэй байна.

3.2.52 Гадаадын зээл, тусламжийн төслүүдийн 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар хөрөнгийн бүртгэл, ашиглалттай холбоотой дараах зөрчлүүд илэрсэн нь төслийн хүрээнд бий болсон хөрөнгөд тавих хяналт хангалтгүй, ТӨБЗГ, захиалагч талууд үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна. Үүнд:

Төслийн хүрээнд бий болсон хөрөнгийг ашиглагч байгууллагад шилжүүлээгүй зөрчлүүд:

- Гачууртын үүлзвараас Налайх-Чойрын уулзвар хүртэлх 20.9 км авто замын өргөтгөл, шинэчлэлтийн төсөл: Төслийн хүрээнд бий болсон, бусад эргэлтийн хөрөнгөд бүртгэлтэй 9.3 тэрбум төгрөгийн хөрөнгийг эрх бүхий байгууллагад хандан ашиглагч байгууллагад шилжүүлээгүй;
- Замын цагдаагийн газрын ойролцоох гүүрэн гарцын төсөл: Төслийн хүрээнд бий болсон 26.2 тэрбум төгрөгийн хөрөнгийг Нийслэлийн Замын хөгжлийн газрын даргын 2023 оны 02/947 дугаар тушаалаар ашиглагч байгууллагад шилжүүлэх шийдвэр гарсан боловч хөрөнгийг шилжүүлээгүй;
- Мазаалай баавгайн амьдрах орчны нөхцөлийг сайжруулах төсөл: Төслийн хүрээнд бэлэглэсэн Их говийн Дархан цаазат газрын "А" бүсийн захиргаан дахь 2 давхар 2 ширхэг контейнер сууц, мазаалай нутагладаг 3 Баянбүрд дэх 3 ширхэг 1 давхар сууц зэрэг нийт 0.2 тэрбум төгрөгийн өртөгтэй хөрөнгийг ашиглагч байгууллагад шилжүүлэхээр холбогдох эрх бүхий байгууллагад саналаа хүргүүлсэн боловч шийдвэрлэгдээгүй;
- Түүл гол дээгүүрх Баянзүрхийн 321 у/м болон Сонсголонгийн 289.4 у/м төмөр бетон гүүрийг шинээр барих төсөл: Төсөл 2021 онд хэрэгжиж дууссан бөгөөд санхүүгийн тайлангийн бусад эргэлтийн хөрөнгө дансанд 4.2 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй, зохих хасалтыг хийгээгүй, ашиглагч байгууллагад шилжүүлэх асуудлыг шийдвэрлээгүй;
- Гэр хорооллын нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулах төсөл: Төслийн хүрээнд бий болсон 2.4 тэрбум төгрөгийн хөрөнгийг Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2025 оны А/30 дугаар тушаалаар ашиглагч байгууллагад шилжүүлэх шийдвэр гарсан боловч хөрөнгийг шилжүүлээгүй;
- Замын засвар, арчлалтын 42 ширхэг машин нийлүүлэх төсөл: Төслийн хүрээнд МА3-5905А2-390 болон МА3-5337А2-348-600 маркийн нийт 42 ширхэг авто машиныг авто замын засвар, арчлалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн өмчит 20 компанид хүлээлгэн өгсөн ч бүртгэлд тусгаагүй;
- АХБ-ны Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замын хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл-2: Төслийн санхүүжилтээр худалдан авсан техник хэрэгсэл, хүнд механизм, замын үзлэгийн тоног төхөөрөмж зэрэг 8.0 тэрбум төгрөгийн хөрөнгийг ашиглагч байгууллагуудад хүлээлгэн өгсөн ч эрх бүхий байгууллагад хандан ашиглагч байгууллагад шилжүүлээгүй байна.

Төслийн хөрөнгийг эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр хассан, ашиглагч байгууллагад хүлээлгэн өгсөн зөрчлүүд:

- Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл: Эрх бүхий байгууллагын тогтоол шийдвэргүйгээр 0.1 тэрбум төгрөгийн тээврийн хэрэгслийг үнэ төлбөргүй шилжүүлсэн;
- Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төсөл: Бусад эргэлтийн хөрөнгө данснаас 0.6 тэрбум төгрөгийн хөрөнгийг холбогдох дээд шатны байгууллагын тушаал шийдвэргүйгээр бүртгэлээс хасаж тайлагнасан;
- Эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн төслийг хөгжүүлэх төсөл: Гүйцэтгэгч компаниудад олгосон систем боловсруулах ажлын төлбөрийг Санхүүгийн тайланд хөрөнгөөр хуримтлуулан бүртгэлгүй, зардлаар тайлагнаж бүртгэсэн тул тухайн системүүдийг ТӨБЗГ-ын тогтоол шийдвэргүйгээр ашиглагч байгууллагуудад хүлээлгэн өгсөн байна.

3.2.53 Төсвийн тухай хуулиар 2019 оноос гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжих төслүүдийг Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд шилжүүлснээр санхүүжилт сайжирсан боловч захиалагч байгууллагууд чиг үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй, төслийн хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүйгээс төсөл хугацаандаа хэрэгжихгүй, олон жил үргэлжилж байна. Тухайлбал:

- Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төсөл: Сонгинохайрхан дүүргийн 40 дүгээр хороон дахь Гал түймэр унтраах, аврах 29 дүгээр ангийн барилга угсралтын 7.9 тэрбум төгрөгийн ажлын гэрээний хугацааг 2 удаа сунгаж, 2025 онд гэрээний хугацаа дууссан. Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 60.2 хувьтай, удаашралтай;
- Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төсөл: Сонгинохайрхан дүүргийн 1, 2, 20 дугаар хороо, Цэргийн хотхон орон сууцны хороолол орчмын Б хэсэгчилсэн талбай дахь гадна дулаан хангамжийн инженерийн шугам сүлжээний барилга угсралтын 4.7 тэрбум төгрөгийн ажлыг

гүйцэтгүүлэх гэрээний хугацааг 1 удаа сунгаж 2025 онд гэрээний хугацаа дууссан. Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 68.1 хувьтай, удаашралтай”;

- Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх төсөл: Сангийн сайдын 2024 оны 01/10803 дугаар албан бичгээр хүргүүлсэн “2025 онд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр болон хойшлуулах ажлын жагсаалт”-д санхүүжүүлэхээр тусгаагүй 2 ажилд 12.3 тэрбум төгрөгийн санхүүжилт олгож, ашиглалтад ороогүй, хэрэглэгчид холбогдоогүй;
- Улаанбаатар хотын ногоон орон сууц төсөл: Төслийг хэлэлцээрт 2026 онд дуусгахаар төлөвлөсөн ч барилга угсралтын ажил хийгдээгүй төслийн хэрэгжилт удаашралтай, гэрээний хугацаанд хэрэгжихгүй байх эрсдэлтэй;
- Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төсөл: Төслийн хүрээнд Дорноговь, Сэлэнгэ, Дархан аймгуудад лабораторийн барилга байгууламж, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил нийлүүлэх ажил 2020 оноос эхлэн хийгдсэн ба барилга байгууламжийг хүлээлгэн өгөхөөс өмнө тоног төхөөрөмжийн нийлүүлэлт хийгдсэн нь тухайн хөрөнгө шаардлага хангахгүй газар удаан хадгалагдах, зарим шинжилгээний урвалж бодисуудын хугацаа дуусах зэрэг эрсдэлтэй;
- Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай газар тариаланг дэмжих төсөл: Ковид-19 цар тахал дэгдэж, үүний улмаас бараа материалын худалдан авалт саатах, нийлүүлэлтийн сүлжээ доголдох, барилга угсралтын ажлууд хойшлох зэрэг нөхцөл байдал үүссэн нь төслийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлсөн байна. Мөн 2 услалтын систем гүйцэтгэх ажлын тоног төхөөрөмжийн нийлүүлэлт удааширснаас гэрээний хугацааг сунгаж ажлын гүйцэтгэл бүрэн дуусаагүй;
- Чойр Сайншандын 220 кВ-ын 2 хэлхээт 220.4 км урт цахилгаан дамжуулах агаарын шугам, 220/110/35кВ-н дэд станц барих төсөл: Төслийн зээлийн хэлэлцээрт 2026 онд дуусгахаар төлөвлөсөн ч тайлант онд зөвлөх үйлчилгээний гэрээний урьдчилгаа төлбөрт 0.8 тэрбум төгрөгийг төлж, барилга угсралтын ажил хийгдэж эхлээгүй;
- Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төслийн нэмэлт санхүүжилтийн төсөл: Төсөл хэрэгжүүлэгч нэгжээс төсөл арга хэмжээний гэрээний хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүйгээс гэрээ цуцлах, төсөл, арга хэмжээний хугацаа сунгах, зураг төсөвт өөрчлөлт орох зэргээр төсөл, арга хэмжээний төсөвт өртөг нэмэгдсэн;
- Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төсөл: Завхан, Баянхонгор, Говь-Алтай, Увс аймгуудын сумдын дөрвөн байришилд хөрсний гүнийн дулааны насос суурилуулах ажлуудын гэрээний хугацаа дууссан, төслийн тоног төхөөрөмжийн худалдан авалт 24.5 хувьтай, барилга угсралтын ажлын гүйцэтгэл дунджаар 56.6 хувьтай;
- Дархан хотын цэвэр усны шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх, ухаалаг тоолуур нэвтрүүлэх төсөл: Төслийн зээлийн гэрээг нийт 3 удаа сунгасан, гэрээнд заасан дуусгавар болох 2026 оны 3 сарын 31-ний хугацаанд бүрэн хэрэгжихгүй байх эрсдэлтэй;
- Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл: “Хатгалын төв замыг орон нутгийн аялал, жуулчлалын замтай холбох Хатгал-Жанхай-Тойлогт чиглэлийн авто зам, Хатгал-Хүзүүвчийн шил чиглэлийн авто зам, Хатгалын авто замын зогсоолын барилга”-ын ажлыг гэрээний хугацаа дууссан, гэрээт ажлын гүйцэтгэл 50.0 орчим хувьтай байна.

3.2.54 Гадаадын зээл, тусламжийн төслүүдийн 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар төслийн хэрэгжилт хангалтгүйгээс зээлийн хураамж төлж, төсвийг үр ашиггүй зарцуулсан дараах зөрчлүүд илэрсэн нь зээлийн ашиглалтыг сайжруулах, төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлэх шаардлагатай байна. Тухайлбал:

- Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээвэр төсөл: Төслийн хэрэгжилт төлөвлөсөн хугацаанаас хоцорч, удаашралтай хэрэгжиж байгаагаас Зээлийн гэрээний 2.04-т “Зээлдэгч нь Зээлийн хөрөнгийн ашиглагдаагүй үлдэгдэлд Хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамжийг жилд нэг хувийн дөрөвний нэг /0.25 хувь/-тэй тэнцэх хэмжээгээр төлнө” гэж заасны дагуу 4.5 тэрбум төгрөгийн хураамж төлсөн;
- Улаанбаатар хотын ногоон орон сууц төсөл: Зээллэгийн хөрөнгийг бүрэн ашиглаагүйгээс дамжуулан зээлдүүлэх гэрээний нөхцөлийн дагуу эх үүсвэрийн ашиглаагүй үлдэгдлийн 0.5 хувь буюу 0.4 тэрбум төгрөгийн хураамж төлөх эрсдэлтэй байна;
- Чойр Сайншандын 220 кВ-ын 2 хэлхээт 220.4 км урт цахилгаан дамжуулах агаарын шугам, 220/110/35кВ-н дэд станц барих төсөл: Зээлийн хөрөнгийг бүрэн ашиглаагүйгээс дамжуулан зээлдүүлэх гэрээний нөхцөлийн дагуу 2 дугаар эх үүсвэрээс 0.1 тэрбум төгрөгийн хураамж төлөх эрсдэлтэй;
- Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээвэр нэвтрүүлэх төсөл: Зээлийн хэлэлцээрт заасан чиглэлийг Засгийн газрын 2025 оны 272 дугаар тогтоолоор өөрчлөн баталснаас төслийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж, ажлын төсөвт өртөг нэмэгдэх эрсдэлийг бий болгосон байна.

3.2.55 “Барих-шилжүүлэх” концессын төслөөр хэрэгжүүлсэн “Дархан – Сэлэнгэ чиглэлийн авто замаас Шаамар-Зүүнбүрэн-Цагааннуур-Түшиг-Зэлтэрийн боомт чиглэлийн хатуу хучилттай 120.85 км авто зам”-ын ажлыг улсын комисс хүлээн авсан боловч ажлын гүйцэтгэлийг хугацаандаа эцэслэн баталгаажуулж, Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүйгээс дүгнэлт гаргах боломжгүй нөхцөл үүсэж, санхүүжилт олгоогүй байна.

3.2.56 Улсын төсвийн эргэж төлөгдөх цэвэр зээл 52.3 тэрбум төгрөг буюу 41.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

3.2.57 Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийн зардалд дотоод эх үүсвэрээс 205.6 тэрбум төгрөг, гадаад эх үүсвэрээс 208.7 тэрбум төгрөг олгохоор төлөвлөснөөс, өмнөх онуудад олгосон зээлээс 541.2 тэрбум төгрөгийг буцаан төвлөрүүлэхээр баталжээ.

3.2.58 Эргэж төлөгдөх дотоод цэвэр зээл 81.7 тэрбум төгрөг буюу 39.7 хувийн, гадаад цэвэр зээл 205.9 тэрбум төгрөг буюу 98.7 хувийн гүйцэтгэлтэй, буцааж төлөгдсөн зээл 339.9 тэрбум төгрөг буюу 62.8 хувийн гүйцэтгэлтэй байна.

3.2.59 Дотоод эх үүсвэрээс зарим хөтөлбөрийн санхүүжилт бүрэн олгогдоогүй, хэрэгжилт хойшилсон зэргээс шалтгаалан 123.9 тэрбум төгрөгийн дутуу гүйцэтгэлтэй байна. Үүнд:

- Боловсролын зээлийн сан: 27.9 тэрбум төгрөгийн зээл олгохоор баталснаас гүйцэтгэлээр гадаад болон дотоодын 1199 суралцагсад 16.2 тэрбум төгрөгийн зээл олгож, төсвийн орлого бүрдээгүйгээс дотоодын их дээд сургуулиудад 2025-2026 оны хичээлийн жилд суралцаж буй 1158 суралцагсдын 2.8 тэрбум төгрөгийн сургалтын зээлийг олгоогүй өр үүсгэсэн;
- Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах хоёр үе шаттай зээлийн төсөл: 18.0 тэрбум төгрөгийн зээл олгохоор баталснаас Төслийн удирдлагын хорооны 5 удаагийн хурлаар 37 аж ахуйн нэгжид нийт 13.8 тэрбум төгрөгийг тус тус олгосон байна.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан арилжааны банкаар дамжуулан олгох зээлийн сонгон шалгаруулалтыг хуулиар тогтоосон хугацаанд зохион байгуулаагүйгээс 45.0 тэрбум төгрөгийн, Сангийн сайд ОУВС-гийн хувь оролцоог нэмэгдүүлэх “ХVI квотын хянан хэлэлцүүлэг” албажаагүй тул 41.2 тэрбум төгрөгийн, Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил нэгж ХХААХҮЯ-ны ТНБД-ын 2024 оны Б/235 дугаар тушаалаар татан буугдсанаас 12.2 тэрбум төгрөгийн, Зээлийн батлан даалтын сан төсвийн хэмнэлтийн горимд шилжсэнтэй холбогдуулан дүрмийн санг нэмэгдүүлэхээр баталсан 5.0 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гараагүй байна.

Хөдөө аж ахуйг дэмжих сангийн²⁸ эргэж төлөгдөх цэвэр зээлийн эргэн төлөлт хангалтгүй, Засгийн газрын тогтоолоор хөнгөлсөн техник тоног төхөөрөмжийн 50.0 хувийн үнийн хөнгөлөлт 27.5 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг шийдвэрлээгүй байна.

3.2.60 Иргэн, ААНБ-уудад олгосон зээлээс 201.3 тэрбум төгрөгийн эргэн төлөлт хийгдээгүй байна. Тухайлбал: Боловсролын зээлийн сан 12.1 тэрбум төгрөг, ААНБ-уудад олгосон дамжуулан зээл 14.7 тэрбум төгрөг, Хөдөө аж ахуйг дэмжих сан 10.0 тэрбум төгрөг, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан 40.2 тэрбум төгрөг, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах хоёр үе шаттай зээлийн төсөл 21.4 тэрбум төгрөг тус тус дутуу төвлөрүүлсэн байна.

3.2.61 БНХАУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төслийн хүрээнд авсан хөдөө аж ахуйн техник тоног төхөөрөмжийн үнийг Засгийн газрын 2020 оны “Газар тариалангийн тогтвортой хөгжлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” 138 дугаар тогтоолоор 50.0 хувиар хөнгөлсөн 27.5 тэрбум төгрөг, Засгийн газрын 2017 оны “Агаарын хэт халалт, хуурайшилттай холбогдуулан авах зарим арга хэмжээний” 205 дугаар тогтоолоор Онцгой байдлын ерөнхий газарт шилжүүлсэн 4.9 тэрбум төгрөгийн трактор, ам.доллараар байгуулсан дамжуулан зээлийн гэрээний дүнг төгрөгт шилжүүлснээс үүссэн гадаад валютын ханшийн зөрүүний гарз 43.7 тэрбум төгрөгийг тус тус шийдвэрлээгүйгээс Хөдөө аж ахуйг дэмжих сангийн зээлийн эргэн төлөлт хангалтгүй байна.

3.2.62 Дампуурсан Анод банкнаас 22.5 тэрбум төгрөг, Зоос банкнаас 58.5 тэрбум төгрөг, татан буугдсан хадгаламж зээлийн хоршооноос 20.6 тэрбум төгрөгийн зээлийн авлагыг жил бүрийн төсөвт баталдаг боловч авлага барагдуулах ажил тодорхой үр дүнд хүрээгүй байна.

²⁸ Засгийн газрын 2023 оны 269 дүгээр тогтоолоор Хөдөө аж ахуйг дэмжих сангийн ажлын албыг татан буулгаж, авлагыг Хөдөө аж ахуйн корпорац ТӨХХК-д шилжүүлсэн

Тайлант онд төлсөн нийт хүүгийн зардлын 23.9 хувийг нийгмийн шинж чанартай зээлийн төслүүдэд төлсөн байна.

3.2.63 Улсын төсвийн хүүгийн зардлыг 1,293.0 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс 1,208.9 тэрбум төгрөгийг төлж, 93.5 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 24. Улсын төсвийн 2025 оны хүүгийн зардал

/тэрбум төгрөг/


Үзүүлэлт	2024 оны гүйц	2025 он				Өмнөх оноос зөрүү
		Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь	
Хүүгийн зардал	1,165.9	1,293.0	1,208.9	84.1	93.5	43.0
Гадаад зээл	599.3	615.1	548.0	67.1	89.1	(51.3)
Гадаад үнэт цаас	559.1	632.7	625.3	7.4	98.8	66.2
Дотоод үнэт цаас	7.5	45.2	35.6	9.6	78.8	28.1

Эх сурвалж: Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

3.2.64 Улсын төсвийн хүүгийн зардал өмнөх оноос 3.7 хувиар өсөж, нийт зарлага ба цэвэр зээлийн дүнгийн 5.9 хувийг эзэлж байна.

Дүрслэл 7. Монгол Улсын нийт зарлага цэвэр зээлийн дүн ба хүүгийн зардал

/тэрбум төгрөг/



Эх сурвалж: Сангийн яам

3.2.65 Гадаад зээлийн хүүгийн зардлын 23.9 хувь буюу 131.0 тэрбум төгрөгийг нийгмийн шинж чанартай боловсрол, халамж, аялал жуулчлал, эрүүл мэндийн салбарын 69 төсөлд, 1.2 хувь буюу 6.4 тэрбум төгрөгийг улсын төсвийн хөрөнгө оруулалт болон бусад эх үүсвэрээр хэрэгжүүлэх боломжтой тоног төхөөрөмж худалдан авах, барилга байгууламж барих 24 төсөлд төлсөн байна.

3.3 ТЕЗ бүрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнг баталсан боловч хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ тодорхой бус, зарим хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтүүд оновчгүй, хэмжих нэгж уялдаагүй, суурь түвшин алдаатай, хэмжигдэхүйц бус зэргээс хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн хэрэгжилтийг үнэлэх боломжгүй байна.

3.3.1 Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн нэгдүгээр хавсралтаар “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт”-д улсын төсвийн 36 ерөнхийлөн захирагчийн 239 хөтөлбөрийг 492 шалгуур үзүүлэлтээр үнэлж, хүрэх зорилтот түвшнийг баталсан байна.

3.3.2 ТЕЗ нар төсвийн төслийг тэргүүлэх чиглэлийн бодлогыг баримталж, хөтөлбөрт суурилан боловсруулж байгаа ч зарим хүрэх үр дүн, зорилтот түвшин, ойлгомжгүй, хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төсөвтэй уялдуулан боловсруулаагүйгээс зардлыг оновчтой төлөвлөсөн эсэхийг дүгнэх боломжгүй байна. Үүнд:

- **Боловсролын сайд:** Боловсролын салбарын 2012-2025 оны хооронд хэрэгжиж дуусах 99.9 тэрбум төгрөгийн 47 төсөл, арга хэмжээ хугацаандаа хэрэгжээгүй, удаашралтай, он дамжсан, хэрэгжилт хангалтгүй, хөрөнгийн эх үүсвэргүй болсон;
- **Сангийн сайд:** Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2024 оны 95 дугаар тогтоолын 1, 2, 3 дугаар хавсралтуудаар 3 үндэсний хороог шинээр байгуулж, харьяа ТЕЗ-ийн эрхлэх хүрээний байгууллагын төсөвт батлалгүйгээр Засгийн газрын 61,

62, 70 дугаар тогтоолуудаар Засгийн газрын нөөц сангийн хөрөнгөөс нийт 4.4 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлсэн байна.

3.3.3 Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн хавсралтаар ТЕЗ бүрийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнг баталсан боловч хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ тодорхой бус, хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтүүд улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдаагүй, хөтөлбөрийн хүрсэн үр дүн, зорилтот түвшнийг үнэлэх аргачлал тодорхойгүйгээс хэрэгжилтийг бодитой үнэлэх боломжгүй байна. Тухайлбал:

- **ГБХНХС:** Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд хэмжих нэгж уялдаагүй 2 арга хэмжээ, суурь болон зорилтот түвшин хэмжигдэхүйц бус 1 арга хэмжээг төлөвлөсөн. Хүний хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэлд хамаарах “Гэр бүлд ээлтэй бодлого хэрэгжүүлж, хүн амын тогтвортой өсөлт, хүний хөгжлийг дэмжинэ” хөтөлбөрийн үр дүнг үнэлэхэд шалгуур үзүүлэлт болох “Хүүхдийн эрхийн индекс” батлагдаагүй. “Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулна”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний суурь эрхийг хангана” арга хэмжээнүүдийн зорилтот түвшнийг оновчтой тодорхойлоогүйгээс зорилтот үр дүнд хүрээгүй. “Хүүхдийн хөгжил хамгааллын хөтөлбөр”-ийн Хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн нийт хүүхдэд эзлэх хувийг тайлант онд 70 хувьд хүргэхээр төлөвлөсөн нь төлөвлөлтийн хувьд алдаатай, үнэлэх боломжгүй;
- **МУШС:** “Бүсчилсэн хөгжлийн бодлого” хөтөлбөрийн үр дүнг үнэлэхэд “аймгуудын өрсөлдөх чадварын индексийн дундаж” шалгуур үзүүлэлтээр тооцохоос 2024, 2025 онд Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв нь аймгийн өрсөлдөх чадварын тайланг гаргаагүйгээс үнэлэх боломжгүй байна.

3.3.4 ТЕЗ нарын хэрэгжүүлэх 239 хөтөлбөрийн үр дүн батлагдсанаас зарим хөтөлбөрийг нэгтгэж, зарим шалгуур үзүүлэлтүүдийг салгаж, 173 хөтөлбөрийн үр дүнг үнэлж, гүйцэтгэлийг тайлагнасан байна. Үүнд: 96 хөтөлбөр 85.0 дээш хувийн, 12 хөтөлбөр 50.1 – 85.0 хувь, 16 хөтөлбөр 30.1 – 50.0 хувь, 43 хөтөлбөр 5.0 – 30.0 хувь хэрэгжиж, 6 хөтөлбөр хэрэгжээгүй байна. Тухайлбал:

- **АҮЭБС:** Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд туссан зарим гол зорилт, арга хэмжээний төлөвлөлт оновчтой бус, төсөв санхүүгийн эх үүсвэр дутмаг, хэрэгжилтэд тавих хяналт сул байснаас хэрэгжилт хангалтгүй. Тухайлбал: Үйлдвэрийн парк, технологийн дэвшил нэвтрүүлэх төслүүдийн хэрэгжилт удаашралтай, гүйцэтгэл хангалтгүй, Эрдэс баялгийн боловсруулах үйлдвэрүүдийн бүтээн байгуулалт, өргөтгөлийн ажлууд бүрэн хэрэгжээгүй, үйлдвэрлэлийн хүчин чадал бодлогын зорилтот хүрээгүй;
- **МУШС:** Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд туссан төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн дундаж үнэлгээ үзэхэд ОБЕГ 70 хувийн, Стандарт хэмжил зүйн газар 88.7 хувийн гүйцэтгэлтэй;
- **ЭЗХС:** Тайлант оны төсвийн гүйцэтгэл 51.8 хувьтай, ТЕЗ-ын хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, хэрэгжилтийн дундаж биелэлт 160.6 хувьтай байгаа нь хөтөлбөр, арга хэмжээний зорилтот түвшний үзүүлэлтийн үр дүнг үнэлэх боломжгүй байна.

3.3.5 ТЕЗ бүрийн 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг бүрэн гүйцэт үнэлээгүй, 65 хөтөлбөр 0.0 – 50.0 хувийн хэрэгжилттэй, улсын төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн гүйцэтгэл 90.5 хувьтай байгаа нь төсвийн зарцуулалт хөтөлбөрийн үр дүнтэй уялдахгүй байна.

БҮЛЭГ 4. ГОЛ НЭР ТӨРЛИЙН ЭРДЭС БАЯЛАГИЙН ҮНЭ ТӨЛӨВЛӨСӨН ХЭМЖЭЭНД ХҮРЭЭГҮЙ, ТӨСВИЙН ЗАРЛАГЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР ХУВААРИЙН ДАГУУ БҮРДЭЭГҮЙ, ТӨСВИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЗАРЧИМ АЛДАГДСАНААС ТӨСВИЙН ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ 1,027.9 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН АЛДАГДАЛТАЙ ГАРСАН БАЙНА.

4.1 Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн тэнцэл 1,027.9 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна.

4.1.1 Төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүнг 30,209.9 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийг 31,573.9 тэрбум төгрөг, төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 1,364.0 тэрбум төгрөгийн алдагдалтай баталсан ч гүйцэтгэлээр 1,027.9 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна.

Хүснэгт 25. Нэгдсэн төсвийн үзүүлэлтүүдийн ДНБ-д эзлэх хувь болон өсөлтийн хувь /тэрбум төгрөг/

№	Нэр	Үзүүлэлт	2022 он	2023 он	2024 он	2022 - 2024 Дундаж	2025 он	Өсөлтийн хувь
1	Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламж	Дүн	17,126.9	23,294.9	29,670.8	23,364.2	30,303.1	29.7
		ДНБ-д эзлэх хувь	32.4	33.8	37.1	34.3	33.7	(0.6)
2	Нийт зарлага ба цэвэр зээл	Дүн	18,159.7	22,509.0	30,591.1	23,753.3	31,331.0	31.9
		ДНБ-д эзлэх хувь	34.3	32.7	38.3	35.1	34.8	(0.3)
3	Тэнцвэржүүлсэн тэнцэл	Дүн	(1032.7)	785.9	(920.2)	(389.0)	(1,027.9)	164.2
		ДНБ-д эзлэх хувь	(2.0)	1.1	(1.2)	(0.7)	(1.1)	(0.4)
4	Нэрлэсэн ДНБ	Өсөлтийн хувь	23.6	30.8	13.5	21.4	12.5	(8.9)

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

4.1.2 Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн өмнөх оноос 2.1 хувиар, өмнөх 3 жилийн дунджаас 29.7 хувиар өссөн боловч нийт импортын орлого төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй, уул уурхайн экспортын гол нэр төрлийн түүхий эдийн үнэ өмнөх оноос буурч, татвар, хураамж бүрэн төвлөрөөгүй зэргээс шалтгаалан төсвийн орлого тасарсан байна.

4.1.3 Тэнцвэржүүлсэн тэнцлийг төсвийн бүрэлдэхүүнээр авч үзвэл Улсын төсөв 1,426.3 тэрбум төгрөг, Орон нутгийн төсөв 500.3 тэрбум төгрөгийн алдагдалтай, Эрүүл мэндийн даатгалын сан 61.3 тэрбум төгрөг, Нийгмийн даатгалын сан 837.5 тэрбум төгрөгийн ашигтай байна.

4.1.4 Тайлант онд Засгийн газрын үнэт цаасны борлуулалтаас 190.0 тэрбум төгрөг, Засгийн газрын гадаад зээлээс 65.5 тэрбум төгрөг, харилцах болон хадгаламжийн дансны үлдэгдлээс 3,324.2 тэрбум төгрөг, өмч хувьчлалын орлогоос 52.2 тэрбум төгрөг, нийт 3,631.9 тэрбум төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж нэгдсэн төсвийн алдагдлыг санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 26. Нэгдсэн төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр /тэрбум төгрөг/

Алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр	2024 оны	2025 оны			
	Гүйц	Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь
А	1	2	3	4=3-2	5=3/2
Харилцах болон хадгаламжийн дансны өөрчлөлт	(10.9)	3,324.2	39.9	3,284.3	1.2
Засгийн газрын бонд	(226.6)	190.0	891.3	701.3	469.1
Засгийн газрын зээл	1,156.7	65.5	92.2	26.7	141.0
Өмч хувьчлал	1.1	52.2	4.4	47.8	8.4
Нийт дүн	920.3	3,631.9	1,027.9	2,604.0	28.3

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

4.1.5 Гүйцэтгэлээр Засгийн газрын дотоод, гадаад үнэт цаасны борлуулалтаас 2,637.2 тэрбум төгрөг, гадаад зээлээс 1,504.2 тэрбум төгрөг, харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлтөөс 39.9 тэрбум төгрөг, өмч хувьчлалын орлогоос 4.4 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг

бүрдүүлж, өмнөх онуудад авч ашигласан Засгийн газрын дотоод, гадаад үнэт цаасны төлбөрт 1,745.9 тэрбум төгрөг, гадаад зээлийн төлбөрт 1,411.9 тэрбум төгрөгийг тус тус төлсөн байна.

4.2 Улсын төсвийн нийт тэнцвэржүүлсэн тэнцэл 1,426.3 тэрбум төгрөгийн алдагдалтай гарч, ДНБ-ий 1.6 хувьтай тэнцэж байна.

4.2.1 Монгол Улсын 2025 оны төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 19,795.0 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийг 22,564.3 тэрбум төгрөг, тэнцвэржүүлсэн тэнцлийг 2,769.3 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар төлөвлөжээ.

4.2.2 Гүйцэтгэлээр төсвийн тэнцвэржүүлсэн орлого 18,988.0 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээл 20,414.3 тэрбум төгрөг болж, тэнцвэржүүлсэн тэнцэл 1,426.3 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна.

Хүснэгт 27. Улсын төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр

/тэрбум төгрөг/

Алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр	2024 оны Гүйц	2025 оны			
		Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь
А	1	2	3	4=3-2	5=3/2
Харилцах болон хадгаламжийн дансны өөрчлөлт	862.8	2,513.8	1,053.4	1,460.4	41.9
Засгийн газрын бонд	(736.4)	190.0	280.2	90.2	147.5
Засгийн газрын зээл	1,156.7	65.5	92.2	26.7	140.8
Өмч хувьчлал	0.2	-	0.4	0.4	-
Нийт дүн	1,283.3	2,769.3	1,426.3	1,343.1	51.5

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

4.2.3 Улсын төсвийн алдагдлыг нөхөх зорилгоор 92.2 тэрбум төгрөгийн гадаад зээл, 280.2 тэрбум төгрөгийн засгийн газрын дотоод үнэт цаас, харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлтөөс 1,053.4 тэрбум төгрөг, өмч хувьчлалын орлогоос 0.4 тэрбум төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж, Засгийн газрын гадаад үнэт цаасны төлбөрт 1,731.5 тэрбум төгрөг, дотоод үнэт цаасны төлбөрт 14.3 тэрбум төгрөг, гадаад төсөл болон төслийн бус зээлийн төлбөрт 1,411.9 тэрбум төгрөг, нийт 3,157.8 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

БҮЛЭГ 5. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО ӨМНӨХ ОНООС 7.2 ХУВИАР, ЗАРЛАГА 12.6 ХУВИАР НЭМЭГДСЭН НЬ ОРЛОГЫН ӨСӨЛТӨӨС ДАВСАН ЗАРЛАГЫГ ХЯЗГААРЛАЖ, САНХҮҮГИЙН САХИЛГА БАТЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

5.1 Орон нутаг нийт орлого ба тусламжаар 7,672.1 тэрбум төгрөг бүрдүүлж, 90.8 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь татварын орлогыг 783.8 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

5.1.1 Орон нутгийн 2025 оны нийт орлого ба тусламжийн дүнг 8,453.2 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 90.8 хувь буюу 7,672.1 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, 9.2 хувиар тасарсан байна.

5.1.2 Орон нутгийн төсвийн нийт орлого ба тусламжийн 5,977.7 тэрбум төгрөг буюу 78.0 хувийг татварын орлого, 1,694.4 тэрбум төгрөг буюу 22.0 хувийг татварын бус орлого эзэлж байна.

5.1.3 Орон нутгийн төсвийн нийт орлого ба тусламжийн 49.8 хувийг Улаанбаатар хот, 21.5 хувийг Өмнөговь аймаг, 4.4 хувийг Орхон аймаг, 1.9 хувийг Дорноговь аймаг, 22.2 хувийг бусад аймгууд бүрдүүлсэн байна.

Хүснэгт 28. Орон нутгийн орлогын гүйцэтгэл эдийн засгийн ангиллаар

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Төлөв	Гүйц	зөрүү	
			дүн	хувь
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	8,453.2	7,672.1	781.1	90.8
1. Татварын орлого	6,761.5	5,977.7	783.8	88.4
1.1. Орлогын албан татвар	5,535.4	4,789.2	746.1	86.5
1.1.1. Хувь хүний орлогын албан татвар	3,124.9	2,987.5	137.4	95.6
1.1.2. Аж, ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар	2,502.8	1,893.9	609	75.7
1.1.3. Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(92.2)	(92.2)	-	100.0
1.2. Хөрөнгийн албан татвар	593.8	609.8	(15.9)	102.7
1.3. Бусад татвар (төлбөр, хураамж)	632.3	578.7	53.6	91.5
2. Татварын бус орлого	1,691.7	1,694.4	(2.7)	100.2
2.1. Нийтлэг татварын бус орлого	977.8	989.3	(11.4)	101.2
2.2. Хөрөнгийн орлого	9.0	9.9	(0.9)	110.7
2.3. Тусламжийн орлого	15.3	10.3	5.0	67.2
2.4. Төсөв хоорондын шилжүүлэг	689.6	684.9	4.7	99.3

Эх сурвалж: Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл

5.1.4 Улаанбаатар 396.9 тэрбум төгрөг, Өмнөговь 391.4 тэрбум төгрөг, Орхон 60.3 тэрбум төгрөг, Дорноговь 30.4 тэрбум төгрөг, Ховд 5.8 тэрбум төгрөг, Баян-Өлгий 5.5 тэрбум төгрөг, Баянхонгор 3.2 тэрбум төгрөг, Сүхбаатар 2.5 тэрбум төгрөгөөр орлогын төлөвлөгөөг тус тус тасалсан байна.

5.1.5 Татварын орлогын 50.0 хувь буюу 2,987.5 тэрбум төгрөгийг хувь хүний орлогын албан татварын орлогоос бүрдүүлж, ХХОАТ-ын буцаалтаар иргэдэд 92.2 тэрбум төгрөгийг олгосон байна.

Татварын орлого

5.1.6 Орон нутгийн төсвийн орлого ба тусламжийн дүн 781.1 тэрбум төгрөгөөр дутуу биелэхэд татварын орлого 783.8 тэрбум төгрөгөөр тасарсан нь голлон нөлөөлжээ.

5.1.7 Орон нутгийн хувь хүний орлогын албан татвар 2,987.5 тэрбум төгрөг буюу 95.6 хувийн гүйцэтгэлтэй, 137.4 тэрбум төгрөгөөр тасарсан байна.

5.1.8 Аж, ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар 1,893.9 тэрбум төгрөг буюу 75.7 хувийн гүйцэтгэлтэй, 609.0 тэрбум төгрөгөөр тасарсан байна. Энэ нь 11 аймаг нийт 45.8 тэрбум

төгрөгөөр давж биелсэн, 10 аймаг болон нийслэл нийт 654.8 тэрбум төгрөгөөр тасарснаас шалтгаалсан байна./Улаанбаатар 122.5 тэрбум төгрөг, Баян-Өлгий 0.3 тэрбум төгрөг, Баянхонгор 2.6 тэрбум төгрөг, Дорноговь 6.4 тэрбум төгрөг, Орхон 104.0 тэрбум төгрөг, Өмнөговь 412.2 тэрбум төгрөг, Сүхбаатар 0.4 тэрбум төгрөг, Увс 0.1 тэрбум төгрөг, Ховд 6.0 тэрбум төгрөг, Хөвсгөл 3 тэрбум төгрөг/

5.1.9 Бусад татвар төлбөр, хураамжийн орлогыг 632.3 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 578.7 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, 53.6 тэрбум төгрөгөөр тасарсан байна. /Баян-Өлгий 0.3 тэрбум төгрөг, Булган 0.7 тэрбум төгрөг, Дорноговь 26.5 тэрбум төгрөг, Өвөрхангай 1.7 тэрбум төгрөг, Өмнөговь 1.7 тэрбум төгрөг, Сүхбаатар 2.1 тэрбум төгрөг, Сэлэнгэ 2.2 тэрбум төгрөг, Төв 0.2 тэрбум төгрөг, Ховд 0.4 тэрбум төгрөг/

Татварын бус орлого

5.1.10 Татварын бус орлогыг 1,691.7 тэрбум төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 1,694.4 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн байна. Үүнээс нийтлэг татварын бус орлого 989.3 тэрбум төгрөг, төсөв хоорондын шилжүүлэг 684.9 тэрбум төгрөг, тусламжийн орлого 10.3 тэрбум төгрөг, хөрөнгийн орлого 9.9 тэрбум төгрөг байна.

5.1.11 Хөрөнгийн орлого 9.9 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, 0.9 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна.

5.1.12 Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 15.3 тэрбум төгрөг, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн шилжүүлгийг 689.6 тэрбум төгрөг, нийт 704.5 тэрбум төгрөгөөр баталснаас, 695.2 тэрбум төгрөгийг шилжүүлж, 98.7 хувийн гүйцэтгэлтэй байна.

Аудитаар илэрсэн зөрчил

- Орон нутгийн ТЕЗ нар 470.4 тэрбум төгрөгийн орлогыг бодитой төлөвлөөгүй, тасалсан, татварын болон татварын бус орлогыг нэр төрлөөр жигд ханган биелүүлээгүй, орлого дутуу төвлөрүүлсэн, төлөвлөлт, гүйцэтгэлийн уялдаа алдагдсан; /Улаанбаатар 439.6 тэрбум төгрөг, Төв 14.0 тэрбум төгрөг, Дундговь 7.4 тэрбум төгрөг, Сүхбаатар 4.3 тэрбум төгрөг, Дорнод 2.6 тэрбум төгрөг, Баянхонгор 1.7 тэрбум төгрөг, Увс 0.4 тэрбум төгрөг, Хэнтий 0.2 тэрбум төгрөг, Архангай 0.1 тэрбум төгрөг, Булган 0.1 тэрбум төгрөг/
- Уул уурхайн тусгай зөвшөөрөл эзэмшигч 7.2 тэрбум төгрөгийг аж ахуйн нэгжээс гэрээний дагуу авах мөнгөн дэмжлэгийг бүрэн аваагүй, орлогыг буруу ангилан төлөвлөж тайлагнасан, үндэслэлгүй нэмж баталсан; /Өмнөговь 2.0 тэрбум төгрөг, Дорнод 1.7 тэрбум төгрөг, Төв 1.8 тэрбум төгрөг, Увс 0.2 тэрбум төгрөг, Говьсүмбэр 0.3 тэрбум төгрөг, Хөвсгөл 1.2 тэрбум төгрөг/
- Улсын төсөвт төвлөрүүлэх 513.1 тэрбум төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн. /Өмнөговь 419.9 тэрбум төгрөг, Орхон 83.4 тэрбум төгрөг, Дорноговь 9.8 тэрбум төгрөг/

5.2 Орон нутгийн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 8,172.4 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй гарч, батлагдсан төлөвлөгөөнөөс 2,548.6 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулсан ч өмнөх оноос 913.9 тэрбум төгрөг буюу 12.6 хувиар нэмэгдсэн байна.

5.2.1 Орон нутгийн төсвийн урсгал зарлагын төлөвлөгөөг 10,721.1 тэрбум төгрөгөөр баталж, 8,172.4 тэрбум төгрөгийг зарцуулж, 76.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

5.2.2 Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 2,548.6 тэрбум төгрөгийн дутуу гүйцэтгэлтэй байгаа нь эргэж төлөгдөх цэвэр зээлд 34.3 тэрбум төгрөг, хөрөнгийн зардалд 1,532.1 тэрбум төгрөг, урсгал зардалд 982.3 тэрбум төгрөгийг тус тус дутуу зарцуулсан нь нөлөөлсөн байна.

Хүснэгт 29. Орон нутгийн зарлагын гүйцэтгэл эдийн засгийн ангиллаар

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2024 он гүйцэтгэл	2025 он				Өмнөх оноос өөрчлөлт
		Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь	
А	1	2	3	4=3-2	5=3/2	6=3-1
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,258.6	10,721.1	8,172.4	2,548.6	76.2	913.9
А. УРСГАЛ ЗАРЛАГА	4,244.6	5,764.1	4,781.7	982.3	83.0	537.2
1. Бараа, үйлчилгээний зардал	2,251.2	2,942.5	2,543.5	398.9	86.4	292.3
2. Хүү	70.0	340.8	339.3	1.5	99.6	269.3
3. Татаас ба урсгал шилжүүлэг	1,923.5	2,480.9	1,898.9	581.8	76.5	(24.5)
Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,888.7	4,846.2	3,314.2	1,532.1	68.4	425.5
В. ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ	125.3	110.8	76.5	34.3	69.0	(48.8)

Эх сурвалж: Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл

5.2.3 Урсгал шилжүүлэгт 2,050.4 тэрбум төгрөг төлөвлөж, 1,473.0 тэрбум төгрөг зарцуулж, 71.8 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

5.2.4 Бусад урсгал шилжүүлэгт 40.4 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Үүнээс хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэгт 2.4 тэрбум төгрөг, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид 6.8 тэрбум төгрөг, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулалд 14.2 тэрбум төгрөг, ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулалд 2.5 тэрбум төгрөг, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулалд 5.1 тэрбум төгрөг, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжид 9.4 тэрбум төгрөгийг зарцуулжээ.

5.2.5 Орон нутгийн төсвөөс улсын төсөвт 1,290.4 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, 513.1 тэрбум төгрөгөөр дутуу байгаа нь Өмнөговь аймаг 419.9 тэрбум төгрөг, Дорноговь аймаг 9.8 тэрбум төгрөг, Орхон аймаг 83.4 тэрбум төгрөгийг тус тус дутуу төвлөрүүлснээс шалтгаалсан байна.

Хүснэгт 30. Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл төсвийн захирагчаар

/тэрбум төгрөг/

Д/д	Үзүүлэлт	2025 он			
		Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь
А	Б	5	6	7=6-5	8=6/5
1	Булган	0.5	0.5	-	100.0
2	Дорноговь	10.8	1.0	9.8	9.3
3	Дорнод	3.0	3.0	-	100.0
4	Дундговь	1.3	1.3	-	100.0
5	Өмнөговь	1,530.9	1,111.0	419.9	72.6
6	Сэлэнгэ	8.7	8.7	-	100.0
7	Төв	2.4	2.4	-	100.0
8	Дархан-Уул	6.8	6.8	-	100.0
9	Улаанбаатар	130.8	130.8	-	100.0
10	Орхон	108.4	25.0	83.4	23.1
Нийт дүн		1,803.5	1,290.4	513.1	71.5

Эх сурвалж: Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл

5.2.6 Хөрөнгийн зардалд 4,846.2 тэрбум төгрөг төлөвлөснөөс 3,314.2 тэрбум төгрөг буюу 68.4 хувийн гүйцэтгэлтэй, 31.6 хувийг дутуу зарцуулсан байна. Барилга байгууламж 854.4 тэрбум төгрөгөөр, бусад хөрөнгө 458.9 тэрбум төгрөг, их засвар 131.3 тэрбум төгрөг, тоног төхөөрөмж 87.5 тэрбум төгрөгийн дутуу гүйцэтгэлтэй байгаа нь нөлөөлжээ.

5.2.7 Орон нутгийн төсвийн 22 ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх нийт 577 хөтөлбөр батлагдсан байна. Үүнээс 102 хөтөлбөрийн 105 үр дүнгийн шалгуур үзүүлэлт 100.0 хувиас дээш, 387 хөтөлбөрийн 392 үр дүнгийн шалгуур үзүүлэлт 85.0-100.0 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн бол 75 хөтөлбөрийн 80 үр дүнгийн шалгуур үзүүлэлт 85.0 хувиас доош

гүйцэтгэлтэй, 13 хөтөлбөрийн 86 үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн биелэлт хангалтгүй үнэлэгдсэн байна.

5.3 Орон нутгийн нийт орлого өмнөх оноос 7.2 хувиар өссөн боловч нийт зарлага 12.6 хувиар нэмэгдэж, төсвийн тэнцэл 500.3 тэрбум төгрөгийн алдагдалтай гарчээ.

5.3.1 Аймаг, нийслэлийн ИТХ-аар нийт орлого ба тусламжийн дүнг 8,453.2 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийг 10,721.1 тэрбум төгрөгөөр төлөвлөж, орон нутгийн төсвийн тэнцлийг 2,267.9 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар баталсан. Алдагдлыг харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлтөөс санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

5.3.2 Гүйцэтгэлээр нийт орлого ба тусламжийн дүн 7,672.1 тэрбум төгрөг нийт зарлага ба цэвэр зээл 8,172.4 тэрбум төгрөгийг зарцуулж, орон нутгийн төсвийн тэнцэл 500.3 тэрбум төгрөгийн алдагдалтай байна.

5.3.3 Монгол Улсын Их Хурлаас баталсан нэгдсэн төсвийн суурь тэнцэл 1,809.4 тэрбум төгрөг буюу ДНБ-ны 2.0 хувьтай тэнцэх хэмжээний ашигтай байхаар баталсан байна. Гэвч аймаг, нийслэл, сум, дүүрэг орон нутгийн төсвийг ИТХ-аар 2,215.7 тэрбум төгрөгийн төсвийн зардлыг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр баталж, гүйцэтгэлээр 1,161.1 тэрбум төгрөг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2 дах хэсэгт орон нутгийн төсвийн алдагдалгүй баталж, хэрэгжүүлэх заалттай зөрчилдөж, нэгдсэн төсвийн суурь тэнцэл хангагдахгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

5.3.4 Дотоод бондоос 308.3 тэрбум төгрөг, гадаад бондоос 302.9 тэрбум төгрөг, өмч хувьчлалаас 4.0 тэрбум төгрөг, нийт 615.2 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлснээс 500.3 тэрбум төгрөгөөр төсвийн алдагдлыг санхүүжүүлж, мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 114.8 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

5.3.5 Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын ирүүлсэн төсвийн төслийн орлогын суурийг Сангийн яам 15.8 хувиар нэмэгдүүлэн хянаж, аймаг, нийслэлийн ИТХ хянасан суурийг дахин 25.3 хувиар өсгөн баталсан, орлогын гүйцэтгэл 90.8 хувьтай гарсан байна.

Аудитаар илэрсэн зөрчил

- Унаа хоолны хөнгөлөлтийг тайлант оны төсөвт тусгаж батлуулаагүй зардал гаргасан, жилийн дундуур гэрээт ажилтан болон түр орлон гүйцэтгэгчийг дур мэдэн авч ажиллуулсан нийт 1.7 тэрбум төгрөг. /Архангай 0.8 тэрбум төгрөг, Баянхонгор 0.4 тэрбум төгрөг, Говь-Алтай 0.5 тэрбум төгрөг, Орхон 0.01 тэрбум төгрөг/
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй үр ашиггүй, үрэлгэн зарцуулсан, ойн арга хэмжээ санхүүжүүлсэн, урсгал зардлыг хөтөлбөрөөс олгосон, хөтөлбөр арга хэмжээний зорилго зорилтод нийцүүлээгүй зардал гаргасан, санхүүжилтийг илүү олгосон, нийлүүлж буй бараа, бүтээгдэхүүний үнийг зах зээлийн үнээс хэт өндрөөр тогтоон төсвийн хөрөнгийн үр ашгийг бууруулсан нийт 10.4 тэрбум төгрөг. /Говь-Алтай 4.3 тэрбум төгрөг, Баянхонгор 0.3 тэрбум төгрөг, Булган 0.01 тэрбум төгрөг, Дундговь 0.4 тэрбум төгрөг, Завхан 3.9 тэрбум төгрөг, Нийслэл 1.1 тэрбум төгрөг, Сэлэнгэ 0.2 тэрбум төгрөг, Ховд 0.2 тэрбум төгрөг/
- Хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас 0.2 тэрбум төгрөгийг урсгал үйл ажиллагааны зардалд дэмжлэг олгосон. /Архангай 0.1 тэрбум төгрөг, Булган 0.1 тэрбум төгрөг, тэрбум төгрөг/
- Албан тушаалтны буруутай шийдвэрээр ажлаас үндэслэлгүйгээр халагдсан нь Шүүхийн шийдвэрээр тогтоогдсон Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д заасны дагуу ажилгүй байсан хугацааны нөхөн 0.2 тэрбум төгрөгийг олговрыг төсвөөс олгож авлагаар бүртгэсэн, хохирлыг барагдуулаагүй. /Баян-Өлгий 0.03 тэрбум төгрөг, Хөвсгөл 0.2 тэрбум төгрөг/
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр төлөвлөгөөнд тусгагдаагүй ажлыг санхүүжүүлсэн, данс андуурч гүйлгээ хийсэн, өр төлбөр үүсгэсэн, хэрэгжилт хангалтгүй зэрэг 4.6 тэрбум төгрөгийн зөрчлүүд илэрсэн байна. /Баянхонгор 0.01 тэрбум төгрөг, Говь-сүмбэр 0.07 тэрбум төгрөг, Ховд 1.8 тэрбум төгрөг, Дундговь 1.7 тэрбум төгрөг, Увс 0.8 тэрбум төгрөг, Хөвсгөл 0.1 тэрбум төгрөг/
- Худалдан авалт зохион байгуулахдаа холбогдох хууль, журамд нийцүүлэн зохион байгуулаагүй зураг төсөв, төсөл арга хэмжээний үнийн тооцоо судалгаа нь урьдчилан хийгдээгүй, тусгай зөвшөөрөлгүй гүйцэтгэгчтэй шууд гэрээ байгуулсан, зургийн трасс зөрсөн, урьдчилгаа төлбөр олгосон төсөл арга хэмжээг ЗГ-ын шийдвэрээр зогсоосон, батлагдсан төлөвлөгөөнд тусгагдаагүй ажил хэрэгжүүлсэн, төсөл арга хэмжээний шилжих хөрөнгө оруулалтыг хянаагүй, санхүүжилтийг зөрүүтэй олгосон зэрэг нийт 427.7 тэрбум төгрөгийн зөрчил илэрсэн. /Улаанбаатар 417.3 тэрбум төгрөг, Сэлэнгэ 6.6 тэрбум төгрөг, Дорнод 3.3 тэрбум төгрөг, Говь-Сүмбэр 0.4 тэрбум төгрөг, Ховд 0.2 тэрбум төгрөг/

БҮЛЭГ 6. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЧӨЛӨӨТ ҮЛДЭГДЛИЙГ САНХҮҮГИЙН ХЭРЭГСЭЛД ХӨРӨНГӨ ОРУУЛАХААР ХУУЛЬЧИЛСАН БОЛОВЧ 40752 АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГААС АВАХ 590.4 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН НДШ-ИЙН АВЛАГЫГ БАРАГДУУЛААГҮЙ НЬ САНГИЙН ХӨРӨНГИЙГ НЭМЭГДҮҮЛЖ, ӨГӨӨЖ ХҮРТЭХ БОЛОМЖИЙГ АЛДАЖ БАЙНА.

6.1 Нийгмийн даатгалын ерөнхий хуульд заасны дагуу сангийн мөнгөн хөрөнгийн чөлөөт үлдэгдлийг арилжааны банканд байршуулж 77.6 тэрбум төгрөгийн хүүгийн орлого, ЗГ-ын үнэт цаас худалдан авч 27.0 тэрбум төгрөгийн хүүгийн өгөөж хүртсэн байна.

6.1.1 Засгийн газрын 2024 оны “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх, тэтгэврийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 221 дүгээр тогтоолоор нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн алба хаасны тэтгэвэр авагчийн тэтгэврийн хэмжээг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 6.0 хувиар нэмсэн, бүрэн тэтгэврийн доод хэмжээг 689.0 мянган төгрөгөөр, хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээг 572.4 мянган төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоосны дагуу 505.6 мянган тэтгэвэр авагчийн тэтгэврийг 300.1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, дундаж тэтгэвэр 832.7 мянган төгрөгт хүрсэн байна.

6.1.2 Нийгмийн даатгалын ерөнхий хууль болон Засгийн газрын 2024 оны 254 дүгээр тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах журам”-д заасны дагуу Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 07 дугаар тогтоолоор²⁹ хадгаламж хэлбэрээр байршуулах мөнгөн хөрөнгийн дээд хэмжээг 700.0 тэрбум төгрөг, 08 дугаар тогтоолоор мөнгөн хадгаламжийн хүүгийн доод хэмжээг жилийн 14.2 хувиар шинэчлэн тус тус баталжээ.

6.1.3 Уг тогтоолын дагуу арилжааны банкуудаас санал авч Монгол банкнаас тогтоосон банкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт хангасан банкиг сонгон шалгаруулж, ХААН банканд 289.7 тэрбум төгрөг, Худалдаа хөгжлийн банканд 176.2 тэрбум төгрөг, Голомт банканд 158.4 тэрбум төгрөг, Төрийн банканд 75.7 тэрбум төгрөгийг тус тус 1 жилийн хугацаатай 15.0 хувийн хүүтэй байршуулж, тайлант онд 70.2 тэрбум төгрөгийн мөнгөн хадгаламжийн хүү хүлээн авсан байна.

6.1.4 Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1³⁰ дэх заалтыг үндэслэн 2024 онд Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс 300.0 тэрбум төгрөгийг 8.5–9.5 хувийн хүүтэй, 1-3 жилийн хугацаатайгаар байршуулж, нийт 55.0 тэрбум төгрөгийн хүүгийн өгөөж хүртэхээр тооцон Засгийн газрын үнэт цаас худалдан авсан.

6.1.5 Өмнөх онд худалдан авсан 1 жилийн хугацаатай 100.0 тэрбум төгрөгийн үнэт цаасны хугацаа дууссан тул үнэт цаас худалдан авах гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж, 9.5 хувийн хүүтэйгээр 3 жилийн хугацаатай 100.0 тэрбум төгрөгийн үнэт цаас нэмж худалдан авснаар 27.0 тэрбум төгрөгийн хүүгийн өгөөж хүртсэн байна.

6.1.6 Хуримтлалын тогтолцоонд үе шаттай шилжих зорилгоор даатгуулагчийн нэрийн дансны мөнгөжүүлсэн орлогыг байршуулах тэтгэврийн нөөц сантай байхаар заасны дагуу Тэтгэврийн нөөц санд³¹ 1,191.8 мянган даатгуулагчийн 794.8 тэрбум төгрөгийг мөнгөжүүлэх орлого байхаар төлөвлөснөөс 302.7 тэрбум төгрөг болж, харилцах дансны үлдэгдлээс тооцогдсон 3 хувийн хүүгийн өгөөж 7.2 тэрбум төгрөг хүлээн авсан.

²⁹ Засгийн газрын 2024 оны 254 дүгээр тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах журам”-ын 2.7-д “Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл Мэргэжлийн хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэж, сангийн чөлөөт үлдэгдлийг нийгмийн даатгалын төрөл тус бүрийн бие даасан сангуудын эх үүсвэр тус бүрээр энэ журмын 2.1-д заасан санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах шийдвэрийг гаргана.”, 2.9-д “Нийгмийн даатгалын ерөнхий газрын хэрэгжүүлж буй санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах үйл ажиллагаанд Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 13.3-т заасан олон нийтийн хяналтын зөвлөл “Орон тооны бус олон нийтийн хяналтын зөвлөлийн дүрэм”-д заасны дагуу хяналт тавина.”

³⁰ 13.1. Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг найдвартай, үр өгөөжтэй, хариуцлагатай, ил тод, хараат бус байх зарчмыг баримтлан дараах санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулж болно: 13.1.1. Засгийн газрын үнэт цаас;

³¹ 29.1. Тэтгэврийн хуваарилалтын тогтолцооноос хуримтлалын тогтолцоонд үе шаттай шилжих зорилгоор даатгуулагчийн нэрийн дансны мөнгөжүүлсэн орлогыг байршуулах тэтгэврийн нөөц сантай байна.

6.1.7 Тэтгэврийн нөөц санд 492.1 тэрбум төгрөгийг дутуу байршуулсан нь Тэтгэврийн даатгалын сангийн орлого 366.3 тэрбум төгрөгөөр тасарснаас шалтгаалсан байна.

6.2 Төрийн байгууллагуудын мэдээллийн системийн уялдааг хангах замаар дотоод хяналтыг сайжруулж, мөнгөн хөрөнгийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

6.2.1 Нийгмийн даатгалын сан нь 40,752 аж ахуйн нэгж, байгууллагаас авах 590.4 тэрбум төгрөгийн НДШ-ийн авлагыг барагдуулаагүй байгаа нь сангийн чөлөөт мөнгөн хөрөнгийг арвижуулах замаар санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулж, өгөөж хүртэх боломжийг алдаж байна.

6.2.2 Тайлант онд НДШ-ийн орлогоос 5,231.9 тэрбум төгрөгийг бүрдүүлж, гүйцэтгэлээр 5,848.5 тэрбум төгрөгийг зарцуулж, улсын төсвөөс 1,452.5 тэрбум төгрөг татаас олгосноор нийт тэнцэл 837.5 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна. Үүнд:

- Тэтгэврийн даатгалын санд НДШ-ийн 4,239.8 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлснээс 5,341.2 тэрбум төгрөгийг зарцуулж, улсын төсвөөс 1,447.4 тэрбум төгрөгийн татаас олгосноос мөнгөн хөрөнгийн 346.1 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй;
- Тэтгэмжийн даатгалын санд 479.5 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлснээс 291.6 тэрбум төгрөгийг зарцуулж, 187.9 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй;
- ҮОМШӨ-ний даатгалын санд 353.3 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлснээс 52.1 тэрбум төгрөгийг зарцуулж, улсын төсвөөс 5.1 тэрбум төгрөгийн татаас олгосноос, мөнгөн хөрөнгийн 306.3 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй;
- Ажилгүйдлийн даатгалын санд 159.3 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлснээс 163.7 тэрбум төгрөгийг зарцуулж, 4.3 тэрбум төгрөгийн алдагдалтай байна.

Хүснэгт 31. Нийгмийн даатгалын сангийн зарлага

/тэрбум төгрөг/

Д/д	Нийгмийн даатгалын сангийн төрөл	2024 оны гүйцэтгэл	2025 оны зарлага			
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1	Тэтгэврийн даатгалын сан	4,666.5	5,360.5	5,341.2	99.6	(19.3)
2	Тэтгэмжийн даатгалын сан	256.3	280.5	291.6	104.0	11.1
3	ҮОМШӨ-ний даатгалын сан	48.1	66.6	52.1	78.2	(14.5)
4	Ажилгүйдлийн даатгалын сан	136.3	161.9	163.7	101.1	1.8
	Нийт зарлага	5,107.2	5,869.5	5,848.5	99.6	(20.9)

Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2025 оны мэдээлэл

6.2.3 Чингис хаан банканд байршиж буй хөрөнгийн эхний үлдэгдэл 93.4 тэрбум төгрөгөөс 4.1 тэрбум төгрөгийг мөнгөн хөрөнгөөр, 7.5 тэрбум төгрөгийг хөрөнгөөр, нийт 11.6 тэрбум төгрөгийг барагдуулж, 80.8 хувь буюу 83.7 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй.

6.2.4 Капитал банкны эрх хүлээн авагчаас авах 65.7 тэрбум төгрөгийн авлагын үлдэгдлээс 1.6 тэрбум төгрөг нь мөнгөн хөрөнгөөр, 6.5 тэрбум төгрөгийг хөрөнгөөр барагдуулсан бөгөөд 55.2 хувь буюу 57.6 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй, 2020 оны шүүхийн шийдвэрийн хэрэгжилт удаашралтай хэвээр байна.

6.2.5 Нийгмийн даатгалын сангийн нийт зардал өмнөх оноос 14.5 хувь буюу 741.3 тэрбум төгрөгөөр өссөн нь Засгийн газрын 2024 оны “Итгэлцүүр батлах тухай” 231 дүгээр тогтоолоор тэтгэвэр тогтооход хэрэглэх итгэлцүүрийг шинэчилсэн, мөн “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” 120 дугаар тогтоолоор нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн тэтгэвэр авч байгаа тэтгэврийн хэмжээг 100,000 төгрөгөөр нэмэгдүүлсэн, тэтгэвэр, тэтгэмж авагчдын тоо өмнөх оноос 13.7 мянган иргэнээр нэмэгдсэнтэй тус тус холбоотой байна.

6.2.6 НДЕГ, Цагдаа болон Эрүүл мэндийн байгууллага, Улсын бүртгэлийн ерөнхий газар зэрэг төрийн байгууллагуудын хоорондын мэдээлэл солилцох ажлын уялдаа холбоо хангалтгүй, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсгийг бүрэн хэрэгжүүлээгүй, энэ талаар журам, заавраар зохицуулаагүй зэргээс шалтгаалан Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт, шалгалтын газраас хийсэн шалгалтаар иргэд нас барсан

даатгуулагчийн тохиолдлыг бүртгүүлдэггүйгээс 2023-2025 оны хооронд 721 иргэнд, нийт 2.6 тэрбум төгрөгийн тэтгэвэр олгосон зөрчил илэрсэн байна.

6.2.7 Төр хариуцан төлдөг шимтгэлийн 58.2 хувь буюу 26.4 тэрбум төгрөгийг малчин, туслах малчны тэтгэврийн даатгалын шимтгэл, 24.1 хувь буюу 10.9 тэрбум төгрөгийг байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа ажил хөдөлмөр эрхлээгүй эх/эцгийн нийгмийн даатгалын шимтгэл, 17.7 хувь буюу 8.0 тэрбум төгрөгийг бусад төрлийн шимтгэл эзэлж байна.

6.2.8 ҮОМШӨ-ний даатгалын сангаас³² үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлэхээр 3.0 тэрбум төгрөгийг төлөвлөснөөс Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвөөр дамжуулан урьдчилан сэргийлэх сургалтад 0.9 тэрбум төгрөг, НДЕГ-аас мэдээлэл, зөвлөгөө, сурталчилгааны арга хэмжээнд 0.3 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна.

6.2.9 Нийгмийн даатгалын сангийн тэнцвэржүүлсэн тэнцлийн 1,105.9 тэрбум төгрөгийн ашигтай байхаар төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 837.5 тэрбум төгрөгийн ашигтай байна. Энэ нь эргэн төлөгдөх цэвэр зээлийн эх үүсвэрээр капитал банкнаас авах 67.2 тэрбум төгрөгийн авлагыг төлөвлөснөөс 1.6 тэрбум төгрөгийг барагдуулж, 65.6 тэрбум төгрөгийг барагдуулаагүй нь нөлөөлсөн.

³² Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд дараах сургалт, сурталчилгаа, судалгааны ажлыг хамааруулна:

БҮЛЭГ 7. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНД ХУВИАРАА ШИМТГЭЛ ТӨЛӨГЧДИЙН ТОО СҮҮЛИЙН 3 ЖИЛИЙН ДУНДЖААР 8.0 ХУВИАР БУУРЧ БАЙГАА ТУЛ ЦААШИД ДААТГУУЛАГЧДЫН ТООГ НЭМЭГДҮҮЛЭХ БОДЛОГЫН АРГА ХЭМЖЭЭ АВАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

7.1 Даатгалын сангийн орлогын эх үүсвэртэй уялдуулан даатгалын үйлчилгээг төлөвлөх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нэхэмжлэлд даатгалын нэгдсэн цахим системээр тавих хяналтын үр нөлөө хангалтгүй байна.

7.1.1 УИХ-ын чуулганы 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар нийт орлогыг 2,525.6 тэрбум төгрөг, нийт зарлагыг 2,293.9 тэрбум төгрөгөөр тус тус баталсан байна.

7.1.2 Төсвийн тодотголоор нийт орлогыг 61.3 тэрбум төгрөгөөр бууруулж 2,464.3 тэрбум төгрөгөөр, зардлыг 51.5 тэрбум төгрөгөөр бууруулж 2,242.4 тэрбум төгрөгөөр өөрчлөн баталжээ.

7.1.3 Энэ нь төсвийн төсөлд өгсөн саналаас төр хариуцах иргэдийн шимтгэл болон тусламж үйлчилгээний орлогыг 19.1 хувь буюу 551.8 тэрбум төгрөгөөр бууруулж, 1,273.8 тэрбум төгрөгөөр баталсан нь нийт орлогын 51.7 хувийг эзэлж байгаа бөгөөд өмнөх оны гүйцэтгэлээс 202.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн.

7.1.4 Даатгалын сангийн орлогын эх үүсвэрийн бүрдүүлэлттэй уялдуулан, үйлчилгээний төрөл, төлбөрийн хэмжээг тогтоож төсөвт ирэх ачааллыг бууруулахаар төлөвлөлтийг сайжруулах шаардлагатай байна.

7.1.5 Улсын болон хувийн хэвшлийн эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудаас 2025 онд нийт 1,796.6 тэрбум төгрөгийн төлбөрийн нэхэмжлэл ирүүлснээс дотоод хяналтаар нийт 81.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг хассан байна.

7.1.6 Нийт хасагдлын 87.2 хувийг нь лавлагаа шатлалын тусламж үйлчилгээ, 9.0 хувийг анхан шатны тусламж үйлчилгээ, 1.6 хувийг эмийн хөнгөлөлт, 1.6 хувийг урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн нэхэмжлэх эзэлж байна.

7.1.7 ТЕЗ-ийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар Эрүүл мэндийн даатгалын нэгдсэн цахим системийн тусламж үйлчилгээний өгөгдлийн мэдээлэл нь тусламж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтын газраас ирүүлсэн мэдээллээс 1.2 тэрбум төгрөгөөр зөрүүтэй зөрчил илэрсэн нь ЭМДС-ийн цахим систем health.gov.mn программын хэрэгжүүлж байгаа хяналт хангалтгүй, цаашид системд мэдээлэл технологийн үнэлгээ хийж хяналтын үр нөлөөг сайжруулах шаардлагатай байна.


7.2 Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийн даатгалд хамрагдалт хангалтгүй байгаагаас хувиараа шимтгэл төлөгчдийн тоо дунджаар 8.0 хувиар буурсан, даатгалын сангийн орлогын 55.4 хувийг төрөөс хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилт болон шимтгэлээр бүрдүүлж, улсын төсвөөс хамааралтай хэвээр байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн нийт орлого

7.2.1 Тайлант онд эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 2,299.5 тэрбум төгрөгт хүрч 93.3 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь өмнөх оноос 381.7 тэрбум төгрөгөөр өссөн байна.

7.2.2 Нийгмийн даатгалын ерөнхий газраас ажил олгогч, даатгуулагчийн төлөх шимтгэлийн орлогыг төлөвлөгөөнөөс 163.5 тэрбум төгрөгөөр, бусад даатгуулагчийн шимтгэлийн орлого 5.7 тэрбум төгрөгөөр тус тус дутуу төвлөрүүлсэн байна.

Дүрслэл 8. ЭМДС-ийн орлогын гүйцэтгэл /тэрбум төгрөг/




7.2.3 Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг бүтцээр нь авч үзвэл 977.2 тэрбум төгрөг буюу 42.5 хувийг ажил олгогч даатгуулагчаас төлөх шимтгэл, 352.2 тэрбум төгрөг буюу 15.3 хувийг төр хариуцах иргэдийн шимтгэл, 921.6 тэрбум төгрөг буюу 40.1 хувийг төр хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилт, 44.1 тэрбум төгрөг буюу 1.9 хувийг бусад даатгуулагчаас төлөх шимтгэлийн орлогоос бүрдүүлж байна.

7.2.4 Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын 2023 онд 939.5 тэрбум төгрөг буюу 58.4 хувийг, 2024 онд 1,070.9 тэрбум төгрөг 55.7 хувийг, 2025 онд 1,273.5 тэрбум төгрөг буюу 55.4 хувийг төр хариуцах тусламж

үйлчилгээний санхүүжилт болон төрөөс хариуцах иргэдийн шимтгэлийн орлого бүрдүүлж байгаа нь тус сангийн орлого улсын төсвөөс шууд хамааралтай хэвээр байна.

7.2.5 Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан 2,302,185 даатгуулагч буюу 70.1 хувийг улсын төсвөөс төр хариуцах иргэд, 793,592 даатгуулагч буюу 24.2 хувийг ажил олгогч хариуцан төлөх иргэд, 187,799 даатгуулагч буюу 5.7 хувийг даатгалын шимтгэлийг өөрөө хариуцан төлөх иргэд эзэлж байна.

Дүрслэл 9. Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг өөрөө хариуцан төлөх иргэдийн тоо



7.2.6 Сүүлийн 3 жилд даатгалын шимтгэлийг өөрөө хариуцан төлөх иргэдийн тоо дунджаар 17,333 буюу 8.0 хувиар буурсан байна. Малчид болон хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хэрэгцээ шаардлага үүссэн тохиолдолдоо даатгалын шимтгэлийг нөхөн төлж, эмнэлгийн үйлчилгээг авдаг нь даатгалын сангийн зарцуулалтыг нэмэгдүүлэхэд нөлөөлж байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн нийт зарлага

7.2.7 Эрүүл мэндийн даатгалын сангийн нийт зарлага 2,242.4 тэрбум төгрөгөөр батлагдсанаас 2,241.6 тэрбум төгрөгийг зарцуулж, 99.9 хувийн гүйцэтгэлтэй, өмнөх оны гүйцэтгэлээс 310.3 тэрбум төгрөгөөр өссөн байна.

7.2.8 Төсвийн гүйцэтгэлээр эрүүл мэндийн байгууллагуудад олгох тусламж үйлчилгээний санхүүжилтэд 2,057.4 тэрбум төгрөг, эмийн үнийн хөнгөлөлтөд 171.1 тэрбум төгрөг, үйл ажиллагааны урсгал зардалд 13.2 тэрбум төгрөг, нийт 2,241.6 тэрбум төгрөгийг зарцуулсан.

7.2.9 Тайлант онд МУЗГ, АХБ-тай хамтран хэрэгжүүлсэн “Ковид-19” цар тахлын эсрэг вакцинжуулалтын арга хэмжээг дэмжих “L4068-MON”, “L4069-MON” төслийн хүрээнд 4.6 тэрбум төгрөгийг эрүүл мэндийн даатгалын өр барагдуулахад нэмж зарцуулсан байна.

7.2.10 ЭМДС-ийн эх үүсвэрийн дутагдалтайгаас шатгаалан эрсдэлийн санг төлөвлөж, байгуулаагүй нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2³³-д заасан заалттай нийцээгүй байна.

7.2.11 Эрүүл мэндийн даатгалын сангийн тэнцвэржүүлсэн тэнцлийн 299.5 тэрбум төгрөгийн ашигтай байхаар төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 61.2 тэрбум төгрөгийн ашигтай байна. Энэ нь эргэн төлөгдөх цэвэр зээлийн эх үүсвэрээр Капитал банкнаас авах 77.6 тэрбум төгрөгийн авлагыг төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 3.4 тэрбум төгрөгийг барагдуулж, 74.2 тэрбум төгрөг буюу барагдуулаагүй нь нөлөөлсөн.

³³ Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 “Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн санг эрүүл мэндийн даатгалын сангийн тухайн жилийн орлогын 10 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээгээр байгуулна”

БҮЛЭГ 8. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН ҮЛДЭГДЭЛД ГАДААД ӨРИЙН ЭЗЛЭХ ХУВЬ ӨНДӨР БАЙГАА НЬ ХАНШИЙН АЛДАГДАЛ, ХҮҮГИЙН ЗАРДЛААР ТӨСӨВТ ҮЗҮҮЛЭХ АЧААЛЛЫГ НЭМЭГДҮҮЛЖ БАЙНА.

8.1 Засгийн газрын өрийн үлдэгдэл нь хуульд заасан 60.0 хувийн босго дүнгээс доогуур буюу 39.4 хувьтай, төсвийн тусгай шаардлагыг хангасан боловч гадаад өрийн эзлэх хэмжээ 95.7 хувьд хүрч, ханшийн зөрүүгээс 1,739.9 тэрбум төгрөгийн алдагдал хүлээсэн байна.

8.1.1 Засгийн газрын өрийн нэрлэсэн үнээр илэрхийлсэн үлдэгдэл 2025 оны жилийн эцсийн байдлаар 35,407.7 тэрбум төгрөгт хүрч, ДНБ-ий 39.4 хувийг эзэлсэн нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шалгуур үзүүлэлт болон Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичигт тусгасан зорилтот түвшнийг хангаж байна.

8.1.2 Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичиг, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, Улсын их хурлын 2024 оны 51 дүгээр тогтоол, Өрийн удирдлагын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6³⁴ дахь заалтыг үндэслэн Засгийн газрын 2025 оны 16 дугаар тогтоолоор “Засгийн газрын 2025 оны зээллэгийн төлөвлөгөө”-г баталсан байна.

8.1.3 Засгийн газрын өрийн багцын үзүүлэлтүүдийн харьцаа 2025 оны гүйцэтгэлээр зохистой түвшинд хадгалагдсан боловч нийт өрийн үлдэгдлийн 95.7 хувийг гадаад валютаар илэрхийлсэн өр эзэлж байгаа нь өмнөх оноос 0.2 нэгжээр буурсан бөгөөд стратегийн баримт бичигт тогтоосон 80.0 хувийн зорилтот түвшнээс давсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 32. Засгийн газрын өрийн үлдэгдэл

/тэрбум төгрөг/

ӨРИЙН БҮТЭЦ, ӨРИЙН ХЭРЭГСЭЛ	2021 он	2022 он	2023 он	2024 он	2025 он	Зөрүү	Хувь
I. Засгийн газрын дотоод өр	657.3	1,035.50	234.1	1,200.4	1,373.3	172.9	3.9
1.1 Засгийн газрын үнэт цаас	657.3	1,035.50	234.1	400.5	688.5	288.0	1.9
1.2 Орон нутгийн үнэт цаас				799.9	684.8	(115.1)	1.9
II. Засгийн газрын гадаад өр	24,693.3	29,641.6	30,274.6	32,021.5	33,868.7	1,847.2	95.7
2.1 Засгийн газрын үнэт цаас	8,175.6	9,359.8	9,371.7	8,655.0	8,964.7	309.7	25.3
2.2 Орон нутгийн үнэт цаас				1,724.9	1,828.1	103.2	5.2
2.3 Зээл	16,517.7	20,281.8	20,902.9	21,641.6	23,075.9	1,434.3	65.2
III. Засгийн газрын өрийн баталгаа	876.5	812.9	29.5	178	165.7	(12.3)	0.5
IV. Концесс (“барих-шилжүүлэх”)*	673.9	463.5	230.9	-	-	-	-
V. Орон нутгийн зээллэг	17.2	12.3	4.5	-	-	-	-
5.1 Дотоод өр	17.2	12.3	4.5	-	-	-	-
ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ӨР (I+II+III+IV+V)	26,918.2	31,965.8	30,773.6	33,399.9	35,407.7	2,007.8	100.0
ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ӨҮЦ)	21,837.3	27,691.6	26,582.9				
Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар тогтоосон өрийн хязгаар**	70.0	70.0	65.0	60.0	60.0		
	(ӨҮЦ)	(ӨҮЦ)	(ӨҮЦ)	(НҮ)	(НҮ)		
Засгийн газрын өр / ДНБ	61.8	59.4	43.7	41.8	39.4		
Засгийн газрын өр (ӨҮЦ) / ДНБ	50.1	51.4	37.7	-	-		
Дотоодын нийт бүтээгдэхүүн (оны үнээр)	43,555.0	53,851.0	70,442.0	79,956.3	89,937.1		
ам.долларын эцсийн ханш	2,848.80	3,444.60	3,410.69	3,420.25	3,556.66		

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

8.1.4 Засгийн газрын нийт өрийн үлдэгдлийн 95.7 хувийг гадаад өр, 3.9 хувийг дотоод өр, 0.5 хувийг Засгийн газрын өрийн баталгаа тус тус эзэлж байна.


8.1.5 Засгийн газрын өрийн бүтцэд гадаад өрийн эзлэх хувь хэт өндөр байгаа нь төсөв, санхүүгийн бодлогын бие даасан байдалд сөргөөр нөлөөлөх, валютын ханшийн савлагаанаас

³⁴ 8.1.6. стратегийн баримт бичиг болон зээллэгийн дээд хэмжээнд үндэслэн тухайн төсвийн жилийн зээллэгийн төлөвлөгөөг батлах;

үүдэх эрсдэлийг нэмэгдүүлэх, түүнчлэн гадаад эх үүсвэрээс хэт хамааралтай байдал үүссэнийг харуулж байна.

8.1.6 Өрийн тусгай шаардлагыг нэрлэсэн үнээр тогтоох болсон нь өрийн хэмжээг хуулиар тогтоосон дээд хязгаартай харьцуулах боломжийг бүрдүүлж байгаа боловч эдийн засгийн өсөлт, инфляц болон валютын ханшийн өөрчлөлтөөс шалтгаалсан өрийн бодит ачааллыг бүрэн илэрхийлэхгүй байх эрсдэлтэй. Иймд Засгийн газрын өрийн тогтвортой байдал, эрсдэлийг үнэлэхдээ нэрлэсэн дүнгийн үзүүлэлтээс гадна өрийн ДНБ-д эзлэх харьцаа болон өрийн бүтцийн үзүүлэлтүүдийг хамтад нь авч үзэх шаардлагатай байна.

Дүрслэл 10. Тогтвортой байдлын хязгаар



8.1.7 Засгийн газрын өрийн нэрлэсэн үнээр³⁵ илэрхийлсэн үлдэгдэл ДНБ-ий 39.4 хувьтай тэнцэж байгаа нь Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэлд³⁶ заасан Засгийн газрын өрийн нийт хэмжээнээс 18,554.5 тэрбум төгрөгөөр бага, дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувиас 20.6 хувиар бага, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар тогтоосон

төсвийн тусгай шаардлагыг³⁷ хангасан байна.

8.1.8 Тайлант хугацаанд Засгийн газрын өрийн үйлчилгээний төлбөрт 2,879.9 тэрбум төгрөг төсөвлөснөөс, гүйцэтгэлээр үндсэн төлбөрт³⁸ 1,411.9 тэрбум төгрөг, хүү болон шимтгэлийн төлбөрт 1,249.9 тэрбум төгрөг, нийт 2,661.8 тэрбум төгрөгийг улсын төсвөөс зарцуулсан байна.

Хүснэгт 33. Засгийн газрын 2025 оны өрийн үйлчилгээний үзүүлэлтийн гүйцэтгэл /тэрбум төгрөг/

Д/д	Засгийн газрын өрийн үйлчилгээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		Тайлант онд төлөгдсөн	Зөрүү	Хувь
			Улсын төсвөөс	Өрийн зохицуулалт			
A	B	1	2	3	4	5=1-2	6=2/1
1	Үндсэн төлбөр	1,701.8	1,527.4	1,731.5	15.0	174.4	89.8
1.1	Дотоод үнэт цаас	110.0	-	-	15.0	110.0	-
1.2	Гадаад үнэт цаас	-	-	1,731.5	-	-	-
1.3	Гадаад зээл	1,476.9	1,411.9	-	-	65.0	95.6
1.4	Орон нутгийн үнэт цаас	114.9	115.5	-	-	(0.6)	100.5
2	Хүүгийн төлбөр	1,293.0	1,249.9	-	-	43.0	96.7
2.1	Гадаад зээл	615.1	589.1	-	-	26.0	95.8
2.2	Гадаад үнэт цаас	632.7	625.3	-	-	7.3	98.8
2.3	Дотоод үнэт цаас	45.2	35.5	-	-	9.7	78.5
	Нийт төлбөр	2,994.8	2,777.3	1,731.5	15.0	217.4	92.7

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

³⁵ Монгол Улсын 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хуулийн өөрчлөлтөөр Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлд "Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалтын "өнөөгийн үнэ цэнээр" гэснийг "нэрлэсэн дүнгээр" гэж, мөн зүйлийн 6.5 дахь хэсгийн "нэмэгдүүлэх, 6.4-т заасан хугацааг сунгахыг" гэснийг "нэмэгдүүлэхийг" гэж, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн "2025" гэснийг "2024" гэж, мөн зүйлийн 19.9 дэх хэсгийн "Энэ хуулийн 6.1.2-т" гэснийг "Энэ хуульд" гэж тус тус өөрчилсүгэй";

³⁶ Монгол Улсын хуулийн 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн өөрчлөлтөөр Нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн үзүүлэлтийн 1 дүгээр зүйлийн 8-д "Засгийн газрын өрийн нийт хэмжээ 47,529.4 тэрбум төгрөг, Дотоодын нийт бүтээгдэхүүний эзлэх хувь 60.0 хувь";

³⁷ Монгол Улсын 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хуулийн өөрчлөлтөөр Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4-д "Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрэхгүй байх";

³⁸ Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн 12 дугаар зүйл "Тухайн төсвийн жилд эргэн төлөгдөх нөхцөлтэй гаргасан зээллэг болон өрийн зохицуулалтын арга хэмжээнээс бусад 2025 оны төсвийн жилд төлөх Засгийн газрын өрийн үндсэн төлбөрийн хэмжээ 1,701,789.2 сая төгрөг байна"

8.1.9 Гадаад үнэт цаасны хүүгийн төлбөрт 632.6 тэрбум төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 625.3 тэрбум төгрөг төлсөн байна. Үүнд:

- “Сенчири 2” үнэт цаасны хүүгийн төлбөрт 183.6 тэрбум төгрөг;
- “Сенчири 3” үнэт цаасны хүүгийн төлбөрт 98.2 тэрбум төгрөг;
- “Номад” бондын хүүгийн төлбөрт 58.3 тэрбум төгрөг;
- “Сенчири 27” үнэт цаасны хүүгийн төлбөрт 76.5 тэрбум төгрөг;
- “Сенчири 31” үнэт цаасны хүүгийн төлбөрт 117.5 тэрбум төгрөг;
- “CENTURY-4” бондын хүүгийн төлбөрт 91.2 тэрбум төгрөг;

8.1.10 Дотоод үнэт цаасны хүүгийн төлбөрт 45.2 тэрбум төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 35.5 тэрбум төгрөг, гадаад зээлийн хүүгийн төлбөрт 615.1 тэрбум төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 589.1 тэрбум төгрөг төлсөн байна.

8.1.11 Засгийн газрын өрийн үлдэгдэл нэрлэсэн үнээр 35,407.7 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 2,007.8 тэрбум төгрөг буюу 2.4 хувиар өсөхөд ханшийн зөрүүгийн алдагдлаас 1,739.9 тэрбум төгрөг, дотоод үнэт цаасны цэвэр ашиглалт 284.0 тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хүснэгт 34. Засгийн газрын 2025 оны өрийн үзүүлэлт

/тэрбум төгрөг/


Д/д	Засгийн газрын өрийн хэрэгсэл	Эхний үлдэгдэл /нэрлэсэн үнээр/	Ашиглалт	Эргэн төлөлт	Ханшийн зөрүү	Хүүгийн төлбөр	Хөнгөлөлт, урамшуулал	Хуримтлагдсан хүүгийн зөрүү	Эцсийн үлдэгдэл /нэрлэсэн үнээр/
1	Засгийн газрын дотоод өр	1,200.4	298.7	130.5	0.7	117.8	(2.2)	6.3	1,373.3
1.1	Засгийн газрын үнэт цаас	400.5	298.7	15.0	-	35.5	(2.2)	6.5	688.5
1.2	Орон нутгийн үнэт цаас	799.9	-	115.5	0.7	82.3	-	(0.2)	684.8
2	Засгийн газрын гадаад өр	32,021.5	3,272.6	3,143.4	1,724.7	1,318.8	(44.8)	37.9	33,868.7
2.1	Засгийн газрын үнэт цаас	8,655.0	1,731.5	1,731.5	338.2	625.3	(44.8)	16.2	8,964.7
2.2	Орон нутгийн үнэт цаас	1,724.9	-	-	68.2	104.4	-	35.1	1,828.1
2.3	Зээл	21,641.6	1,541.1	1,411.9	1,318.3	589.1	-	(13.4)	23,075.9
3	Засгийн газрын өрийн баталгаа	178.0	-	26.7	14.5	9.3	-	0.1	165.7
	Нийт	33,399.9	3,571.3	3,300.6	1,739.9	1,445.9	(47.0)	44.3	35,407.7

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

8.1.12 Тайлант хугацаанд төгрөгийн евротой /EUR/ харьцах ханш 619.7 төгрөгөөр, зээлжих тусгай эрхтэй /SDR/ харьцах ханш 416.9 төгрөгөөр тус тус суларсан, экспортын орлого өмнөх оны мөн үеэс 0.1 хувиар буурч, төсвийн орлого нэмэгдсэний үр дүнд 1,739.9 тэрбум төгрөгийн гадаад валютын ханшийн зөрүүний алдагдалтай гарсан.

Дүрслэл 11. Ханшийн алдагдлын статистик

/тэрбум төгрөг/



Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл


8.2 Засгийн газрын түвшинд дотоод эх үүсвэрийн ашиглалт, төлбөр хуваарийн дагуу явагдаж байгаа боловч орон нутгийн зээллэгийн хуулийн нийцэл, үр ашиг, төлөвлөлтийн чанар зэрэг нь тулгамдсан асуудал хэвээр байна.

Засгийн газрын дотоод үнэт цаас

8.2.1 Засгийн газрын нийт өрийн дүнд дотоод үнэт цаасны үлдэгдлийн эзлэх хувь 2020-2023 онд тогтмол буурсан боловч 2025 онд өмнөх оноос 288.0 тэрбум төгрөгөөр өсөж, 688.5 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй болсон нь нэрлэсэн үнээр илэрхийлсэн Засгийн газрын өрийн багцын 1.9 хувийг эзэлж байна.

Дүрслэл 12. Засгийн газрын дотоод үнэт цаасны статистик

/тэрбум төгрөг/



Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

8.2.2 Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдлийн 303.4 тэрбум төгрөг буюу 44.1 хувийг Засгийн газрын санхүүжилтийн хэрэгцээг бага зардлаар, боломжит эрсдэлийн түвшинд хангах зорилгоор Нийгмийн даатгалын сангаас гаргасан үнэт цаас, 97.1 тэрбум төгрөг буюу 14.1 хувийг Монгол Улсын хөгжлийн банкны эзэмшиж байгаа Сайн хувьцаа хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилгоор арилжаалсан үнэт цаас, 133.5 тэрбум төгрөг буюу 19.4 хувийг Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийг дэмжих үнэт цаас, 154.5 тэрбум төгрөг буюу 22.4 хувийг Төсвийн улирлын чанартай орлогын дутагдлыг санхүүжүүлэх зорилгоор хаалттай арилжаалсан үнэт цаас тус тус эзэлж байна.

Хүснэгт 35. Засгийн газрын дотоод үнэт цаас

/тэрбум төгрөг/

Д/д	Үнэт цаасны зориулалт	Эхний үлдэгдэл /нэрлэсэн үнэ /	Шинээр гарсан /ашиглалт/	Урамшуулал, хөнгөлөлт	Эргэн төлөлт	Урамшуулал, хөнгөлөлт	Эцсийн үлдэгдэл /нэрлэсэн үнэ/	Хүүгийн төлбөр
1	Сайн хувьцаа хөтөлбөр	97.1			-		97.1	1.0
2	Төсвийн улирлын чанартай орлогын дутагдлыг санхүүжүүлэх	-	150.0		-		154.5	5.2
3	Нийгмийн даатгалын сан	303.4	-		-		303.4	27.0
4	Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийг дэмжих	-	148.7	(4.2)	15.0	(2.0)	133.5	2.3
Нийт		400.5	298.7	(4.2)	15.0	(2.0)	688.5	35.5

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

8.2.3 Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийн дэмжих зорилгоор Монголын хөрөнгийн биржээр дамжуулан 148.7 тэрбум төгрөгийн үнэт цаасыг нээлттэй хэлбэрээр, төсвийн улирлын чанартай орлогын дутагдлыг санхүүжүүлэх зорилгоор 150.0 тэрбум төгрөгийн үнэт цаасыг хаалттай хэлбэрээр тус тус арилжаалсан байна.

8.2.4 Засгийн газрын дотоод үнэт цаасны богино хугацаат үнэт цаасны дундаж хүү 9.3 хувь, дунд хугацаат үнэт цаасны дундаж хүү 10.8 хувь, урт хугацаат үнэт цаасны дундаж хүү 13.3 хувь байна.

8.2.5 Тайлант жилд нийт 32 удаагийн нээлттэй арилжааг зохион байгуулснаас давхардсан тоогоор 237 хөрөнгө оруулагч оролцож 425 саналыг ирүүлсэн. Засгийн газрын дотоод үнэт цаасны 71.7 хувийг арилжааны банк, 9.9 хувийг даатгалын байгууллага, 18.5 хувийг гадаад дотоодын иргэд, аж ахуйн нэгж эзэмшиж байна.

Орон нутгийн дотоод үнэт цаас

8.2.6 Орон нутгийн дотоод үнэт цаасанд хуримтлагдсан хүү 1.3 тэрбум төгрөг, ханшийн зөрүү 0.7 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, нэрлэсэн үнээр илэрхийлсэн эцсийн үлдэгдэл 684.8 тэрбум төгрөгт хүрч, Засгийн газрын өрийн багцын 1.9 хувийг эзэлж байна.

Хүснэгт 36. Орон нутгийн дотоод үнэт цаасны төрөл

/тэрбум төгрөг/

Үнэт цаасны төрөл	Зориулалт	Гаргасан огноо	Хүүгийн хувь	Эргэн төлөх огноо	Эхний үлдэгдэл	Үндсэн төлбөр	Ханшийн зөрүү	Хуримтлагдсан хүү	Эцсийн үлдэгдэл	Хүүгийн төлбөр
Засгийн газрын 2024 оны 201 дүгээр тогтоол /нээлттэй арилжаалсан/										
Транч 1	Бөөрөлжүүт цахилгаан станц	2024.06.25	14.00	2027.06.25	300.0	-	-	0.8	300.0	42.0
Транч 2	Зам засвар арчилгаа	2024.06.25	13.00	2026.06.25	100.0	-	-	0.2	100.0	13.0
Транч 3	Зам засвар арчилгаа	2024.06.25	12.00	2025.06.25	100.0	100.0	-	-	-	6.0
Засгийн газрын 2024 оны 264 дүгээр тогтоол /хаалттай арилжаалсан/										
Транч 1	Батерей хуримтлуурын төсөл	2024.12.26	7.40	2029.12.26	212.8	11.0	0.5	0.2	202.1	16.5
Транч 2	Батерей хуримтлуурын төсөл	2024.12.26	5.67	2029.12.26	85.5	4.4	0.2	0.1	81.2	5.1
Нийт дүн					798.3	115.4	0.7	1.3	684.8	82.6

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

8.2.7 Монгол банк, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хамтарсан урт хугацаат своп хэлцэл, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн А/791 дугаартай "Хөрөнгө гаргах тухай" захирамжаар Олон улсын санхүүгийн корпорацаас авсан үнэт цаасны эргэн төлөх ханшийг 3,420.92 төгрөгөөр авсан байгаа нь 2024 оны жилийн

эцсийн ханшаас 0.67 төгрөгөөр нэмэгдсэн буюу нийслэлийн дотоод үнэт цаасны ханшийн алдагдлыг 668.4 сая төгрөгт хүргэсэн байна.

8.2.8 Тайлант онд мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс 308.3 тэрбум төгрөг буюу 89.5 хувийг төсөл, арга хэмжээнд ашиглаж, 36.1 тэрбум төгрөг буюу 10.5 хувийг ашиглалтгүй үлдэгдэлтэй хэвээр байна.

8.2.9 Төвлөрүүлсэн хөрөнгийн 43.2 хувийг эхний жилдээ ашиглаж чадалгүй мөнгөн хөрөнгийн үлдэгдэл хэлбэрээр байршуулсан нь төлөвлөлт хангалтгүй байсныг илтгэж, өндөр хүүтэй богино хугацаатай зээллэгийг үр ашиггүй зарцуулсан байна. Мөн бэлтгэл ажил хангагдаагүй төслүүдэд эх үүсвэр хуваарилсан нь Өрийн удирдлагын тухай хуульд заасан "өр үүсгэж бий болгосон хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах" зарчмыг зөрчиж, төсөвт хүүгийн зардлын бодит ачааллыг бий болгож байна.

8.3 Засгийн газар гадаад өрийн дахин санхүүжилтийг амжилттай хийж, зээлжих зэрэглэлээ ахиулсан боловч төслийн бэлтгэл ажил хангагдаагүй, ашиглалт удаашралтай байгаагаас үүдэн ханшийн зөрүү болон ашиглаагүй зээлийн хүүгийн зардалд их хэмжээний алдагдал хүлээж байна.

Засгийн газрын гадаад өр

8.3.1 Засгийн газрын гадаад өрийн үлдэгдэлд 389.7 тэрбум төгрөгийн хуримтлагдсан хүү бүртгэгдсэнээр нэрлэсэн үнээр илэрхийлсэн үлдэгдэл 33,868.7 тэрбум төгрөгт хүрсэн байна.

8.3.2 Төсвийн алдагдлын 83.7 хувийг гадаад төсөл, хөтөлбөрийн зээлээр санхүүжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 71.4 хувийг бүрдүүлсэн байна.

8.3.3 Сүүлийн 7 жилийн хугацаанд Засгийн газрын өрийн 61.8-69.0 хувийг гадаад зээл эзэлж, жил бүр дунджаар 1.2 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

8.3.4 Засгийн газрын гадаад валютаар илэрхийлэгдэж байгаа өрийн багцад ам.доллар 67.7 хувь, иен 8.9 хувь, зээлжих тусгай эрх 14.6 хувь, евро 5.2 хувь, вон 3.5 хувь, динар 0.1 хувийг тус тус эзэлж байгаа бөгөөд тайлант оны эцсийн үлдэгдлийн 1 ам.долларын ханшийг 3,556.66 төгрөгөөр тооцон илэрхийлсэн байна.

Засгийн газрын гадаад үнэт цаас

8.3.5 Засгийн газрын гадаад үнэт цаасны үлдэгдэл үндсэн төлбөрийн 1,731.5 тэрбум төгрөгөөр хасагдаж, ханшийн тэгшитгэлийн зөрүүгээс 338.1 тэрбум төгрөгийн алдагдал хүлээж, хуримтлагдсан хүү 192.0 тэрбум төгрөг, нэрлэсэн үнээр илэрхийлсэн эцсийн үлдэгдэл 8,964.7 тэрбум төгрөгт хүрч Засгийн газрын өрийн багцын 25.3 хувийг эзэлж байна.

8.3.6 Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн Зорилт 2-т "Засгийн газрын гадаад үнэт цаасны төлбөрүүдийг эдийн засаг, дарамт учруулахгүйгээр төлж, дахин санхүүжилтийн эрсдэлийг бууруулна" гэж заасны дагуу 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдөр 1,731.5 тэрбум төгрөгийн 6.625 хувийн хүүтэй "Сенчири-4" үнэт цаасыг олон улсын зах зээл дээр арилжаалж, "Номад" үнэт цаасны төлбөрөөс 1,356.5 тэрбум төгрөгийг, "Сенчири-2" үнэт цаасны төлбөрөөс 374.9 тэрбум төгрөгийг дахин санхүүжүүлсэн байна.

8.3.7 Тайлант хугацаанд өрийн зохицуулалтаас бусад Засгийн газрын өрийн үйлчилгээний төлбөрт нийт 2,661.8 тэрбум төгрөгийг төлснөөс үндсэн төлбөрт 1,411.9 тэрбум төгрөг, хүү болон шимтгэлийн төлбөрт нийт 1,249.9 тэрбум төгрөгийг тус тус төлжээ.

Орон нутгийн гадаад үнэт цаас

8.3.8 Орон нутгийн гадаад үнэт цаас, ханшийн зөрүүгээр 68.2 тэрбум төгрөгийн алдагдал хүлээж, хуримтлагдсан хүү 49.7 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, нэрлэсэн үнээр илэрхийлсэн эцсийн үлдэгдэл 1,828.1 тэрбум төгрөгт хүрч, Засгийн газрын өрийн багцын 5.1 хувийг эзэлж байна.

Хүснэгт 37. Орон нутгийн гадаад үнэт цаасны үлдэгдэл

/тэрбум төгрөг/

Үнэт цаасны төрөл	Зориулалт	Гаргасан огноо	Хүүгийн хувь	Эргэн төлөх огноо	Эхний үлдэгдэл /нэрлэсэн үнээр/	Ханшийн өөрчлөлт	Хуримтлагдсан хүү	Эцсийн үлдэгдэл /нэрлэсэн үнээр/	Хүүгийн төлбөр
Транч 1	Сэлбэ дэд төв төсөл	2024.11.21	7.75	2027.08.21	1,710.1	68.2	49.7	1,828.1	104.4

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

8.3.9 Засгийн газрын 2024 онд “Нийслэлийн гадаад үнэт цаас гаргах, Засгийн газрын өрийн баталгаа гаргах” тухай 265 дугаар тогтоолоор Нийслэлийн Улаанбаатар хотын гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд хэрэгжих Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх зориулалтаар жилийн 7.75 хувийн хүүтэй 33 сарын хугацаатай 500.0 сая ам.долларыг олон улсын зах зээлд арилжаалсан ч зориулалтын дагуу ашиглаагүй, арилжааны банканд хадгаламж хэлбэрээр байршиж байна.

8.3.10 Дээрх санхүүжилтийн эх үүсвэрийг Сэлбэ дэд төвийн төслийн ажил эхлээгүй шалтгаанаар тус үнэт цаасны 500.0 сая ам.доллараас 400.0 сая ам.долларыг 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн /1 ам.долларын ханш 3,416.71 төгрөг/ ханшаар хөрвүүлж 1,329.1 тэрбум төгрөгийг арилжааны 6 банканд 6-24 сарын хугацаатай жилийн 12.5-16.1 хувийн хүүтэй төгрөгийн хадгаламжид, үлдэгдэл 100.0 сая ам долларыг Худалдаа хөгжлийн банканд 24 сарын хугацаатай, жилийн 8.05 хувийн хүүтэй гэрээ байгуулж валютын хадгаламжид тус тус байршуулсан байна.

8.3.11 Тус үнэт цаасны хөрөнгө нийслэлийн төрийн сангийн холбогдох дансанд 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдөр 100.0 сая ам.доллар нь валютаар, 400.0 сая ам.доллар нь төгрөгөөр төвлөрснөөс ханшийн тэгшитгэл хийсэн дүнгээр тооцож 1,710.1 тэрбум төгрөгөөр бүртгэсэн байна.

8.3.12 Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1336 дугаартай захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн шийдвэрээр тус хөрөнгийг арилжааны 6 банканд байршуулж, арилжааны банкны хадгаламжаас 117.4 тэрбум төгрөгийг чөлөөлж, хадгаламжийн хүүгийн орлого 199.5 тэрбум төгрөг төвлөрснөөс Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төсөл хэрэгжүүлэгч нэгжээс ирүүлсэн гүйцэтгэлээр нийт 302.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

8.3.13 Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 25/132 тогтоолоор гадаад үнэт цаасны өрийн үйлчилгээний төлбөрт 330.2 тэрбум төгрөг баталж, ашиглалт хангалтгүй байхад төлбөрийн хуваарийн дагуу 104.4 тэрбум төгрөгийн хүүгийн зардал төлсөн байна.

8.3.14 Жилийн эцэст арилжааны банкнуудад байршуулсан хадгаламжийн хүүгээс 104.4 тэрбум төгрөгөөр хүүгийн төлбөрийг төлсөн боловч ханшийн зөрүүгээр 68.2 тэрбум төгрөгийн алдагдал хүлээж, бондын эх үүсвэрийг ашиглаагүйгээс үнэт цаасны төлөгдөөгүй хуримтлагдсан хүү 49.7 тэрбум төгрөгт хүрсэн байна.

8.3.15 Засгийн газар өрийн баталгаагаар 500.0 сая ам.долларын гадаад үнэт цаас гаргаж, арилжааны банканд байршуулсан нь Монгол Улсын валютын нөөцийг өрөөр нэмэгдүүлсэн байна.

8.3.16 Засгийн газрын 2024 оны 265 дугаар тогтоолын дагуу Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр гаргасан гадаад үнэт цаасны эргэн төлөлт 2027 оны 08 дугаар сард төлөгдөх хуваарьтай. Тус үнэт цаасны хөрөнгөөр хэрэгжүүлсэн Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төслийн явц 17.7 хувьтай байгаа нь төсөл төлөвлөсөн хугацаанд хэрэгжихгүй байх, дахин санхүүжилт хийх эрсдэл бий болох, бондын эргэн төлөлтөд хүндрэл үүсэж, улсын төсөвт дарамт учруулж болзошгүй байна.

8.3.17 Тайлант онд Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/1750 дугаар захирамжийн дагуу хадгаламжийн бүтцэд өөрчлөлт оруулснаас хугацаа нь дууссан Хас банк, Голомт банкны 175.7 тэрбум төгрөг, Капитрон банкнаас чөлөөлсөн 100.0 тэрбум төгрөг, Төрийн банкнаас чөлөөлсөн 24.3 тэрбум төгрөг, нийт 300.0 тэрбум төгрөгийг ХААН банканд 9 сарын хугацаатай, жилийн 14.4 хувийн хүүтэйгээр шилжүүлэн байршуулсан байна.

8.3.18 Хэдийгээр эх үүсвэрийг банкны хадгаламжид байршуулснаар 2025 онд 81.5 тэрбум төгрөгийн санхүүгийн ашигтай ажилласан боловч энэ нь Өрийн удирдлагын тухай хуулийн 6.4.3 болон 6.4.4-т заасан "зээллэгийн хөрөнгийг төслийн бус зориулалтаар ашиглахгүй байх, үр ашигтай захиран зарцуулах" зарчимтай нийцэхгүй байна.

8.3.19 Засгийн газар болон орон нутгийн түвшинд өрийн хэрэгслээр дамжуулан хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэхдээ төслийн бэлтгэл ажлыг бүрэн хангах, ашиглалтын хугацааг оновчтой төлөвлөх замаар ханшийн болон хүүгийн зардлын эрсдэлээс урьдчилан сэргийлэх шаардлагатай байна.

8.3.20 Иймд өрийн хэрэглээг хатуу хяналттай байлгаж, алдагдалтай төсвийн бүтэцтэй зэрэгцэн өр нэмэгдэх явдлыг хязгаарлах бодлого хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Засгийн газрын гадаад зээл

8.3.21 Засгийн газрын гадаад зээлийн үлдэгдэл 1,541.1 тэрбум төгрөгийг ашиглалтаар, хуримтлагдсан хүү 148.0 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэж, үндсэн төлбөрийн 1,411.9 тэрбум төгрөг, ханшийн тэгшитгэлийн зөрүү 1,318.3 тэрбум төгрөгөөр хасагдаж, нэрлэсэн үнээр илэрхийлсэн үлдэгдэл 23,075.9 тэрбум төгрөгт хүрч, Засгийн газрын өрийн багцын 65.2 хувийг эзэлж байна.

Хүснэгт 38. Засгийн газрын гадаад зээлийн үлдэгдэл

/тэрбум төгрөг/

Зээлийн ангилал	Эхний үлдэгдэл	Ашиглалт	Үндсэн төлбөр	Ханшийн зөрүү	Эцсийн үлдэгдэл	Хуримтлагдсан хүү	Эцсийн үлдэгдэл /нэрлэсэн үнэ/	Хүүгийн төлбөр
Төслийн зээл	15,543.7	1,535.7	830.4	(1,022.0)	17,271.1	101.7	17,372.9	383.6
Хөтөлбөрийн зээл	5,936.6	5.4	581.5	(296.3)	5,656.7	46.3	5,703.0	205.5
Дүн	21,480.3	1,541.1	1,411.9	(1,318.3)	22,927.8	148.0	23,075.9	589.1

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

8.3.22 Олон улсын банк санхүүгийн байгууллага, түншлэгч орнуудын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй 75 төсөл, хөтөлбөрийн хүрээнд 2025 онд нийт 1,541.1 тэрбум төгрөгийг авч ашигласнаас төслийн зээлийн ашиглалтад 1,535.7 тэрбум төгрөг, хөтөлбөрийн зээлийн ашиглалтад 5.4 тэрбум төгрөгийг тус тус шинээр ашигласан байна.

8.3.23 Засгийн газар 2025 онд гадаад зээлийн үндсэн төлбөрт 1,411.9 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 589.1 тэрбум төгрөг, нийт 2,001.0 тэрбум төгрөгийг өрийн үйлчилгээний төлбөрт төлсөн байна.

8.3.24 Засгийн газрын нийт гадаад зээлийн 12,156.6 тэрбум төгрөг буюу 52.7 хувийг олон талт гэрээгээр, 10,919.3 тэрбум төгрөг буюу 47.3 хувийг хоёр талт гэрээгээр авсан зээлээр бүрдүүлж байна.

8.3.25 Засгийн газрын гадаад зээлийн ашиглалт 2025 онд 1,541.1 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 871.1 тэрбум төгрөгөөр буурч, гадаад зээлийн эргэн төлөлт 1,411.9 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 178.9 тэрбум төгрөгөөр өссөн байна.

8.3.26 Засгийн газрын гадаад зээлийн ашиглалтын 235.8 тэрбум төгрөг буюу 16.5 хувийг эдийн засагт үр өгөөж багатай нийгмийн салбарт ашигласан. Үүнээс 3.5 хувийг боловсрол, 3.0 хувийг нийгмийн халамж, 2.7 хувийг онцгой байдлын салбарт, 2.7 хувийг засаглалын салбарт, 2.6 хувийг эрүүл мэнд, 1.0 хувийг байгаль орчин аялал зуучлалын салбарт ашигласан байна.

8.3.27 Иймд өрийн менежментийн үр ашгийг сайжруулахын тулд өрийг ирээдүйд эдийн засгийн үр өгөөж бий болгох, бүтээмж нэмэгдүүлэх төслүүдэд чиглүүлэх шаардлагатай байна.

8.3.28 Гадаад зээлийн гэрээ байгуулж, зээлийн эрх нээгдсэн 45 төсөл арга хэмжээний 9,109.5 тэрбум төгрөгийн ашиглаагүй зээлийн үлдэгдэлд, гэрээнд заасны дагуу тайлант онд 37.6 тэрбум төгрөгийн амлалтын хүү, төлбөр хураамжийг төлсөн байна.

8.3.29 Засгийн газраас 2024 онд байгуулсан гэрээний нийт 724.6 сая ам.доллар болон 48.0 сая еврогийн өртөг бүхий гадаад зээлийн 11 төсөл, арга хэмжээний ашиглаж эхлэх хугацааг 2025

онд шилжүүлсэн байна. Эдгээр төслөөс 3 төсөл гэрээнд заасан хугацаандаа ашиглалт эхлүүлээгүй, зээлийн хүүгийн төлбөрт 2.1 тэрбум төгрөгийг төлж улсын төсөвт ачаалал үүсгэсэн байна.

8.3.30 Ашиглалт гараагүй 2019-2023 онд гэрээ байгуулсан, 2024-2033 онд үндсэн төлбөрөө төлж эхлэх, 6 гадаад зээлийн төслийн 54.1 тэрбум төгрөгийн үлдэгдэлд 3.0 тэрбум төгрөгийн хүүгийн зардал төлсөн байна.

Засгийн газрын өрийн баталгаа

8.3.31 Засгийн газрын өрийн баталгааны эхний үлдэгдэл 178.0 тэрбум төгрөг, үндсэн төлбөрт 26.7 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 9.3 тэрбум төгрөг, ханшийн тэгшитгэлийн зөрүүгээр 14.5 тэрбум төгрөгөөр тус тус хасагдаж, эцсийн үлдэгдэл 165.7 тэрбум төгрөг болж, нийт гадаад өрийн 0.6 хувийг эзэлж байна.

8.3.32 "Монгол Улсын Хөгжлийн банк": Монгол Улсын Их хурлын 2023 оны 90 дүгээр тогтоолоор зөвшөөрөл олгосны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 133 дугаар тогтоолоор БНХАУ-ын хөгжлийн банкны 420.0 сая юанийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа "Чойбалсан ДЦС-ыг 50 мвт-аар өргөтгөх төсөл"-ийн санхүүжилтэд 12 жилийн хугацаатай жилийн 5.1 хувийн хүүтэйгээр 196.6 тэрбум төгрөгийн өрийн баталгаа гаргаснаас 165.7 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

8.3.33 Нийслэлийн Засаг даргын Тамгын газар: Тайлант онд шинээр өрийн баталгаа гаргаагүй бөгөөд Монгол Улсын Их хурлын 2024 оны 17 дугаар тогтоолоор зөвшөөрөл олгосны дагуу Засгийн газрын 2024 оны 265 дугаар тогтоолоор "Сэлбэ дэд төвийг орон сууцжуулах төсөл"-ийг санхүүжүүлэх зорилгоор жилийн 7.75 хувийн хүүтэй 33 сарын хугацаатай 500.0 сая ам.долларын гадаад үнэт цаасанд Засгийн газрын өрийн баталгаа гаргасан байна.

БҮЛЭГ 9. ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧДЫН НЭМЭЛТ ТӨСВӨӨР 982.5 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН ОРЛОГО БҮРДҮҮЛЖ, ГҮЙЦЭТГЭЛЭЭР 876.7 ТЭРБУМ ТӨГРӨГ ЗАРЦУУЛСАН БАЙНА.**9.1 Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 318.9 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 23.1 хувиар өссөн байна.**

9.1.1 Төсвийн ерөнхийлөн захирагч нарын нэмэлт төсөв тайланд онд 982.5 тэрбум төгрөг болж өмнөх оноос 15.3 хувиар буурсан байна. Нийт орлогын 63.1 хувь буюу 620.0 тэрбум төгрөгийг улсын төсвийн, 36.9 хувь буюу 362.5 тэрбум төгрөгийг орон нутгийн төсвийн байгууллагууд бүрдүүлжээ.

Хүснэгт 39. Нэмэлт төсвийн эх үүсвэрийг өмнөх онтой харьцуулахад

/тэрбум төгрөг/

Орлогын үзүүлэлт	2024 оны гүйцэтгэл	2025 оны гүйцэтгэл	Үүнээс		Өсөлт	
			УТЕЗ	ОНТЕЗ	Зөрүү	Хувь
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	56.5	66.2	38.9	27.3	9.7	17.2
Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	-	6.0	6.0	-	6.0	100.0
Засгийн газрын болон Засаг даргын нөөц хөрөнгө	354.5	264.1	162.8	101.3	(90.4)	(25.5)
Дээд шатны төсөв захирагчаас доод шатны төсөв захирагчид хуваарилсан хөрөнгө	482.9	320.3	134.6	185.7	(162.6)	933.7)
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	259.1	318.9	270.7	48.2	59.8	23.1
Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	7.1	7.0	7.0	-	(0.1)	(1.4)
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	1,160.1	982.5	620.0	362.5	(177.6)	(15.3)

Эх сурвалж: МУНТГ-ийн 2024, 2025 оны нэмэлт төсвийн тайлан

9.1.2 Дээд шатны төсөв захирагчаас доод шатны төсөв захирагчид хуваарилсан хөрөнгө өмнөх оноос 9.0 хувиар, Засгийн газрын болон Засаг даргын нөөц хөрөнгө 3.7 хувиар тус тус буурч, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 10.2 хувиар нэмэгдсэн байна. Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлоготой холбоотой дараах зөрчил илэрсэн. Тухайлбал:

Аудитын илрүүлэлт:

- **МУЕС:** Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар техник хяналтын зардлын данснаас 50.0 сая төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлэн байгууллагын үндсэн үйл ажиллагаанд зарцуулсан;
- **Булган:** Нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулагдаагүй үлдэгдлээс 2022 оны 8.9 сая төгрөг, 2023 оны 10.7, сая төгрөг, 2024 оны 55.7 сая төгрөг буюу нийт 75.1 сая төгрөгийн орлогыг аймгийн Засаг даргын 2024 оны А/ЗЗ, 2025 оны А/86 тоот захирамжийн дагуу аймгийн төсвийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлээгүй.
- **Говь-Алтай:** Хөхморьт, Дарив сумын Засаг даргын Тамгын газар нэмэлт санхүүжилтийн дансаар 36.2 сая төгрөгийн хандив зөвшөөрөлгүй авч, зарцуулсан;
- **Хөвсгөл:** Нэмэлт санхүүжилтийн дансны орлогыг 64.5 сая төгрөгөөр илүү дүнтэй тайлагнасан.

9.2 Нэмэлт төсвийн зарлага 876.7 тэрбум төгрөг болж өмнөх оноос 24.4 хувиар буюу 283.8 тэрбум төгрөгөөр буурахад Сангийн яамнаас зарцуулалтын эрхийг хязгаарласан нь голлон нөлөөлсөн байна.

9.2.1 Тайлант онд нэмэлт төсвийн зарлага 876.7 тэрбум төгрөг болж өмнөх оноос 24.4 хувиар буюу 283.8 тэрбум төгрөгөөр буурсан. Нэмэлт төсвөөс бараа, ажил, үйлчилгээний зардалд 732.4 тэрбум төгрөг, хөрөнгийн зардалд 86.4 тэрбум төгрөг, татаас 29.1 тэрбум төгрөг, урсгал шилжүүлэгт 24.8 тэрбум төгрөг, хүүгийн зардалд 4.0 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна.

9.2.2 Урсгал шилжүүлгийн зардал өмнөх оноос 252.2 тэрбум төгрөг буюу 91.1 хувь, бараа ажил үйлчилгээний зардал 80.1 тэрбум төгрөг буюу 9.9 хувиар буурсан нь Сангийн яамнаас зарцуулалтын эрхийг хязгаарласан нь голлон нөлөөлсөн байна.

9.2.3 Нэмэлт төсвийн бараа ажил үйлчилгээний зардлын зарцуулалтыг эдийн засгийн бүлгээр авч үзэхэд өдөр тутмын шинж чанартай урсгал зардлуудад голлон зарцуулсан байна. Тухайлбал: Бараа үйлчилгээний бусад зардал 281.0 тэрбум төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 193.6 тэрбум төгрөг, цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 92.7 тэрбум төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал 74.3 тэрбум төгрөг, хангамж, бараа материалын зардал 19.5 тэрбум төгрөг, норматив зардал 15.7 тэрбум төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 3.2 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна.

9.2.4 Мөн нэмэлт санхүүжилтийн данснаас 80.4 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлснээс 56.5 тэрбум төгрөг буюу 70.3 хувийг Сангийн сайдын 2026 оны "Дансны үлдэгдэл буцаан олгох тухай" 47 дугаар тушаалаар 22 улсын төсвийн ерөнхийлөн захирагчдад олгохоор шийдвэрлэж, өглөгөөр бүртгэсэн байна.

9.2.5 Төсвийн ерөнхийлөн захирагч нарын нэмэлт төсвийн зарцуулалттай холбоотой дараах зөрчил илэрсэн байна. Тухайлбал:

Аудитын илрүүлэлт:

- Улаанбаатар хот: СБД-ийн ТТЗ нэмэлт санхүүжилтийн данснаас зориуд нэр данс зөрүү гэх утгаар 172.4 сая төгрөгийн гүйлгээг гаргасан, төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан, өмнөх оны аудитын шийдвэрийг бүрэн биелүүлээгүй;
- ХХААХҮС: Засагийн газрын 2013 оны "Сурагчийн дүрэмт хувцасны үндэсний үйлдвэрлэлийг дэмжих тухай" 250 дугаар тогтоолд 23.0 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 2013 онд багтаан эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр олгох шийдвэр гарсан. Тус тогтоолын хүрээнд зээл авсан компаниудаас шүүхийн шийдвэрээр зээлийн эргэн төлөлтөд орж ирсэн 1.2 тэрбум төгрөгийг ХЭДС-д тооцоо нийлсэн актгүйгээр төвлөрүүлсэн, хамтарсан хяналтын зөвлөл хяналтаа хэрэгжүүлдэггүй, гэрээний үүргийн биелэлт хангалтгүй;
- ГБХНХС: НДЕГ нь ТӨБЗГ-ын шийдвэргүйгээр бэлтгэсэн 15.0 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн. Орхон аймгийн НДГ нэмэлт санхүүжилтийн зардлаас 7.9 сая төгрөгийн бараа материалыг худалдан авалт хийж, шууд зардалд тайлагнасан;
- Баянхонгор: Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа аймаг, сумдын Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтын 30-с доошгүй хувийг "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.1, 2.1.2-д зарцуулах байтал 7.3 хувийг зарцуулсан байгаа нь журмын 3.4-д заасантай нийцэхгүй байна. Мөн нийт зарцуулалтын 34.7 хувийг дээрх журмын 2.1.5 дахь заалтыг үндэслэн зардлыг үрэлгэн байдлаар зарцуулсан;
- Завхан: Алдархаан сумын ЗДТГ, авто замын сан 64.5 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан,
- Цагаанхайрхан ЗДТГ худалдан авах ажиллагаанд 57.0 сая төгрөгийг журам зөрчиж зарцуулсан, Идэр сумын ЗДТГ автозамын засвар арчлалтын ажил хийгдээгүй, Завханмандал ЗДТГ 27.5 сая төгрөгийн нөөцийн өвс тэжээлийг бүртгэлд тусгаагүй;
- Өмнөговь: ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын нэмэлт санхүүжилтийн дансанд санхүүгийн тайлангийн аудитаар нийт 9 байгууллагад 494.8 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 101.9 сая төгрөгийн 1 зөрчилд таслан зогсоох, санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах зөвлөмж өгч, 292.7 сая төгрөгийн зөрчилд давтан гаргахгүй байх 10 албан шаардлага хүргүүлж, 100.1 сая төгрөгийн 4 зөрчилд төлбөрийн акт тогтоосон.


БҮЛЭГ 10. ӨМНӨХ ОНЫ АУДИТААР НИЙТ 29 ЗӨВЛӨМЖ ӨГСНӨӨС 68.5 ХУВИЙН ХЭРЭГЖИЛТТЭЙ БАЙНА.

10.1 Өмнөх оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитаар 7 төсвийн ерөнхийлөн захирагчид, нийт 29 зөвлөмжийг хүргүүлсэн.

10.2 Аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг Сангийн сайдын 2026 оны 01/2088 дугаар, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2026 оны 02/1572 дугаар, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2026 оны 76 дугаар, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын 2026 оны 01/619 дугаар, Монгол Улсын тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2026 оны 01/1530 дугаар, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2026 оны А-1/1037 дугаар албан бичгээр тус тус Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

10.3 Өмнөх оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитаар Ерөнхий сайд 11 зөвлөмж 50.5 хувь, Сангийн сайд 11 зөвлөмж 79.1 хувь, Хяналт үнэлгээний үндэсний хорооны дарга 2 зөвлөмж 50.0 хувь, Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайд 2 зөвлөмж 100.0 хувь, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд 1 зөвлөмж 100.0 хувь, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл 1 зөвлөмж 100.0 хувь, Хяналт үнэлгээний үндэсний хорооны дарга 2 зөвлөмж 50.0 хувь, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 1 зөвлөмж хэрэгжээгүй, нийт 29 зөвлөмж 68.5 хувийн хэрэгжилттэй байна.

Дүрслэл 13. Нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын зөвлөмжийн хэрэгжилт /тоо, хувиар/



10.4 Өмнөх оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжөөс нийт 3 зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс алдаа, зөрчил давтан гарах эрсдэлтэй байна. Үүнд:

Ерөнхий сайдад:

- Төрийн албаны тухай хууль болон Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулан төрийн үйлчилгээний албан тушаалын үндсэн цалингийн дээд хэмжээ хязгаарыг тогтоож, төсвийн сахилга батыг дээшлүүлэх;

Хууль зүй, дотоод хэргийн сайдад:

- Татварын байгууллагаас хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн мөнгө угаасан байж болзошгүй, татварын бүрдүүлэлт ногдуулалттай холбоотой гэмт хэргийн шинжтэй хэргүүдийг шийдвэрлэх ажиллагааны хууль эрх зүйн орчныг сайжруулах;

Монгол Улсын сайд бөгөөд Хяналт үнэлгээний үндэсний хорооны даргад:

- Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын чиг үүргийн хүрээнд тухайн жилийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитаар Төсвийн ерөнхийлөн захирагч нарт өгсөн аудитын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, хэрэгжилтийг нэгтгэн, үр дүнг хянаж, ирүүлэх гэсэн 3 зөвлөмж хэрэгжээгүй байна.

БҮЛЭГ 11. ШИЛЭН ДАНСНЫ НЭГДСЭН ЦАХИМ ХУУДАСНЫ ЗАРИМ МОДУЛЬ ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛЬ БОЛОН ХОЛБОГДОХ ЖУРМЫН ЗОХИЦУУЛАЛТТАЙ УЯЛДААГҮЙ, БАЙГУУЛЛАГУУД МЭДЭЭЛЛЭЭ ХУУЛЬД ЗААСАН ХУГАЦААНД БҮРЭН БАЙРШУУЛААГҮЙ БАЙНА.

11.1 Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны нэр томьёо нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т заасантай нийцэхгүй байна.

11.1.1 Улсын Их Хурлаас 2014 оны 07 дугаар сарын 01-ний өдөр Шилэн дансны тухай хуулийг баталж, 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн бөгөөд Шилэн дансны тухай хуулийн 3³⁹ дугаар зүйлд дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна гэж заасан. Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны байгууллагын төрөл нь хуулийн үйлчлэлд хамаарах төрөлтэй нэр томьёоны хувьд зөрүүтэй байна.

11.1.2 Шилэн дансны нэгдсэн цахим хуудас нь төрийн санхүүгийн мэдээллийг олон нийтэд ил тод, ойлгомжтой хүргэх зорилготой боловч системд ашиглаж буй мэдээллийн нэр томьёо нь хуульд заасан нэршилтэй нийцэхгүй байгаа нь иргэд мэдээллийг ойлгох, ашиглах, хяналт тавих боломжийг хязгаарлаж, Шилэн дансны тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан иргэний хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх нөхцөл бүрдэхгүй байна.

11.1.3 Иймд Шилэн дансны тухай хуулийн 4.1.2⁴⁰ дахь заалтын хэрэгжилтийг хангах хүрээнд цахим системийн зарим голлох мэдээллийн нэр томьёог хуульд заасан нэршилээр нэрлэн төрөлжүүлэх шаардлагатай байна.

11.1.4 Шилэн дансны цахим мэдээллийн нэгдсэн системд Шилэн дансны тухай хуулийн 6⁴¹ дугаар зүйлд заасан нийт 52 төрлийн мэдээлэл байршуулж байгаагаас 21 төрлийн буюу 40.4 хувийн мэдээллийг Сангийн яамны төсөв, санхүүгийн мэдээллийн системүүдээс автоматаар татан байршуулж байна.

11.2 Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2 заасан байгууллагууд мэдээллээ хугацаа хоцроосон, 3.1.3, 3.1.4, 3.1.5-д заасан байгууллагууд мэдээллийн 55.1 хувийг байршуулаагүй байна.

11.2.1 Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулах мэдээллийг давтамжаар нь авч үзэхэд “жил бүр”, “хагас жил бүр”, “улирал бүр”, “сар бүр”, “тухай бүр” мэдээлэхээр байх бөгөөд хэрэгжилт 94.2 хувьтай байна.

11.2.2 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн үнэлгээгээр улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 93.8 хувь, нийслэл болон орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын хэрэгжилт 94.9 хувь байна.

11.2.3 Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байгууллагын 6 төрөлд бүртгэлтэй нийт 6654 байгууллага нь “Төсөв гүйцэтгэл” “Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт”, “Бусад” гэсэн үндсэн 3 цэсэд холбогдох хууль, журамд заасан 52 төрлийн мэдээллийг байршуулсан байдлыг нэгтгэн харуулбал дараах байдалтай байна.

³⁹ Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1. Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна: 3.1.1.төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд; 3.1.2.төрийн өмчит үйлдвэрийн газар; 3.1.3.хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани; 3.1.4.улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага; 3.1.5.төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч; 3.1.6.төрийн санхүүжилт авч байгаа нам, эвсэл.

⁴⁰ Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх;

⁴¹ Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Шилэн дансны мэдээлэл

Хүснэгт 40. Шилэн дансны хөтлөлт, үнэлгээ /байгууллагын төрлөөр/

Хуулийн заалт	Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны байгууллагын төрөл	Байгууллагын тоо	Нийт оруулах мэдээлэл	Оруулсан мэдээлэл	Хугацаа хоцроосон мэдээлэл	Мэдээлээгүй	Хэрэгжилтийн Хувь
3.1.1	Төсвийн байгууллага	4,792	872,768	831,850	19,281	21.637	95.3
3.1.1	Засгийн газрын тусгай сан	185	28,635	25,030	365	3.24	87.4
3.1.1	Олон улсын санхүүжилттэй төсөл хөтөлбөр	76	11,368	8,574	221	2.573	75.4
3.1.1	Бусад улсын бүртгэлд бүртгэлгүй мэдээлэл оруулах нэгж (Төрийн сан дээр данстай)	7	976	829	14	133	84.9
3.1.2	Төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар	411	61,898	56,968	832	4.098	92
3.1.3	Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой компани	304	44,182	39,491	648	4.043	89.4
3.1.4 3.1.5 3.1.6	Аж ахуй нэгж, төрийн бус байгууллага, иргэн	879	5,087	2,286	300	2.501	44.9

Эх сурвалж: Шилэн дансны нэгдсэн цахим системийн өгөгдлийн сан.

11.2.4 Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүртгэлтэй байгууллага шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээлэх ёстой 21661 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

11.2.5 Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, 3.1.4, 3.1.5-д хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч байгууллагуудыг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулна гэж заасан.

11.2.6 Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд аж ахуй нэгж, төрийн бус байгууллага, иргэн улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 10 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий ажил, үйлчилгээ гүйцэтгэсэн талаарх мэдээллийг 879 аж ахуйн нэгж байгууллага, иргэд хуульд заасан 5087 мэдээллээс 2586 мэдээллийг оруулсан ба 300 мэдээллийг хугацаа хоцроож, 2801 мэдээллийг байршуулаагүй байна. Мөн Шилэн дансны тухай хуулийн 3.1.6-д заасан төрийн санхүүжилт авч байгаа нам, эвсэл санхүүжилтийн талаар мэдээлэхгүй байна.

11.2.7 Шилэн дансны тухай хуульд заасан 2,319.3 тэрбум төгрөгийн мэдээллийг хуулийн хугацаа хоцроосон, мэдээлээгүй зөрчлийг арилгах 540 албан шаардлага, 996 зөвлөмж, 36 хариуцлага тооцуулах санал хүргүүлсэн байна.

БҮЛЭГ 12. УЛС ТӨРИЙН НАМУУДАД ОЛГОСОН ТӨРИЙН САНХҮҮЖИЛТИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ЗАРДЛЫН АНГИЛАЛ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ ТОДОРХОЙГҮЙ, ХУУЛЬ, ЖУРМЫН ЗААЛТ УЯЛДААГҮЙ, ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ ЧИГ ҮҮРЭГ ДАВХАРДАЖ БАЙНА.**12.1 Улс төрийн намд төрөөс олгосон санхүүжилтээс нийт 0.19 тэрбум төгрөгийг зориулалт бус зарцуулсан байна.**

12.1.1 СЕХ-ны 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 05 дугаар тогтоолоор төрийн санхүүжилтийн хэмжээг эцэслэн тогтоож, СЕХ-ны даргын 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн А/14, 2025 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн А/32 дугаар захирамжид тус тус үндэслэн улс төрийн 7 намд 7.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Хүснэгт 41. Улс төрийн намд олгосон төрийн санхүүжилт

/тэрбум төгрөг/

№	Намын нэр	Эвсэлд нэгдсэн намуудын нэр	29.9-т заасны дагуу олгосон хэмжээ		
			29.9-т	27.7-т /квот болон ХБИ/	Нийт
А	Б		1	2	3
1	Монгол Ардын нам		2.8	0.0	2.8
2	Ардчилсан нам		2.1	0.0	2.2
3	Хүн нам		0.6	0.4	1.0
4	Иргэний зориг ногоон нам		0.3	0.1	0.5
5	Монголын Ногоон нам	Үндэсний эвсэл	0.2	-	0.2
6	Монголын Үндэсний Ардчилсан нам		0.0	-	0.0
7	Шинэ Нам	"Шинэ Нэгдсэн Эвсэл" (МУНН-ШН)	0.2	0.1	0.3
8	Монголын Уламжлалын Нэгдсэн нам		-	-	-
9	Үнэн ба Зөв нам		-	-	-
Нийт дүн			6.3	0.6	7.0

Эх сурвалж: СЕХ-ний мэдээлэл

12.1.2 Улс төрийн намууд нь төрийн санхүүжилтийг авах хүсэлтийг сонгуулийн төв байгууллагад ирүүлэхдээ хуульд заасан зориулалтаар зарцуулах төсөв, төлөвлөгөөг баталгаажуулж ирүүлдэггүй байна.

12.1.3 Төрийн санхүүжилт авсан 7 улс төрийн нам нь УТНТ хуулийн 26 дугаар зүйлийн 26.3⁴²-т заасан зориулалтаар эмэгтэй, ахмад, залуу, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн бүлгүүдийн улс төрийн оролцоог дэмжих, сургаж бэлтгэхэд 1.3 тэрбум төгрөг буюу 18.1 хувь, Намын гишүүдийн болон иргэдийн улс төрийн боловсролыг дээшлүүлэх, ардчилал, хүний эрхийн үнэт зүйлийг нийтэд таниулахад 1.1 тэрбум төгрөг буюу 15.4 хувь, Намын хөтөлбөр, бодлого боловсруулахад чиглэсэн судалгаа хийх, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, намын дотоод ардчиллыг хөгжүүлэхэд 1.5 тэрбум төгрөг буюу 22.1 хувь, нийт 3.9 тэрбум төгрөг буюу 55.6 хувийг хуульд заасан зориулалтаар зарцуулсан байна.

12.1.4 Төрөөс олгосон санхүүжилтээс нийт 0.19 тэрбум төгрөгийг зориулалтын дагуу зарцуулаагүй зөрчил илэрсэн. Үүнд:

- Анхан шатны баримтгүй 0.09 тэрбум төгрөгийн ажил гүйлгээг бүртгэж, тайлагнасан; /МАН 0.06 тэрбум төгрөг, МУАН 0.01 тэрбум төгрөг, ИЗНН нь 0.01 тэрбум төгрөг, МУАН 0.01 тэрбум төгрөг/
- Төрийн санхүүжилтийн эх үүсвэрээс 0.06 тэрбум төгрөгийг сургалт зохион байгуулах, медиа контент бүтээлгэх зардалд зарцуулахаар гүйцэтгэгч байгууллагад шилжүүлсэн боловч намын дүрмээ шинэчлэн батлуулаагүй шалтгаанаар гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллаагүй; /МНН 0.06 тэрбум төгрөг/
- Бэлэг дурсгал, урлаг соёлын арга хэмжээний дардалд 0.04 тэрбум төгрөгийг зарцуулсан; /ХҮН 0.04 тэрбум төгрөг/.

12.1.5 Улс төрийн намууд төрийн санхүүжилтээс ажиллагсдын цалингийн зардал 2.3 тэрбум төгрөг, түрээсийн төлбөр, ашиглалтын зардал, тээврийн зардал, шуудан холбооны зардал, бичиг хэргийн зардал, төлбөр хураамж, дотоод албан томилолт, хангамжийн материал зэрэгт 0.3 тэрбум төгрөг, зөвлөх үйлчилгээний зардалд 0.1 тэрбум төгрөг, хэвлэл сурталчилгааны зардалд 0.1 тэрбум төгрөг, үндсэн хөрөнгө худалдан авах зардалд 0.1 тэрбум, бусад үйл ажиллагааны зардалд 0.2 тэрбум төгрөг, нийт 3.1 тэрбум төгрөг буюу санхүүжилтийн 44.4

⁴² Намд олгох жил бүрийн төрийн санхүүжилтийн дараах хувийг доор дурдсан зориулалтаар зарцуулна.

хувийг үйл ажиллагааны зардалд зарцуулсан байна. (МАН-1.4 тэрбум төгрөг, ШН-0.1 тэрбум төгрөг, АН-0.8 тэрбум төгрөг, ИЗНН-0.2 тэрбум төгрөг, МНН-0.1 тэрбум төгрөг, ХҮН-0.5 тэрбум төгрөг)

12.1.6 Дээрх 3.1 тэрбум төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулсан нь УТНТ хуулийн 26 дугаар зүйлийн 26.3⁴³, 26.4⁴⁴ дэх хэсэгт заасантай нийцэхгүй байна.

12.2 Сонгуулийн ерөнхий хороо улс төрийн намд олгох төрийн санхүүжилтийг хуульд заасны дагуу зарцуулж, тайлагнасан эсэхийг дүгнээгүй, чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.

12.2.1 СЕХ нь УТНТ хуульд заасны дагуу намын санхүүгийн тайланг баталгаажуулах зорилгоор аудитын хуулийн этгээдээр хараат бусаар дүгнэлт гаргуулах ажлыг зохион байгуулж, 5 аудитын хуулийн этгээдийг сонгон шалгаруулсан байна.

12.2.2 Аудитын хуулийн этгээд нь батлагдсан ажлын даалгаврын хүрээнд төрийн санхүүжилтийн зарцуулалтад горим сорил хэрэгжүүлж, улс төрийн 4 намд зөвлөмж өгч, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар дурдсан боловч төрийн санхүүжилтийн зарцуулалтыг зориулалтын дагуу зарцуулсан эсэх, орлогын эх үүсвэрээр нь зарцуулалтыг ялгаж аудитлаагүй байна.

12.2.3 СЕХ нь Сонгуулийн төв байгууллагын тухай хууль болон УТНТ хуульд заасан чиг үүргийн хүрээнд төрийн санхүүжилт авсан улс төрийн 7 намын 2025 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, үйл ажиллагааны товч тайлан болон 6 намын санхүүгийн тайланд хийсэн хараат бус аудитын хуулийн этгээдийн дүгнэлт, тайланг хянаж нэгтгэсэн боловч тус тайланд төрийн санхүүжилтийн зарцуулалтыг УТНТ хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.1⁴⁵, 26.3.2⁴⁶, 26.3.3⁴⁷, 26.4⁴⁸-т заасан зарцуулбал зохих доод хэмжээнд хүрч зарцуулсан эсэхийг ангилан тайлагнаагүй байна.

12.2.4 Нэр бүхий хоёр нам нь төрийн санхүүжилтийг УТНТ хуулийн 26.3.1-д “төрийн санхүүжилтийн 20-оос доошгүй хувийг эмэгтэй, ахмад, залуу, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн бүлгүүдийн улс төрийн оролцоог дэмжих, сургаж бэлтгэх”, 26.3.2-т “төрийн санхүүжилтийн 15-аас доошгүй хувийг намын гишүүдийн болон иргэдийн улс төрийн боловсролыг дээшлүүлэх, ардчилал, хүний эрхийн үнэт зүйлийг нийтэд таниулах” гэж заасны дагуу зарцуулбал зохих доод хязгаарт хүргээгүй, 0.16 тэрбум төгрөгийг дутуу зарцуулсныг хараат бус аудитын хуулийн этгээд болон СЕХ хянаж дүгнээгүй байна. /АН 0.13 тэрбум төгрөг, ИЗНН /0.03 тэрбум төгрөг/

12.2.5 Шилэн дансны тухай хууль, УТНТ хууль, СЕХ-ны 2024 оны 209 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Намд төрийн санхүүжилт олгох, шууд бус дэмжлэгийг шийдвэрлэх, намын санхүү болон үйл ажиллагааг тайлагнах, мэдээлэх, хяналт тавих журам”-д улс төрийн нам санхүүгийн тайлан, үйл ажиллагааны товч тайлан зэрэг нийтэд ил тод мэдээлэх мэдээллийн талаар зохицуулалтыг заасан боловч улс төрийн намууд санхүүжилтийн төсөвт өртөг, зарлага, санхүүжилтийн мэдээлэл, тайланг шилэн дансанд мэдээлээгүй, цахим системд бүртгэлгүй байна.

12.2.6 Иймд СЕХ төрийн санхүүжилтийн зарцуулалтад хяналтыг сайжруулах, улс төрийн намуудыг шилэн дансны цахим хуудас хөтлүүлж, ил тод мэдээлэх зэрэг хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах шаардлагатай байна.

⁴³ Намд олгох жил бүрийн төрийн санхүүжилтийн дараах хувийг доор дурдсан зориулалтаар зарцуулна;

⁴⁴ Энэ хуулийн 26.3.1, 26.3.2, 26.3.3-т заасан зорилтот санхүүжилт тус бүрийн гуравны нэгээс доошгүйг намын бодлогын судалгааны байгууллагын үйл ажиллагаанд зарцуулна;

⁴⁵ Төрийн санхүүжилтийн 20-оос доошгүй хувийг эмэгтэй, ахмад, залуу, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн бүлгүүдийн улс төрийн оролцоог дэмжих, сургаж бэлтгэх;

⁴⁶ Төрийн санхүүжилтийн 15-аас доошгүй хувийг намын гишүүдийн болон иргэдийн улс төрийн боловсролыг дээшлүүлэх, ардчилал, хүний эрхийн үнэт зүйлийг нийтэд таниулах;

⁴⁷ Төрийн санхүүжилтийн 15-аас доошгүй хувийг намын хөтөлбөр, бодлого боловсруулахад чиглэсэн судалгаа хийх, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, намын дотоод ардчиллыг хөгжүүлэх;

⁴⁸ Энэ хуулийн 26.3.1, 26.3.2, 26.3.3-т заасан зорилтот санхүүжилт тус бүрийн гуравны нэгээс доошгүйг намын бодлогын судалгааны байгууллагын үйл ажиллагаанд зарцуулна.

12.3 Сонгуулийн ерөнхий хорооны хяналтын шалгуур үзүүлэлт тодорхойгүй, авч хэрэгжүүлсэн арга хэмжээг үнэлэх боломжгүй байна.

12.3.1 СЕХ нь УТНТ хуульд заасны дагуу намуудын 2025 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, үйл ажиллагааны товч тайлан болон мэдээллийн ил тод байдлыг хэрэгжилтийг хянан “Улс төрийн намын тухай хууль”, “Улс төрийн намын санхүүгийн тайлангийн бүтэц, тайлагнах журам”, “Намд төрийн санхүүжилт олгох, шууд бус дэмжлэгийг шийдвэрлэх, намын санхүү болон үйл ажиллагааг тайлагнах, мэдээлэх, хяналт тавих журам”-ын зарим заалтын хэрэгжилтийг хангалтгүй гэж дүгнэсэн байна.

12.3.2 Төрийн санхүүжилтийн зарцуулалт, түүний тайлагналыг хянах шалгуур үзүүлэлт тодорхойгүй, хуулийг дагаж мөрдөх журам, заавар, хуулийн нийцэл уялдаагүй, ойлголтын зөрүүтэй, төрийн санхүүжилтийг бусад эх үүсвэрээс тусад нь салгаж тайлагнуулаагүй зэрэг цаашид засаж залруулах зөрчилтэй асуудлууд байна.

12.3.3 УТНТ хуульд улс төрийн намын санхүүгийн тайланд хараат бус аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулах, Сонгуулийн ерөнхий хорооноос тайланг хүлээн авч хянах, Төрийн аудитын байгууллагаас төрийн санхүүжилтийн зарцуулалт, тайлагналд дүгнэлт гаргах чиг үүргийг тус тусдаа байхаар хуульчилсан нь хяналт, шалгалтын чиг үүргийн давхардал үүсгэх нөхцөлийг бүрдүүлж байна.

12.3.4 УТНТ хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3⁴⁹, 39 дүгээр зүйлийн 39.4⁵⁰, 39.5⁵¹ дахь хэсгүүдэд Төрийн аудитын байгууллагын аудитын хамрах хүрээ, дүгнэлт гаргах болон тайлагнах хугацааг өөр өөр байдлаар хуульчилсан нь төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргах төрийн аудитын байгууллагын эрх, үүрэг, хариуцлагын хүрээг тодорхой бус болгож байна.

БҮЛЭГ 13. НЭГДСЭН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

13.1 Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн хүрээнд зарим төрлийн зардлын төлөвлөлт, гүйцэтгэлийг үнэлэх зорилгоор улс, орон нутгийн төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдээс түүврийн аргаар тоон болон чанарын мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийсэн.

13.2 Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн, салбарын бодлогын хэрэгжилтэд оруулах гүйцэтгэлийн гол үзүүлэлт (KPI) тодорхойлогдоогүй, хүрсэн түвшин, гаргасан зардлын үр өгөөж, гүйцэтгэсэн ажлын өртөг тооцох тогтолцоо байхгүйгээс төсвийг зарцуулахдаа арвилан хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах соёл төлөвшихгүй, төсөв тэлэх байдлаар ажиллаж байна. Тухайлбал: Урсгал зардалд хийсэн түүвэр судалгаагаар ТЕЗ-ийн дэргэдэх 24 хороо, зөвлөл, ажлын албадын гүйцэтгэлийн зардалд 17.5 тэрбум төгрөг, хоол, унааны зардалд 698.8 тэрбум төгрөг, 4367 гадаад албан томилолтын арга хэмжээнд 74.3 тэрбум төгрөг, 16206 сургалт, семинар, хурал, зөвлөгөөн түүнтэй адилтгах арга хэмжээнд 61.0 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан боловч төрийн бодлогын зорилтод оруулсан хувь нэмэр, иргэдийн амьдралд гарсан эерэг өөрчлөлтийг үнэлэх боломж хязгаарлагдмал байна.

Ажлын алба, хороо, зөвлөлийн талаар:

13.3 ТЕЗ-ийн дэргэдэх 24 хороо, зөвлөл, ажлын албадын 2025 оны нийт гүйцэтгэлийн зардал 17,539.3 сая төгрөгт хүрсэн бөгөөд үүний 55.7 хувийг цалин, урамшууллын зардал, 19.8 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал эзэлж байна. Мөн батлагдсан төсөвгүй хоёр хороо, зөвлөлд нийт 463.9 сая төгрөгийн зардал гарсан нь төсвийн төлөвлөлт, санхүүгийн хяналтыг сайжруулж, төрийн байгууллагуудын чиг үүрэгт давхардал байгаа эсэхийг хянах замаар төсвийг хэмнэх боломжтой байна.

⁴⁹ Төрийн аудитын байгууллага нь сонгуулийн төв байгууллагын төсвийн багцад туссан намд олгох төрийн санхүүжилт, түүний зарцуулалт, тайлагналд Төсвийн тухай хуульд заасан цаглаврын дагуу аудит хийж, дүгнэлт гаргана;

⁵⁰ Энэ хуульд заасны дагуу намын санхүүгийн тайланг сонгуулийн төв байгууллага хүлээн авч хянаад жил бүрийн 04 дүгээр сарын 05-ны өдрийн дотор Төрийн аудитын байгууллагад дүгнэлт гаргуулахаар хүргүүлнэ;

⁵¹ Төрийн аудитын байгууллага төрөөс намд олгосон санхүүжилт, гүйцэтгэлд гаргасан дүгнэлтийг жил бүрийн төсвийн гүйцэтгэлийн тайланд тусган тайлагнана.

Гадаад албан томилолтын зардлын талаар:

13.4 Улс, орон нутгийн 53 төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа 445 байгууллага 5,169 гадаад албан томилолтын арга хэмжээнд 97.5 тэрбум төгрөг баталж, гүйцэтгэлээр 4,367 арга хэмжээнд 74.3 тэрбум төгрөг буюу 76.2 хувийг зарцуулсан байна. Гадаад албан томилолт, арга хэмжээнд 14 ТЕЗ-ын харьяа 19 байгууллага тушаал, шийдвэргүйгээр 0.6 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

Хэвлэл мэдээллийн зардлын талаар:

13.5 Улс, орон нутгийн 54 төсвийн ерөнхийлөн захирагчийн 411 байгууллагыг хамруулан хэвлэл, мэдээллийн байгууллагаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардалд судалгаа хийхэд нийт 22.3 тэрбум төгрөг зарцуулсан боловч төрийн бодлогын зорилтод оруулсан хувь нэмэр, хэрлэгчдийн мэдлэг, ойлголтын түвшин нэмэгдсэн эсэхийг үнэлэх боломж хязгаарлагдмал, байгууллагын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй 1187 арга хэмжээг 14.2 тэрбум төгрөгөөр санхүүжүүлсэн байна.

Унаа, хоолны хөнгөлөлтийн талаар:

13.6 Судалгаанд улсын болон орон нутгийн 54 төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа 4138 байгууллага, унаа, хоолны хөнгөлөлтөд 583.5 тэрбум төгрөгийн төсөв баталж, гүйцэтгэлээр 698.8 тэрбум төгрөг зарцуулсан.

13.7 Судалгаанд хамрагдсан байгууллагын 26.4 хувь буюу 1093 байгууллага нь унаа, хоолны хөнгөлөлт олгосон, 73.6 хувь буюу 3045 байгууллага унааны зардал олгоогүй, хоолны хөнгөлөлт олгосон байна. Нэг хүнд ногдох 1 өдрийн хоолны хөнгөлөлтийн тариф 690-54,500 төгрөг, унааны тариф 400-27,350 төгрөгийн хооронд хэлбэлзэж байна. Унаа, хоолны хөнгөлөлт олголт нь төсвийн төлөвлөлттэй бүрэн уялдаагүй, зарим байгууллага хоолны хөнгөлөлтийг дангаар олгож, унааны зардлыг олгодоггүй байна.

13.8 Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Засгийн газрын тогтоол зэрэг суурь зохицуулалтаар зөвшөөрсөн хэдий ч үнэ тариф тогтоох тодорхой аргачлал, жишиг хязгаар тогтоогоогүй байна. Үүний улмаас байгууллагууд өөрсдийн дотоод журам, тушаал, шийдвэрээр тариф тогтоож байгаа нь мөнгөн дүнгийн хэлбэлзэл өндөр, байгууллага бүр харилцан адилгүй, цаашид зардал өсөх магадлалтай байна.

Сургалт, семинар, хурал зөвлөгөөний зардлын талаар:

13.9 Судалгаанд улсын болон орон нутгийн 55 төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа 2041 байгууллага 18101 сургалт, семинар, хурал, зөвлөгөөн түүнтэй адилтгах арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, 77.5 тэрбум төгрөгийн төсөв баталж, гүйцэтгэлээр 16206 арга хэмжээг хэрэгжүүлж, 61.0 тэрбум төгрөг зарцуулсан байна. Эрх бүхий этгээдээс баталсан тушаал, шийдвэргүй 0.9 тэрбум төгрөгийн зардал гаргасан байна.

13.10 Судалгааны үр дүнгээс үзэхэд зарим байгууллага цөөн тооны сургалт, арга хэмжээнд өндөр хэмжээний зардал зарцуулсан бол зарим байгууллага олон тооны сургалт, арга хэмжээг харьцангуй бага өртгөөр хэрэгжүүлсэн байна.

13.11 Арга хэмжээний тоон үзүүлэлтээс гадна нэг хүн болон нэг арга хэмжээнд ногдох зардал, хамрах хүрээ, хүрсэн үр дүн, зорилтот бүлгийн хамрагдалт зэрэг үзүүлэлтээр үр ашигт байдлыг үнэлэх тогтолцоо байхгүйгээс энэ хэмжээний зардал зарцуулаад бий болгосон бүтээмж нь тодорхойгүй байна.

Бүтэц, орон тооны цомхотголын талаар:

13.12 Улс, орон нутгийн 52 төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа 2345 байгууллагыг хамруулан судалгаа хийж үзэхэд төрийн албан хаагчдын тоог 9.0 хувиар бууруулах бодлого, чиглэлийг хэрэгжүүлснээр 4874 орон тоог бууруулснаас 221 буюу 4.5 хувь нь удирдах, 2893 буюу 59.4 хувь нь гүйцэтгэх, 1760 буюу 36.1 хувь нь төрийн үйлчилгээний албан тушаалд хамаарч байна. Бууруулсан орон тооны 95.0 хувь нь гүйцэтгэх болон үйлчилгээний албан тушаалд ногдож байгаа нь бодлогын арга хэмжээний гол үр нөлөө төрийн байгууллагын хэрэгжүүлэгч түвшинд төвлөрсөн болохыг харуулж байна.

ДҮГНЭЛТ

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитын тайлангийн дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна. Үүнд:

- Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангаар нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 30,303.1 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 31,331.0 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1,027.9 тэрбум төгрөгийн алдагдалтай байна;
- Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн суурь тэнцэл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагыг хангаагүй, тухайн жилийн төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах бүрд төсвийн хүрээний мэдэгдлийг өөрчилж байгаа нь дүнд хугацааны төсвийн төлөвлөлтийн ач холбогдлыг бууруулж, төсвийн тогтвортой байдлын зарчмыг алдагдуулж байна;
- Монгол Улсын 2025 оны төсвийн төслийг дахин боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулахдаа төсвийн бодлогыг шинэчлэн боловсруулаагүй, үр дүнг нэгтгээгүй, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд батлагдсан төсөл, арга хэмжээний 53.7 хувийг төсөвт тусгаагүй байна;
- Нэгдсэн төсвийн орлого 33,179.2 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 5.5 хувиар өссөн боловч төлөвлөгөө 2.7 хувиар тасарсан, эрдэс, баялгийн бүтээгдэхүүний экспортоос хамааралтай орлогод суурилсан төсвийн урсгал зарлагын тэлэлт эдийн засгийн эмзэг байдлыг нэмэгдүүлж, төсвийн бодлого хэрэгжүүлэх орон зайг хязгаарласаар байна;
- Стратегийн болон үүсмэл ордуудын хайгуул хийж, нөөц тогтоосон хэлбэрийг судалж, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлэх бодлогыг баримтлах, Ирээдүйн өв сангийн тухай хуульд заасан сангийн хөрөнгийг мандатын дагуу удирдах корпорац, түүний хараат бус байдал, олон нийтийн оролцоо, хяналтыг олон улсын жишгийн дагуу төлөвшүүлэх, засаглалын тогтолцоо үгүйлэгдэж байна;
- Төсвийн орлого тасарсан, тайлант онд хэрэгжсэн зарим хөтөлбөр, арга хэмжээний санхүүжилтийг бүрэн олгоогүйгээс дараа оны төсөвт ачаалал үүсгэж, төлөвлөгдсөн төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжихгүй байх эрсдэлийг бий болгож байна;
- Улсын хөгжлийн бодлогын баримт бичигт төсвийн төлөвлөлтийг үр дүнд чиглүүлэхээр хуулиар зохицуулсан боловч тухайн жилийн төсвийн тухай хуулиар хөтөлбөр, арга хэмжээг зардалтай уялдуулан батлаагүй, суурь түвшин, шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг оновчтой тодорхойлоогүй, хэмжигдэхүйц бус төлөвлөснөөс хэрэгжилтийг үнэлэх, үр дүнд суурилсан төлөвлөлтөд шилжих боломжийг хязгаарлаж байна;
- Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.7, 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэгт заасны дагуу Сангийн сайдын баталсан Төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсөвт зохицуулалт хийх, зарцуулалтад хяналт тавих журмууд уялдахгүй байгаагаас төсөвт төлөвлөөгүй, үр ашиггүй зардал гарах, төсвийн сахилга бат алдагдах нөхцөлийг бүрдүүлж байна;
- Гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр олон жил үргэлжилсэн, гэрээний хугацаа сунгасан төслүүд хэрэгжилт удааширнаас төслийн үр өгөөж буурах, нэмэлт зардал гарах, төслийн үр дүнд бий болсон хөрөнгийн ашиглалт буурах, эзэнгүйдэх эрсдэлтэй байна;
- Орон нутгийн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийг ИТХ төсвийн хүрээний мэдэгдлээр баталсан хязгаараас нийт 3,782.2 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан нь орон нутгийн төсвийг батлах, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд төсвийн нэгдмэл байдал, хяналтын зарчмыг алдагдуулж байна;
- Нийгмийн даатгалын сан нь 40752 аж ахуйн нэгж, байгууллагаас авах 590.4 тэрбум төгрөгийн НДШ-ийн авлагыг барагдуулаагүй байгаа нь сангийн чөлөөт мөнгөн хөрөнгийг

арвижуулах замаар санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулж, өгөөж хүртэх боломжийг алдаж байна;

- Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн даатгалын хамрагдалт хангалтгүй, дунджаар 8.0 хувиар буурсан, сангийн орлогын 55.4 хувийг төрөөс хариуцах иргэдийн шимтгэлийн орлого бүрдүүлж, эрүүл мэндийн даатгалын сан улсын төсвөөс шууд хамааралтай хэвээр байна;
- Засгийн газрын нийт өрийн 95.7 хувийг гадаад өр эзэлж байгаа нь Засгийн газрын өрийн удирдлагын стратегийн баримт бичигт заасан дунд хугацааны зорилтот бүтцийг хангахгүй, зээлийн үр ашиг бууруулах, өрийн үйлчилгээний төлбөр, ханшийн зөрүүгээс алдагдал хүлээх байдлаар төсөв, гадаад валютын нөөцөд дарамт үзүүлж байна;
- Гадаад зээлийн гэрээнд заасны дагуу 45 төсөл, арга хэмжээний 9,109.5 тэрбум төгрөгийн ашиглаагүй зээлийн үлдэгдэлд 37.6 тэрбум төгрөгийн амлалтын хүү, төлбөр хураамжийг төлж, тухайн жилийн өрийн үйлчилгээний зардлыг нэмэгдүүлж, төсөвт ачаалал үүсгэсэн байна;
- Засгийн газрын өрийн баталгаа гаргаж, нийслэлийн богино хугацаатай, гадаад үнэт цаасаар санхүүжүүлсэн төслийн ашиглалт хангалтгүй байгаагаас төсөл төлөвлөсөн хугацаанд хэрэгжихгүй байх, дахин санхүүжилт хийх эрсдэл бий болох, бондын эргэн төлөлтөд хүндрэл үүсэж болзошгүй байна;
- Өмнөх оны Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 29 зөвлөмж хүргүүлснээс бүрэн хэрэгжүүлсэн 14, хэрэгжих шатандаа 5, хэрэгжилт хангалтгүй 7, хэрэгжээгүй 3 буюу 68.5 хувийн хэрэгжилттэй байна;
- Шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээлэл байршуулах байгууллагын хэрэгжилт дунджаар 94.2 хувьтай байна. Шилэн дансны нэгдсэн цахим хуудас болон холбогдох хууль, журмын нэр томъёо зөрүүтэй уялдаа холбоо хангагдаагүй, хуулийг хэрэгжүүлэх шилэн дансны нэгдсэн цахим хуудасны мэдээлэл байршуулах үйл ажиллагаанд тавих дотоод хяналтын тогтолцоог сайжруулах шаардлагатай байна.

Улс төрийн намд олгох төрийн санхүүжилт түүний зарцуулалтад хийсэн аудитаар дараах дүгнэлтийг өгч байна. Үүнд:

- Улс төрийн нэр бүхий 7 намд 7.0 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосны 0.19 тэрбум төгрөгийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна;
- Сонгуулийн ерөнхий хороо нь улс төрийн намд олгосон төрийн санхүүжилтийг хуульд заасны дагуу зарцуулсан эсэхэд хяналт тавих чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна;
- Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.11 дэх хэсэгт нийцүүлэн улс төрийн намуудад шилэн дансны нэгдсэн цахим хуудас хөтлүүлж, ил тод мэдээлэх хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байна.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛД ТОЛИЛУУЛАХ НЬ:

1. Засгийн газраас тайлагнасан Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 30,303.1 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 31,331.0 тэрбум төгрөгийн гүйцэтгэлийг аудитаар баталгаажууллаа;
2. Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн суурь тэнцэл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагыг хангаагүй, тайлант жилийн Төсвийн тухай хуулийг батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах бүрдээ төсвийн хүрээний мэдэгдлийг өөрчилдөг байдал давтагдсаар байгаад анхаарал хандуулах;
3. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн тусгай шаардлагыг бүрэн хангаж, нэгдсэн төсвийн суурь тэнцлийн зорилтот үзүүлэлтийг алдагдуулахгүй, орон нутгийн төсвийг алдагдалгүй батлах эрх зүйн орчин бүрдүүлэх.

ЗӨВЛӨМЖ**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД-д:**

1. Стратегийн болон үүсмэл ордуудын хайгуул хийж, нөөц тогтоосон хэлбэрийг судалж, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлэх бодлого баримталж, Ирээдүйн өв сангийн тухай хуульд заасан сангийн хөрөнгийг мандатын дагуу удирдах корпорац, хөрөнгийн менежмент, хараат бус байдал, олон нийтийн оролцоог хангаж, засаглалын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэх;
2. Урсгал зардлыг нэмэгдүүлэх гэнэтийн шийдвэрийг хязгаарлаж, төлөвлөсөн хөтөлбөр, арга хэмжээг хүрэх үр дүн, чанарыг бууруулахгүйгээр илүү үр ашигтай, оновчтой хувилбараар зохион байгуулж, хэрэгжүүлэх;
3. Засгийн газраас гэрээ байгуулсан гадаад зээлийг эрэмбэлж, ашиглалтыг сайжруулах талаар арга хэмжээ авч ажиллах;
4. Монгол Улсын Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар харьяа дотоод аудитын нэгжээр нэгдсэн төлөвлөгөө гаргуулж, нотлох баримтад үндэслэн биелэлтийг хугацаанд нь гаргуулан Үндэсний аудитын газарт ирүүлэх.

МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД-д:

1. Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хадгалах, бодит секторыг чиглэсэн, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжсэн, мөчлөг сөрсөн төсвийн болон татварын бодлого хэрэгжүүлэх;
2. Төрийн бодлогын хэрэгжилтийг үнэлэх гүйцэтгэлийн гол үзүүлэлтүүд (KPI)-ийг салбар бүрээр тодорхойлж, байгууллага бүрийн бодлогын хэрэгжилтийг хангуулах төсөл, хөтөлбөр, арга хэмжээний өртгийг тооцох, төсвийн төлөвлөлттэй уялдуулах тогтолцоо бий болгох төлөвлөгөө хэрэгжүүлж үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөвлөлт хийх тогтолцоог төлөвшүүлэх.

САНГИЙН САЙД-д:

1. Улсын Хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгасан улсын төсвөөс санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд тухайн жилийн төсвийн бодлогыг чиглүүлэн төлөвлөж, хэрэгжилт, үр дүнг нэгтгэн, хяналт үнэлгээ хийлгэж, төсвийн гүйцэтгэлийн тайланд тусган, тайлагнаж байх;
2. Төсвийн орлогыг төлөвлөхдөө макро эдийн засгийн суурь нөхцөл, гол нэр төрлийн эрдэс баялгийн түүхий эдийн үнийн савлагааны эрсдэлийг тодорхой хувилбаруудаар тооцоолж, эрсдэлийн удирдлагатай уялдуулан төлөвлөх;
3. Төсвийн сахилга батыг сайжруулах хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсөвт хийсэн зохицуулалтад хяналт тавьж, давтамж ихтэй зардалд дүн шинжилгээ хийж, төсөвт зохицуулалт хийх журмыг зарцуулалтад хяналт тавих журамтай уялдуулан шинэчлэн сайжруулах;

4. Гадаад зээлийн хөрөнгийг эдийн засгийн үр өгөөж бий болох төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглүүлж, гэрээний үүргийн хэрэгжилтийг хангаж, төслийн үр дүнд бий болсон хөрөнгийн ашиглалтыг сайжруулах;
5. Засгийн газрын өрийн удирдлагын стратегийн баримт бичигт заасан дунд хугацааны зорилтод нийцүүлэн, гадаад болон дотоод өрийн бүтцийг сайжруулж, валютын ханшийн алдагдлаас төсөвт учрах дарамтыг бууруулах;
6. Шилэн дансны тухай хууль, журам, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ашиглагдаж буй байгууллагын төрөл, нэршлийг уялдуулах, цахим хуудасны хэрэглэгчдэд мэдээллийг ойлгомжтой байдлаар ашиглах боломжийг бүрдүүлэх, ил тод байдлыг хангах, мэдээлэл байршуулах эрх бүхий албан тушаалтанд сургалт зохион байгуулах, арга зүйгээр хангах, хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4, 3.1.5, 3.1.6 дахь заалтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД БӨГӨӨД НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА-д:

1. Нийгмийн даатгалын сангийн НДШ-ийн авлагын насжилтын судалгааг гаргаж, үе шаттайгаар барагдуулах арга хэмжээг зохион байгуулж, сангийн чөлөөт мөнгөн хөрөнгийг нэмэгдүүлэх.

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД БӨГӨӨД ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА-д:

1. Малчид болон хувиараа хөдөлмөр эрхлэгчийн даатгалын шимтгэлийг сар бүр тогтмол төвлөрүүлж байхад чиглэсэн бодлогын арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ НАРТ:

1. Улсын хөгжлийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигтэй ТЕЗ-ийн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хөтөлбөрийн хүрэх үр дүнг уялдуулан боловсруулж, суурь болон зорилтот түвшин, шалгуурыг оновчтой тодорхойлж үр дүнг бодитой тайлагнах.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИД:

1. Гадаад үнэт цаасны хөрөнгөөр санхүүжүүлж буй төслийн ашиглалтыг эрчимжүүлж, зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах арга хэмжээг авч, дахиж санхүүжилт хийх эрсдэлийг бууруулах.

СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНД:

1. Улс төрийн намын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3, 26.4-т заасан улс төрийн намд олгож байгаа санхүүжилтийг зарцуулах хувь, зардлын ангилал, шалгуур үзүүлэлт, бүртгэл тайлагналыг тодорхой болгох ажлыг зохион байгуулах, холбогдох журам, маягыг хуульд нийцүүлэх;
2. Улс төрийн намд олгосон санхүүжилтийг анхан шатны баримт, цахим төлбөрийн баримтад үндэслэн хуульд заасан зориулалтаар зарцуулах, бүртгэл, тайланд бүрэн тусгах;
3. Төрийн санхүүжилт авч байгаа нам, эвслийн шилэн дансны нэгдсэн цахим хуудас хөтлүүлэх, ил тод мэдээлүүлэх ажлыг зохион байгуулж, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах.

МОНГОЛ УЛСЫН 2025 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТААР ТОГТООСОН ТӨЛБӨРИЙН АКТ, ӨГСӨН АЛБАН ШААРДЛАГЫН ЖАГСААЛТ

д/д	Хариуцах байгууллага, албан тушаалтан	Зөрчлийн утга	Зөрчлийн дүн /сая төгрөг/	Гаргасан шийдэл
1	Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга	Гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлсэн олон жил үргэлжлэн, гэрээний хугацаа сунгаж, хэрэгжилт удааширснаас төслийн үр өгөөж буурах, нэмэлт зардал гарах, төслийн үр дүнд бий болсон хөрөнгийн ашиглалт буурах, эзэнгүйдэх эрсдэлтэй байна. Тухайлбал: Азийн хөгжлийн банкны Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замын хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл-2: Төслийн санхүүжилтээр худалдан авсан техник хэрэгсэл, хүнд механизм, замын үзлэгийн тоног төхөөрөмж зэрэг 7,952,063,804.00 /Долоон тэрбум есөн зуун тавин хоёр сая жаран гурван мянга найман зуун дөрөв/ төгрөгийн хөрөнгийг ашиглагч байгууллагуудад хүлээлгэн өгсөн ч эрх бүхий байгууллагад хандан ашиглагч байгууллагад шилжүүлээгүй байна.	7,952.1	Албан шаардлага
2	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	Хөдөө аж ахуйг дэмжих сангийн /хуучин нэрээр/ зээлийн эргэн төлөлтийг 13,619,221,000.00 /Арван гурван тэрбум зургаан зуун арван есөн сая хоёр зуун хорин нэгэн мянга/ төгрөгөөр төлөвлөснөөс 10,047,048,915.00 /Арван тэрбум дөчин долоон сая дөчин найман мянга есөн зуун арван тав/ төгрөгийн дутуу гүйцэтгэлтэй байна. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр "Хөдөө аж ахуйн бага оврын трактор худалдан авах", "Газар тариалангийн зориулалттай зарим техник, тоног төхөөрөмж худалдан авах", "Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих" төслүүдийн хүрээнд хөдөө аж ахуйн техник, усалгааны тоног төхөөрөмж худалдан авсан байна. Төрөөс баримталж байгаа бодлого, валютын ханшийн алдагдал үүссэн зэргээс шалтгаалж дээрх тоног төхөөрөмжийн зээлийн эргэн төлөлт хангалтгүй байна. Үүнд: - Засгийн газрын 2020 оны "Газар тариалангийн тогтвортой хөгжлийг дэмжих зарим ар хэмжээний тухай" 138 дугаар тогтоолоор зээлийн хөрөнгөөр нийлүүлсэн техник, тоног төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулах хүрээнд 27,536,001,265.00 /Хорин долоон тэрбум таван зуун гучин зургаан сая нэг мянга хоёр зуун жаран тав/ төгрөгийг хөнгөлсөн; - Засгийн газрын 2017 оны "Агаарын хэт халалт, хуурайшилттай холбогдуулан авах зарим арга хэмжээний" 205 дугаар тогтоолоор ой, хээрийн түймрийн нөхцөл байдал хүндэрсэнтэй холбогдуулан Онцгой байдлын ерөнхий газарт 4,949,069,195.00 /Дөрвөн тэрбум есөн зуун дөчин есөн сая жаран есөн мянга нэг зуун ерэн тав/ төгрөгийн тракторыг шилжүүлсэн; - Сангийн яам, Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны /хуучнаар/ хооронд 2013 оны 4 дүгээр сарын 11-ний өдөр, 2020 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн ам.доллаароор байгуулсан "Дамжуулан зээлийн гэрээ"-г төгрөгт шилжүүлсэнтэй холбогдуулан валютын ханшийн зөрүүнд 43,709,466,480.00 /Дөчин гурван тэрбум долоон зуун есөн сая дөрвөн зуун жаран зургаан мянга дөрвөн зуун ная/ төгрөгийн алдагдал гарсныг эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлээгүй байна.	76,194.5	Албан шаардлага
3	Хууль зүй, дотоод хэргийн сайд	Гааль, Татварын байгууллагаас хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн мөнгө угаасан байж болзошгүй, татварын бүрдүүлэлт, ногдуулалттай холбоотой гэмт хэргийн шинжтэй хэргүүдийг шийдвэрлэх ажиллагааны хууль эрх зүйн орчныг сайжруулах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, тайлант онд дээрх байгууллагуудаас 443 зөрчлийн танилцуулга хүргүүлснээс 101 зөрчлийг хүлээн авч, холбогдох мөрдөн шалгах ажиллагааг явуулсан байна.	-	Албан шаардлага
4	Сангийн сайд	Нэгдсэн төсвийн нийт орлогыг бодитой, үндэслэлтэй төлөвлөөгүй, хэт өндөр төсөөлснөөс татварын орлого тасарч, татвар төлөгчдөөс 1,247,893,617,963.68 (Нэг их наяд хоёр зуун дөчин долоон тэрбум найман зуун ерэн гурван сая зургаан зуун арван долоон мянга есөн зуун жаран гурван төгрөг жаран найман мөнгө)-ний татвар хураамжийг урьдчилан төлүүлж, тайлант оны гүйцэтгэлээр бүртгэж, тайлагнасан нь дараа оны төсвийн орлогын бүрдүүлэлтэд хүндрэл үүсгэхээр байна.	1,247,893.6	Албан шаардлага
5	Сангийн сайд, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга	Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн татварын бус орлогын төлөвлөгөөнд төрийн өмчит хуулийн этгээдүүдийн ашигт ажиллагаанаас нийт 100,000,000,000.00 /Нэг зуун тэрбум/ төгрөгийг төвлөрүүлэхээр төлөвлөсөн боловч 21,791,072,400.00 /Хорин нэгэн тэрбум долоон зуун ерэн нэгэн сая далан хоёр мянга дөрвөн зуун/ төгрөгийн орлогын эх үүсвэр тодорхойгүй, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 312 дугаар тогтоолоор 78,208,927,600.00 /Далан найман тэрбум хоёр зуун найман сая есөн зуун хорин долоон мянга зургаан зуун/ төгрөгийг 31 хуулийн этгээдээс бүрдүүлэхээр баталж, нэр бүхий 9 хуулийн этгээд 15,623,976,146.92 /Арван таван тэрбум зургаан зуун хорин гурван сая есөн зуун далан зургаан мянга нэг зуун дөчин зургаан төгрөг ерэн хоёр мөнгө/ ийг дутуу төвлөрүүлжээ.	15,624.0	Албан шаардлага
6	Орхон аймгийн засаг дарга	Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд заасан улсын төсөвт төвлөрүүлэх орлогоос Орхон аймаг 83,420,298,160.00 /Наян гурван тэрбум дөрвөн зуун хорин сая хоёр зуун ерэн найман мянга нэг зуун жаран/ төгрөгийг дутуу төвлөрүүлсэн байна.	83,420.3	Албан шаардлага

7	Дорноговь аймгийн Засаг дарга	Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд заасан улсын төсөвт төвлөрүүлэх орлогоос Дорноговь аймаг 9,751,843,640.00 /Есөн тэрбум долоон зуун тавин нэгэн сая найман зуун дөчин гурван мянга зургаан зуун дөчин/ төгрөгийг дутуу төвлөрүүлсэн байна.	9,751.8	Албан шаардлага
8	Өмнөговь аймгийн Засаг дарга	Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд заасан улсын төсөвт төвлөрүүлэх орлогоос Өмнөговь аймаг 419,918,456,260.00 /Дөрвөн зуун арван есөн тэрбум есөн зуун арван найман сая дөрвөн зуун тавин зургаан мянга хоёр зуун жаран/ төгрөгийг дутуу төвлөрүүлсэн байна.	419,918.5	Албан шаардлага
9	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/ ТАХ-ний "Байгаль хамгаалагч, цаг уурын мэдээлэл авах ажилтны мотоцикл" багцын хүрээнд бэлтгэн нийлүүлж хуваарилсан 310 ширхэг мотоциклын тоо ширхэг, үнийн дүн зөрүүтэй, арлын дугаар давхардсан, тээврийн хэрэгслийн улсын бүртгэлд бүртгэгдсэн эсэхийг хянахад 927.5 сая төгрөгийн 240 ширхэг мотоциклийг ашиглагч байгууллагын эзэмшилд бүртгээгүй.	927.5	Албан шаардлага
10	Зам тээврийн яам	ЗТС-ын багцын 45.0 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй Увс нуур-Улаангом чиглэлийн хатуу хучилттай авто замын эхний үе шат, 26.39 км /Увс/ ТАХ-ний зураг төслийг боловсруулахдаа 980.7 мянган м2 ул хөрс нягтруулах ажлын тоо хэмжээг давхардуулан тооцсоноос 468.6 сая төгрөгийг илүү төлөвлөсөн.	267.8	Албан шаардлага
11	Сангийн яам	"Гашуунсухайт боомтын салбар лабораторийн барилгын тоноглол, хэрэгсэл" ТАХ болон "Гашуунсухайт боомтын салбар лабораторийн зориулалтыг өөрчлөх магадлалын дагуу засварын ажил" ТАХ-г хэрэгжүүлэхдээ ажлын даалгаварт давхардуулан тусгаснаас 97.1 сая төгрөгийн тоног төхөөрөмж илүү бэлтгэсэн, 74.0 сая төгрөгийн зарим тоног төхөөрөмжийг биетээр хүлээн аваагүй боловч хүлээн авснаар актыг баталгаажуулж санхүүжилтийг бүрэн олгосон; "Төсөл, арга хэмжээний бэлтгэл хангах хөрөнгө оруулалт /Бүсүүд/" барилга байгууламж ангиллын төсөл, арга хэмжээний хүрээнд нийт 18 багцаас 11 багц ажлыг хэрэгжүүлэхдээ батлагдсан ангиллаас өөр зориулалтаар тоног төхөөрөмжийн төсөл, арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлсэн; Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг журам, аргачлалын дагуу үнэлж эрэмбэлээгүй, үнэлгээ бодитой бус, үндэслэлгүй, барилга байгууламж, их засварын 438.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 89 ТАХ төсөвлөлтийн шаардлага хангаагүй, 2025 оноос эхлэн хэрэгжих 34 ТАХ-ний санхүүжилтийг хэрэгжих хугацаанд тэнцүү хуваарилж төлөвлөөгүй.	3,992.9	Албан шаардлага
12	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам	Аймгийн хөгжимт драмын театрын тоног төхөөрөмж /Архангай, Эрдэнэбулган/ ТАХ-ний хүрээнд урсгал зардлаас санхүүжүүлэх 77.0 сая төгрөгийн хангамжийн материал бэлтгэн нийлүүлсэн, худалдан авсан 2,873.7 сая төгрөгийн 5288 ширхэг тоног төхөөрөмж, тавилга, хөрөнгө материал ашиглалтгүй; Орон нутгийн музейн соёлын өвийн тоног төхөөрөмж /Говь-Алтай, Есөнбулаг/ ТАХ-ний хүрээнд урсгал зардалд санхүүжүүлэх 85.7 сая төгрөгийн 18 нэр төрлийн бараа материал, хангамжийн зүйлсийг худалдаж авсан, музейд нийлүүлсэн зарим техник, тоног төхөөрөмжийн чанар, ашиглалтын байдал хангалтгүй, техникийн тодорхойлолт зөрүүтэй, 5.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 52 ширхэг хөрөнгийг хүлээн авсан ч зарим өмч хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгахдаа үнийн дүнг зөрүүтэй бүртгэсэн.	2,964.6	Албан шаардлага
13	Төрийн худалдан авах ажиллагааны газар	Төрийн худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулсан 127,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 тендер шалгаруулалтын үнэлгээний хороо нь тендерийг хянан үзэх, үнэлэх чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүйгээс тендер шалгаруулалтын баримт бичигт заасан зарим шаардлагыг хангаагүй оролцогчийг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулсан.	127,000.0	Албан шаардлага
14	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам	Барилгын материалын сорилт шинжилгээний түргэвчилсэн лабораторийн тоног төхөөрөмж (Дорноговь, Замын-Үүд сум/ ТАХ-ний хүрээнд 2024 оны 12 дугаар сар, 2025 оны 6 болон 12 дугаар саруудад 15,945.0 сая төгрөгийн лабораторийн тоног төхөөрөмжийг тус тус хүлээж авсан боловч ашиглаагүй, лабораторийн үйл ажиллагааг эхлүүлээгүй, тоног төхөөрөмж угсарч суурилуулах зардал, ажиллуулах сургалтын зардалд 260.4 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон ч тэдгээрийн өртөг зардлын нарийвчилсан тооцоололгүй, зарцуулалт тодорхойгүй.	16,205.4	Албан шаардлага
15	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам	Хэнтий аймгийн Хэрлэн сумын цэвэр, бохир ус, дулааны шугам сүлжээнд холбох зорилгоор 2021 оноос эхлэн нийт 135.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 4 төсөл, арга хэмжээг 8 багцад задлан хэрэгжүүлснээс 61.2 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй 4 багц төсөл, арга хэмжээг 2024, 2025 онуудад ашиглалтад хүлээн авч санхүүжилтийг бүрэн олгосон боловч туршилт тохируулга хийгдээгүй, ашиглаж эхлээгүй, айл өрх, хэрэглэгчид холбоогүй, зураг төслийн алдааг бүрэн залруулаагүй, зарим ажлууд нь зураг төслийн дагуу хийгдээгүй, барилгын норм, дүрмийн шаардлагад нийцээгүй; Магадлалаар баталгаажсан зураг төсөвгүй "Ундны усны эх үүсвэрийн 1 дүгээр талбайн эхний ээлжийн ашиглалтын худаг, барилга байгууламжийн төсөл" болон -"Хэлтгий цагаан нуур сэргээх, бохирдолт, ширгэлтээс хамгаалах судалгаа, төсөл" ТАХ-ний өртгийг батлагдсан төсвийн жишиг норм дүрэмд тулгуурлаж тооцоогүй, өртгийн тооцоолол үндэслэлгүй; "Шинэ Хархорум хотын унд ахуйн зориулалттай ундны усны эх үүсвэрийн 1 дүгээр талбайн эхний ээлжийн ашиглалтын худаг, барилга байгууламжийн төсөл" ТАХ-ний гүйцэтгэлийг хянаж баталгаажуулахдаа 6 худгийн өрөмдлөг, тоноглолын ажил болон ажлын зураг хийгдээгүй байхад баталгаажуулснаас 1,443.7 сая төгрөгийн санхүүжилт илүү олгосон; "Авто машингүй гудамж-авто зогсоолын техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улаанбаатар/" ТАХ-ний эхлэлийн тайланд авто замын бус барилгын мэргэжлийн байгууллагаар хяналт хийлгэсэн, захиалагчийн хяналт хэрэгжүүлээгүй байхад 17.8 сая төгрөгийн захиалагчийн хяналтын зардал олгосон; "Авто машингүй гудамж-авто зогсоолын техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улаанбаатар/", "Явган хүн, энгийн болон цахилгаан хөдөлгүүрт дугуйн зам, байгууламжийн техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улаанбаатар/" ТАХ-ний гэрээг шинэчлэн байгуулахдаа ТЭЗҮ, судалгааны ажлын хүрээнд хийж гүйцэтгэх ажилбар бүрийг тусгай нөхцөлд нарийвчлан тодорхой тусгаагүй, тухайн ажлын чанар, үе шат, гүйцэтгэлд тавигдах шаардлагыг тусгаагүй.	135,237.4	Албан шаардлага

16	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/ ТАХ-ний 5 багц ажлын 96.6 сая төгрөгийн чанарын баталгааг байршуулаагүй; "Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын тоног төхөөрөмж" /Улсын хэмжээнд/ төсөл, арга хэмжээний багцын хүрээнд 0.8 тэрбум төгрөгийн 1101 ширхэг хөлдөөгч худалдан авч цэцэрлэг, сургууль зэрэг байгууллагуудад тараан олгосон ч бүртгэл, хяналт хангалтгүй, 2.0 тэрбум төгрөгийн 1118 ширхэг оёдлын машин бэлтгэн нийлүүлж, иргэдэд хамтран ажиллах гэрээ байгуулан тараан олгосон ч бүртгэл, хуваарилалт, хяналт хангалтгүй, ашиглах нөхцөл, үнэ өртгийг зргэн төлөх хугацаа, нөхцөлийг гэрээнд тодорхой тусгаагүй.	2,874.3	Албан шаардлага
17	Эдийн засаг, хөгжлийн яам	ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах 8,308.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 19 ТАХ-ний төсөвт өртгийн нарийвчилсан тооцоолол тухайн яаманд байхгүйгээс үндэслэлтэй тооцсон эсэх нь тодорхойгүй, ТЭЗ, агентлаг болон орон нутгаас санал ирүүлсэн ТАХ-ний өртгийн тооцооллыг авч хянахгүйгээр ирүүлсэн саналын дүнгээр төсөвт өртгийг баталсан, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуульчилсан сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг 200.0 сая төгрөгөөр төлөвлөж санхүүжүүлсэн, Ханги боомтын техник, эдийн засгийн үндэслэл, өргөтгөл, шинэчлэлийн ажлын зураг, төсвийг гүйцэтгүүлж 2024 онд магадлалаар баталгаажуулсан байхад 2025 онд "Ханги боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө" /Дорноговь, Хатанбулаг сум/ боловсруулах ажлыг давхардуулан төлөвлөж 645.0 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан, өмнөх аудитаар техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах ажлын даалгаварт тавигдах шаардлага, хүлээн авах шалгуур, төсөвт өртгийг тооцох жишиг үнийг тогтоож мөрдүүлэх зөвлөмж өгсөн ч хэрэгжилт хангалтгүй.	9,153.2	Албан шаардлага
18	Эрүүл мэндийн яам	Техникийн тодорхойлолтыг боловсруулж батлуулахдаа хугацаа алдаж худалдан авах ажиллагааг оройтож эхлүүлснээс шалтгаалан Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/, Хавдрын эмнэлгийн зориулалтаар ашиглах тоног төхөөрөмж /Улаанбаатар/ ТАХ-ний багцын зарим ажлууд гэрээ байгуулж амжаагүйгээс 44,178.3 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн багц ажлууд төсвийн хэмнэлтэд тооцогдсон; Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/ ТАХ-ний Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын тоног төхөөрөмж багцын худалдан авах ажиллагаанаас үүссэн тендерийн хэмнэлтийг зарцуулж 69.7 сая төгрөгөөр авто машин болон компьютер худалдан авсан.	44,248.0	Албан шаардлага
19	Боловсролын яам	Сургуулийн барилга, 960 суудал /Увс, Улаангом сум, 1 дүгээр сургууль/ ТАХ-ний магадалшгүй ажлын зардлаас санхүүжилт олгохдоо төсөвт тусгагдсан боловч хийгдээгүй худдаасан шалны ажлын төсвийн зөрүү 44.9 сая төгрөгийн санхүүжилтийг илүү олгосон.	44.9	Төлбөрийн акт
20	Эрүүл мэндийн яам	Сэргээн засах эмнэлгийн барилга, 40 ор /Өмнөговь, Даланзадгад сум, 6 дугаар баг/ гадна ханыг металл фасад болгон өөрчилж гүйцэтгүүлэхдээ 1811.2 м2 өнгөлгөөний металл хавтангийн үнийг гүйцэтгэгчийн худалдан авсан үнээс илүү дүнгээр баталгаажуулж 116.1 сая төгрөгийн санхүүжилт илүү олгосон.	166.1	Төлбөрийн акт
НИЙТ ДҮН			2,203,836.7	

Хавсралт 1.

Нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл

/тэрбум төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	Нэгдсэн		Улсын		О Нутаг		ЭМДС		НДС		ҮБС	
	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	34,116.8	33,179.2	20,224.1	19,550.5	8,453.2	7,672.1	2,464.3	2,299.5	6,908.1	6,684.4	1,956.2	2,313.6
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	429.1	562.5	429.1	562.5	-	-	-	-	-	-	-	-
ИРЭЭДҮЙН ӨВ САН	1,394.1	1,710.6	-	-	-	-	-	-	-	-	1,394.1	1,710.6
ХУРИМТЛАЛЫН САН	562.1	603.0	-	-	-	-	-	-	-	-	562.1	603.0
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	31,731.5	30,303.1	19,795.0	18,988.0	8,453.2	7,672.1	2,464.3	2,299.5	6,908.1	6,684.4	-	-
1 Татварын орлого	29,241.6	27,213.0	16,499.6	15,612.1	6,761.5	5,977.7	2,464.3	2,299.5	5,455.6	5,231.9	-	-
1.1. Орлогын албан татвар	9,371.0	8,560.3	3,835.6	3,771.1	5,535.4	4,789.2	-	-	-	-	-	-
1.1.1. Хувь хүний орлогын албан татвар	3,124.9	2,987.5	-	-	3,124.9	2,987.5	-	-	-	-	-	-
1.1.2. Аж, ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар	6,338.3	5,665.0	3,835.6	3,771.1	2,502.7	1,893.9	-	-	-	-	-	-
1.1.3. Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татвар	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
1.1.4. Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(92.2)	(92.2)	-	-	(92.2)	(92.2)	-	-	-	-	-	-
1.2. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	5,980.5	5,623.3	-	-	-	-	2,464.3	2,299.5	5,455.6	5,231.9	-	-
1.3. Хөрөнгийн албан татвар	593.8	609.8	-	-	593.8	609.8	-	-	-	-	-	-
1.4. Нэмэгдсэн өртгийн албан татвар	6,646.8	6,207.3	6,646.8	6,207.3	-	-	-	-	-	-	-	-
1.5. Онцгой албан татвар	1,254.5	949.0	1,254.5	949.0	-	-	-	-	-	-	-	-
1.6. Тусгай зориулалтын орлого	31.5	25.5	31.5	25.5	-	-	-	-	-	-	-	-
1.7. Гадаад үйл ажиллагааны орлого	2,114.0	1,842.2	2,114.0	1,842.2	-	-	-	-	-	-	-	-
1.8. Бусад татвар (төлбөр, хураамж)	3,249.5	3,395.6	2,617.2	2,816.9	632.3	578.7	-	-	-	-	-	-
2 Татварын бус орлого	2,489.9	3,090.1	3,295.4	3,375.9	1,691.7	1,694.4	-	-	1,452.5	1,452.5	-	-
2.1. Нийтлэг татварын бус орлого	2,048.6	2,734.6	1,070.8	1,745.3	977.8	989.3	-	-	-	-	-	-
2.2. Хөрөнгийн орлого	9.0	9.9	-	-	9.0	9.9	-	-	-	-	-	-
2.3. Тусламжийн орлого	432.3	345.6	421.1	340.2	15.3	10.3	-	-	1,452.5	1,452.5	-	-
2.4. Төсөв хоорондын шилжүүлэг	-	-	1,803.5	1,290.4	689.6	684.9	-	-	-	-	-	-

Хавсралт 2.

Нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэл

/тэрбум төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	Нэгдсэн		Улсын		О Нутаг		ЭМДС		НДС		ҮБС	
	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	35,363.4	31,331.0	22,564.3	20,414.3	10,721.1	8,172.4	2,164.8	2,238.3	5,802.2	5,846.9	-	-
А. УРСГАЛ ЗАРЛАГА	25,970.8	24,237.7	17,983.9	16,706.7	5,764.1	4,781.7	2,242.4	2,241.7	5,869.5	5,848.5	-	-
1 Бараа, үйлчилгээний зардал	11,218.9	10,124.8	8,920.0	8,194.8	2,942.5	2,543.5	13.1	12.7	1.4	0.9	-	-
1.1. Цалин, хөлс	6,473.6	6,229.1	5,662.1	5,482.1	802.6	738.3	8.9	8.7	-	-	-	-
1.2. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	-	-	555.0	535.5	102.0	90.5	1.1	1.1	-	-	-	-
1.3. Бараа, үйлчилгээний бусад зардал	4,745.3	3,895.7	2,702.9	2,177.2	2,037.9	1,714.7	3.1	2.9	1.4	0.9	-	-
2 Хүү	1,633.8	1,548.2	1,293.0	1,208.9	340.8	339.3	-	-	-	-	-	-
3 Татаас ба урсгал шилжүүлэг	13,118.1	12,564.7	7,770.9	7,303.0	2,480.8	1,898.9	2,229.3	2,229.0	5,868.1	5,847.6	-	-
3.1. Татаас	1,005.3	799.6	2,027.3	1,826.2	430.4	425.9	-	-	-	-	-	-
3.2. Урсгал шилжүүлэг	12,112.8	11,765.1	5,743.6	5,476.8	2,050.4	1,473.0	2,229.3	2,229.0	5,868.1	5,847.6	-	-
Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9,553.6	7,074.1	4,707.4	3,759.9	4,846.2	3,314.2	-	-	-	-	-	-
1 Барилга байгууламж	6,862.4	5,158.2	3,937.1	3,087.3	2,925.3	2,070.9	-	-	-	-	-	-
2 Их засвар	521.9	381.2	119.8	110.4	402.1	270.8	-	-	-	-	-	-
3 Хөрөнгийн бусад зардал	2,169.3	1,534.7	650.5	562.2	1,518.8	972.5	-	-	-	-	-	-
5 Төсвөөс эргэн төлөгдөх хөрөнгө оруулалт	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
В. ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ	(161.0)	19.2	(127.0)	(52.3)	110.8	76.5	(77.6)	(3.4)	(67.3)	(1.6)	-	-
1 Эргэж төлөгдөх дотоод цэвэр зээл	(369.8)	(186.7)	(335.8)	(258.2)	110.8	76.5	(77.6)	(3.4)	(67.3)	(1.6)	-	-
2 Эргэж төлөгдөх гадаад цэвэр зээл	208.8	205.9	208.8	205.9	-	-	-	-	-	-	-	-

Хавсралт 3.

Нэгдсэн төсвийн тэнцэл

/тэрбум төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	Нэгдсэн		Улсын		О Нутаг		ЭМДС		НДС		ҮБС	
	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	34,116.8	33,179.2	20,224.1	19,550.5	8,453.2	7,672.1	2,464.3	2,299.5	6,908.1	6,684.4	1,956.2	2,313.6
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	429.1	562.5	429.1	562.5	-	-	-	-	-	-	-	-
ИРЭЭДҮЙН ӨВ САН	1,394.1	1,710.6	-	-	-	-	-	-	-	-	1,394.1	1,710.6
ХУРИМТЛАЛЫН САН	562.1	603.0	-	-	-	-	-	-	-	-	562.1	603.0
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	31,731.5	30,303.1	19,795.0	18,988.0	8,453.2	7,672.1	2,464.3	2,299.5	6,908.1	6,684.4	-	-
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	35,363.4	31,331.0	22,564.3	20,414.3	10,721.1	8,172.4	2,164.8	2,238.3	5,802.2	5,846.9	-	-
СУУРЬ ТЭНЦЭЛ		1,113.9										
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	(3,631.9)	(1,027.9)	(2,769.3)	(1,426.3)	(2,267.9)	(500.3)	299.5	61.2	1,105.9	837.5	-	-
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛСЭН ЭХ ҮҮСВЭР:	3,631.9	1,027.9	2,769.3	1,426.3	2,267.9	500.3	(299.5)	(61.2)	(1,105.9)	(837.5)	-	-
1. Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	3,324.2	39.9	2,513.8	1,053.4	2,215.7	(114.8)	(299.5)	(61.2)	(1,105.9)	(837.5)	-	-
3. ЗГ-ын бонд	190.0	891.4	190.0	280.2	-	611.1	-	-	-	-	-	-
3.1. Урт хугацаат	190.0	891.4	190.0	280.2	-	611.1	-	-	-	-	-	-
3.1.1. Дотоод	190.0	588.5	190.0	280.2	-	308.3	-	-	-	-	-	-
3.1.1.1. Шинээр гаргах	300.0	602.8	300.0	294.5	-	308.3	-	-	-	-	-	-
3.1.1.2. Үндсэн төлбөр	(110.0)	(14.3)	(110.0)	(14.3)	-	-	-	-	-	-	-	-
3.1..2. Гадаад	-	302.9	-	-	-	302.9	-	-	-	-	-	-
3.1.2.1. Шинээр гаргах	-	2,034.4	-	1,731.5	-	302.9	-	-	-	-	-	-
3.1.2.2. Үндсэн төлбөр	-	(1,731.5)	-	(1,731.5)	-	-	-	-	-	-	-	-
3.2. Богино хугацаат	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
3.2.1. Дотоод	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
3.2.1.1. Шинээр гаргах	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
3.2.1.2. Үндсэн төлбөр	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
4. ЗГ-ын зээл	65.5	92.2	65.5	92.2	-	-	-	-	-	-	-	-
4.1. Дотоод	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
4.1.2. Авлага	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
4.1.2.3. Ирээдүйн өв сангийн авлага барагдуулалт	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
4.2. Гадаад	65.5	92.2	65.5	92.2	-	-	-	-	-	-	-	-
4.2.1. Төслийн зээл	703.6	621.4	703.6	621.4	-	-	-	-	-	-	-	-
4.2.1.1. Шинээр авах	1,542.4	1,504.2	1,542.4	1,504.2	-	-	-	-	-	-	-	-
4.2.1.2. Үндсэн төлбөр	(838.9)	(882.8)	(838.9)	(882.8)	-	-	-	-	-	-	-	-
4.2.2. Хөтөлбөр болон төслийн бус зээл	(638.0)	(529.1)	(638.0)	(529.1)	-	-	-	-	-	-	-	-
4.2.2.1. Шинээр авах	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
4.2.2.2. Үндсэн төлбөр	(638.0)	(529.1)	(638.0)	(529.1)	-	-	-	-	-	-	-	-
7. Ирээдүйн өв сангийн шилжүүлэг	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
8. Тогтворжуулалтын сангийн хуримтлагдсан үлдэгдэл	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
9. Өмч хувьчлал	52.2	4.4	-	0.4	52.2	4.0	-	-	-	-	-	-
10. НДС-ийн арилжааны банкнаас авах шилжүүлэг	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

Хавсралт 4.

Монгол Улсын 2025 оны макро эдийн засгийн үзүүлэлт

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2022	2023	2024	2025
МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ					
Нэрлэсэн ДНБ	тэрбум төгрөг	53,851.0	70,441.5	79,956.3	89,937.0
уул уурхайн	тэрбум төгрөг	12,402.0	19,814.1	21,802.1	22,747.0
уул уурхайн бус	тэрбум төгрөг	41,449.0	50,627.5	58,154.2	67,190.0
өсөлтийн хувь	хувь	26.4	22.1	14.9	15.5
Бодит ДНБ, (2015 оны үнээр)	тэрбум төгрөг	28,455.0	30,567.1	32,053.9	34,332.0
Эдийн засгийн өсөлт, хувь	хувь	5.0	7.4	4.9	6.8
уул уурхайн	хувь	(15.3)	23.4	10.8	10.6
уул уурхайн бус	хувь	8.2	5.4	4.0	6.3
Дефляторын өөрчлөлт	хувь	17.7	21.8	8.2	5.0
Инфляц /жилийн дундаж/	хувь	13.2	7.9	9.0	8.6
Мөнгөний нийлүүлэлт M2	тэрбум төгрөг	29,664.8	37,624.1	43,334.0	47,077.0
Мөнгөний нийлүүлэлт M2 өсөлт	хувь	6.5	26.8	15.2	10.6
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	тэрбум төгрөг	1,089.2	1,151.7	1,222.2	1,244.4
Бэлэн мөнгөний өсөлт	хувь	(1.5)	5.7	6.1	1.8
Нийт экспорт	сая ам.доллар	12,540.4	15,186.9	15,783.4	15,701.0
өсөлт	хувь	35.7	21.1	3.9	(0.5)
Нийт импорт	сая ам.доллар	8,701.0	9,252.0	11,612.0	11,312.0
өсөлт	хувь	27.2	6.3	25.6	(2.6)
Гадаад худалдааны тэнцэл	сая ам.доллар	3,835.0	5,934.9	4,171.4	4,389.0
өсөлт	хувь	60.1	54.8	(29.8)	5.2
Гадаад валютын албан нөөц	сая ам.доллар	3,399.6	4,921.5	5,509.8	7,005.0
өсөлт	хувь	(22.1)	44.8	12.0	27.1
Ам.долларын тайлант үеийн эцсийн ханш	сая ам.доллар	3,444.6	3,410.7	3,420.5	3,557.0
өсөлт	хувь	20.9	(1.0)	0.3	4.0
ТӨСВИЙН ОРЛОГЫН ҮЗҮҮЛЭЛТ					
Нийт орлого тусламжийн дүн	тэрбум төгрөг	18,521.6	24,387.1	31,456.6	33,179.2
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	тэрбум төгрөг	17,126.9	23,294.9	29,670.8	30,303.1
өсөлт	хувь	34.7	36.0	27.4	2.1
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн ДНБ-д эзлэх хувь	хувь	31.8	33.1	37.1	33.7
Татварын орлого	тэрбум төгрөг	15,459.0	21,484.2	27,417.4	27,213.0
Өсөлт	хувь	36.8	39.0	27.6	(0.7)
Татварын бус орлого	тэрбум төгрөг	1,668.0	1,810.7	2,253.5	3,090.1
Өсөлт	хувь	18.2	8.6	24.5	37.2
Улсын төсвийн орлогын нийт орлогоод эзлэх хувийн жин	хувь	60.2	65.7	59.3	55
Орон нутгийн төсвийн орлогын нийт орлогоод эзлэх хувийн жин	хувь	13.9	17.3	19.7	21.1
НДС-ийн орлогын нийт орлогоод эзлэх хувийн жин	хувь	2.8	2.7	2.7	13.0
ЭМДС-ийн орлогын нийт орлогоод эзлэх хувийн жин	хувь	14.4	14.4	14.1	3.9
ИӨС-ийн орлогын нийт орлогоод эзлэх хувийн жин	хувь	8.8			
УБС-ийн орлогын нийт орлогоод эзлэх хувийн жиг	хувь	0	0	4.3	7.0
ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ҮЗҮҮЛЭЛТ					
Нийт зарлагын цэвэр зээлийн дүн	тэрбум төгрөг	18,159.7	22,509.0	30,591.0	31,331.0
өсөлт	хувь	16.2	24.0	35.9	2.4
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн ДНБ-д	хувь	33.7	32.0	38.3	34.8
Урсгал зарлага	тэрбум төгрөг	14,229.3	17,091.4	22,176.6	24,237.7
өсөлт	хувь	11.1	20.1	29.8	9.3
Хөрөнгийн зардал	тэрбум төгрөг	3,803.4	5,188.2	7,970.8	7,074.1
өсөлт	хувь	27.5	36.4	53.6	11.3
Эргэж төлөгдөх цэвэр зээл	тэрбум төгрөг	127.0	229.4	443.7	19.2
өсөлт	хувь	(181.5)	80.7	93.4	95.7
Урсгал зардлын цэвэр зээлийн дүнд эзлэх хувь	хувь	78.4	75.9	72.5	77.4
Баруа үйлчилгээний зардлын урсгал зарлагад эзлэх хувь	хувь	26.7	29.8	43.1	41.8
Хүүний төлбөрийн урсгал зарлагад эзлэх хувь	хувь	5.6	6.7	5.6	6.4
Татаас ба урсгал шилжүүлгийн урсгал зарлагад эзлэх хувь	хувь	67.6	63.5	51.3	51.8
Хөрөнгийн зарлагад нийт зарлага ба цэвэр зээлийн дүнд эзлэх хувь	хувь	20.9	23.0	26.1	29.2
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийн нийт зарлагад эзлэх хувь	хувь	0.7	1.0	1.5	0.1
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ					
Тэнцвэржүүлсэн нийт тэнцэл	тэрбум төгрөг	(1,032.7)	785.9	(920.2)	(1,027.9)
өсөлт	хувь	(64.60)	(176.10)	(217.10)	(11.7)
Тэнцлийн ДНБ-д эзлэх хувь	хувь	(1.9)	1.1	(1.2)	(1.1)
ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН ҮЗҮҮЛЭЛТ					
Засгийн газрын нийт өр	тэрбум төгрөг	31,964.7	30,773.5	33,399.9	35,407.7
өсөлт	хувь	18.7	(3.7)	8.5	6.0
Засгийн газрын дотоод өр	тэрбум төгрөг	1,511.3	469.5	1,200.4	1,373.3
өсөлт	хувь	12.1	(68.9)	155.7	14.4
Засгийн газрын гадаад өр	тэрбум төгрөг	30,453.4	30,304.1	32,199.5	33,868.7
өсөлт	хувь	19.1	(0.5)	6.3	5.2
ӨҮЦ-ээр илэрхийлсэн засгийн газрын өр	тэрбум төгрөг	27,690.6	26,582.9		
Засгийн газрын өр (ӨҮЦ)/засгийн газрын нийт өр	хувь	86.6	86.4		
Засгийн газрын өр (ӨҮЦ)/ДНБ	хувь	51.4	37.7		
Хуулиар тогтоосон өрийн хязгаар (Засгийн газрын өр (ӨҮЦ)/ДНБ)	хувь	70.0	65.0	60.0	60.0
Засгийн газрын өрийн хүүний төлбөрийн төсвийн орлогоод эзлэх хувь	хувь	4.7	4.7	3.9	3.76
Засгийн газрын өрийн үндсэн төлбөрийн төсвийн орлогоод эзлэх хувь	хувь	9.9	9.2	7.7	10.7
Засгийн газрын нийт өрийн үйлчилгээний төлбөр	тэрбум төгрөг	2,503.5	3,243.5	3,446.3	2,661.9
өсөлт	хувь	3.5	29.6	6.3	(22.7)
Төсвийн орлогоод эзлэх хувь	хувь	14.6	13.9	11.6	8.0
ДНБ-д эзлэх хувь	хувь	4.6	4.6	4.3	3.0



ХАВСРАЛТ ТАЙЛАН 1. УЛСЫН ТӨСВИЙН 2025 ОНЫ
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ,
ҮР ДҮНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

ХАВСРАЛТ ТАЙЛАН 1. УЛСЫН ТӨСВИЙН 2025 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨХ,
БАТЛАХ, ХЭРЭГЖҮҮЛЭХ, БҮРТГЭХ, ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ БҮРД
ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ БОЛОН ОРОЛЦОГЧ
БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТНУУДЫН ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА
СУЛ, ХАМТЫН АЖИЛЛАГАА ХАНГАЛТГҮЙ БАЙГАА НЬ ҮР ДҮНД
СӨРГӨӨР НӨЛӨӨЛЖ БАЙНА

АГУУЛГА

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	92
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	94
БҮЛЭГ 1. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТ ОНОВЧГҮЙ, БОДЛОГЫН ЗОРИЛТЫГ ХАНГАХАД БҮРЭН ЧИГЛЭЭГҮЙ БАЙНА.....	95
БҮЛЭГ 2. ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗУРАГ ТӨСӨЛ, ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, АЖЛЫН ДААЛГАВРЫГ БОЛОВСРУУЛАХАД ХУГАЦАА АЛДАЖ БАЙГАА НЬ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНД СӨРГӨӨР НӨЛӨӨЛЖ БАЙНА.....	108
БҮЛЭГ 3. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ЗАМ ТЭЭВЭР, ХОТ БАЙГУУЛАЛТ, ЭРЧИМ ХҮЧ, БОЛОВСРОЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРТ ТӨВЛӨРЧ СУУРЬ ДЭД БҮТЭЦ, НИЙГМИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХАД ЧИГЛЭСЭН Ч ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ, ХЭМЖИХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ ОНОВЧГҮЙ БАЙНА	116
АУДИТЫН ДҮГНЭЛТ.....	142
АУДИТЫН ЗӨВЛӨМЖ.....	144
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛ.....	146
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГӨХ ХАРИУ ТАЙЛБАР	148

ТОВЧИЛСОН ҮГС ИЙН ЖАГСААЛТ

Товчилсон үгс	Тайлбар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АТГ	Авлигатай тэмцэх газар
БОУАӨС	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд
БЗД	Баянзүрх дүүрэг
БС	Боловсролын сайд
БЯ	Боловсролын яам
БСҮХД	Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга
ГБХНХС	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
ГХС	Гадаад харилцааны сайд
ЗГХЭГД	Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга
ЗТС	Зам тээврийн сайд
ЗТЯ	Зам тээврийн яам
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ССАЖЗС	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд
ССАЖЗЯ	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
СХД	Сонгинохайрхан дүүрэг
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТБОНӨХБАУХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
ТӨЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТШББ	Тендер шалгаруулалтын баримт бичиг
ТХААГ	Төрийн худалдан авах ажиллагааны газар
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ШС	Шадар сайд
УДШ	Улсын дээд шүүх
УЕП	Улсын ерөнхий прокурор
УИХ	Улсын Их Хурал
УИХД	Улсын Их Хурлын дарга
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
УХЖТ	Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө
ХЗДХЯ	Хууль, зүй дотоод хэргийн яам
ХЗДХС	Хууль, зүй дотоод хэргийн сайд
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХААБХ	Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтэс
ХББОСС	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд
ХББОСЯ	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам
ЦХИХХС	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл
ЭЗХС	Эдийн засаг, хөгжлийн сайд
ЭЗХЯ	Эдийн засаг, хөгжлийн яам
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭХС	Эрчим хүчний сайд

Хүснэгтийн жагсаалт

- Хүснэгт 1. Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалт
- Хүснэгт 2. УТХО-ын ТАХ-үүд болон УХЖТ-ний уялдаа
- Хүснэгт 3. УТХО-ын ТАХ-үүд болон УХЖТ-ний уялдаа, ТЕЗ бүрээр
- Хүснэгт 4. Санхүүжилтийн эх үүсвэргүйгээс хэрэгжээгүй 9 зорилт, арга хэмжээ
- Хүснэгт 5. Үнэлгээний онооны нийлбэр дүнгээр эрэмбэлэх заалтыг мөрдөөгүй жишээг харуулбал:
- Хүснэгт 6. Магадлалаар баталгаажсан зураг төсөвгүй ТАХ-ний тоо, ТЕЗ бүрээр
- Хүснэгт 7. ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах төсөл арга хэмжээ
- Хүснэгт 8. Зарим ТЕЗ-дын төсвийн төслийн санал, өргөн мэдүүлсэн болон батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ
- Хүснэгт 9. УТХО-аар хэрэгжүүлэх зарим төсөл, арга хэмжээний үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлт, төлөвлөсөн зорилтот түвшний үзүүлэлтүүд
- Хүснэгт 10. УТХО-аар шинээр хэрэгжих ТАХ-ний ХАА-г зохион байгуулах эрх шилжүүлсэн байдал
- Хүснэгт 11. Тендер шалгаруулалтын үр дүн, гэрээний мэдээлэл
- Хүснэгт 12. Гэрээ байгуулсан ХАА-ны үр дүнд үүссэн тендерийн хэмнэлт, тэрбум төгрөгөөр
- Хүснэгт 13. Худалдан авах ажиллагааны гомдол
- Хүснэгт 14. Гэрээний хугацааг сунгасан байдал /ТАХ-ний эдийн засгийн ангиллаар/
- Хүснэгт 15. Тухайн жилийн төлөвлөсөн санхүүжилт, гүйцэтгэлийн хувь, тэрбум төгрөгөөр
- Хүснэгт 16. Гүйцэтгэлийг хянаж баталгаажуулахад 7 хоногоос дээш хугацаа зарцуулсан давтамж
- Хүснэгт 17. Формальдегид /НСНО/ нэгдлийн хүлцэх хэмжээ болон илэрсэн хэмжээ
- Хүснэгт 18. Бензолын концентраци хүлцэх хэмжээ болон илэрсэн хэмжээ
- Хүснэгт 19. Эмнэлгүүдийн ор хоногийн ашиглалт
- Хүснэгт 20. Боловсролын салбарын зорилтот түвшин, түүний хэрэгжилт
- Хүснэгт 21. Зам, тээврийн салбарын зорилтот түвшин, түүний хэрэгжилт
- Хүснэгт 22. Эрчим хүчний салбарын зорилтот түвшин, түүний хэрэгжилт

Дүрслэлийн жагсаалт

- Дүрслэл 1. ТАХ-ний төсөвт өртөг, санхүүжих дүн, төсвийн ерөнхийлөн захирагчдаар
- Дүрслэл 2. Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээ
- Дүрслэл 3. Төрийн худалдан авах ажиллагааны үе шатыг дүрслэлээр харуулбал
- Дүрслэл 4. 2025 онд хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөсөн ажлын хэрэгжилт, ТАХ-ний тоогоор болон гэрээний дүнгээр
- Дүрслэл 5. 2025 онд хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөсөн ТАХ-ний хэрэгжилт, ангиллаар
- Дүрслэл 6. 2025 онд хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөсөн ТАХ-ний хэрэгжилт багатай ТЕЗ нар
- Дүрслэл 7. Гэрээний хугацааг сунгасан дундаж хоног ба давтамж, ТЕЗ-аар
- Дүрслэл 8. Тухайн жилд төлөвлөсөн санхүүжилтийн гүйцэтгэл, ТАХ-ээр, хувиар
- Дүрслэл 9. Цахим системд баримтжуулсан мэдээллийн самбар
- Дүрслэл 10. УТХО-ын төсөвт өртгийн 80 хувийг эзэлж буй голлох салбарууд

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь заалт, Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2025 оны 25 дугаар тогтоолд үндэслэн Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд аудитыг хийж гүйцэтгэв.

Аудитын зорилго, зорилт

Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд аудит хийж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмжийг Улсын Их Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдсэн. Уг зорилгын хүрээнд дараах дэд асуудлуудад аудитыг чиглүүлэн хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг оновчтой төлөвлөсөн эсэх;
- Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулж хяналт тавьсан эсэх;
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх.

Аудитын хамарсан хүрээ

Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан, гэрээ байгуулсан, хянаж санхүүжүүлсэн ТЭЗ нар, тэдгээрийн харьяа байгууллагууд болон Барилгын хөгжлийн төв, Эрчим хүчний хөгжлийн төв, Зам тээврийн хөгжлийн төв зэрэг байгууллагыг аудитад хамруулав.

Төсөл, арга хэмжээний төлөвлөлтийн баримт бичиг, ажлын даалгавар, ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, төлөвлөсөн болон хүрсэн үр дүнд холбогдох баримт материалуудад тулгуурлан аудитыг хийж гүйцэтгэсэн.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Төрийн аудитын стандарт, MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах нотлох баримтыг цуглуулж баримтжуулан дүн шинжилгээ хийх, харьцуулах, тулган баталгаажуулах, түүвэрлэн хянах зэрэг судалгааны арга зүйг аудитад ашигласан.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт

Аудитад дараах шалгуур үзүүлэлтийг ашиглав. Үүнд:

- Төсвийн тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт;
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль;
- Барилгын тухай хууль;
- Эрчим хүчний тухай хууль;
- Авто замын тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр;
- Улсын Их Хурлын 2024 оны 35 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”;

- Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”;
- Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар”;
- Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам болон холбогдох аргачлалууд”;
- Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”;
- Сангийн сайдын 2023 оны А/261, 2025 оны А/106 дугаар тушаалаар тус тус баталсан “Харьцуулалтын аргаар үйлчилгээ авах тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг”;
- Барилга байгууламжийн үнэ бүрдэл, төсөв зохиох норм, дүрэм, стандарт;
- Батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, ажил гүйцэтгэх гэрээ болон холбогдох эрх зүйн актууд.

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн, хугацаа

Аудитыг Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд хянан удирдаж үе шатны хяналтыг аудитын менежер Ю.Энхтуяа хэрэгжүүлэн ахлах аудитор У.Оюунхүү, Ш.Дэлгэрмаа, аудитор М.Доржмаа, Д.Нямжаргал, А.Учрал, Б.Ууганбилэг, Б.Идэрбалжинням, Б.Мөнх-Эрдэнэ нар аймаг, нийслэл дэх Төрийн аудитын байгууллагатай хамтран батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд гаргасан хөндлөнгийн мэргэжлийн шинжээчийн дүгнэлт болон сургууль, цэцэрлэгийн барилгын дотоод агаарын чанарт хийсэн лабораторийн дүгнэлтийг аудитад ашиглав.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020–2025 онуудад хэрэгжүүлсэн ерөнхий боловсролын сургууль, иргэдэд үйлчлэх төв, соёлын төв, эрүүл мэнд, авто зам болон инженерийн шугам сүлжээний барилга байгууламжийн зардал үр ашгийн шинжилгээг “Нээлттэй нийгэм форум” ТББ-ын санхүүжилттэйгээр “Зэт файнаншил энд Инвестмент Консалтинг” ХХК-ийн судалгааны багтай хамтран гүйцэтгэж дүнг тайланд тусгав.

Аудитын хүндрэл, бэрхшээл

Төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн бодит байдалд аудит хийхэд хүний нөөц хүрэлцэхгүйн улмаас эрсдэлд суурилан түүвэрлэн хянав.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийг УИХ-аар 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр батлахдаа улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 9,132.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 621 төсөл, арга хэмжээг 3,124.1 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр баталжээ.

УИХ-аас 2025 оны 7 дугаар сарын 09-ний өдөр тухайн жилийн төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж 8,735.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 611 ТАХ-нд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2,914.9 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор нэмэлт өөрчлөлт оруулан баталсан бөгөөд тухайн жилийн санхүүжилтийг анх төлөвлөснөөс 209.2 тэрбум төгрөгөөр буюу 6.7 хувиар бууруулжээ.

Тухайн жилийн төлөвлөсөн санхүүжилтийн 33.8 хувийг 2025 оноос шинээр хэрэгжүүлэх 106 ТАХ-ний, 66.2 хувийг өмнөх онуудаас шилжин хэрэгжиж буй 505 ТАХ-ний санхүүжилтэд зарцуулахаар төлөвлөсөн байна.


Хүснэгт 1. Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалт (тэрбум төгрөг)

Ангилал	Шинэ ТАХ			Шилжих ТАХ			Нийт ТАХ		
	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
Барилга, байгууламж	41	1,721.0	548.4	486	6,180.2	1,878.1	527	7,901.2	2,426.5
Их засвар	17	271.0	109.2	6	28.6	10.1	23	299.6	119.3
Тоног төхөөрөмж	42	376.7	306.6	12	134.8	41.0	54	511.5	347.6
ТЭЗҮ	6	23.0	21.4	1	0.2	0.1	7	23.2	21.5
Нийт	106	2,391.7	985.6	505	6,343.8	1,929.3	611	8,735.5	2,914.9

Эх сурвалж: Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль

Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ нь төсөвт өртгийн хувьд зам тээвэр, боловсрол, хот байгуулалт, эрчим хүч, эрүүл мэнд, соёлын салбарын хөрөнгө оруулалтад чиглэжээ.

Дүрслэл 1. ТАХ-ний төсөвт өртөг, санхүүжих дүн төсвийн ерөнхийлөн захирагчдаар



БҮЛЭГ 1. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТ ОНОВЧГҮЙ, БОДЛОГЫН ЗОРИЛТЫГ ХАНГАХАД БҮРЭН ЧИГЛЭЭГҮЙ БАЙНА**Шинээр эхлүүлэх 3 төсөл, арга хэмжээ тутмын 1 нь хөгжлийн бодлогын зорилт, арга хэмжээтэй уялдаагүй байна**

1.1. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг Засгийн газар жил бүрийн 5 дугаар сарын 1-ний өдрийн дотор өргөн мэдүүлж УИХ-аас 6 дугаар сарын 01-ний өдрийн дотор батлахаар, Монгол Улсын тухайн жилийн төсвийн төслийг боловсруулж батлуулахдаа Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байхаар хуульчилсан.

1.2. Засгийн газраас Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төслийг 2024 оны 5 дугаар сарын 01-ний өдөр өргөн мэдүүлсэн ч тухайн үеийн УИХ нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 18.3⁵²-д заасан хугацаанд хэлэлцэж батлаагүй байна.

1.3. Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төслийг 2024 оны 7 дугаар сард шинээр байгуулагдсан УИХ-аар 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдөр хэлэлцүүлснийг УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32.4⁵³ дэх заалтыг баримтлан буцаажээ.

1.4. Төсвийн тухай хуулийн дагуу ТЕЗ нарын төсвийн саналыг Сангийн яам 2024 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн дотор авч нэгтгэн боловсруулж, Монгол Улсын 2025 оны төсвийн төслийг Засгийн газар 2024 оны 8 дугаар сарын 30-ны өргөн мэдүүлэх үед Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлагдаагүй байсан ба Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.8⁵⁴, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.3⁵⁵-дахь заалтуудтай нийцээгүй, төлөвлөлтөд суурилсан төсөвлөлтийн зарчим алдагдсан байна.

1.5. Төсвийн төслийг хэлэлцэх явцад УИХ-ын 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 35 дугаар тогтоолоор Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөг баталж 328 зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 179 зорилт, арга хэмжээний санхүүжүүлэх эх үүсвэрийг урсгал зардал, хөрөнгө оруулалт гэж ангилахгүйгээр ерөнхий байдлаар “улсын төсөв” гэж тусгажээ.

1.6. Эдгээрээс хөрөнгө оруулалтын төслүүдийг ангилахад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 88 зорилт, арга хэмжээний 43.2 хувь буюу 38 зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн ТАХ-г улсын төсвөөр хэрэгжүүлэхээр тусгаж баталсан байна.

1.7. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 оноос хэрэгжүүлэхээр төлөвлөсөн шинэ 106 ТАХ-ний 50 хувь буюу 53 ТАХ нь Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөтэй уялдсан байна.

Хүснэгт 2. УТХО-ын ТАХ-үүд болон УХЖТ-ний уялдаа, (тэрбум төгрөг)

УТХО	Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдсан эсэх	Төсөвт өртөг		ТАХ-ний тоо	
		Дүн	Хувь	Тоо	Хувь
Шинэ 106 ТАХ	УХЖТ-тэй уялдсан	1,753.7	73.3	53	50.0
	УХЖТ-ний санхүүжүүлэх эх үүсвэр, шалгуур үзүүлэлттэй уялдаагүй	61.4	2.6	12	11.3
	УХЖТ-тэй уялдаагүй	576.6	24.1	41	38.7
	Нийт	2,391.7	100	106	100

1.8. Шинээр эхлүүлэх 106 ТАХ-ний 11.3 хувь буюу 12 ТАХ нь бодлогын зорилтын шалгуур үзүүлэлттэй уялдаагүй, өөр эх үүсвэрээс санхүүжүүлэхээр төлөвлөсөн, 38.7 хувь буюу 41 ТАХ нь тухайн жилийн хөгжлийн төлөвлөгөөтэй уялдаагүй байна.

1.9. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар тухайн оноос эхлэн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 3 ТАХ бүрийн 1 нь тухайн жилд төлөвлөсөн хөгжлийн бодлогын зорилт, арга хэмжээтэй

⁵² 18.3. “Засгийн газар Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг жил бүрийн 05 дугаар сарын 01-ний дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, .. хүргүүлнэ. Улсын Их Хурал 6 дугаар сарын 01-ний дотор батална”

⁵³ 32.4. “Өмнөх Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаанд хэлэлцэж батлаагүй хууль, тогтоолын төслийг хууль санаачлагчид нь буцаасанд тооцно”

⁵⁴ 27.1.8. “Төсвийн төслийг боловсруулахад ... улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилсан байх”

⁵⁵ 6.10 .3. “Улсын төсөв нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх”

уялдаагүй байгаа нь хөрөнгө оруулалтын төлөвлөлт оновчгүй, бодлогын зорилтыг хангахад бүрэн чиглээгүйг харуулж байна.

Хүснэгт 3. УТХО-ын ТАХ-үүд болон УХЖТ-ний уялдаа, ТЕЗ бүрээр

№	ТЕЗ	ТАХ-ний тоо	УХЖТ-тэй уялдсан ТАХ	УХЖТ-тэй уялдаагүй ТАХ	№	ТЕЗ	ТАХ-ний тоо	УХЖТ-тэй уялдсан ТАХ	УХЖТ-тэй уялдаагүй ТАХ
1	АТГД	2	-	2	15	Сангийн Сайд	8	4	4
2	АҮЭБС	1	-	1	16	СЗХД	1	-	1
3	БОУАӨС	6	3	3	17	УДШЕШ	3	3	-
4	БХС	2	2	-	18	УЕП	1	-	1
5	БС	2	1	1	19	ҮСХД	1	-	1
6	ГХС	2	-	2	20	ХББОСС	5	3	2
7	ГБХНХС	4	2	2	21	ХЗДХС	8	4	4
8	ЗТС	14	8	6	22	ХЭҮҚД	1	-	1
9	Ерөнхий Сайд	1	-	1	23	ХХААХҮС	3	1	2
10	Ерөнхийлөгч	2	-	2	24	ЦХИХХС	1	1	-
11	УИХД	1	-	1	25	ШЕЗ	6	1	5
12	ЗГХЭГД	2	-	2	26	ШСХД	1	1	-
13	ЭЗХС	3	-	3	27	ЭМС	7	2	5
14	ШС	4	3	1	28	ЭХС	14	14	-

1.10. УХЖТ-тэй уялдаагүй ТАХ-г УТХО-аар хэрэгжүүлэхээр тусгаснаар тухайн жилд төлөвлөсөн зарим зорилт арга хэмжээнд санхүүжилт хүрэлцэхгүй орхигдож байна.

1.11. Тухайлбал УХЖТ-д тусгасан 208.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй дараах 9 зорилт, арга хэмжээ хөрөнгө, санхүүгийн эх үүсвэргүйгээс 2025 онд хэрэгжээгүй орхигдож төлөвлөсөн бодлогын зорилт, үр дүндээ хүрээгүй байхад нөгөө талдаа УХЖТ-тэй уялдаагүй 576.6 тэрбум төгрөгийн ажлыг УТХО-аар санхүүжүүлжээ.

Хүснэгт 4. Санхүүжилтийн эх үүсвэргүйгээс хэрэгжээгүй 9 зорилт, арга хэмжээ, (тэрбум төгрөг)

Төлөвлөсөн үр дүн	Зорилт, арга хэмжээ	Төсөвт өртөг
Аялал жуулчлалын бүс нутгийн авто замын дэд бүтцийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ	Хэрлэн-Тосон-Уул-Халх гол чиглэлийн хатуу хучилттай 256 км авто зам барих	75.0
	Налайх-Тэрэлж чиглэлийн 37 км авто замыг 4 эгнээ болгон өргөтгөх	55.5
Авто замын сүлжээг өргөтгөнө	Баяндалай-Гурвантэс чиглэлийн 80 км авто замын дуусгал, 74.2 км авто зам	48.0
Мэдээлэл, харилцаа холбооны хатуу, зөөлөн дэд бүтцийг өргөтгөж, сайжруулна	Сэлгэн ажиллах дата төвийн тоног төхөөрөмжийн нөөцийг бий болгох	11.9
	Мэдээлэл технологийн ХАБ байгуулах	1.0
Түүх, соёлын дурсгалт зүйлийг сэргээн засварлаж, хадгалалт, хамгаалалтын байдлыг сайжруулна	Улсын дуурь бүжгийн эрдмийн театрын барилгыг хүчитгэх	4.8
	Улсын драмын эрдмийн театрын барилгыг хүчитгэх	4.8
Гамшгийн эрсдэлийг бууруулах чадавхыг нэмэгдүүлнэ	Цаг уурын радарын улсын сүлжээг байгуулах	6.5
Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ	Тариалангийн үйлдвэрлэлийг эрсдэлээс хамгаалах, бүс нутагт тохирсон таримал, сорт сонгох зорилгоор анхан шатны үр үржүүлэг, сорт сорилтын төвийг байгуулах	0.6
<i>Хөрөнгө, санхүүжилтийн эх үүсвэргүйгээс хэрэгжээгүй 9 зорилт, арга хэмжээ</i>		208.1

1.12. Эдгээр нь тухайн жилийн УТХО хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгасан зорилт, арга хэмжээг санхүүжүүлэхэд бүрэн чиглээгүй, төлөвлөлтөд суурилсан төсөвлөлтийн зарчим алдагдах эрсдэлийг дагуулж байна.

1.13. Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.1.8-д “Төсвийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах, хүртээмж, үр ашгийг нэмэгдүүлэх хүрээнд төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө иргэдийн санал авах, тусгах, уялдуулах арга

хэмжээг зохион байгуулж болно” гэж заасны дагуу Сангийн яам нь 2024 оны 03 дугаар сарын 01-ээс 31-ний өдрийн хооронд Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системээр дамжуулан УТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-нд олон нийтийн саналыг авсан бөгөөд нийт 11829 иргэнээс 1135 төслийн санал ирүүлжээ.

1.14. Санал асуулгад оролцсон иргэдийг байршлаар авч үзвэл Хөвсгөл аймгаас 3646 иргэн санал өгч нийт саналын 30.8 хувийг, Дундговь аймгаас 1448 иргэн санал өгч нийт саналын 12.2 хувийг, Увс аймгаас 1229 иргэн санал өгсөн нь нийт саналын 10.4 хувийг тус тус эзэлж байгаа бол Төв аймгийн 42, Орхон аймгийн 32, Говьсүмбэр аймгийн 28, Баян-Өлгий аймгийн 5, Улаанбаатар хотын 419 иргэн санал асуулгад оролцжээ.

1.15. Санал асуулгад оролцогчдын дийлэнх хувийг цөөн тооны аймаг бүрдүүлж, зарим аймаг, орон нутгийн иргэдийн оролцоо харьцангуй бага байгаа нь иргэдээс санал авах ажиллагааны хүртээмж, хамрагдалтын түвшин жигд бус байгааг харуулж байна.

1.16. Санал асуулгаар үүсгэсэн ТАХ-нд иргэд 0-5 хүртэл оноо өгсөн бөгөөд дунджаас дээш буюу 3-5 оноо авсан 582 төслийг хөрөнгө оруулалтын төрлөөр авч үзвэл:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх боломжтой инженерийн шугам сүлжээ, сургууль, эрүүл мэндийн төв, цэвэрлэх байгууламж, хөв цөөрөм, үерийн далан гэх мэт 53 төрлийн 452 барилга байгууламж;
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх боломжтой ногоон байгууламж, багийн төв, цэцэрлэгт хүрээлэн, тоглоомын талбай, гэрэлтүүлэг, тохижилт, хорооллын доторх авто зам гэх мэт 19 нэр төрлийн 77 төсөл, арга хэмжээ;
- Урсгал зардлаар санхүүжүүлэх боломжтой тээврийн хэрэгсэл, тавилга, тоног төхөөрөмж, замын тэмдэглэгээ гэх мэт 6 төрлийн 25 төсөл, арга хэмжээ;
- Хувийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх боломжтой сувилал, орон сууц, аялал жуулчлалын байгууламж зэрэг 9 төрлийн 28 төсөл байна.

1.17. Төсвийн төсөлд олон нийтийн санал авах үйл ажиллагааны хүртээмж, хамрах хүрээ, оролцоог сайжруулах, мөн хэрэгжүүлэхээр төлөвлөж буй ТАХ бүрээр санал авах ажиллагааг зохион байгуулах шаардлагатай байна.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлын судалгаа тооцоолол хангалтгүйгээс оновчтой эрэмбэлж төлөвлөж чадахгүй байна

1.18. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 оноос шинээр хэрэгжүүлэх 106 ТАХ-ээс барилга байгууламжийн ангилалд 1,612.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 37 ТАХ-г төлөвлөжээ.

1.19. Барилга байгууламжийн шинээр хэрэгжих 37 ТАХ-ээс 13 ТАХ-нд тодорхой хэмжээнд зардал-үр дүнгийн шинжилгээний мэдээллийг цахим системд хийж оруулсан, 10 ТАХ-нд хийсэн шинжилгээ нь аргачлалын дагуу бус, 14 ТАХ-нд огт дүн шинжилгээ хийгээгүй байна.

1.20. Эдийн засгийн үр, ашиг, нийгмийн ач холбогдлын тооцоолол хийсэн 13 ТАХ-ний зардал-үр дүнгийн болон хамгийн бага зардлын шинжилгээ, тооцооллыг хянаж үзэхэд шаардлага хангахгүй байна. Тухайлбал:

- Зардлын шинжилгээ, тооцоололд шаардлагатай өгөгдөл, мэдээллийг бүрэн гүйцэд тусгаагүй, ашигласан тоон мэдээллийн эх үүсвэр, тайлбарыг оруулаагүй, өгөгдөл нь үнэн зөв, бодитой эсэх нь тодорхойгүй;
- Барьж байгуулах, ХАА, их засвар хийх гэх мэт олон хувилбараар зардлын шинжилгээ хийгээгүйгээс хамгийн бага зардлын аргаар харьцуулах, сонгох боломжгүй;
- Үр ашигтай, ач холбогдолтой эсэх нь зардлын шинжилгээгээр тодорхойгүй, бүрэн бус байгаа нь зардал үр ашиг, үр дүнгийн шинжилгээний чанар, хяналт, үр нөлөө сул, нэр төдий хийж байгааг харуулж байна.

1.21. Зардал үр ашиг, үр дүнгийн шинжилгээг бүрэн хийгээгүй, бодитой, үндэслэлтэй тооцоолохгүй байгаа нь ТАХ-г эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлоор нь эрэмбэлж, нэн тэргүүний хэрэгцээ шаардлагыг оновчтой сонгож, төлөвлөх боломжийг хязгаарлаж байна.

1.22. Төсвийн ерөнхийлөн захирагч нар 1008 барилга байгууламжийн шинэ ТАХ-г төсвийн төсөлд тусгуулахаар цахим системээр санал хүргүүлснээс Сангийн яам 593 ТАХ-г үнэлж эрэмбэлэн 40 ТАХ-г төсвийн төсөлд тусган УИХ-д өргөн мэдүүлжээ.

1.23. Барилга байгууламжийн 593 ТАХ-г ТЕЗ болон Сангийн яам тус бүр үнэлгээ өгч хоёр үнэлгээний нийлбэр онооны хамгийн өндрөөр эрэмбэлж сонгохоор журамд заасан ч улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд хэрэгжүүлээгүй байна.

1.24. Хөрөнгө оруулалтын ТАХ-г төлөвлөх явцад үнэлгээний аргачлалыг мөрдөөгүй, өгсөн үнэлгээ, оноо нь бодитой бус, өндөр онооны эрэмбийг баримтлахгүй байгаагаас өндөр үнэлгээтэй ТАХ төсвийн төсөлд тусгагдахгүй орхигдож, түүнээс эрэмбэ доогуур, харьцангуй бага үнэлгээтэй ТАХ-г төсөвт тусгаж төлөвлөх зөрчил давтагдсаар байна.

Хүснэгт 5. Үнэлгээний онооны нийлбэр дүнгээр эрэмбэлэх заалтыг мөрдөөгүй жишээг харуулбал:

Өндөр үнэлгээтэй боловч төсөвт тусгагдаагүй ТАХ		Бага үнэлгээтэй боловч төсөвт тусгагдсан ТАХ	
ЭХС-ын багцад			
Улаангомьн дулааны хоёрдугаар станцын зуухны өргөтгөл /Увс, Улаангом сум/	193	Аймгийн төвд баригдаж байгаа дулааны станцын 2 дугаар хэлхээ, дэд бүтэц /Төв/	181.5
Дулааны станцын өргөтгөл /Дархан-Уул, Шарын гол сум/	193	Налайх Дулааны шинэ эх үүсвэр 79 МВт-ын эхний ээлжийн ажил /Улаанбаатар, Налайх/	169
ХББОСС-ын багцад			
960 айлын орон сууцны хорооллын гадна инженерийн шугам сүлжээний 2 дугаар ээлжийн ажил /Сүхбаатар, Баруун-Урт сум/	166.5	Бүсүүдийн хөгжлийг дэмжих инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц /Бүсүүдэд/	150
Бохир ус цэвэрлэх байгууламж /Улаанбаатар, Багануур дүүрэг/	158.5	Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах цогц хөтөлбөр, 1 дүгээр үе шат /Бүсүүдэд/	101
ЗТС-ын багцад			
Чойр-Мандалговь-Арвайхээр чиглэлийн хэвтээ тэнхлэгийн авто зам, Мандалговь-Чойр чиглэлийн хатуу хучилттай авто замын үргэлжлэл, 2 дугаар үе шат /Говийн бүс/	158	Аргалант-Баянцогт сум чиглэлийн хатуу хучилттай авто зам, 26.7 км, төмөрбетон гүүр, 36 у/м /Төвийн бүс/	146.5
Налайх-Тэрэлж чиглэлийн 37 км авто замыг 4 эгнээ болгон өргөтгөх шинэчлэл, 6 гүүрэн байгууламж хамт /Улаанбаатар/	139	Мандал сумын Түнхэл тосгоноос Төв аймгийн Батсүмбэр хүртэлх 45.2 км хатуу хучилттай авто зам, Түнхэл тосгон доторх 4 км хатуу хучилттай авто зам /Төвийн бүс/	120
Баяндалай-Гурвантэс чиглэлийн 80 км хатуу хучилттай авто замын дуусгал, 74.2 км /Говийн бүс/	143		
БОУАӨС-ын багцад			
Цаг уурын өртөөний барилга /Дорнод, Халхгол сум/	129.5	Нэгдсэн Үндэстний Байгууллагын "Цөлжилттэй тэмцэх тухай" суурь конвенцын талуудын 17 дугаар бага хурлын байгууламж /Улаанбаатар/	105
Хөвсгөл аймгийн "Ногоон Суварга" хөтөлбөрийн хүрээнд 2021-2024 онуудад Мөрөн суманд шинээр ногоон байгууламж хийх газруудын ландшафт төлөвлөлт /Хөвсгөл, Мөрөн сум/	125.5		
Аялал жуулчлалын цогцолбор /Улаанбаатар, Налайх дүүрэг, 4-р хороо/	117.5		

1.25. Аргачлалын дагуу үнэлгээний оноог бодитоор үнэлэхгүй байгаа нь үнэлэх, эрэмбэлэх, өндөр эрэмбээр сонгох зарчмыг алдагдуулж төлөвлөлт үндэслэлгүй хийгдэх, оновчгүй сонгох эрсдэлийг дагуулж байна.

1.26. Тухайлбал өмнө дурдсан эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцоогүй 14 ТАХ-нд "тооцсон" гэсэн шалгуурт хамаарах өндөр оноог өгч үнэлсэн нь үнэлгээ бодитой, үндэслэлтэй хийгдэхгүй байгааг харуулж байна.

1.27. Энэ нь Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-г үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам"-ын 4.2.4⁵⁶, 4.3⁵⁷, 4.5⁵⁸ дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

⁵⁶ 4.2.4 "тухайн төслийн төрлөөс хамааран техник, эдийн засгийн үндэслэлийн тооцоо, судалгаа болон Аргачлал 2-т заасны дагуу төслийн шинжилгээг хийсэн байх"

⁵⁷ 4.3 "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх барилга байгууламжийн шинэ төслийн тухайд Аргачлал 2-ын дагуу төслийн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцох шинжилгээг хийсний үндсэн дээр Аргачлал 3-ын дагуу үнэлэх, эрэмбэлэх, сонгох үйл ажиллагааг хэрэгжүүлнэ"

⁵⁸ 4.5 "Төсөл нь холбогдох аргачлалд заасны дагуу шалгуур үзүүлэлтээр үнэлэгдсэн, эдийн засгийн үр ашигтай, нийгмийн ач холбогдолтой, тэргүүлэх зэрэглэлийн төслүүд байна"

1.28. Төслийг үнэлэх, сонгох, эрэмбэлэх үе шатанд магадлалаар баталгаажсан зураг төсөвгүй зарим ТАХ-г хамруулан үнэлж эрэмбэлсэн байна. Тухайлбал:

- БОУАӨС-ын багцын 6.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй “Гадаргын ус хуримтлуулах хөв цөөрөм байгуулах /Баруун бүс/”;
- БОУАӨС-ын багцын 8.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй “Нэгдсэн Үндэстний Байгууллагын “Цөлжилттэй тэмцэх тухай” суурь конвенцын талуудын 17 дугаар бага хурлын байгууламж /Улаанбаатар/”;
- ШЕЗ-ийн багцын 8.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй “Багануур дүүрэг дэх шүүхийн барилга /Улаанбаатар, Багануур дүүрэг/”;
- ШЕЗ-ийн багцын 12.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй “Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн хялбар ажиллагааны тойргийн анхан шатны шүүхийн барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/” ТАХ-нүүд магадлалаар батлагдсан зураг төсөвтэй байх шаардлагыг хангаагүй байхад үнэлэх, эрэмбэлэх үе шатанд үнэлгээ хийж сонгосон байна.

1.29. Эдгээр нь Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-г үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам”-ын 5.5⁵⁹ дахь заалт, “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох аргачлал”-ын 2.4⁶⁰ дэх заалтыг зөрчсөн байна.

1.30. ТАХ-г үнэлж, эрэмбэлэх, сонгоход батлагдсан аргачлалыг баримтлах, бодитоор үнэлж, тэргүүн эрэмбээс сонгож оновчтой төлөвлөх шаардлагатай байна.

Шинээр эхлүүлэх барилга байгууламж, их засварын ажлын 50 хувь нь батлагдсан зураг төсөв, газрын зөвшөөрөлтэй байх төсөвлөлтийн шаардлагыг хангахгүй байна

1.31. УТХО-аар 2025 оноос эхлэн хэрэгжүүлэх шинэ 106 ТАХ, үүнээс барилга байгууламж, их засварын 58 ТАХ батлагдаж, ТЕЗ-ийн шийдвэрээр багцад хуваарилагдан 178 багц ТАХ болж задарчээ.

1.32. Барилга байгууламж, их засварын дээрх 1,882.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй шинэ 178 ТАХ-ээс дараах 438.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 89 ТАХ буюу 50 хувь нь сүүлийн 2 жилийн дотор магадлалаар баталгаажсан зураг төсөв, газрын зөвшөөрөлтэй байх төсөвлөлтийн шаардлагыг хангаагүй байна. Үүнд:

- Магадлалаар баталгаажсан зураг төсөвгүй 279.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 84 ТАХ; /үүнээс 1 ТАХ газрын зөвшөөрөлгүй/
- Төсвийн тооцоолол хоёр жилээс өмнө хийгдсэн буюу сүүлийн 2 жилд магадлалаар баталгаажсан байх шаардлага хангаагүй 159.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 5 ТАХ-г тус тус төсөвт тусгаж баталжээ.

1.33. Төсөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ-г жил бүр төлөвлөж баталж байгаа нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, 29¹ дүгээр зүйлийн 29^{1.2.2}, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.3, 16 дугаар зүйлийн 16.1.4 дэх заалтад нийцэхгүй байна.

1.34. Төсөвлөлтийн шаардлага хангаагүй 89 ТАХ нь нийт 10 ТЕЗ-д хамаарч байна. Үүнээс нийт ТАХ-нд эзлэх хувиар Хүснэгт 6-д харуулав.

Хүснэгт 6. Магадлалаар баталгаажсан зураг төсөвгүй ТАХ-ний тоо, ТЕЗ бүрээр

№	ТЕЗ	ТАХ-ний тоо	Үүнээс төсөвлөлтийн шаардлага хангаагүй		
			Төсөвт өртөг /тэрбум.төг/	ТАХ-ний тоо	Эзлэх хувь
1	Шадар сайд	2	4.4	2	100.0
2	БОУАӨС	38	59.7	33	86.8
3	ШЕЗ	5	30.1	3	60.0
4	ХББОСС	38	87.5	21	55.2
5	ГБХНХС	2	1.2	1	50.0
6	ЭХС	36	93.9	18	50.0
7	ЗГХЭГД	3	0.3	1	33.3
8	ЗТС	19	160.0	6	31.5
9	ХХААХҮС	22	0.5	3	13.6

⁵⁹ 5.5 “Энэ журмын 5.4-т заасны дагуу ирүүлэх төсөл нь эрх бүхий байгууллагаас олгосон газрын зөвшөөрөлтэй, газар нь чөлөөлөгдсөн, барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийгдэж, дүгнэлт гаргуулсан байх шаардлагатай бөгөөд уг шаардлагыг хангаагүй төсөлд сонгох үнэлгээг хийхгүй”

⁶⁰ 2.4 “Төслийг эрэмбэлэх, сонгох үе шатанд зөвхөн эрх бүхий байгууллагаас олгосон газрын зөвшөөрөлтэй, тухайн газар нь чөлөөлөгдсөн болон барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийлгэж, дүгнэлт гаргуулсан төслүүдийг оруулж үнэлнэ”

10	ЭМС	8	0.6	1	12.5
11	ЭЗХС	1	-	-	-
12	АТГД	1	-	-	-
13	ХЗДХС	3	-	-	-
	Нийт	178	438.2	89	50.0

Эх сурвалж. Төсвийн тухай хууль, Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем


1.35. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 611 ТАХ-ний 32 нь төсвийн төслийг анх хэлэлцэх явцад УИХ-аар нэмэгдэж баталсан ТАХ байна.

1.36. Төсвийн төслийн хэлэлцүүлгийн явцад нэмэгдсэн дээрх 32 ТАХ-с 31.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 4 ТАХ нь магадлалаар баталгаажсан зураг төсөвгүй, төсөвлөлтийн шаардлага хангаагүй байна. Үүнд:

- ШЕЗ-ийн багцад 12.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй “Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн хялбар ажиллагааны тойргийн анхан шатны шүүхийн барилга”;
- ШЕЗ-ийн багцад 9.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй “Өмнөговь аймаг дахь шүүхийн барилга /Өмнөговь, Даланзадгад сум”;
- ШЕЗ-ийн багцад 8.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй “Багануур дүүрэг дэх шүүхийн барилга /Улаанбаатар, Багануур дүүрэг”;
- ГБХНХС-ын багцад 1.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй “Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалт хөгжлийн төв”-ийн үйлдвэрийн барилгын их засвар /Улаанбаатар, Баянгол/ ТАХ тус тус магадлалаар баталгаажсан зураг төсөвгүй, төсөвлөлтийн шаардлага хангаагүй байна.

1.37. Магадлалаар баталгаажсан зураг төсөвгүй 89 ТАХ-ний 85 нь ТЕЗ, 4 нь төсвийн төслийг хэлэлцэх явцад УИХ-аар нэмж баталсан ТАХ байна.

Дүрслэл 2. Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээ



1.38. Төсвийн төслийг хэлэлцэх явцад УТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний жагсаалтад нэмэлт өөрчлөлт оруулахаар зарчмын зөрүүтэй санал гаргасан тохиолдолд тухайн ТАХ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4⁶¹-д заасан төсөвлөлтийн шаардлагыг хангасан байхаар Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.7.3⁶² дахь заалтад тусгасан байна.

1.39. Хэлэлцүүлгийн явцад хөрөнгө оруулалтын ТАХ-нд нэмэлт өөрчлөлт оруулах тохиолдолд тухайн ТАХ нь хуульд заасан төсөвлөлтийн шаардлагыг хангасан эсэхийг хэн хэрхэн хянах, шаардлага хангаагүй тохиолдолд авч хэрэгжүүлэх арга хэмжээний зохицуулалт УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд тодорхой тусгагдаагүй байна.

1.40. Энэ нь төсвийн төслийг байнгын хороодоор болон УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцэх явцад эдийн засгийн үр ашиг, хэрэгцээ шаардлага, өртөг зардлын судалгаа тооцоогүй, баталгаажсан зураг төсөвгүй, төсөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ хөрөнгө оруулалтын ТАХ-ний жагсаалтад нэмэгдэж батлагдах эрсдэлийг дагуулж байна.

1.41. Батлагдсан зураг төсөлгүй барилга, их засварын ажлыг төлөвлөх нь тухайн ажлын өртгийг судалгаа тооцоо, норм стандарт, жишиг үнэ тарифт тулгуурлан хэмнэлттэй, үр ашигтай

⁶¹ 29.4. “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана”

⁶² 71.7.3. “Байнгын болон дэд хороо, нам, эвслийн бүлгийн хуралдаанаар төсвийн төслийн ... хэлэлцүүлэг явуулах үед гишүүд, Монгол Улсын Ерөнхийлөгч, нам, эвслийн бүлгийн гаргасан санал нь ... Төсвийн тухай хуулийн ... 29.4-т нийцсэн байх ... шаардлагыг хангасан байна”

байдлаар бодитой тооцоолох төлөвлөлтийн суурь зарчим, шаардлагыг алдагдуулж цаашид өртөг нэмэгдэх, хэрэгжилт удаашрах үндсэн шалтгаан болж байна.

1.42. Тухайлбал Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсаны дараа төсөвлөлтийн шаардлага хангаагүй дээр дурдсан 89 ТАХ-ээс 192.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэйгээр төлөвлөсөн 49 ТАХ-ний зураг төсөв нь боловсруулагдаж өртөг нь магадлалын ерөнхий дүгнэлтээр 241.7 тэрбум төгрөгөөр хянагдаж 25.6 хувиар өсжээ. Тухайлбал:

- ЭХС-ын багцад төсөвт өртгийг 1.4 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн Бүс нутгийн найдвартай цахилгаан хангамж, 1 дүгээр үе шат /Бүсүүд/, Дэргэний УЦС-аас Чандмань сумын төв хүртэл 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, 35/10 кВ-ын дэд станцын барилга угсралтын эхний ээлжийн ажил /Ховд, Чандмань сум/ ТАХ-ний өртгийг магадлалын дүгнэлтээр 10.2 тэрбум төгрөгөөр хянаж баталгаажуулсан нь төлөвлөснөөс 7.2 дахин өндөр;
- ЭХС-ын багцад төсөвт өртгийг 4.5 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн Бүс нутгийн найдвартай цахилгаан хангамж, 1 дүгээр үе шат /Бүсүүд/, Аймгийн төвийн 6 кВ-ын хүчдэлийг 10 кВ-ын хүчдэлийн түвшинд шилжүүлэх ажлын хүрээнд 35/10 кВ-ын "Улиасны хэв" дэд станцын өргөтгөл, шинээр 35/10 кВ-ын дэд станц барих /Увс, Улаангом сум/ ТАХ-ний өртгийг магадлалын дүгнэлтээр 10.3 тэрбум төгрөгөөр хянаж баталгаажуулсан нь төлөвлөснөөс 2.2 дахин өндөр;
- ХББОСС-ын багцад төсөвт өртгийг 11.6 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн Бүсүүдийн хөгжлийг дэмжих инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц, улс, аймаг, сумдад хэрэгжүүлэхэд шаардагдах Улсын төсвийн хөрөнгө /Бүсүүд/, Сумын төвийн инженерийн дэд бүтэц, шугам сүлжээний ажил /Хөвсгөл, Тариалан сум/ ТАХ-ний өртгийг магадлалын дүгнэлтээр 25.6 тэрбум төгрөгөөр хянаж баталгаажуулсан нь төлөвлөснөөс 2.2 дахин өндөр;
- ХББОСС-ын багцад төсөвт өртгийг 1.6 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн Бүсүүдийн хөгжлийг дэмжих инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц, улс, аймаг, сумдад хэрэгжүүлэхэд шаардагдах Улсын төсвийн хөрөнгө /Бүсүүд/, Сумын ундны усны эх үүсвэр, инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийн өргөтгөл шинэчлэлийн ажил /Сүхбаатар, Баруун-Урт сум/ ТАХ-ний өртгийг магадлалын дүгнэлтээр 6.4 тэрбум төгрөгөөр баталгаажуулсан нь төлөвлөснөөс 4 дахин;
- ШЕЗ-ийн багцад төсөвт өртгийг 9.5 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн Өмнөговь аймаг дахь шүүхийн барилга /Өмнөговь, Даланзадгад сум/ ТАХ-ний өртгийг магадлалын дүгнэлтээр 13.8 тэрбум төгрөгөөр баталгаажуулсан нь анх төлөвлөснөөс 1.4 дахин өндөр байна.

1.43. Их засварын ТАХ-г төлөвлөхөд "барилга байгууламжийн ашиглалт, норм, хугацаа, элэгдлийн байдал, мэргэжлийн байгууллагын гаргасан дүгнэлтэд үндэслэсэн байх" шаардлагыг Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 3.2.3.4⁶³ дэх заалтад тусгасан.

1.44. УТХО-ын төлөвлөгөөнд тусгасан их засварын 30 ТАХ-ний 90 хувь буюу 27 барилгын төлөв байдалд барилгын техник хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гаргаагүй, их засвар хийх зайлшгүй хэрэгцээ шаардлага бий болсон эсэхийг нотлох дүгнэлтгүй байхад төсөвт тусган хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

1.45. Их засварын ТАХ-г төлөвлөхдөө барилга байгууламжийн ашиглалтын норм, хугацаа, элэгдлийн байдал, мэргэжлийн байгууллагын дүгнэлтэд үндэслэхгүй байгаа нь хэрэгцээ шаардлагыг бодитой тодорхойлж, үнэлж эрэмбэлэн төлөвлөхөд хүндрэл учруулж байна.

Тоног төхөөрөмж, ТЭЗҮ ангиллын төсөл, арга хэмжээг нэн тэргүүний хэрэгцээ шаардлага, судалгаа тооцоонд тулгуурлаж төлөвлөхгүй байна

1.46. Шинээр эхлүүлэх тоног төхөөрөмж ангиллын ТАХ-ний 37 хувийг буюу 81.3 тэрбум төгрөгийг хууль зүй, дотоод хэргийн салбарт, 20 хувь буюу 41.6 тэрбум төгрөгийг батлан хамгаалах салбарт, 13 хувь буюу 28.5 тэрбум төгрөгийг эрчим хүчний салбарт, 11 хувь буюу 24.7 тэрбум төгрөгийг эрүүл мэндийн салбарт, 10 хувь буюу 21.4 тэрбум төгрөгийг боловсролын салбарт, үлдэх 10 орчим хувийг байгаль орчин, гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгаалал, эдийн засгийн салбарт зарцуулахаар төлөвлөжээ.

1.47. Төсвийн төсөлд Боловсролын яамнаас хүргүүлсэн шинээр худалдан авах тоног төхөөрөмжийн саналд тусгасан нийт дүнгийн 15 хувийг 2025 оны улсын төсөвт тусгасан нь салбарын хэрэгцээ шаардлагатай уялдаагүйгээс нийслэлийн зарим дүүргүүдэд шинээр

⁶³ 3.2.3.4 "Тухайн барилга байгууламжийн ашиглалт, норм, хугацаа, элэгдлийн байдал, мэргэжлийн байгууллагын гаргасан дүгнэлт, засварын хөрөнгийн төсөв, холбогдох баримт бичигт үндэслэсэн байх"

ашиглалтад орсон сургууль, цэцэрлэгүүд ширээ сандал, тоног төхөөрөмж хүрэлцэхгүй, сургалтын үйл ажиллагааг хичээлийн жилийн эхэнд эхлүүлэх боломжгүй нөхцөл байдал үүссэн байна. Тухайлбал:

- Сургуулийн барилга, 640 суудал, спорт заал, /Баянзүрх дүүрэг, 26 дугаар хороо, Олимп хотхон/ 183 дугаар сургууль;
- Сургуулийн барилга, 640 суудал /Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 16 дугаар хороо/ 178 дугаар сургууль;
- Сургуулийн барилга, 640 суудал / Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг 19 дүгээр хороо 62 дугаар сургууль;
- Сургуулийн барилга, 640 суудал 171 дугаар сургууль;
- Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор /Улаанбаатар Хан-Уул дүүрэг 16 дугаар хороо 181 дүгээр сургууль/;
- Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор /Улаанбаатар Баянгол, 23-р хороо, 182 дугаар сургууль/;
- Цэцэрлэгийн барилга 240 ор / Улаанбаатар Хан-Уул дүүрэг 1 дүгээр хороо/
- Цэцэрлэгийн барилга /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг 28 дугаар хороо 34-р цэцэрлэг/

1.48. Салбарын тухайн жилийн зорилт, арга хэмжээтэй тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтууд нь уялдсан эсэхийг хянахад шинээр эхлүүлэх тоног төхөөрөмжийн 42 ТАХ-ний 66.7 хувь нь бодлогын зорилттой уялдсан бол 33.3 хувь нь уялдаагүй, хүрэх зорилт үр дүн нь тодорхойгүй байна. Үүнд:

- 28 ТАХ буюу 66.7 хувь нь дулааны цахилгаан станцыг өргөтгөх, бэлэн байдлыг хангах, гамшигаас хамгаалах техник, тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх, шүүх шинжилгээний байгууллагын шинжилгээний техник, тоног төхөөрөмжийг сайжруулах, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын чадавхыг бэхжүүлэн төвлөрлийг сааруулах зэрэг зорилттой уялдуулж төлөвлөсөн;
- 14 ТАХ буюу 33.3 хувь нь хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдаагүй, богино хугацааны бодлогын баримт бичгийн зорилтуудтай нийцээгүй, шалгуур үзүүлэлт болон хэрэгцээ шаардлага нь тодорхойгүй байна.

1.49. Түүнчлэн тоног төхөөрөмж худалдан авснаар шийдвэрлэгдэх асуудал, ажил, үйлчилгээний чанар, стандартад хэрхэн нөлөөлөх, ашиглалтын хугацаа дууссан тохиолдолд шинэчилж байгаа эсэх, орон тоо бүтцийн өөрчлөлт, барилга ашиглалтад орсонтой холбоотой хэрэгцээ шаардлага үүссэн эсэх нь тодорхойгүй байна.

1.50. Салбарын хэмжээнд ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжийн тоо, нэр төрөл, ашиглалтад орсон он, ашиглах хугацааны нэгдсэн судалгаа байхгүй, шинээр худалдан авах тоног төхөөрөмжийн нэгжийн өртөг, тоо хэмжээг тооцож төлөвлөсөн үндэслэл, үнийн харьцуулсан судалгаа тооцоолол дутмаг, нэр төрөл, тоо ширхэг бүрээр бус нийт үнийн дүнгээр төлөвлөх зөрчил нийтлэг байгаа бөгөөд түүнд тавих хяналт хангалтгүй байна. Тухайлбал:

- ГБХНХС-ын багцад 5,100.1 сая төгрөгөөр 2060 ш, Сангийн сайдын багцад 2,102.1 сая төгрөгөөр 626 ш, ХХААХҮС-ийн багцад 573.8 сая төгрөгөөр 203 ш, ШС-ын багцад 213.2 сая төгрөгөөр 83 ш, ЭМС-ын багцад 150.4 сая төгрөгөөр 57 ширхэг нийт 8,139.6 сая төгрөгөөр 3029 ширхэг суурин болон зөөврийн компьютер худалдан авсан ч хэрэгцээ шаардлагын үндэслэл тооцоолол, салбарын харьяа байгууллагуудад бүртгэлтэй компьютерын тоо хэмжээ, ашиглалтын хугацаатай холбоотой нэгдсэн судалгаа, мэдээлэл дутмаг байна.

1.51. Эдгээр нь Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системд тоног төхөөрөмжийн ТАХ-г салбар, багцаар нь бөөн дүнгээр төлөвлөж байгаатай холбоотой бөгөөд Сангийн яам болон ТЕЗ нар төсвийн саналын хавсралт, нарийвчилсан тооцоолол, судалгааг бүрэн бүрдүүлээгүй, цахим системд бүртгэхгүй байна.

1.52. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бэлтгэх тоног төхөөрөмжийг төлөвлөхдөө салбарын хэмжээний тоног төхөөрөмжийн суурь судалгаа мэдээлэлд тулгуурлан хэрэгцээ шаардлагыг оновчтой тодорхойлж эрэмбэлэх шаардлагатай байна.

1.53. Тоног төхөөрөмжийн ТАХ-г төлөвлөхдөө зардлын эдийн засгийн ангиллыг баримтлаагүйгээс урсгал зардлын шинжтэй бараа материалыг бэлтгэсэн байна. Тухайлбал:

- ССАЖЗС-ын багцын “Аймгийн хөгжимт драмын театрын тоног төхөөрөмж” /Архангай, Эрдэнэбулган сум/ ТАХ-ний хүрээнд хогийн сав, агуулахын тэрэг, орны бүтээлэг, хөшиг, хөнжил, гудас, дэр, ор дэрний цагаан хэрэгсэл, хувцасны өлгүүр, толь, тавиур гэх мэт аж ахуйн бараа материал 641 ширхгийг худалдан авахад 77.0 сая төгрөг ;

- ССАЖЗС-ын багцын “Орон нутгийн музейн соёлын өвийн тоног төхөөрөмж” /Говь-Алтай, Есөнбулаг сум/ ТАХ-ний хүрээнд ахуйн хэрэгцээний болон бусад бараа материал 970 ширхэг үүнд: /ариун цэврийн өрөөний ханын толь, баглаа боодлын материал хөөсөнцөр, галын хор, гутал арчигч, гар хатаагч, шалны хулдаас, шалны будаг, кофены машин, тавиур, хайрцаг сав гэх мэт/ худалдан авахад 66.0 сая төгрөг;
- ГБХНХС-ын багцын 2.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй “Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалт хөгжлийн төв”-ийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянгол дүүрэг/ ТАХ-ний хүрээнд урсгал зардлаас санхүүжүүлэх боломжтой олон төрлийн гадаргуу дээр брайль хэвлэх машины хор, дагалдах хэрэгслийг худалдан авахад 30.0 сая төгрөг;
- УДШЕШ-ийн багцын Салбарын тоног төхөөрөмж /Улаанбаатар, Чингэлтэй/ ТАХ-ний хүрээнд урсгал зардлаас санхүүжүүлэх компьютерын программ хангамжийн 50 ширхэг лиценз 24.1 сая төгрөгөөр худалдан авсан;
- БОУАӨС-ын төсвийн багцын Салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/ ТАХ-ний хүрээнд 75.6 сая төгрөгөөр Firewall лиценз худалдан авсан;
- ЭЗХС-ын багцын 7.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Шинжлэх ухааны академийн харьяа хүрээлэнгийн Хэрэглээний биотехнологийн лабораторийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянзүрх/ ТАХ-ний 1 дүгээр багцын хүрээнд нийлүүлэх 2.7 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй 26 нэр төрлийн тоног төхөөрөмж бүрэн нийлүүлэгдээгүй;
- ССАЖЗС-ын багцын Орон нутгийн музейн соёлын өвийн тоног төхөөрөмж /Говь-Алтай, Есөнбулаг/ ТАХ-ний хүрээнд байгууллагын үйл ажиллагааны урсгалд зардлаас санхүүжүүлэх 18 нэр төрлийн бараа материал, хангамжийн зүйлсийг тоног төхөөрөмжийн ангилалд тусган 85.7 сая төгрөгөөр худалдаж авсан байна.

1.54. Төсвийн хөрөнгө оруулалтын тоног төхөөрөмж ангиллаас урсгал зардлыг санхүүжүүлсэн нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан журамд⁶⁴ нийцэхгүй байна.

1.55. Өмнөх онд хийсэн аудитаар Сангийн сайдад тоног төхөөрөмжийн ТАХ-г үнэлэх, эрэмбэлэх заавар журам боловсруулж, батлах зөвлөмж өгсний дагуу ЦХИХХЯ-тай хамтран төрийн байгууллагуудад ашиглах компьютер, техник хэрэгслийн үзүүлэлт, норм стандартыг салбарын онцлогт уялдуулан боловсруулахаар ажиллаж байгаа нь тоног төхөөрөмжийг ялангуяа компьютер, техник хэрэгслийн хэрэгцээ шаардлагыг бодитоор тодорхойлж, оновчтой төлөвлөхөд ахиц гарах нөхцөл бүрдэхээр байна.

1.56. Цаашид төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системд дэд цэс үүсгэн ТЕЗ төсвийн санал хүргүүлэхдээ тоног төхөөрөмжийг нэр төрөл, тоо ширхэг, нэгжийн болон нийт үнийн дүн бүрээр нарийвчлан төлөвлөж эрэмбэлэх, хэрэгцээ шаардлага, хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийн судалгаа, тооцоолол зэргийг хавсаргаж баримтжуулах, үнэлж эрэмбэлэх, хянах боломжтой байдлаар хөгжүүлэлт хийх шаардлагатай байна.

1.57. Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах 23.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 7 ТАХ-г санхүүжүүлэхээр УИХ-аар баталсныг ТЕЗ-ийн шийдвэрээр багцад хуваарилан 32 багц арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

Хүснэгт 7. ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах төсөл арга хэмжээ, сая төгрөг

№	ТЕЗ	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	ТАХ-ний тоо	Багцад задарсан ТАХ
1	ЭЗХС	7,675.8	7,675.8	1	20
2	ХББОСС	13,730.8	12,160.0	3	9
3	Сангийн сайд	899.0	899.0	1	1
4	Боловсролын сайд	680.0	680.0	1	1
5	БОУАӨС	245.0	95.0	1	1
	Нийт	23,230.6	21,509.8	7	32

1.58. ЭЗХС-ын хувьд 2025 оны төсвийн төслийг Сангийн яаманд 2024 оны 7 дугаар сард хүргүүлэхдээ ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлын хүрээнд хийх ТАХ-г нэр, байршил, зориулалт бүрээр төлөвлөж хүргүүлээгүй, төсвийн төслийг өргөн мэдүүлсний дараа яам агентлаг, аймгуудаас санал авч нэгтгэн тухайн жилд хэрэгжүүлэх ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах 40 ТАХ-г сонгож төлөвлөн 2025 оны 3 дугаар сард баталжээ.

⁶⁴ Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам

1.59. ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ТАХ-ний саналыг ТЕЗ нараас авч нэгтгэн төлөвлөх үе шатыг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан цагалбарт хугацаанд буюу 2024 оны 7 дугаар сарын 25-ны өдрөөс өмнө хэрэгжүүлэхгүйгээр дээрх байдлаар хугацаа алдсанаас шалтгаалан 2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 40 ТАХ-ээс 20 ТАХ-г гүйцэтгэх гэрээг 5 дугаар сарын 31-ний дотор амжиж байгуулаагүйгээс төсвийн тодотголоор хасагдсан байна.

1.60. ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах ажлын төсөвт өртгийг тооцсон үндэслэл, баримталсан журам аргачлал, нарийвчилсан тооцооллын талаарх мэдээллийг Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системд байршуулаагүй, төлөвлөлтийн үе шатанд баримтжуулж архивлаагүй, бүрэн бус зэргээс шалтгаалан бодитой, үндэслэлтэй, зөв тооцсон эсэх нь тодорхойгүй, өртгийн тооцоололд ТЕЗ нараас тавих хяналт хангалтгүй байна. Тухайлбал:

- БСҮХД-ын төсвийн багцаас Сангийн сайдын багцад шилжин хэрэгжсэн 1.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй “Буйр нуурын усан замын боомт байгуулах судалгаа, ТЭЗҮ, зураг төсөв /Зүүн бүс/” ТАХ-ний төсөвт өртгийн нарийвчилсан тооцоолол, үндэслэл тодорхойгүй;
- ХББОСС-ын багцын “Шинэ Хархорум” хотын эхний ээлжийн барилгажилтын төсөл, инженерийн бэлтгэл арга хэмжээ, нэвтрэх хонгилын систем, хоёрдугаар ээлжийн инженерийн шугам сүлжээ болон авто замын ажлын зураг төсөл /Хангайн бүс/ ТЭЗҮ, зураг төсөл ангилалд батлагдсан байхад ТЕЗ-ийн шийдвэрээр багцад хуваарилж төлөвлөхдөө усны барилга байгууламжийн ажлыг төлөвлөсөн, өртгийн тооцоололд батлагдсан норм дүрмийг баримтлаагүй. Үүнд:
 - Магадлалаар баталгаажсан зураг төсөөгүй “Ундны усны эх үүсвэрийн 1 дүгээр талбайн эхний ээлжийн ашиглалтын худаг, барилга байгууламжийн төсөл” ТАХ-г 6.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэйгээр төлөвлөсөн, тухайн ажлын өртгийн 90 хувь нь цэвэр усны цооног өрөмдөх усны барилга байгууламжийн ажил байхад өртгийг батлагдсан төсвийн жишиг норм дүрэмд тулгуурлаж тооцоогүй;
 - “Хэлтгий цагаан нуур сэргээх, бохирдолт, ширгэлтээс хамгаалах судалгаа, төсөл” ТАХ-г 2.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэйгээр төлөвлөхдөө өртгийн 50 хувьд хамаарах гүний усаар сэргээх эх үүсвэрийн гүний 2 худаг гаргах, бохирдол ширгэлтээс хамгаалах, технологийн туршилт зүгшрүүлэлт хийх ажлыг батлагдсан төсвийн жишиг норм дүрэмд үндэслэж тооцоогүй.
- ЭЗХС-ын багцын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах 8,308.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 19 ТАХ-ний төсөвт өртгийн нарийвчилсан тооцоолол тухайн яаманд байхгүйгээс үндэслэлтэй тооцсон эсэх нь тодорхойгүй, яам, агентлаг болон орон нутгаас санал ирүүлсэн ТАХ-ний өртгийн тооцооллыг авч хянахгүйгээр ирүүлсэн саналын дүнгээр төсөвт өртгийг баталсан. Үүнд:
 - УИХ-ын зарим гишүүн болон Архангай, Завхан аймгаас санал ирүүлсэн 2,270.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 ТАХ-ний өртгийг тооцоход баримталсан журам аргачлал, норм норматив тодорхойгүй, нарийвчилсан тооцоолол байхгүй;
 - ЗТЯ, ГХЯ, ЭХЯ, БЯ-аас болон Увс аймгаас санал ирүүлсэн 3,938.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 ТАХ-ний өртгийг тооцоход баримталсан журам аргачлал, норм нормативын нэрийг дурдсан боловч нарийвчилсан тооцоолол, сонгосон жишиг үнэ, ажлын үндэслэл, төвөгшил, холбогдох итгэлцүүр зэрэг мэдээлэл байхгүйгээс нийт өртгийг үндэслэлтэй, зөв тооцсон эсэхийг хянах боломжгүй;
 - БСҮХ-оос Ханги, Булган, Байтаг боомтын хэсэгчилсэн болон хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, зураг төсөв боловсруулах 3 ТАХ-г 2,100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгээр тусгуулахаар санал ирүүлэхдээ өртгийг нарийвчилсан тооцоогүй, “бусад боомтуудад хийгдэх зураг төсвийн ажлын өртөгтэй ойролцоо” гэж судалгаа, тооцоо, үндэслэлгүйгээр ерөнхий дүнгээр санал өгсөн байна.

1.61. Эдгээр нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.2.3.3⁶⁵, 3.2.4⁶⁶ дахь заалт болон Усны цооног өрөмдөх ажлын төсвийн жишиг нормд /БНБД 81-12-02/ нийцэхгүй байна.

1.62. ЭЗХС-ын багцын “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ” /Бүсүүд/ ТАХ-ний багцаас

⁶⁵ 3.2.3.3. “холбогдох баримт бичиг, нотлох баримтаар баталгаажсан, зорилтод нийцсэн, хэрэгцээ шаардлагад тулгуурласан байх;

⁶⁶ 3.2.4. ТЭЗҮС, ТЭЗҮ боловсруулах төсөл, арга хэмжээ болон зөвлөх үйлчилгээний ажил нь холбогдох хууль тогтоомжид үндэслэсэн, тухайн байгууллага, эсхүл салбарын зорилт болон дунд хугацааны төлөвлөлтөд нийцсэн, эрэлт хэрэгцээ, бодит шаардлагад тулгуурласан байна”

200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Их-Уул сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө” /Хөвсгөл аймаг/ ТАХ-г хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нь Хот байгуулалтын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2⁶⁷ дахь заалтад нийцээгүй зөрчил илэрсэн тул албан шаардлага хүргүүлэв.

1.63. Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуульчилсан дээрх ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах ТАХ-г улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төлөвлөж хэрэгжүүлсэн нь хөрөнгө оруулалтын зарим зарцуулалт оновчгүй, үр ашиггүй байгааг харуулж байгаа бөгөөд цаашид улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төлөвлөж санхүүжүүлэхгүй байх шаардлагатай байна.

Шинээр эхлүүлэх төсөл, арга хэмжээний төсөвт өртгөөс тухайн жилд ногдох санхүүжилтийг оновчтой хуваарилаагүй, дутуу төлөвлөж байгаа нь хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна

1.64. УТХО-аар 2025 оноос эхлэн хэрэгжих 2,391.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 106 ТАХ-ээс 506.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 68 ТАХ нь нэг жилд хэрэгжиж дуусах, 1,885.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 38 ТАХ-г хоёроос гурван төсвийн жил дамжин хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

1.65. Нэг жилд хэрэгжих 68 ТАХ-ний санхүүжилтийг 2025 онд бүрэн төлөвлөсөн бол хоёроос гурван жил дамжин хэрэгжих 38 ТАХ-ний 89.5 хувь буюу 34 ТАХ-ний санхүүжилтийг хэрэгжих хугацаанд тэнцүү хуваарилж төлөвлөөгүй байна.

1.66. Эдгээрийн дийлэнх нь төсөвт өртөг өндөртэй, дэд бүтцийн ТАХ бөгөөд дээрх 34 ТАХ-ний 1,795.6 тэрбум төгрөгийн төсөвт өртгийг хэрэгжих хугацаанд тэнцүү хуваарилахад тухайн жилийн санхүүжилтэд 657.1 тэрбум төгрөг төлөвлөхөөр байхад 35.4 хувиар бага буюу 232.3 тэрбум төгрөг дутуу төлөвлөж баталжээ. Тухайлбал:

- ЭХС-ын багцад 2025-2027 онд хэрэгжих Аймгийн төвд баригдаж байгаа дулааны станц төслийн 2 дугаар хэлхээ, дэд бүтэц /Баянхонгор, Баянхонгор сум/ ТАХ-ний 51.9 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөс тухайн жилд ногдох 17.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 5.7 дахин багаар буюу 3.0 тэрбум төгрөгөөр;
- ЭХС-ын багцад 2025-2027 онд хэрэгжих Налайх Дулааны шинэ эх үүсвэр 79 МВт-ын эхний ээлжийн ажил /Улаанбаатар, Налайх дүүрэг/ ТАХ-ний 55.7 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөс тухайн жилд ногдох 18.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 16.9 тэрбум;
- ЭХС-ын багцад 2025-2027 онд хэрэгжих Аймгийн төвд баригдаж байгаа дулааны станцын 2 дугаар хэлхээ, дэд бүтэц /Говь-Алтай/ ТАХ-ний 23.9 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөс тухайн жилд ногдох 7.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 6.1 тэрбум төгрөгөөр;
- ЗТС-ын багцад 2025-2027 онд хэрэгжих Баруун-Урт-Бичигт чиглэлийн хатуу хучилттай авто зам /Зүүн бүс/ ТАХ-ний 319.9 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөс тухай жилд ногдох 106.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 3.3 дахин багаар буюу 31.7 тэрбум төгрөгөөр;
- ЗТС-ын багцад 2025-2027 онд хэрэгжих Өлгий-Сагсай-Улаанхус-Цэнгэл сум чиглэлийн хатуу хучилттай авто замын дуусгал, 66 км /Баруун бүс/ ТАХ-ний 150.9 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөс тухай жилд ногдох 50.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 1.7 дахин багаар буюу 29.7 тэрбум төгрөгөөр;
- ХББОСС-ын багцад 2025-2027 онд хэрэгжих Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах цогц хөтөлбөр, 1 дүгээр үе шатыг аймаг, сумдад хэрэгжүүлэхэд шаардагдах Улсын төсвийн хөрөнгө /Бүсүүд/ ТАХ-ний 56.7 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөс тухайн жилд ногдох 18.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 13.4 тэрбум төгрөгөөр;
- ШЕЗ-ийн даргын багцад 2025-2026 онд хэрэгжих Өмнөговь аймаг дахь шүүхийн барилга /Өмнөговь, Даланзадгад сум/ ТАХ-ний 9.5 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөс тухай жилд ногдох 4.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 2.9 тэрбумаар бага буюу 1.7 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөсөн байна.

⁶⁷ 15.1.2-т “Аймаг, орон нутгийг хөгжүүлэх төсөл, аймгийн төв, нийслэл хот орчмын бүсийн дагуул хот, орон нутгийн зэрэглэлтэй хот болон тосгоны ерөнхий төлөвлөгөө, тэдгээрийн суурь судалгааг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх”

1.67. Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5⁶⁸, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 16.1.6⁶⁹, 17.1.5⁷⁰ дахь заалтад нийцээгүй байна.

1.68. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын ТАХ-ний санхүүжилтийг хэрэгжих хугацаанд тэнцүү хуваарилж төлөвлөөгүй зөрчил жил бүр давтагдаж 2024 онд 9 хувьтай байсан бол 2025 онд 32 хувьд хүрч өссөн байна.

1.69. Тухайн жилийн санхүүжилтийг дутуу төлөвлөх нь хэрэгжилт удаашрах, өртөг нэмэгдэх эрсдэлийг дагуулахаас гадна дараагийн жилүүдэд шинэ ТАХ-г эхлүүлэх хөрөнгө оруулалтын орон зайг хязгаарлаж байна.

Өмнөх онуудаас шилжин тухайн онд хэрэгжиж дуусах зарим төсөл, арга хэмжээний тухайн жилийн санхүүжилтийг дутуу төлөвлөсөн байна

1.70. УТХО-аар өмнөх онуудаас шилжин хэрэгжих 505 ТАХ-ээс 145 ТАХ-ний хэрэгжиж дуусах хугацаа нь 2025 он бөгөөд тухайн онд санхүүжилтийг бүрэн төлөвлөсөн эсэхийг хянахад 24 ТАХ-ний санхүүжих дүнг 52.6 тэрбум төгрөгөөр дутуу төлөвлөжээ. Тухайлбал:

- ЗГХЭГД-ын багцын 2021-2025 онд хэрэгжиж дуусах Удирдлагын академийн кампус, өргөтгөлийн барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/ ТАХ-ний 20.7 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөс тухайн жилд ногдох 6.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 4.0 тэрбум төгрөгөөр;
- ХХААХҮС-ын багцын 2021-2025 онд хэрэгжиж дуусах Бяслэгийн үйлдвэр /Хөвсгөл, Жаргалант, Цагаан-Уул, Галт, Тосонцэнгэл, Ренчинлхүмбэ, Цагаан-Үүр, Рашаант, Их-Уул сум/ ТАХ-ний 6.8 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөс тухайн жилд ногдох 4.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 3.2 тэрбум төгрөгөөр;
- ХХААХҮС-ын багцын 2024-2025 онд хэрэгжиж дуусах Хөдөө аж ахуйн үйлдвэржилтийн агропарк /Сэлэнгэ/ ТАХ-ний 5.0 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөс тухайн жилд ногдох 3.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 2.0 тэрбум төгрөгөөр;
- ГБХНХС-ын багцын 2014-2025 онд хэрэгжиж дуусах Усан спорт цогцолбор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, Найрамдал зуслан/ ТАХ-ний 17.2 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөс тухайн жилд ногдох 4.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 0.9 тэрбум төгрөгөөр;
- ЭЗХС-ын багцын 2012-2025 онд хэрэгжиж дуусах ШУ-ны судалгааны лаборатори, спорт танхимын барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 13 дугаар хороо/ ТАХ-ний 5.2 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөс тухайн жилд ногдох 4.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 1.0 тэрбум төгрөгөөр;
- ЭМС-ын багцын 2022-2025 онд хэрэгжиж дуусах Сэргээн засах эмнэлгийн барилга, 40 ор /Өмнөговь, Даланзадгад сум, 6 дугаар баг/ ТАХ-ний 9.3 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөс тухайн жилд ногдох 4.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 1.0 тэрбум төгрөгөөр;
- ЭМС-ын багцын 2024-2025 онд хэрэгжиж дуусах Эрүүл мэндийн төвийн барилга /Хөвд, Цэцэг сум/ ТАХ-ний 3.4 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөс тухайн жилд ногдох 2.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 1.8 тэрбум төгрөгөөр;
- БС-ын багцын 2024-2025 онд хэрэгжиж дуусах Сургуулийн барилга, 640 суудал /Сүхбаатар, Баруун-Урт сум, 3 дугаар сургууль/ ТАХ-ний 14.7 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөс тухайн жилд ногдох 14.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 11.7 тэрбум төгрөгөөр;
- БС-ын багцын 2019-2025 онд хэрэгжиж дуусах Сургуулийн барилга, 960 суудал /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 2 дугаар хороо/ ТАХ-ний 8.6 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөс тухайн жилд ногдох 1.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 0.7 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөжээ.

1.71. Түүнчлэн 2026, 2027 онд үргэлжлэн хэрэгжих 227 ТАХ-ээс 79 ТАХ-ний төсөвт өртгөөс тухайн жилд ногдох санхүүжих дүнг 144.1 тэрбум төгрөгөөр дутуу төлөвлөсөн байна.

1.72. ТАХ-ний тухайн жилийн санхүүжилтийг дутуу төлөвлөх нь хуулиар батлагдсан хугацаандаа хэрэгжих боломжийг хязгаарлаж, дараагийн жилүүдэд төсөвт илүү ачаалал үүсэх, санхүүжилтээс хамааран хэрэгжих хугацаа хойшлох үр дагавартай байна.

⁶⁸ 29.3.5.шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож, гурван жилд багтаан санхүүжүүлж, дуусгах;

⁶⁹ 16.1.6.хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох санхүүжилт нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваасан хэмжээнээс багагүй байхаар батлах.

⁷⁰ 17.1.5.хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох санхүүжилт нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар төлөвлөх.

Төсвийн төсөлд санал авах, боловсруулж өргөн мэдүүлэх, батлах явцад хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд өөрчлөлт оруулахдаа бодлогын зорилтот түвшин, шалгуур үзүүлэлтийг уялдуулж төлөвлөөгүй байна

1.73. Монгол Улсын 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төсөлд ТЕЗ-аас нийт 2404 ТАХ-г тусгуулах санал хүргүүлсэн бөгөөд Засгийн газраас улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 618 ТАХ-г санхүүжүүлэхээр өргөн мэдүүлснийг УИХ-аар хэлэлцэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар анх 9,132.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 621 ТАХ-г 3,124.1 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

1.74. ТЕЗ нараас шинээр хэрэгжүүлэхээр төсвийн төсөлд санал ирүүлсэн ТАХ-ний тоог дараах байдлаар бууруулж Засгийн газраас нэгтгэн төсвийн төсөлд өргөн мэдүүлсэн байна.

Хүснэгт 8. Зарим ТЕЗ-дын төсвийн төслийн санал, өргөн мэдүүлсэн болон батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ

№	ТЕЗ	Төсвийн төслийг боловсруулж батлуулах явцад өөрчлөгдсөн хөрөнгө оруулалтын ТАХ-ний тоо		
		Санал хүргүүлсэн	Өргөн мэдүүлсэн	Батлагдсан
1	Боловсролын сайд	473	189	190
2	ЭМС	218	38	39
3	ЭХС	154	37	38
4	ЗТС	176	96	97
5	ХББОСС	325	54	54

Эх сурвалж. Сангийн яамны мэдээлэл, 2025 оны төсвийн тухай

1.75. ТЕЗ нарын төлөвлөсөн ТАХ-ний тоонд дээрх байдлаар өөрчлөлт орсон ч Төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтад тусгах хөрөнгө оруулалтын төсөл, ТАХ-ний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшнийг Сангийн яам нэгтгэн боловсруулж УИХ-д өргөн мэдүүлэхдээ өөрчлөлт оруулахгүйгээр дараах байдлаар нэгтгэн өргөн мэдүүлж батлуулжээ.

Хүснэгт 9. УТХО-аар хэрэгжүүлэх зарим төсөл, арга хэмжээний үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлт, төлөвлөсөн зорилтот түвшний үзүүлэлтүүд

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Зорилтот түвшин		
				ТЕЗ-ийн санал	Өргөн мэдүүлсэн	Баталсан
1	Нэг ээлжээр хичээллэх боломжтой төрийн өмчийн сургуулийн хувь	Хувь	50.2	60	60	60
2	Дулааны шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлт хийх	Км	66.5	60.4	60.4	60.4
3	Орон нутгийн цахилгаан хангамж дамжуулах, түгээх сүлжээний өргөтгөл шинэчлэл хийх	Сумдын тоо	28	31	31	31
4	Ашиглалтад оруулах олон улс, улсын болон орон нутгийн чанартай авто зам	Км	1100	1245.6	1245.6	1245.6
5	Хатуу хучилттай авто замын нийт авто замын сүлжээнд эзлэх хувь	Хувь	53	57.7	57.7	57.7
6	Шинээр барих болон шинэчлэх цэвэр усны шугам сүлжээний хэмжээ	Км	30	50	50	50
7	Шинээр барих болон шинэчлэх бохир усны шугам сүлжээний хэмжээ	Км	20	50	50	50
8	Шинээр барих цэвэрлэх байгууламжийн бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл	Хувь	70	60	60	60

Эх сурвалж. Төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралт, Сангийн яамнаас ирүүлсэн мэдээлэл

1.76. Төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар батлагдсан хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлт, зорилтот түвшнийг нэгтгэн боловсруулахдаа УТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний тоо, хүчин чадалтай уялдуулж төлөвлөх, бодлогын зорилтот үр дүнд чиглэсэн оновчтой шалгуур үзүүлэлтээр хэмжиж төлөвлөх шаардлагатай байна.

БҮЛЭГ 2. ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗУРАГ ТӨСӨЛ, ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, АЖЛЫН ДААЛГАВРЫГ БОЛОВСРУУЛАХАД ХУГАЦАА АЛДАЖ БАЙГАА НЬ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНД СӨРГӨӨР НӨЛӨӨЛЖ БАЙНА

Захиалагч ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг хугацаанд нь хүргүүлээгүйгээс тендер шалгаруулалтын 52 хувь нь 4 дүгээр сараас хойш зарлагджээ

2.1. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 730 ТАХ-ний жагсаалтыг баталснаас 110 ТАХ нь 2025 оноос эхлэн шинээр хэрэгжих ТАХ байна.

2.2. Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 233 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар ТХААГ-т худалдан авах ажиллагааг зохион байгуулах 2,067.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 90 ТАХ-ний жагсаалтыг, 2 дугаар хавсралтаар нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэх 50.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1 ТАХ-ний жагсаалтыг тус тус баталжээ. Харин 605.6 тэрбум төгрөгийн 20 ТАХ-ний худалдан авах ажиллагааг ТЕЗ нар зохион байгуулахаар шийдвэрлэсэн байна.

Хүснэгт 10. УТХО-аар шинээр хэрэгжих ТАХ-ний ХАА-г зохион байгуулах эрх шилжүүлсэн байдал

№	ХАА-ны эрх шилжүүлсэн	Төсөвт өртөг /тэрбум төгрөг/	Эзлэх хувь	ТАХ-ний тоо	Багцад задарсан ТАХ	Эзлэх хувь
1	ТХААГ	2,067.5	77.3	90	522	71.5
2	ТЕЗ нарт	605.6	22.7	20	208	28.5
	Нийт	2,673.1	100	110	730	100

2.3. Засгийн газрын 2024 оны 233 дугаар тогтоолд ХАА-г зохион байгуулахад шаардлагатай ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, зураг төсөв зэрэг мэдээллийг ТХААГ-т болон аймаг, нийслэлийн ХААГ-т 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн дотор хүргүүлэхийг ТЕЗ нарт үүрэг болгожээ.

2.4. ТХААГ-ын хэрэгжүүлэх 90 ТАХ нь 522 багцад, ТЕЗ нарын хэрэгжүүлэх 20 ТАХ нь 208 багцад, нийт 730 багц ТАХ болж задарсан байна.

2.5. ТХААГ-т эрх шилжүүлсэн 90 ТАХ-ээс Засгийн газрын 2025 оны 144 дугаар тогтоолоор “Сэлгэн ажиллах дата төвийн нөөцийн тоног төхөөрөмж”, 162 дугаар тогтоолоор “Төсөл, арга хэмжээний бэлтгэл хангах хөрөнгө оруулалт /Бүсүүд”, “Даланзадгад-Мандалговь чиглэлийн хатуу хучилттай авто замын их засвар”-ын 177.5 тэрбум төсөвт өртөгтэй 3 ТАХ /24 багц/ ТХААГ-ын хэрэгжүүлэх ТАХ-ний жагсаалтаас хассан байна.

2.6. Төрийн худалдан авах ажиллагааны газар зохион байгуулсан 494 ТАХ-ний 16.1 хувь буюу 80 ТАХ-ний тендер зарлахад шаардлагатай баримт бичгийг ТЕЗ нар Засгийн газрын тогтоолд заасан хугацаанд, 83.9 хувь буюу 494 ТАХ-ний холбогдох баримт бичгийг хугацаа хоцорч 2-5 дугаар сард хүргүүлжээ. Үүнд:

- 1 дүгээр сард 16 хувь буюу 80 ТАХ;
- 2 дугаар сард 34.2 хувь буюу 169 ТАХ;
- 3 дугаар сард 32.3 хувь буюу 159 ТАХ;
- 4 дүгээр сард 17.1 хувь буюу 85 ТАХ;
- 5 дугаар сард 0.2 хувь буюу 1 ТАХ-ний ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, зураг төсвийг тус тус хүргүүлсэн;
- ЭМЯ-ны 2 ТАХ, Боловсролын яамны 1 ТАХ-ний холбогдох мэдээллийг хүргүүлээгүй байна.

2.7. ТЕЗ нар тендер зарлахад шаардлагатай баримт бичгийг тогтоолд заасан хугацаанд ТХААГ-т хүргүүлээгүйгээс тендер шалгаруулалтын 52 хувь нь оройтож зарлагдан 4 дүгээр сараас хойш зохион байгуулагдсанаар 2-3 сарын хугацаа алдсан байна. Үүнд:

- 1 дүгээр сард 36 ТАХ буюу 6.2 хувь;
- 2 дугаар сард 87 ТАХ буюу 15.2 хувь;
- 3 дугаар сард 151 ТАХ буюу 26.3 хувь;
- 4 дүгээр сард 252 ТАХ буюу 44 хувь;
- 5 дугаар сард 46 ТАХ буюу 8.3 хувь нь тендер шалгаруулалт зарласан байна.

2.8. Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд ТХААГ болон ТЕЗ нар УТХО-ын 572 ТАХ-ний тендер шалгаруулалт зарлаж үүнээс 61.1 хувь буюу 350 ТАХ-ний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулжээ.

2.9. Нээлттэй тендер шалгаруулалтын аргаар тендер зарлах, хүлээн авч хянаж үнэлэх, шийдвэр гаргаж үр дүнг нийтлэх, гэрээ байгуулах хүртэл дунджаар ажлын 36 өдөр буюу хуанлийн 50 хоног зарцуулахаар хуулийн хугацаатай байгаа бөгөөд тендер амжилтгүй болох, гомдол гарах тохиолдолд 14-30 хүртэл хоног нэмж зарцуулахаар байна.

2.10. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын ТАХ-ний ХАА-г тухайн жилийн 5 дугаар сарын 31-ний өдрийн дотор зохион байгуулж дуусгаагүй, гэрээ байгуулаагүй тохиолдолд санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцохоор Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1.1, 13.1.2 дахь заалтад хуульчилсан нь 2025 оноос хэрэгжиж эхэлсэн.

2.11. ТЕЗ нар ТАХ-ний ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, зураг төсвийг боловсруулж батлуулах бэлтгэл ажлыг бүрэн хангаагүй, зураг төсөв, техникийн тодорхойлолтыг ТХААГ ирүүлээгүйгээс шалтгаалж нийт тендер шалгаруулалтын 71 хувь нь 3 болон 4 дүгээр сард зохион байгуулагдаж байгаа нь тухайн тендер шалгаруулалтын явцад гомдол гарсан тохиолдолд 5 дугаар сарын 31-ны өдөр багтан гэрээ байгуулах боломжгүйд хүргэж байна.

2.12. Тендер зарлахаас үр дүнг нийтлэх хүртэл хугацаа 409 ТАХ-нд дунджаар хуанлийн 49 хоног зарцуулсан бөгөөд нэг удаагийн сонгон шалгаруулалтаар гүйцэтгэгч шалгарч, гомдол гараагүй гэж тооцвол ажлын 6 өдрийн дараа гэрээ байгуулах нөхцөл бүрдэх ба нийтдээ 60 орчим хоног буюу 2 сарын хугацаа зарцуулахаар байна.

2.13. Эдгээр боломжит хугацаагаар тооцоход шинээр эхлүүлэх ТАХ-ний ХАА-г хуульд заасан хугацаанд зохион байгуулж дуусгахын тулд ТЕЗ нар ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, зураг төсвийг ХАА-ны нэгжид тухайн оны 4 дүгээр сарын 01-ээс өмнө хүргүүлэх шаардлага тулгарч, хугацаа хойшлох тутам гэрээ байгуулах боломжгүйд хүрэх эрсдэл нэмэгдэж байна.

2.14. Тухайлбал 8 ТЕЗ 14 ТАХ-ний ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, зураг төсвийг ТХААГ-т 2025 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш ирүүлснээс 28.6 хувь нь тендер зарласан ч гэрээ байгуулаагүй, БЯ 2 ТАХ, ЭХЯ 1 ТАХ, ЭМЯ 3 ТАХ-ний холбогдох материалыг хүргүүлээгүйгээс тендер зарлаагүй байна.

2.15. Иймд ТБОНӨХБАҮХАТ хуульд худалдан авах ажиллагааны эрх шилжүүлэх шийдвэр гаргах хугацаа, ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, зураг төсвийг ХАА-г зохион байгуулах нэгжид хүргүүлэх хугацааг тодорхой тусгах замаар эрх зүйн зохицуулалтыг сайжруулах шаардлагатай байна.

Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа нэг төрлийн, ойролцоо төсөвтэй тендерт оролцогчдод тавигдах шалгуурыг харилцан адилгүй тогтоосон байна

2.16. Захиалагч нь тухайн тендерт оролцогчийн санхүүгийн болон техникийн чадавх, туршлагын шаардлага, шалгуур үзүүлэлтийг ТАХ-ний цар хүрээ, онцлогт үндэслэн тендер шалгаруулалтын баримт бичигт тусгаж сонгон шалгаруулалтыг зохион байгуулах чиг үүрэгтэй.

2.17. УТХО-аар хэрэгжсэн барилга байгууламж ангиллын ТАХ-ний 2025 онд зохион байгуулсан тендерийн баримт бичгүүдэд тусгасан тендерт оролцогчдод тавьсан санхүүгийн болон техникийн чадавх, туршлагын шаардлагуудад харьцуулсан судалгаа хийж үзэхэд тендерийн баримт бичгийг жишиг баримт бичигт тулгуурлан боловсруулж байгаа боловч захиалагч буюу ХАА-г зохион байгуулагч байгууллага өөр байх тохиолдолд ижил төрлийн, ойролцоо төсөвт өртөгтэй ажилд харилцан адилгүй шаардлага, шалгуур тогтоосон байна. Тухайлбал:

- *Инженерийн шугам сүлжээний барих ижил төрлийн ТАХ-г харьцуулахад бага төсөвт өртөгтэй ажлын тендерт оролцогчдод илүү өндөр борлуулалтын орлого шаардсан бол түүнээс өндөр төсөвт өртөгтэй ажилд харьцангуй бага орлогын шаардлага тусгасан;*

ХАА-г зохион байгуулсан	Төсөл, арга хэмжээ	Төсөвт өртөг (тэрбум)	Борлуулалтын орлогын шаардлага	
			Төсөвт өртгийн %	Босго дүн (тэрбум)
Увс аймгийн ЗДТГ	Сумын төвийн инженерийн шугам сүлжээний ажил	4.5	50%	2.3
ХББОСЯ	Сумын төвийн инженерийн шугам сүлжээний ажил	5.2	30%	1.6

- Авто замын ижил төрлийн ТАХ-г харьцуулахад бага төсөвт өртөгтэй ажлын тендер оролцогчдод илүү өндөр борлуулалтын орлого шаардсан бол түүнээс өндөр төсөвт өртөгтэй ажилд харьцангуй бага орлоготой байх шаардлагыг тусгасан;

ХАА-г зохион байгуулсан	Төсөл, арга хэмжээ	Төсөвт өртөг (тэрбум)	Борлуулалтын орлогын шаардлага	
			Төсөвт өртгийн %	Босго дүн (тэрбум)
ТХААГ	Өлгий-Сагсай-Улаанхус-Цэнгэл сум 66км	163.7	5.4%	8.9
	Бор өндөр 179.9км /Багц 3/	47.0	30%	14.1
	Нөмрөг-Улаангом чиглэлийн авто зам	46.0	11.4%	5.2
	Мандал сумын Түнхэл тосгоноос Төв аймгийн Батсүмбэр хүртэлх авто зам /Төвийн бүс/	52.4	8.9%	4.7

2.18. ТБОНӨХБАҮХАТ хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2⁷¹-д болон 15 дугаар зүйлийн 15.1⁷²-д тендер шалгаруулалтад оролцогчдод тавигдах зайлшгүй шаардлагад үндэслэн санхүүгийн болон техникийн чадавх, туршлагын шаардлага, түүний шалгуур үзүүлэлтийг тус тус ТШББ-т тусгахаар хуульчилсан.

2.19. ТШББ-т хуульд заасны дагуу ижил төстэй ажил гүйцэтгэсэн тухай холбогдох нотлох баримт ирүүлэхийг оролцогчоос шаардаж байгаа боловч ижил төстэй ажлыг тооцох шалгуур үзүүлэлтийг тодорхой тусгахгүй байна.

2.20. БСҮХД-ын /хуучнаар/ багцаас Сангийн сайдын багцад шилжин хэрэгжсэн 1.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй “Буйр нуурын усан замын боомт байгуулах судалгаа, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв” /Зүүн бүс/ ТАХ-ний ТШББ-ийг үнэлгээний хороо боловсруулахдаа тусгай зөвшөөрлийн шаардлагыг тусгаагүй ба ажлын даалгаварт салбарын мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэх, ТЭЗҮ-д экспертизийн дүгнэлт гаргуулж магадлалаар баталгаажуулах шаардлагыг мөн тусгахгүй орхигдуулжээ.

2.21. Энэ нь Хот байгуулалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6⁷³ дахь, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1.3.8⁷⁴-д заасан буюу ХБ-1.1, ХБ-1.2⁷⁵ тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагыг зөрчсөн байна.

2.22. Үүнээс шалтгаалан тусгай зөвшөөрөлгүй оролцогч тендер оролцон гүйцэтгэгчээр шалгарч гэрээ байгуулсан ба хийж гүйцэтгэсэн суурь судалгаа, ТЭЗҮ нь үндэслэлтэй, шаардлага хангасан эсэхэд мэргэжлийн экспертизээр хянуулж баталгаажуулах боломжгүй нөхцөл байдалд хүрчээ.

⁷¹ 11.2. “Оролцогчийг тендер бэлтгэж ирүүлэхэд шаардагдах мэдээлэл, оролцогчид тавих шаардлага, заавар, хамгийн сайн тендерийг шалгаруулах шалгуур үзүүлэлт, аргачлал, захиалагчийн санал болгож байгаа гэрээний нөхцөлүүд, техникийн тодорхойлолт, тендерийн жишиг маягыг тендер шалгаруулалтын баримт бичигт тусгана”

⁷² 15.1. “Захиалагч гэрээний үүрэг гүйцэтгэхэд сонирхогч этгээд болон оролцогчид тавигдах зайлшгүй шаардлагад үндэслэсэн санхүүгийн болон техникийн чадавх, туршлагын талаар хангавал зохих доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг тендер шалгаруулалтын баримт бичигт заана”

⁷³ 11.6. “Хот байгуулалтын баримт бичгийн захиалагч нь хот байгуулалтын баримт бичигт холбогдох хууль тогтоомж, норм ба дүрэм, журамд заасны дагуу улсын экспертизийн дүгнэлт гаргуулна”

⁷⁴ 8.1.3.8. “Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхэлнэ: Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах”

⁷⁵ ХБ-1.1. “Хот тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хот, тосгоныг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах тусгай зөвшөөрөл”, ХБ-1.2. “Бүс нутгийн хөгжлийн төсөл, аялал жуулчлал, дэд бүтцийн хөгжлийн төсөл боловсруулах тусгай зөвшөөрөл”

2.23. Засгийн газрын 2016 оны 35 дугаар тогтоолоор “Ногоон хөгжлийн 2016-2030 оны бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г баталж тухайн төлөвлөгөөний 3.6 дахь хэсэгт Засгийн газрын худалдан авалтын 20-оос доошгүй хувийг “байгаль орчинд ээлтэй, үр ашигтай, хэмнэлттэй бараа, ажил үйлчилгээ авахад зарцуулах”-аар төлөвлөж, Сангийн сайдын 2023 оны 66 дугаар тушаалаар “Ногоон худалдан авах ажиллагааны техникийн тодорхойлолт боловсруулах аргачлал”-ыг баталсан боловч ТЕЗ нар техникийн тодорхойлолт, ажлын даалгаврыг боловсруулахдаа тус аргачлалыг ашиглаагүй байна.

2.24. Ногоон худалдан авалтыг дэмжих, эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй бараа бүтээгдэхүүн худалдан авах чиглэлд төлөвлөсөн зорилт арга хэмжээ, батлагдсан аргачлал байгаа хэдий ч хэрэгжилт хангалтгүй байгаа нь тус төлөвлөгөөний зорилтыг биелүүлэх боломжгүйд хүргэж байна.

Худалдан авах ажиллагааг эхлүүлэхэд хугацаа алдсанаас тендер шалгаруулалт зарласан төсөл, арга хэмжээний 39 хувьд нь гэрээ байгуулаагүй, төлөвлөсөн санхүүжилт төсвийн хэмнэлтэд тооцогдсон байна

2.25. ТХААГ болон бусад ТЕЗ нь 2025 онд нийт 572 ТАХ нээлттэй тендер шалгаруулалтыг зарлаж үүнээс 2025 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 61.1 хувь буюу 350 ТАХ-нд шалгарсан оролцогчтой гэрээ байгуулжээ.

Хүснэгт 11. Тендер шалгаруулалтын үр дүн, гэрээний мэдээлэл

№	Байгууллага	Тендер зарласан			Гэрээ байгуулсан			Гэрээ байгуулаагүй		
		Төсөвт өртөг	ТАХ	Хувь	Төсөвт өртөг	ТАХ	Хувь	Төсөвт өртөг	ТАХ	Хувь
1	ТХААГ	1,873.7	494	100	1,595.4	297	60.1	278.3	197	39.9
2	ЗТЯ	159	5	100	37.6	3	60	121.4	2	40
3	ХББОСЯ	303.1	49	100	181.7	28	57.1	121.4	21	42.9
4	УДШ	6	12	100	4.5	11	91.6	1.5	1	8.4
5	УЕП	3.7	5	100	3.7	5	100	-	-	100
6	АТГ	2.2	4	100	2.2	4	100	-	-	100
7	СЗХ	0.25	1	100	0.25	1	100	-	-	100
8	Үндэсний дата төв	9.5	2	100	6.8	1	50	2.7	1	50
	Нийт	2,357.4	572	100	1,832.1	350	61.1	525.3	222	38.9

2.26. Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан 2,357.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 572 ТАХ-ээс 2025 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 525.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 222 ТАХ-ний гэрээ байгуулагдаагүйгээс санхүүжилт нь хэмнэлтэд тооцогдон төсвийн тодотголоор хасагдсан байна.

2.27. ЭМЯ худалдан авах тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолтыг боловсруулж батлуулан ТХААГ-т хүргүүлэхэд хугацаа алдаж “Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж” /Улсын хэмжээнд/ жагсаалтыг 2025 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр, Хавдрын эмнэлгийн зориулалтаар ашиглах объектын тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолт жагсаалтыг 5 дугаар сарын 19-ний өдөр тус тус хүргүүлжээ. Үүнээс шалтгаалан тендер шалгаруулалт оройтож 5 дугаар сард зарласан ч зарим багц амжилтгүй болсноор 72 ТАХ хэмнэлтэд тооцогдож энэ нь 2025 онд амжилтгүй болсон нийт тендер шалгаруулалтын 32.2 хувийг дангаар эзэлж байна.

2.28. ТХААГ болон ТЕЗ нар зохион байгуулж гэрээ байгуулсан 1,832.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 350 ТАХ-ний ХАА-ны үр дүнд нийт төсөвт өртгийн 3.6 хувьтай тэнцэх 66.8 тэрбум төгрөгийн тендерийн хэмнэлт үүсжээ.

Хүснэгт 12. Гэрээ байгуулсан ХАА-ны үр дүнд үүссэн тендерийн хэмнэлт, тэрбум төгрөгөөр

№	ХАА зохион байгуулсан байгууллага	Төсөвт өртөг	Гэрээний дүн	ТАХ-ний тоо	Тендерийн хэмнэлт	
					Дүн	Хувь
1	ТХААГ	1,595.4	1,534.7	297	60.7	90.8
2	7 ТЕЗ	236.8	230.7	53	6.1	9.2
	Нийт	1,832.2	1,765.4	350	66.8	100

2.29. ТЕЗ нар дунджаар 4.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 53 ТАХ-ний тендер шалгаруулалтыг зохион байгуулж төсөвт өртөгөөс дунджаар 115 сая төгрөг хэмнэсэн бол ТХААГ дунджаар 5.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 297 ТАХ-ний тендер шалгаруулалтаас 204.3 сая төгрөгийн хэмнэлт үүсгэсэн нь ТЕЗ нартай харьцуулахад 2 дахин их байна.

2.30. ЭМЯ-аас “Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж” /Улсын хэмжээнд/ ТАХ-ний хүрээнд “Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын тоног төхөөрөмж” багцын худалдан авах ажиллагааг зохион байгуулж тухайн тендерийн хэмнэлтээс 51.2 сая төгрөгийн 2ш Тоёота пробокс автомашин, 18.5 сая төгрөгийн 7ш суурин компьютерын иж бүрдлийг нэмэлт гэрээ байгуулан худалдан авсан байна.

2.31. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3-д “Худалдан авах ажиллагаанаас үүссэн хэмнэлтийг зарцуулахгүй байх” заалтыг зөрчсөн байна.

Зарим төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтад шаардлага хангаагүй оролцогчийг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулж гэрээ байгуулсан байна

2.32. ТХААГ-аас зохион байгуулсан ТШББ-т хяналт хийхэд ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын шаардлагыг тусгасан ч түүнийг нотлох шалгуур үзүүлэлтийг нарийвчлан тусгахгүй орхигдуулах тохиолдол байгаа ба тендерт оролцогчоос шаардсан ижил төстэй туршлагын шаардлага нь бие даан гүйцэтгэсэн ажил байх эсэх, туслан гүйцэтгэгчээр ажилласан туршлагыг тооцох эсэх нь тодорхойгүй байна.

2.33. ТШББ-т шаардсан тусгай зөвшөөрлийг ирүүлээгүй, тусгай зөвшөөрөлгүй үедээ байгуулсан ажлын гэрээ ирүүлсэн тохиолдолд эрх бүхий эсэхийг үнэлгээний хороо хянаж шалгахгүй орхигдуулснаас шаардлага хангахгүй оролцогчийг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулсан байна. Тухайлбал:

- ХББОСС-ын багцын 1.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй “Авто машингүй гудамж - авто зогсоолын техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөв” /Улаанбаатар/ ТАХ-ний ТШББ-ийн 19.3-т “ХББОСЯ-ны ЗТ-2.1, 10.1, 10.2 тусгай зөвшөөрөлтэй байх” шаардлагыг хангаагүй буюу ЗТ-10.1 тусгай зөвшөөрөлгүй оролцогчийг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулсан; /Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1.5. “Зам, тээврийн чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх бөгөөд дараах этгээд олгоно”, 8.1.5.2. “Авто зам, замын байгууламжийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах, барих, арчлах, засварлах, техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлэх”/
- ЭЗХС-ын багцын 0.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй “Ханги боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө” /Өмнөговь, Хатанбулаг сум/ ТАХ-ний ТШББ-ийн 19.3-т шаардсан ХББОСЯ-ны ЗТ-6.1, 6.2, 6.3, 6.4, 7.1, 7.2 тусгай зөвшөөрөлгүй оролцогчийг шалгаруулсан;
- ЭЗХС-ын багцын 0.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй “Булган боомтын ачаа тээврийн терминалыг хилийн 126, 127 тэмдэгтэд шилжүүлэх зураг төсөв” /Ховд, Булган сум/ ТАХ-ний ТШББ-ийн 19.3-т шаардсан ХББОСЯ-ны ЗТ-4.2, 6.3, 6.4, 7.1, 7.2, 7.3 тусгай зөвшөөрөлгүй оролцогчийг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулсан;

2.34. Үнэлгээний хороо ТШББ-т тусгасан шаардлагыг хангаагүй оролцогчийг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулсан нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3 дахь заалтыг зөрчсөн байна.

2.35. ТХААГ-аас ХАА-г зохион байгуулсан ЗТС-ын багцын 1,098.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 16 ТАХ-ний ТШББ-т “Ерөнхий инженерийг хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан ажилд давхцуулан санал болгоогүй байх” шаардлагыг тусгасан ч түүнийг нотлох шалгуур үзүүлэлтийг тусгаагүй, хэрхэн хянаж үнэлж байгаа нь тодорхойгүйгээс зарим тохиолдолд оролцогчийг шаардлага хангахгүй шалтгаанаар хассан ч 118.4 тэрбум төгрөгийн ТАХ-ний тендерт тухайн шаардлагыг хангаагүй оролцогчийг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулсан байна. Тухайлбал:

- ЗТС-ын багцын 118.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй “Орхонтуул-Цээл чиглэлийн хатуу хучилттай авто зам, 62.6 км” /Төвийн бүс/ ТАХ-ний тендерт оролцогч нь 2022 онд зарласан ЗТХЯ-202212030 дугаартай ажилд шалгарч тухайн ажил нь дуусаагүй үргэлжлэн хэрэгжиж ерөнхий инженерээ давхардуулсан эсэхийг нягтлан шалгалгүйгээр гүйцэтгэгчийн албан бичигт үндэслэн гүйцэтгэгчээр сонгон шалгаруулсан;

2.36. Энэ нь ТХААГ-ын үнэлгээний хороо ТБОНӨХБАҮХАТ хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д заасан тендерийг шалгуурын дагуу үнэлэх, 50 дугаар зүйлийн 50.2.2-д заасан тендерийг нээх,

хянан үзэх, үнэлэх чиг үүргээ хэрэгжүүлээгүй, тус хуулийн хариуцлагатай байх зарчимд нийцээгүй байна.

2.37. Үнэлгээний хорооны гишүүд тендерт оролцогчийн хэрэгжүүлж буй бусад ажлын мэдээллийг тухайн үед шалгах шаардлагатай боловч ТХААГ нь Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системд нэвтрэх эрхгүй, тендерт оролцож буй оролцогчийн ирүүлсэн материалыг бусад цахим системээс нягтлан шалгах боломж хязгаарлагдмал байна.

2.38. БОУАӨС-ын 2025 оны А/08 дугаар тушаалаар “Нэгдсэн Үндэстний Байгууллагын “Цөлжилттэй тэмцэх тухай” суурь конвенцын талуудын 17 дугаар бага хурлыг зохион байгуулахтай холбоотой хөрөнгө оруулалтын ажил” ТАХ-г Нийслэлийн Засаг даргад эрх шилжүүлжээ.

2.39. ТБОНӨХБАҮХТ хуулийн 10 дугаар зүйлийн 10.8 дахь заалтыг баримтлан Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/749 тоот захирамжаар дээрх ТАХ-ний хүрээнд хийгдэх 10.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй авто зам, зогсоолын ажлыг “Улаанбаатар зам засвар, арчлалтын газар” ОНӨААТҮГ-тай шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлэхээр шийдвэрлэжээ.

2.40. Нийслэл хотын аж ахуй, инженер хангамжийн бараа, ажил, үйлчилгээг тухайн салбарын төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газраар гүйцэтгүүлэх нь үр ашигтай гэж захиалагч үзсэн тохиолдолд нээлттэй тендер шалгаруулалтын аргыг хэрэглэхгүй байхаар ТБОНӨХБАҮХАТ хуулийн 10.8-д заасан байдаг.

2.41. Гэтэл шууд гэрээ байгуулах нь үр ашигтай гэх үндэслэлээр гэрээ байгуулсан боловч “Улаанбаатар зам засвар, арчлалтын газар” ОНӨААТҮГ нь тухайн ажлыг гүйцэтгэхгүйгээр “Сотэ кашмер” ХХК-тай 10.2 тэрбум төгрөгийн дүнгээр 2025 оны 8 дугаар сарын 29-ний өдөр шууд гэрээг байгуулан гүйцэтгүүлж байгаа нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 32.1, 41.1.1 дэх заалтыг тус тус зөрчсөн байна. Хууль зөрчиж гэрээ байгуулсан уг асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэв.

Тендер шалгаруулалтад гаргасан гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийгээгүй, алдаа зөрчлийн шалтгаан нөхцөлийг тодорхойлж бууруулахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлээгүйгээс хяналт, хариуцлага сул байна.

2.42. Тендерт оролцогч сонгон шалгаруулалтын дүнг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд хуульд заасны дагуу захиалагчийн шийдвэр гарснаас хойш ажлын 5 хоногийн дотор гомдол гаргах эрхтэй бөгөөд ТБОНӨХБАҮХТХ-ийн 59.8.-д *“Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тендер шалгаруулалтад холбоотой цахим системд байршуулсан баримт бичиг, мэдээлэл, тендер шалгаруулалтын хувийн хэрэгт үндэслэн гомдлын үндэслэлийн хүрээнд ажлын 10 өдөрт багтаан гомдлыг хянан шийдвэрлэнэ”* гэж заасан.

2.43. Төрийн худалдан авах ажиллагааны газар, Төсвийн ерөнхийлөн захирагч нар 2025 онд УТХО-аар хэрэгжүүлэх 572 ТАХ-ний худалдан авах ажиллагааг зохион байгуулснаас 39.6 хувь буюу 227 ТАХ-ний тендер шалгаруулалтад гомдол гарсан байна.

2.44. Сангийн яамны холбогдох нэгж нь нийт 104 гомдол хянан үзсэнээс 6 гомдлыг ТБОНӨХБАҮХТ хуулийн 59 дүгээр зүйлийн 59.8⁷⁶ дахь хэсэгт заасан хугацаанд шийдвэрлээгүй байна.

2.45. Хүлээн авч хянасан нийт 104 гомдлын 75 хувь буюу 78 гомдлыг үндэслэлтэй гэж үзэж дүгнэлт, зөвлөмжийг ХАА-г зохион байгуулсан байгууллага, нэгжид хүргүүлсэн байна.

⁷⁶ 59.8. “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тендер шалгаруулалтад холбоотой цахим системд байршуулсан баримт бичиг, мэдээлэл, тендер шалгаруулалтын хувийн хэрэгт үндэслэн гомдлын үндэслэлийн хүрээнд ажлын 10 өдөрт багтаан гомдлыг хянан шийдвэрлэнэ”

Хүснэгт 13. Худалдан авах ажиллагааны гомдол

№	ХАА-г зохион байгуулсан захиалагч	Гомдлын тоо			Үүнээс үндэслэлтэй	
		Нийт	Буцаасан	Хянасан	Гомдлын тоо	Эзлэх хувь
1	Төрийн худалдан авах ажиллагааны газар	202	110	92	67	73
2	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам	8	5	3	3	100
3	Улсын нэгдүгээр төв эмнэлэг	6	1	5	5	100
4	Эрчим хүчний яам	4	3	1	-	100
5	Зам, тээврийн яам	2	2	-	-	-
6	Улсын дээд шүүх	1	1	-	-	-
7	Авлигатай тэмцэх газар	1	-	1	1	100
8	Үндэсний дата төв	3	1	2	2	100
	Нийт	227	123	104	78	75

2.46. Сангийн яамны ХААБХ нь 47 ТАХ-ний ХАА-тай холбоотой 78 гомдлыг хянаж дахин үнэлгээ хийх 55, захиалагч үнэлгээний хорооны зөвлөмж хууль тогтоомжид нийцсэн эсэхэд хяналт тавих 12, нийт 67 дүгнэлт зөвлөмж хүргүүлсэн ч хэрэгжилтийг хянаагүй, хэрхэн шийдвэрлэсэн талаар нэгдсэн судалгаа мэдээлэлгүй, гомдлыг хянах явцад илэрч байгаа нийтлэг алдаа зөрчилд судалгаа шинжилгээ хийгээгүй, шалтгаан нөхцөлийг тодорхойлох, зөрчлийг бууруулах чиглэлд арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй байна.

2.47. Энэ нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 55 дугаар зүйлийн 55.1.6⁷⁷-д заасан худалдан авах ажиллагаанд холбогдох хууль тогтоомж, журам, заавар, аргачлалын хэрэгжилтэд хяналт тавьж, дүн шинжилгээ хийх чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэхгүй байгааг харуулж байна.

2.48. ТХААГ-аас зохион байгуулсан УТХО-аар 92 ТАХ-ний тендерт оролцогчоос гаргасан гомдлыг Сангийн яамны ХААБХ хүлээн авч хянаад үндэслэл бүхий 67 ТАХ-ний гомдлыг шийдвэрлэж холбогдох дүгнэлт, зөвлөмжийг ТХААГ-т хүргүүлжээ.

2.49. Тухайн 67 дүгнэлт, зөвлөмжийн 12 нь тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журмын 5 дугаар зүйлийн 5.9 дахь заалтыг хэрэгжүүлэх буюу ТБОНӨХБАҮХАТ хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.3 дахь заалтад заасны дагуу захиалагч үнэлгээний хорооны зөвлөмж хууль тогтоомжид нийцэх эсэхэд хяналт хэрэгжүүлэхээр тусгажээ.

2.50. Тендер шалгаруулалтад гарсан гомдлыг хянан шийдвэрлэх ажиллагааг тусгайлсан журмаар зохицуулж байгаа хэдий ч тухайн журамд гомдлыг шийдвэрлэсэн шийдвэрийн биелэлтийг тайлагнах, нэгтгэн дүн шинжилгээ хийх талаар тусгаагүй нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 55 дугаар зүйлийн 55.1.6 дахь заалтад заасан хууль, журмын хэрэгжилтэд хяналт тавих, дүн шинжилгээ хийх боломжгүйд хүргэж байна.

2.51. Сангийн яамнаас хүргүүлсэн дүгнэлт, зөвлөмжийн биелэлтийг ХАА зохион байгуулж буй байгууллагууд нэгтгэж мэдээлээгүй, дүн шинжилгээ хийж цаашид шаардлагатай арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлэхгүй байгаа нь тендер шалгаруулалтад гарч буй гомдлыг бууруулах чиглэлд ахиц гарахгүй байх шалтгаан болж байна.

Төрийн худалдан авах ажиллагааны цахим системийн бүртгэл, мэдээлэлд хяналт шинжилгээ, үнэлгээ хийгээгүй, цахимжуулах асуудал хангалтгүй байна

2.52. Төрийн худалдан авах ажиллагааны тогтолцооны боловсронгуй бус байдал нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, төрөөс авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ үр дүнгүй болох нэг шалтгаан болж байгаа тул улс орнууд ТХАА-г төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, хянах үе шатанд цахим систем нэвтрүүлж байна.

2.53. Монгол Улсын хувьд төсвийн байгууллага, ТБОНӨААН-ийн урсгал зардал, улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын ТАХ-ний тендер шалгаруулалтыг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-ээр зохион байгуулж байна.

⁷⁷ 55.1.6. "Худалдан авах ажиллагаанд холбогдох хууль тогтоомж, журам, заавар, аргачлалын хэрэгжилтэд хяналт тавьж, дүн шинжилгээ хийх"

2.54. Төрийн худалдан авах ажиллагааны цахим системийн үйл ажиллагааны шинэчлэл, сайжруулалтыг ХАА-ны хууль, журамд нийцүүлэн тасралтгүй хийх зохицуулалтыг Сангийн сайдын 2023 оны А/248 дугаар тушаалаар баталсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2.3-д тусгажээ.

2.55. Худалдан авах ажиллагааг төлөвлөх, тендер шалгаруулалт зарлах, үнэлэх, үр дүнг нийтлэх оролцогч нарт мэдэгдэх зарим үйл ажиллагааг цаасаар болон цахим системээр зохион байгуулахаар журамд тусгасан нь давхардал, ачаалал үүсгэж үе шат дамжлага, процессыг хялбаршуулах, цахим хэлбэрт бүрэн шилжих үйл явцад сөргөөр нөлөөлж байна.

Дүрслэл 3. Төрийн худалдан авах ажиллагааны үе шатыг дүрслэлээр харуулбал



2.56. Тус журмын 2 дугаар зүйлийн 2.2.2-т үнэлгээний хороо байгуулсан шийдвэрийг цахим системд хавсаргаж, үнэлгээний хорооны гишүүн бүрийг системд бүртгэхээр, 2.2.3-т ТШББ-ийг боловсруулан баталж системд оруулахаар, 2.3.5-д оролцогчийн чадавх, туршлагыг нотлох баримтыг "PDF" форматаар хөрвүүлэн оруулахаар тус тус заажээ.

2.57. УТХО-ын ТАНХ-ний 572 нээлттэй тендер шалгаруулалтад нийт 1409 оролцогч санал ирүүлж оролцогч бүр дунджаар 67 хуудас, нийт 94,403 хуудас буюу 400 орчим архивын боть баримттай дүйцэх цаасан материалыг "PDF" форматад хөрвүүлэн цахим системд илгээжээ.

2.58. ТШББ-ийг боловсруулах, үнэлгээний хорооны гишүүдийн саналыг цахим системээр дамжуулан баталгаажуулах нь цаг хугацааны хэмнэлттэй, үр ашигтай байх боломжтой байна.

2.59. Мөн тендерийг үнэлэх, шийдвэрийг баталгаажуулах, оролцогчдод үр дүнг мэдэгдэх үе шатыг цахим системээр зохион байгуулах нь цаг хугацааг хэмнэх болон үнэлгээний хорооны гишүүдийн хараат бус байдлыг нэмэгдүүлэх давуу талтай байна.

2.60. Сангийн сайдын 2023 оны А/255 дугаар тушаалаар баталсан “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ын дагуу Маягт 1-10-ын мэдээллийг үнэлгээний хорооны гишүүд гараар хийж буй үнэлгээний бүх үйл явц, түүний дотор арифметик алдааг залруулах, үнийн хөнгөлөлт тооцох, давуу эрх олгох, харьцуулах үнийг тодорхойлох зэргийг автоматаар үүсгэх хөгжүүлэлт цахим системд хийгдээгүй байна.

2.61. Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын хавсралт маягтууд, төлөвлөгөө, тайланг "Excel" хүснэгтээр нэгтгэдэг ба улсын хэмжээний мэдээллийг нэгтгэх татах боломж системийн хувьд хязгаарлагдмал байна.

2.62. Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгасан ногоон худалдан авалтыг үе шаттай нэвтрүүлэх, дотоодын үйлдвэрлэлийг дэмжих, цахимжилт болон дэвшилтэт технологийг ашиглан ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилтын хэрэгжилт бүрэн хангагдаагүй байна.

БҮЛЭГ 3. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ЗАМ ТЭЭВЭР, ХОТ БАЙГУУЛАЛТ, ЭРЧИМ ХҮЧ, БОЛОВСРОЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРТ ТӨВЛӨРЧ СУУРЬ ДЭД БҮТЭЦ, НИЙГМИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХАД ЧИГЛЭСЭН Ч ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ, ХЭМЖИХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ ОНОВЧГҮЙ БАЙНА


Тухайн онд хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөсөн барилга байгууламж, техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах ажлын хэрэгжилт муу байна

3.1. Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан 611 ТАХ-г ТЕЗ нарын шийдвэрээр багцад хуваарилснаар 1337 багц ТАХ-д задарч үүнээс 888 ТАХ-г 2025 онд хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөжээ.

3.2. Тухайн онд хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөсөн 3,132.7 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй 888 ТАХ-ээс 1,901.8 тэрбум төгрөгийн 667 ТАХ хэрэгжиж дууссан, үлдэх 1,230.9 тэрбум төгрөгийн 221 ТАХ хугацаандаа хэрэгжиж дуусаагүй дараагийн он руу шилжжээ.


3.3. Төлөвлөсөн ажлын хэрэгжилтийг ТАХ-ний тоо хэмжээгээр харьцуулахад 75.1 хувьтай, өртөг буюу гэрээний үнийн дүнгээр харьцуулахад 60.7 хувьтай байна.

Дүрслэл 4. 2025 онд хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөсөн ажлын хэрэгжилт, ТАХ-ний тоогоор болон гэрээний дүнгээр



3.4. Тоног төхөөрөмж, их засварын ажлын хэрэгжилт харьцангуй сайн, 95.4-98.2 хувьтай байгаа бол тухайн жилд хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөсөн барилга байгууламж 60 хувь, ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах ажил 15 хувьтай, хэрэгжилт муу байна.


Дүрслэл 5. 2025 онд хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөсөн ТАХ-ний хэрэгжилт, ангиллаар



3.5. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөсөн барилга байгууламжийн 2 ажил тутмын нэг нь, ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах 5 ажил тутмын дөрөв нь хугацаа хоцорч тухайн онд бүрэн хэрэгжиж дуусаагүй байна.

3.6. ТЕЗ-аар ангилж үзэхэд 29 ТЕЗ нарын төлөвлөсөн ажлын хэрэгжилтийн хувь харилцан адилгүй, 16 нь 93-100 хувийн хэрэгжилттэй сайн, 6 нь 71-84 хувийн хэрэгжилттэй дундаж түвшинд байгаа бол 7 ТЕЗ хувьд 7-69 хувьтай буюу хэрэгжилт муу байна.

Дүрслэл 6. 2025 онд хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөсөн ТАХ-ний хэрэгжилт багатай ТЕЗ нар



3.7. ТЕЗ нар болон захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч байгууллага нь ТАХ-ний төлөвлөсөн графикт хугацаа, үе шатны ажлын явцыг хянах, гэрээт ажлыг төлөвлөсөн хугацаанд нь гүйцэтгүүлэхэд чиглэсэн зохион байгуулалт, хамтын ажиллагаа дутмаг, хяналт сул байгаа нь ТАХ хугацаандаа хэрэгжихгүй удаашрахад нөлөөлж байна.

3.8. Тухайн онд хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөсөн ч хэрэгжиж дуусаагүй 221 ТАХ-ний шалтгааныг ерөнхийд нь ангилж авч үзэхэд 27.4 хувь нь захиалагчаас, 27 хувь нь гэрээ оройтож байгуулагдсанаас шалтгаалж тухайн ондоо хэрэгжиж дуусаагүй байна. Үүнд:


- Худалдан авах ажиллагааг эхлүүлэх, зохион байгуулахад хугацаа алдаж оройтон 2025 оны 8-12 дугаар сард гэрээ байгуулснаас шалтгаалан 59 ТАХ буюу 27 хувь;
- Гүйцэтгэгч гэрээнд заасан график хөтөлбөрт хугацаанд ажлаа хийж гүйцэтгээгүйгээс шалтгаалан 70 ТАХ буюу 31.6 хувь;
- Газрын байршил өөрчлөгдсөн, газар чөлөөлөх ажил хүлээгдсэн, газрын зөвшөөрөлгүйгээс шалтгаалан 5 ТАХ буюу 2.7 хувь;
- Төсөвт өртөг нэмэгдсэн гэх шалтгаанаар 25 ТАХ буюу 11.3 хувь;
- Захиалагчаас буюу ТЕЗ, захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч, зөвшилцөх байгууллага, мэргэжлийн зөвлөл, зөвшөөрөл олгох байгууллага, хянах хүлээн авах комисс зэрэг ТАХ-г эхлүүлэх, хэрэгжүүлэх, хянах үйл ажиллагаанд оролцогч байгууллага, албан тушаалтны шийдвэр, зөвшөөрөл удааширснаас шалтгаалан 62 ТАХ буюу 27.4 хувь нь тухайн ондоо хэрэгжиж дуусаагүй байна.

3.9. Хөрөнгө оруулалтын ТАХ төлөвлөсөн хугацаандаа хэрэгжиж дуусахгүй дараа онд шилжих, ялангуяа барилга байгууламж, ТЭЗҮ зураг төсөв боловсруулах ажлууд хэрэгжилт муутай байгаа нь өртөг нэмэгдэх, төлөвлөсөн хугацаа сунжрах эрсдэлтэй байна.

3.10. Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системд гүйцэтгэгчтэй байгуулсан зарим гэрээний мэдээлэл дутуу бүртгэгдсэн бөгөөд 2023 оноос хойш системд бүртгэгдсэн давхардсан тоогоор 3140 гэрээний мэдээлэлд дүн шинжилгээ хийхэд ТЕЗ нар гэрээний хугацааг дунджаар 15-312 хоногоор сунгасан байна.

3.11. Гэрээнд өөрчлөлт оруулж сунгасан дундаж хугацааг ТЕЗ-аар харьцуулахад ЭЗХС дунджаар 312 хоног, ХББОСС дунджаар 237 хоног, ЭХС дунджаар 177 хоног байгаа нь сунгасан хамгийн урт хугацаанд хамаарч байна.

Дүрслэл 7. Гэрээний хугацааг сунгасан дундаж хоног ба давтамж, ТЕЗ-аар



3.12. Системд бүртгэгдсэн гэрээний мэдээллээс харахад дуусах хугацааг гурваас илүү жилээр сунгасан 12 ТАХ байна. Тухайлбал:

БС-ын багцад:

- Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор /Улаанбаатар, Сонгинохайрхан, 7-р хороо/;
- Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга /Улаанбаатар, Чингэлтэй, 12-р хороо/;
- Оюутны дотуур байрны барилга, 300 ор /Улаангом сум, Политехник коллеж/;
- Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал /Улаанбаатар, Сүхбаатар, 71-р сургууль/;

ЭХС-ын багцад

- "Шинэ Зуунмод" хотын эхний ээлжийн 220/110/35кВ-ын 2*125 МВА чадалтай "Сэргэлэн" дэд станц, удирдлагын барилга угсралтын ажил /Төв, Сэргэлэн/
- "Хөшигийн хөндийн шинэ хотын инженерийн дэд бүтэц" төсөл /Төв/ Багц-1 220 кВ-ийн 2 хэлхээт ЦДАШ-ын тулгуур 1-ээс тулгуур 49 хүртэлх угсралтын ажил болон Багц-2 тулгуур 49-өөс тулгуур 93 хүртэлх угсралтын ажил байна.

3.13. Эдийн засгийн ангиллаар авч үзвэл барилга, байгууламжийн ТАХ-ний 47 хувь буюу 2 ажил тутмын 1 нь гэрээний хугацааг сунгасан байгаа бол ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ТАХ-ний дийлэнх буюу 92.9 хувь нь гэрээний хугацааг 3 хүртэлх жилээр сунгасан байна.

3.14. Тухайлбал 2024 оны төсвийн жилд ТЭЗҮ ангиллын ТАХ-ний хүрээнд хамгийн өндөр санхүүжих дүнтэй буюу 317.0 тэрбум төгрөгийн дүнтэй 16 ТАХ-г тухайн жилдээ хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөсөн боловч оны эцэст 9.1 тэрбум төгрөг буюу төлөвлөсөн санхүүжилтийн 2.9 хувийг гүйцэтгэлээр зарцуулсан байна.

Хүснэгт 14. Гэрээний хугацааг сунгасан байдал /ТАХ-ний эдийн засгийн ангиллаар/

№	Ангилал	ТАХ-ний тоо	Хугацаандаа хэрэгжсэн		Хугацааг сунгасан	
			ТАХ-ний тоо	Эзлэх хувь	ТАХ-ний тоо	Эзлэх хувь
1	Барилга байгууламж	1674	875	52.3%	799	47.7
2	Их засвар	194	65	33.5%	129	66.5
3	Тоног төхөөрөмж	1047	347	33.1%	700	66.9
4	ТЭЗҮ	225	16	7.1%	209	92.9
	Нийт	3140	1303	41.5%	1837	58.5

3.15. ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ТАХ-ний 7.1 хувь нь гэрээний хугацаанд боловсруулагдаж дууссан буюу хэрэгжилт хангалтгүй байгаа нь нэг талаас гэрээний хугацааг оновчтой тодорхойлж төлөвлөөгүйтэй холбоотой байна.

3.16. Нөгөө талаас гүйцэтгэгч гэрээг хэрэгжүүлэх явц, үе шатанд захиалагчаас тавих хяналт сул, хэрэгжүүлэх явцад төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа дутмаг захиалагч талаас шалтгаалах техникийн нөхцөл, газар олголт, чөлөөлөлт зэрэг шаардлагатай зөвшөөрөл, шийдвэрийг гаргуулах, тулгарч буй асуудлыг шуурхай шийдвэрлэх зохион байгуулалт хангалтгүй байгаатай холбоотой байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар тухайн жилд төлөвлөсөн санхүүжилт гүйцэтгэлээр 72.9 хувьтай гарч өмнөх онтой харьцуулахад 10.2 нэгжээр өссөн байна

3.17. УТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний санхүүжилтэд 2025 онд 2,914.9 тэрбум төгрөг төлөвлөснөөс тухайн жилд 2,124.9 тэрбум төгрөгийг зарцуулснаар санхүүжилтийн гүйцэтгэл 72.9 хувьтай гарсан нь өмнөх оноос 10.2 нэгжээр өссөн байна.

Хүснэгт 15. Тухайн жилийн төлөвлөсөн санхүүжилт, гүйцэтгэлийн хувь, тэрбум төгрөгөөр


№	УТХО-ын төрөл	Тухайн жилийн санхүүжилт /тэрбум/			Өмнөх онтой харьцуулсан	
		Төлөвлөсөн	Олгосон	2025 онд хувь	2024 онд	Өөрчлөлт
1	Барилга байгууламж	2,426.5	1,702.5	70%	66%	+ 4
2	Их засвар	119.4	112.9	95%	70%	+25
3	Тоног төхөөрөмж	347.6	297.9	86%	78%	+ 8
4	ТЭЗҮ, зураг төсөл	21.5	11.5	54%	3%	+51
	Нийт	2,914.9	2,124.9	72.9	62.7	+10.2

3.18. ТЕЗ-аар ангилж үзвэл 14 ТЕЗ төлөвлөсөн санхүүжилтийн 90-100 хувийг зарцуулж гүйцэтгэл сайн байгаа бол 8 ТЕЗ нь дундаж түвшинд буюу тухайн жилийн санхүүжилтийн 73-88 хувийг зарцуулжээ.

3.19. Харин тухайн жилд төлөвлөсөн санхүүжилтээс 7 ТЕЗ 51-67 хувийг зарцуулсан нь хамгийн бага байна. Үүнд ЭМС 67 хувь, ЭЗХС 65 хувь, ХББОСС 64 хувь, УИХД 62 хувь, ЭХС 58 хувь, Сангийн сайд 53 хувь, ЦХИХХС 51 хувьтай зарцуулалт хангалтгүй байна.

3.20. ТАХ-г олгосон санхүүжилтийн гүйцэтгэлээр бүлэглэж авч үзвэл 1337 ТАХ-ний 16 хувь буюу 213 ТАХ-ний гүйцэтгэгч тухайн жилд төлөвлөсөн 329.3 тэрбум төгрөгөөс огт санхүүжилт аваагүй байна.

Дүрслэл 8. Тухайн жилд төлөвлөсөн санхүүжилтийн гүйцэтгэл, ТАХ-ээр, хувиар



3.21. УТХО-д төлөвлөсөн санхүүжилт 72.9 хувийн гүйцэтгэлтэй гарсан ба үүнд дараах 5 ТЕЗ-ийн тухайн жилд төлөвлөсөн санхүүжилтийн гүйцэтгэл дунджаас доогуур байгаа нь голлон нөлөөлжээ. Үүнд:

- ЦХИХХС-ын багцын шилжих барилга байгууламжийн санхүүжилтэд 16.4 тэрбум төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 31 хувь буюу 5.2 тэрбум;
- Сангийн сайдын багцын барилга байгууламжийн санхүүжилтэд 107.5 тэрбум төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 44 хувь буюу 47.5 тэрбум,
- ЭХС-ын багцын барилга байгууламжийн санхүүжилтэд 193.9 тэрбум төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 61 хувь буюу 118.8 тэрбум, тоног төхөөрөмжийн санхүүжилтэд 28.5 тэрбум төгрөг төлөвлөснөөс 30 хувь буюу 8.5 тэрбум,
- ХББОСС-ын багцын барилга байгууламжийн санхүүжилтэд 303.4 тэрбум төгрөг төлөвлөснөөс 62 хувь буюу 188.5 тэрбум,
- ЭЗХС-ын багцын ТЭЗҮ-ийн санхүүжилтэд 7.6 тэрбум төгрөг төлөвлөснөөс 22 хувь буюу 1.6 тэрбум төгрөгийг тус тус тухайн онд зарцуулсан нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл төлөвлөснөөс бага гарахад голлон нөлөөлжээ.

3.22. Захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч байгууллага, албан тушаалтан, мөн ТЕЗ нарын ТАХ-ний гүйцэтгэлийг хянаж баталгаажуулах процесс удаашралтай, гүйцэтгэлийн баримт бичиг нь дунджаар захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч байгууллагын 5, ТЕЗ-ийн 6, нийт 11 албан тушаалтны гарын үсгээр баталгаажсаны дараа Сангийн яаманд илгээгдэж мөн цаасаар болон цахим системээр давхар явагдаж байгаа нь хугацаа алдах шалтгаан болж байна.

3.23. Санхүүжилт хүссэн гүйцэтгэлийг хянаж баталгаажуулахад ТЕЗ буюу захиалагчийн зарцуулж байгаа хугацааг харьцуулахад 29 ТЕЗ нар нийт 1956 удаагийн санхүүжилт хүссэн гүйцэтгэлээс 1710 хүсэлт буюу 87.4 хувийг 0-6 хоногт, 181 хүсэлтийг 8-14 хоногт, 66 хүсэлтийг 15-60 хоногт тус тус хянаж баталгаажуулсан байна. Тухайлбал:

- ЭМС-ын багцын Өрхийн эрүүл мэндийн төвийн барилга /Дархан-Уул, Дархан сум/ ТАХ 60 хоног, Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах төв /Улаанбаатар, Сүхбаатар/ ТАХ 48 хоног;
- ХББОСС-ын багцын "Шинэ Хархорум" хотын БОНБУ хийх ТАХ 58 хоног, Нийтийн халуун усны барилга /Хөвсгөл, Алаг-Эрдэнэ сум/ Багц-1 ТАХ 51 хоног;
- Нийслэлийн ЗДТГ-т эрх шилжсэн "Цөлжилттэй тэмцэх тухай суурь конвенцын талуудын 17 дугаар бага хурлын байгууламж" /Улаанбаатар/ ТАХ-ний Багц 2 "Инженерийн дэд бүтцийн ажлын

зураг боловсруулах ажил /Улаанбаатар хот/” ТАХ 58 хоног, Гэр хорооллын айл өрхийн цахилгаан эрчим хүчний холболт, шугам сүлжээний шинэчлэл ТАХ 47 хоног;

- БХС-ын багцын Зэвсэгт хүчний 341 дүгээр ангийн ажилчдын орон сууцны барилга, 50 айл /Говь-Алтай, Есөнбулаг сум/ ТАХ 47 хоног;
- ХЗДХС-ын багцын ЦЕГ-ын төв байрны засвар /4. 5.6 дугаар давхар/ ТАХ 45 хоног тус тус зарцуулсан байна.

3.24. Гүйцэтгэлийн баримт бичгийг баталгаажуулахад хамгийн их хугацаа зарцуулсан буюу 1 гүйцэтгэл баталгаажуулахад зарцуулсан хоногийг ТЕЗ-аар ангилахад ЗТС 56 гүйцэтгэлийг хянахад 42 хүртэл, ЭМС 29 гүйцэтгэлийг хянахад 48 хүртэл, ХББОСС 22 гүйцэтгэлийг хянахад 58 хүртэл, ЭХС 18 гүйцэтгэлийг хянахад 50 хүртэл хоног тус тус зарцуулсан байна.

Хүснэгт 16. Гүйцэтгэлийг хянаж баталгаажуулахад 7 хоногоос дээш хугацаа зарцуулсан давтамж

№	ТЕЗ	Санхүүжилт хүссэн гүйцэтгэл /удаа/	Ажлын гүйцэтгэлийг хянаж баталгаажуулахад зарцуулсан хугацаа	
			Хугацааны интервал	Хамгийн ихдээ
1	ХББОСС	22	7-оос 58 хоног	58
2	ЭХС	18	7-оос 50 хоног	50
3	ЭМС	29	7-оос 48 хоног	48
4	ЗТС	56	7-оос 42 хоног	42
5	БОУАӨС	6	7-оос 34 хоног	34
6	ХХААХҮС	6	12-оос 31 хоног	31
7	БС	12	7-оос 25 хоног	25
8	ГБХНХС	5	7-оос 21 хоног	21

3.25. Хөрөнгө оруулалтын ТАХ-ний гүйцэтгэлийг хянаж баталгаажуулахад зарцуулж буй ТЕЗ нарын хугацаа харилцан адилгүй, зарим тохиолдолд ажлын гүйцэтгэлийг хянаж баталгаажуулахад 40-60 хоног зарцуулан 2 сарын хугацаа алдаж байгаа нь хэрэгжилтэд сөрөг нөлөөлөхөөр байна.

3.26. Цаашид ТЕЗ болон захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч нар ТАХ-ний гүйцэтгэлийг хянаж баталгаажуулахад зөвхөн цахим систем ашиглах, тоон гарын үсгээр баталгаажуулах, шат дамжлагыг бууруулах замаар ажлын гүйцэтгэлийг тухай бүр хянаж баталгаажуулах, шаардлага хангаагүй тохиолдолд шалтгааныг тодорхой тусган буцаах, бүртгэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

3.27. Захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч байгууллагууд ТАХ-ний гүйцэтгэлийг бодит гүйцэтгэлээс өндрөөр буюу хийгдээгүй ажлыг баталгаажуулснаас шалтгаалан 3.0 тэрбум төгрөгийн санхүүжилт илүү олгосон байна. Үүнд:

- ХББОСС-ын төсвийн багцын “Шинэ Хархорум хотын унд ахуйн зориулалттай ундны усны эх үүсвэрийн 1 дүгээр талбайн эхний ээлжийн ашиглалтын худаг, барилга байгууламжийн төсөл” ТАХ-ний ажлын даалгаварт ус хангамжийн эх үүсвэрийн ашиглалтын 16 худгийн өрөмдлөг, тоноглолын ажил бүрэн дууссан, иж бүрэн ажлын зураг боловсруулсан байхаар гэрээний тусгай нөхцөлд тусгасан ч бүрэн хийгдээгүй 6 худгийн өрөмдлөг, тоноглолын ажил дутуу, зөвхөн загвар зураг хийгдсэн байхад тайланг баталгаажуулан дундын санхүүжилтийг бүрэн олгосноос 1.4 тэрбум төгрөг илүү;
- ЗТС-ын багцын 1.5 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй “Сумын төвийн хатуу хучилттай авто замын шинэчлэл” /Өвөрхангай, Хужирт сум/ ТАХ-ний хийгдээгүй ажлын гүйцэтгэлийг баталгаажуулснаас 261.9 сая төгрөг илүү;
- ГБХНХС-ын багцын 4.2 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төвийн барилга” /Өвөрхангай, Арвайхээр сум/ ТАХ-ний 2 автомашины дулаан зогсоолыг хийж гүйцэтгээгүй байхад баталгаажуулснаас 261.9 сая төгрөг илүү;
- ЗТС-ын багцын 0.9 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй “Чойбалсан хот доторх хатуу хучилттай авто замын шинэчлэл, сайжруулалт” /Дорнод, Хэрлэн сум/ ТАХ-ний багц 6 буюу авто замын хашлага суурилуулах, суурь байгуулах ажил хийгдээгүй байхад баталгаажуулснаас 51.0 сая төгрөг илүү;
- ЗТС-ын багцын 8.7 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй “Сумын төвийн хатуу хучилттай авто замын өргөтгөл, шинэчлэл 2.8 км” /Дорнод, Хэрлэн сум, Лхамжавын гудамж/ ТАХ-ний хүрээнд төлөвлөсөн 3526 м² талбайн зүлэгжүүлэлт, явган хүний замын ажлыг гүйцэтгээгүй байхад баталгаажуулснаас 13.7 сая төгрөг илүү;

- ЗТС-ын багцын 1.6 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй “Чойбалсан хот доторх хатуу хучилттай авто замын шинэчлэл, сайжруулалт” /Дорнод, Хэрлэн сум/ ТАХ-ний 2 дугаар багцын ажлаас дутуу хийсэн явган хүний зам, авто замын тоноглол, термопластик будгийн ажил хийгдээгүй байхад баталгаажуулснаас 311.9 сая төгрөг илүү;
- ЗТС-ын багцын 1.6 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй “Чойбалсан хот доторх хатуу хучилттай авто замын шинэчлэл, сайжруулалт” /Дорнод, Хэрлэн сум/ ТАХ-ний 7 дугаар багцын ажлаас явган хүний 80 м² зам дутуу хийгдсэн байхад хүлээн авч 80.3 сая төгрөгийн санхүүжилт илүү олгосон;
- БС-ын багцын 11.9 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй Дотуур байрны барилга, 150 ор /Ховд, Манхан сум, Төгрөг гол баг/ ТАХ-ний гадна ханыг кл өнгөлгөөний тоосгоор хийхээр зураг төсөвт тусгагдсаныг өөрчилж ердийн тоосгоор хийсэн ажлын материал тээврийн зардлын зөрүүг 44.1 сая төгрөгийг илүү олгосон;
- ЭМС-ын багцын “Эрүүл мэндийн төвийн өргөтгөл” /Ховд, Мөст сум/ ТАХ-ний барилга угсралтын ажил 69.3 хувийн гүйцэтгэлтэй байхад зураг төсөл зохиогчид зохиогчийн хяналтын зардлын 89.9 хувь буюу 20.6 хувь болох 5.5 сая төгрөгийг илүү олгосон,
- ЗГХЭГ-ын 2.3 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй “Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга” /Хөвсгөл, Жаргалант сум/ ТАХ-ний гүйцэтгэлийг захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч 80 хувиар хянаж баталгаажуулсан 84 хувиар санхүүжүүлж 92.0 сая төгрөг илүү олгосон, мөн захиалагчийн хянаж баталгаажуулсан гүйцэтгэлийг бодит гүйцэтгэлтэй тулгахад 15 нэр төрлийн 123.8 сая төгрөгийн ажлыг гүйцэтгээгүй байхад баталгаажуулснаас нийт 215.8 сая төгрөгийн санхүүжилт илүү олгосон;
- БОУАӨС-ын багцын 0.2 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй “Цаг уурын өртөөний барилга” /Хөвсгөл, Шинэ-Идэр сум/ ТАХ-ний гүйцэтгэгч 4 нэр төрлийн 28.2 сая төгрөгийн ажлыг хийж гүйцэтгээгүй байхад хянаж баталгаажуулсан;
- БОУАӨС-ын 0.2 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүнтэй “Цаг уурын өртөөний барилга” /Хөвсгөл, Цагаан-Үүр сум/ ТАХ-ний бодит гүйцэтгэл 20 орчим хувьтай байхад 50 хувийн санхүүжилтийг олгосноос 78.7 сая төгрөг тус тус илүү санхүүжүүлсэн;
- ЭМС-ын багцын 9.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Сэргээн засах эмнэлгийн барилга, 40 ор /Өмнөговь, Даланзадгад сум, 6 дугаар баг/ ТАХ-ний санхүүжилтийг олгохдоо 1811.2 м² өнгөлгөөний металл хаветангийн үнийг зах зээлийн үнээс өндрөөр тооцож санхүүжүүлсэн;
- БС-ын багцын 15.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Сургуулийн барилга, 960 суудал /Увс, Улаангом сум, 1 дүгээр сургууль/ ТАХ-ний магадалшгүй ажлын зардлыг олгохдоо хийгдэхгүй хулдаасан шалны ажлын зардлыг хасаж тооцоогүй байна.

3.28. ЗТС-ын багцын 45.0 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй Увс нуур-Улаангом чиглэлийн хатуу хучилттай авто замын эхний үе шат, 26.39 км /Увс/ ТАХ-ний зураг төслийг боловсруулахдаа 980.7 мянган м² ул хөрс нягтруулах ажлын тоо хэмжээг давхардуулан тооцсоноос 468.6 сая төгрөг илүү төлөвлөсөн байна.

3.29. Тухайн ажлыг гүйцэтгэх явцад нэмэлтээр хийж гүйцэтгэсэн 180м хатуу хучилттай замын ажлын өртөг 200.8 сая төгрөгийг дээр дурдсан төсөвт илүү төлөвлөсөн 468.6 сая төгрөгөөс хасаж, зөрүү 267.8 сая төгрөгөөр гэрээний үнийн дүнг бууруулах албан шаардлага хүргүүлэв.

3.30. Эдгээр зөрчлүүд Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.8.12⁷⁸, Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор баталсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 3.16⁷⁹ дахь заалтыг тус тус зөрчжээ.

3.31. ХББОСС-ын багцын “Шинэ Хархорум хотын эхний ээлжийн авто зам, замын байгууламжийн ажлын зураг төсөл” ТАХ-ний эцсийн санхүүжилтийг 2025 онд барьцаа хөрөнгийн данснаас гүйцэтгэгчид олгохдоо суутган тооцсон 117.5 сая төгрөгийн алдангийг улсын төсөвт төвлөрүүлээгүй зөрчлийг аудитын явцад залруулж төсөвт төвлөрүүллээ.

3.32. БСҮХ-ны даргын багцаас Сангийн сайдын багцад шилжиж хэрэгжсэн “Хилийн боомтуудын барилга байгууламжийн их засвар” /Боомтуудад/ ТАХ-ний Багц-2 “Гашуунсухайт боомтын салбар лабораторийн зориулалтыг өөрчлөх зураг төсөв, магадлал хийлгэх, өөрчлөлтийн дагуу хийгдэх засварын ажил”-ын хүрээнд хүлээн авсан гэх 4 ширхэг

⁷⁸ 4.8.12. “Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлээр олгох”

⁷⁹ “Барилгын ажлыг батлагдсан зураг төслийн дагуу гүйцэтгээгүй, чанаргүй, дутуу гүйцэтгэсэн, захиалагч болон эрх бүхий байгууллагын шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд захиалагч барилгын үе шатны ажлын гүйцэтгэлийг баталгаажуулахгүй. Энэ тохиолдолд төсвийн ерөнхийлөн захирагч болон хөрөнгө оруулагч санхүүжилт олгохгүй байж болно

3.41. ЭМЯ нь “Хавдар судлалын үндэсний төвийн робот мэс заслын тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/” ТАХ-ний тендерийн баримт бичгийн гэрээний тусгай нөхцөл хэсэгт чанарын баталгааг гэрээний дүнгийн 5 хувиар тусгахаар заасан боловч гүйцэтгэгчтэй гэрээ байгуулахдаа тус нөхцөлийг тусгахгүй орхигдуулсан байна.

3.42. УЕП-ын багцын Прокурорын салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/ ТАХ-ний 3.1 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй 4 багц ажлын гэрээний тусгай нөхцөлийн 4.11-т чанарын баталгааг гэрээний үнийн дүнгийн 5 хувиар байршуулахаар заасан ч чанарын баталгааг суутган тооцоогүй, мөн ХХААХҮЯ-ын багцын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/ ТАХ-ний 1.9 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй 5 багц ажлын гэрээний тусгай нөхцөлийн 4.11-т чанарын баталгааг шаардахаар тусгасан ч хувь хэмжээг тодорхойлж тусгаагүйгээс чанар баталгааг суутгаагүй байна.

3.43. ХББОСС-ын багцын “Алтанбулаг хилийн боомтын будгийн болон химийн лабораторийн тоног төхөөрөмж” /Сэлэнгэ, Алтанбулаг сум/ ТАХ-ний хүрээнд сургалтын зардалд 115.0 сая, Барилгын материалын сорилт шинжилгээний түргэвчилсэн лабораторийн тоног төхөөрөмж /Дорноговь, Замын-Үүд сум/ ТАХ-ний хүрээнд тоног төхөөрөмж угсрах суурилуулах болон сургалт зохион байгуулах зардлыг санхүүжүүлэхээр гэрээнд тусган 145.4 сая төгрөг тус тус олгосон ч сургалтын зардлын төсөв тооцоолол, зарцуулалт тодорхойгүй байна.

3.44. ХББОСС-ын багцын орон нутагт эрх шилжин хэрэгжсэн 4.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй “Инженерийн шугам сүлжээний ажил” /Увс аймаг, Улаангом сум/ ТАХ-ний хүрээнд тохижилтын ажлууд төлөвлөж хэрэгжүүлсэн зөрчил илэрсэн тул холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар албан шаардлага хүргүүлсэн.

Захиалагчийн хяналт хангалтгүйгээс зарим төсөл, арга хэмжээг зураг төслийн дагуу гүйцэтгээгүй байна

3.45. Барилга хот, байгуулалтын сайдын 2016 оны 178 дугаар тушаалаар баталсан “Барилга байгууламжийн барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт хийх гэрээний үлгэрчилсэн загвар”-ын 2.3.7, захиалагч гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний 10.12-т заасны дагуу төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх явцад ажлын тоо хэмжээ болон материалд өөрчлөлт оруулах тохиолдолд зураг төсөл зохиогчоор хянуулж, зөвшөөрөл авч баталгаажуулах үүрэгтэй.

3.46. ТАХ-ний хэрэгжилтэд хийсэн хяналтаар батлагдсан зураг төсөл, техникийн тодорхойлолт, ажлын даалгаврыг өөрчлөн гүйцэтгэсэн, төлөвлөсөн ажлыг дутуу хийсэн, чанарын шаардлага хангаагүй мөн өөрчлөлтийг зохих журмын дагуу баталгаажуулаагүй зөрчил илэрлээ. Тухайлбал:

- ЗТС-ын багцын 8.7 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй Чойбалсан хот доторх хатуу хучилттай авто замын шинэчлэл, сайжруулалт /Дорнод, Хэрлэн сум/ ТАХ-ний 1 дүгээр багцын замын бродюрт байрлах ус зайлуулах шугам газраас өндөр түвшинд байрласан, харааны бэрхшээлтэй хүний зорчих хэсгийн эхлэл болон төгсгөлийг буруу байрлуулсан;
- ЗТС-ын багцын 0.9 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй Чойбалсан хот доторх хатуу хучилттай авто замын шинэчлэл, сайжруулалт /Дорнод, Хэрлэн сум/ ТАХ-ний 7 дугаар багцын замын төгсгөл хэсэгт хийгдэх 31.9 сая төгрөгийн 80 м² явган замын ажил, 2195 м² хэвтээ тэмдэглэгээний ажлыг хийж гүйцэтгээгүй, мөн тухайн замын төгсгөл хэсэгт асфальт хучилтын зузаан шаардлага хангаагүй, суулт өгсөн, хагарсан, явган хүний хөтөч хавтанг зургийн дагуу гүйцэтгээгүй, комиссоос өгсөн үүрэг даалгаварт хуучин гэрлийн шонгийн нүхийг дүүргэх зэрэг үүргийг биелүүлээгүй, тухайн ажлыг гүйцэтгээгүй;
- ЗТС-ын багцын 4.6 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 3.4 км /Говьсүмбэр, Баянтал сум/ ТАХ-ний явган замыг өнгөт хавтангаар хийх байсныг асфальт бетон хучилттайгаар хийсэн, сургуулийн авто зогсоолын байршлыг шилжүүлсэн, хороолол доторх авто замын трассыг шилжүүлсэн, авто зам дээгүүр ус давуулах даланг ус зайлуулах хоолой болгож өөрчилснөөс замын түвшин нэмэгдсэн;
- БС-ын багцын 9.7 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй Сургуулийн барилга, 720 суудал /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 12 дугаар хороо/ ТАХ газар чөлөөлөлттэй холбоотойгоор байршил өөрчлөгдөж, газрын халаалтын зуух айлтай ойртсон, явган зам суулт өгсөн, хөтөч хавтанг буруу суулгасан, спорт заал дулаан алдалттай;
- БС-ын багцын 5.7 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй Цэцэрлэгийн барилга, 240 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 42 дугаар хороо/ ТАХ-ний хана цууралт өгсөн, хүйтний улиралд шал хийсэнтэй холбоотой шалны хулдаас хөөлттэй;

- БС-ын багцын 5.7 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй Цэцэрлэгийн барилга, 240 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 40 дүгээр хороо/ ТАХ-ний ажил удаашралтай, олон удаагийн ажил эрчимжүүлэх албан шаардлага өгч, гэрээ цуцлах шийдвэр гарсан ч гүйцэтгэгч барилга угсралтын ажлыг үргэлжлүүлэн явуулсан;
- БС-ын багцын 8.7 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй Сургуулийн барилга, 960 суудал /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 2 дугаар хороо/ ТАХ-ний спорт заалны тааз зураг төсөв зохиогчийн алдаанаас шалтгаалж намхан болсон тул Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар буцаан буулгаж таазыг өндөрлөсөн;
- ЭМС-ын багцын 1.6 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй Өрхийн эрүүл мэндийн төвийн барилга (Улаанбаатар, Багануур дүүрэг, 4 дүгээр хороо, "Энх-Өрх" өрхийн эмнэлэг) ТАХ-ний техникийн нөхцөл гарсан боловч гадна инженерийн шугам сүлжээ иргэний газар олголттой давхацсан тул зөвшилцөлд хүрээгүй ажил удааширсан;
- БС-ын багцын 2.9 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй "Сургуулийн дотуур байрны барилга, 100 ор /Орхон, Баян-Өндөр сум, Ирээдүйн одод сургууль/" - гадна фасадын дулаалгыг зураг төсөвт зааснаас бага хийсэн, ус тусгаарлагчийг хийгээгүй;
- ХББОСС-ын багцын 4.3 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй Ф720 мм-ийн дулааны төв шугам сүлжээний өргөтгөлийн ажил /Орхон, Баян-Өндөр сум/ ТАХ-ний нуман хаалга /арк/-ыг гүйцэтгэж дуусгаагүй;
- ХББОСС-ын багцын 4.3 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй Төв дулаан, цэвэр усны шугам сүлжээний өргөтгөл, ус дулаан дамжуулах төв барих ажил /Орхон, Баян-Өндөр сум, Цагаан чулуут, Наран баг/ - гадна генераторыг холбоогүй, ус, дулаан дамжуулах төвийн дотор заслыг бүрэн дуусгаагүй;
- ЭХС-ын багцын 2.1 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй "Дулаан хангамжийн шугам сүлжээ, зуухны барилга /Сүхбаатар, Асгат сум/" болон "Соёл амралтын хүрээлэн багц 1, 2 /Сүхбаатар аймаг, Баруун-Урт/" ТАХ-г зургийн дагуу бүрэн гүйцэтгээгүй, зарим ажлыг зураг төсөв, техникийн шийдэл, батлагдсан төсвөөс өөрчилсөн, өөрчлөгдсөн ажлын зураг төсөв, төсвийн тооцоог зохих журмын дагуу баталгаажуулаагүй, бодит гүйцэтгэлд үндэслэн хяналт хэрэгжүүлээгүй;
- ЗТС-ын 45.0 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй Увс нуур-Улаангом чиглэлийн хатуу хучилттай авто замын эхний үе шат, 26.39 км /Увс/ ТАХ-ний давуулах далангийн хөндлөн заадас болон ажлын заадсыг зураг төслийн дагуу хийгээгүй /аудитын явцад засварласан/, авто замын асфальтын нягт нь 89.7 хувь, явган зам 79.8 хувийн нягттай буюу техникийн шаардлагад нийцээгүй зөрчил илэрсэн.

3.47. Барилга байгууламжийн ТАХ-ний зураг төсөвт өөрчлөлт оруулж гүйцэтгүүлэх тохиолдолд өөрчлөлтийн төсвийг тухай бүр тооцож баталгаажуулахгүй байна.

Захиалагчийн хяналт тавих эрх бүхий байгууллагуудаас шалтгаалан төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналт харилцан адилгүй байна

3.48. Захиалагчийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагуудын чиг үүрэг, хяналтын тогтолцоо харилцан адилгүй байна. Тухайлбал:

- ГХС-ын багцын 8.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй дипломат төлөөлөгчийн газруудын засварын ажлуудын гэрээг тухайн улсын хууль, журам зохицуулалтын дагуу гүйцэтгэх шаардлагатай болдог тул санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн тухай бүр олгодоггүй, хөрөнгө оруулалтын системд гэрээний мэдээллийг бүртгээгүй, ажиллах хүчний нөөц бололцооноос хамаарч гүйцэтгэлийг барилгын мэргэжлийн бус албан хаагчид хяналт тавьж хүлээн авсан;
- ХЗДХС-ын харьяа ЦЕГ болон ШШГЕГ-ын барилга, байгууламжийн ТАХ-ний захиалагчийн хяналтыг тухайн байгууллагын холбогдох нэгжүүд хэрэгжүүлдэг бөгөөд эдгээр нэгжийн үйл ажиллагааны зардлыг барилга, байгууламжийн захиалагчийн хяналтын зардал болон урсгал зардлын эх үүсвэрээс давхар санхүүжих нөхцөл бүрдсэн;
- Барилгын хөгжлийн төв нь Боловсролын сайд, ГБХНХС, ССАЖЗС, ЭМС, ХББОСС-ийн багцад хамаарах нийт 327 ТАХ-нд захиалагчийн техник хяналтыг гэрээгээр гүйцэтгэж байгаа ба гэрээний чиг үүргийн тодорхой хэсгийг орон нутгийн байгууллагуудад шилжүүлэн хэрэгжүүлж байгаагаас захиалагчийн хяналтыг ТЕЗ, Барилгын хөгжлийн төв, орон нутгийн ГХБХБГ гэсэн олон шатлалтайгаар хэрэгжүүлж хяналтын зардлыг гэрээний нөхцөлөөр тохиролцон хувааж зарцуулж байна.

3.49. Захиалагчийн хяналтыг олон шатлалтайгаар дамжуулан хэрэгжүүлэхдээ гэрээнд хариуцлагын зааг ялгааг тодорхой тусгаж хяналтыг сайжруулах, хяналт хэрэгжүүлэгчийн санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхой болгож давхардлыг арилгах, үр ашигтай, хэмнэлттэй байхаар зохион байгуулах шаардлагатай байна.

3.50. ХББОСС-ын багцын “Шинэ Хархорум хотын унд ахуйн зориулалттай ундны усны эх үүсвэрийн 1 дүгээр талбайн эхний ээлжийн ашиглалтын худаг, барилга байгууламжийн төсөл”-д захиалагчийн хяналт гүйцэтгүүлэхээр Хархорин хотын захирагчийн ажлын албатай гэрээ байгуулсан, ЭЗХС-ын болон ХББОСС-ын багцын авто зам, гүүр, авто замын байгууламж, замын их засварын ажлын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах 5 ТАХ-нд авто замын мэргэжлийн байгууллагаар бус БХТ, Хархорум хотын захирагчийн ажлын алба болон Архангай, Сэлэнгэ аймгийн ЗДТГ-аар захиалагчийн хяналтыг гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан байна.

3.51. Энэ нь Авто замын тухай хуулийн 4.1.11⁸⁰, Усны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5.5⁸¹ дахь заалтын дагуу усны аудит хийх эрх бүхий мэргэжлийн байгууллага тухайн ажилд хяналт хэрэгжүүлж, хуулийн 16 дугаар зүйлийн 16¹.4.10⁸² дахь заалтын дагуу Усны газар дүгнэлт гаргахаар хуульчилсантай нийцэхгүй байна.

3.52. Хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн барилга байгууламж, тоног төхөөрөмжийн зарим ажлыг зураг төсөв, техникийн тодорхойлолтын дагуу гүйцэтгүүлээгүй, захиалагчийн хяналт хангалтгүй байна. Үүнд:

- Сангийн сайдын багцын 344.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Татварын байгууллагын барилгын их засвар /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/ ТАХ нь батлагдсан зураг төсөвгүй байхад магадалшгүй ажлын зардлын 15.0 сая төгрөг олгосон, зохиогч болон захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй, хяналт хийсэн тайлангүй байхад санхүүжилтийг бүрэн олгож ашиглалтад хүлээн авсан;
- БСҮХД-ын /хуучнаар/ багцын 945.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Гашуун сухайт боомтын салбар лабораторийн зориулалтыг өөрчлөх засварын ажил” их засварын ТАХ-ний хүрээнд төсвөөс ангилал зөрүүлж зориулалт бусаар тоног төхөөрөмж худалдан авсан, гүйцэтгэгчээс гэрээний дагуу хүлээн авсан гэх баримт үйлдсэн ч 4 ширхэг лабораторийн хөргөгч бодитоор байхгүй, хүлээн аваагүй;
- ССАЖЗС-ын багцын 15.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Олон угсаатны театрын барилга /Ховд, Жаргалант сум/ ТАХ-ний инженерийн шугам сүлжээний ажлын гүйцэтгэлд захиалагчийн хяналтыг хангалттай хэрэгжүүлээгүй, гүйцэтгэгчид өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хянаж баталгаажуулаагүйгээс ажлын чанар, хийц стандартын шаардлагад нийцээгүй;
- ЗГХЭГД-ын багцын 3.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Хэнтий, Мөрөн сум/ ТАХ-нд захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн талаар ажлын тайлан байхгүй, фото зургаар баримтжуулаагүй;
- ХЗДХС-ын багцын ЦЕГ-аас захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн Цагдаагийн тасгийн барилга /Баянхонгор, Богд сум/, Цагдаагийн тасгийн байр /Хэнтий, Батноров сум, Бэрх тосгон/, Цагдаагийн тасгийн байр /Өвөрхангай, Богд сум/, Цагдаагийн “Оч” зуслангийн их засвар, Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны гадна талбайн засвар, Төв байрны 4,5,6 дугаар давхрын засварын техник хяналтын зардал, НЦУГ-ын барилгын их засварын ТАХ-ний захиалагчийн хяналтын зардлыг зарцуулаагүй, 1-4 жилийн хугацаанд техник хяналтын зардлын дансанд байршиж байсныг аудитын явцад төсөвт төвлөрүүлэв.

3.53. Эдгээр нь ТАХ-ний хэрэгжилт, гүйцэтгэлд тавих үе шатны хяналт хангалтгүй, ашиглалтад хүлээн авах комисс нь ажлын даалгавар, техникийн тодорхойлолтод заасан шалгуур үзүүлэлт бүрээр тулган хянаж хүлээн авах үүргээ бүрэн хэрэгжүүлэхгүй байгаатай холбоотой байх тул холбогдох ТЕЗ нарт албан шаардлага хүргүүлэв.

⁸⁰ 4.1.11. “Замын байгууламж гэж бүх төрлийн гүүр, тавилан, гүүрэн гарц, унадаг дугуй болон явган зорчигч, хөгжлийн бэрхшээлтэй хүн зорчиход зориулсан зам, ус зайлуулах хоолой, шуудуу, хонгил, замын хөдөлгөөнийг зохицуулах болон хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зориулалттай төхөөрөмж, авто замын зурвас газарт байгаа төлбөр авах цэг, авто зогсоол болон бусад байгууламжийг”

⁸¹ 21.5.5. “Усны аудит хийх эрх бүхий мэргэжлийн байгууллага усны нөөцийн ашиглалт, усны нөөцийн төлбөр төлөлт, усны барилга байгууламж барих, сэргээн засварлах, шинэчлэх ажлын гүйцэтгэлд аудит хийх, холбогдох дүгнэлт, зөвлөмж гаргах, тайланг улсын усны мэдээллийн санд хүлээлгэн өгөх”

⁸² 16¹.4.10.голын голдирлыг өөрчлөх, урсцад тохируулга хийх, шилжүүлэн ашиглах, усны барилга байгууламж барих, усны сан бүхий газрын ашиглалтын төсөлд дүгнэлт гаргах

Тоног төхөөрөмжийн зарим төсөл, арга хэмжээний хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, хуваарилах, хүлээлцэх ажиллагааны зохион байгуулалт, хяналт сул байгаагаас төсвийн хөрөнгө оруулалтыг үр ашиггүй зарцуулах, хөрөнгө эзэнгүйдэх эрсдэлтэй байна

3.54. Зарим ТЕЗ-ийн төсвийн багцад тусгаж худалдаж авсан тоног төхөөрөмжийн ТАХ-ний гэрээний хэрэгжилтийг үнэлж дүгнээгүй, тоног төхөөрөмжийг хүлээн авах, ашиглагч талд хүлээлгэн өгөхдөө холбогдох журмыг мөрдөөгүй байна. Тухайлбал:

- *БОУАӨС-ын багцад Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/ ТАХ-ний хүрээнд нийт 310 ширхэг мотоциклыг байгаль хамгаалах, цаг уурын мэдээлэл авах зориулалтаар нийлүүлэх 1.1 тэрбум төгрөгийн гэрээгээр худалдан авсан боловч салбарын сайдын тушаалаар баталсан хуваарийн дагуу хуваарилах, хүлээлгэн өгөх, бүртгэлд тусгах үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллаагүй, мотоциклуудыг 2025 оны 6-7 дугаар сард холбогдох байгууллагуудад хүлээлцэх акт үйлдэн тараасан боловч байгаль хамгаалагч, цаг уурын мэдээлэл авах ажилд зориулсан мотоциклуудыг 2026 оны 6 дугаар сарын байдлаар хуваарийн дагуу нийлүүлээгүй;*
- *ХХААХҮС-ын багцын 7.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/ ТАХ-ний хүрээнд “Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих оёдлын машин худалдан авах” 5 дугаар багцын ажлын хүрээнд 2.0 тэрбум төгрөгөөр нийт 1118 ширхэг оёдлын машин худалдан авч “Нийслэлийн Жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих төв” Нийслэлийн өмчит үйлдвэрийн газартай хамтран ажиллах гэрээ байгуулан иргэдэд олгосон, мөн “Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих тоног төхөөрөмж худалдан авах” 6 дугаар багцын хүрээнд 0.8 тэрбум төгрөгөөр 1101 ширхэг хөлдөөгч худалдан авч “Нийслэлийн Жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих төв” Нийслэлийн өмчит үйлдвэрийн газартай хамтран ажиллах гэрээ байгуулан цэцэрлэг, сургууль, эмнэлэгт тараан олгосон байна.*

3.55. Төсвийн хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн дээрх хөрөнгийн хуваарилалт, бүртгэлд тусгагдсан эсэхэд хяналт тавих, ашиглалт, үр дүнг сайжруулах, илэрсэн зөрчлийг арилгуулахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх албан шаардлага хүргүүлэв.

3.56. Соёлын салбарт нэн тэргүүний хэрэгцээ шаардлагатай эсэх нь тодорхойгүй тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил нийлүүлэхээр төлөвлөж худалдаж авсан боловч ашиглалтгүй, зарим нь ашиглагч талд нийлүүлээгүй агуулахад хадгалагдаж байна. Тухайлбал:

- *ССАЖЗС-ын багцын 2.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй “Аймгийн хөгжимт драмын театрын тоног төхөөрөмж /Архангай, Эрдэнэбулган сум/ ТАХ-ний хүрээнд 5288 ширхэг тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авсан боловч театрын барилга ашиглалтад ороогүйгээс шалтгаалан ашиглагдаагүй;*
- *ССАЖЗС-ын багцын “Орон нутгийн музейн соёлын өвийн тоног төхөөрөмж” /Говь-Алтай, Есөнбулаг сум/ ТАХ-ний хүрээнд нийлүүлсэн музейн зарим техник тоног төхөөрөмжүүд суурилуулагдаагүй, ашиглагдаагүй;*
- *ССАЖЗС-ын багцын 3.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй “Орон нутгийн музейн соёлын өвийн тоног төхөөрөмж /Говь-Алтай, Есөнбулаг сум/ төсөл арга хэмжээний хүрээнд сургалтын зориулалттай тавцантай сандал 100 ширхэг нийлүүлэгдсэнээс 80 орчим нь агуулахад хураалттай, албан бичгийн ширээ 8 ширхэг нийлүүлэгдсэнээс 7 нь ашиглалтгүй байна.*

3.57. Салбарын сайдын эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх чиг үүргийн хэрэгжилт хангалтгүй байх тул алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлэв.

Барилгад ашигласан материалаас ялгарах дэгдэмхий органик нэгдэл, хорт бодисын агууламж хүлцэх хэмжээнд байгаа эсэхэд тавих хяналт сул байна

3.58. Барилгын материалаас барилгын дотоод орчны агаарт ялгарах 4 төрлийн дэгдэмхий органик нэгдлийн болон 98 төрлийн хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээг ЭМС, БХБС-ын хамтарсан 2018 оны А/05/08 дугаар тушаалаар тогтоож хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тухайн яамдын Төрийн нарийн бичгийн дарга нарт үүрэг болгожээ.

3.59. Салбарын сайд нарын хамтарсан тушаалаар өгсөн дээр дурдсан үүргийн хэрэгжилт хангалтгүй, ЭМЯ-ны болон ХББОСЯ-ны салбарын хяналтын газруудаас тухайн чиглэлээр хяналт шалгалт хийгээгүй, хүлцэх хэмжээнд байгаа эсэх, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлж буй эсэхийн судалгаа мэдээлэлгүй байна.

3.60. Барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах, дотор засал, их засварын ажлыг гүйцэтгүүлэх, хүлээн авах, захиалагчийн хяналт хэрэгжүүлэх, комисс ажиллахтай холбоотой

дүрэм, журамд дээрх дэгдэмхий органик нэгдэл, хорт бодисын шинжилгээг хийлгэхийг шаардах, хүлцэх хэмжээг хянах, хэтэрсэн тохиолдолд авч хэрэгжүүлэх арга хэмжээтэй холбоотой нарийвчилсан зохицуулалтгүй байна.

3.61. Барилгын материалаас дотоод орчны агаарт ялгарах органик нэгдэл, хорт бодисыг шинжлэх төр, хувийн хэвшлийн лабораториудын чадамж, тухайн чиглэлд хийгдэж буй шинжилгээ, судалгаа, мэдээлэл нь салбарын яамдад байхгүй, дотор агаарын чанар, хорт хийн ялгарлыг хянах, эрүүл мэндэд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн тогтолцоо бүрдээгүй байна.

3.62. Монгол Улсад 2026 оны байдлаар хувийн хэвшлийн нэг лаборатори дэгдэмхий органик нэгдэл, химийн хорт бодисын хүлцэх хэмжээг тогтоосон 102 төрлөөс 7 төрлийг нь дотоод орчны агаараас дээж авч шинжлэх боломжтой ч тухайлсан барилгын материал эсвэл тавилга эд хогшлоос шалтгаалж байгаа эсэхийг тухай бүрд ялган тогтоох боломжгүй байна.

3.63. УТХО-аар ХББОСС-ын багцад нийт 15,945.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Барилгын материалын сорилт шинжилгээний түргэвчилсэн лабораторийн тоног төхөөрөмж /Дорноговь, Замын-Үүд сум/ ТАХ 2024-2026 онуудад хэрэгжиж дууссан байна.

3.64. Тус ТАХ-ний хүрээнд анхны иж бүрэн барилгын материалыг шинжлэх боломжтой лаборатори байгуулагдах нөхцөл бүрдэж лабораторийн тоног төхөөрөмжийг 2025 оны 12 дугаар сард бүрэн хүлээн авсан боловч тоног төхөөрөмжийн угсралт, туршилт тохируулга бүрэн хийгдээгүй, хүний нөөцийн асуудлаас шалтгаалан ашиглалтгүй байна.

3.65. УТХО-аар хэрэгжиж 2025 оны 9 дүгээр сараас 2026 оны 4 дүгээр сар хүртэлх хугацаанд байнгын ашиглалтад хүлээн авсан, Улаанбаатар хотод байршилтай сургууль, цэцэрлэгийн 13 барилгын дотоод орчны агаараас дээж авч шинжлүүлээ.

3.66. Түүвэрт хамрагдсан 13 барилгад ашигласан барилгын материалын чанарын гэрчилгээг хянахад зөвхөн 1 барилгын гүйцэтгэгч нь дотор засалд ашигласан материалын формальдегидийн ялгаралтын шинжилгээний гэрчилгээтэй, 4 барилгын гүйцэтгэгч дэгдэмхий органик нэгдлийн шинжилгээний гэрчилгээтэй байгаа бөгөөд ашиглалтад хүлээлгэн өгсөн барилгын дотоод орчны агаарт ялгарч буй бодис хүлцэх хэмжээнд байгаа эсэхэд шинжилгээ хийлгээгүй байна.

3.67. Энэ нь захиалагч Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.5⁸³-д заасан чиг үүргээ хэрэгжүүлээгүй, “Барилгын материалын эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлтийн зөвшөөрөгдөх дээд хэмжээг батлах тухай” тушаалын хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллагуудын уялдаа сул, хяналт хангалтгүй байгааг харуулж байна.

3.68. Сургууль, цэцэрлэгийн 13 барилгын дотоод орчны агаараас 35 дээж авч агаарт ялгарч буй 4 төрлийн дэгдэмхий органик нэгдэл, хорт бодисын хэмжээг шинжлэхэд 62 хувьд буюу 8 сургууль, цэцэрлэгийн дотоод орчны агаарт формальдегид болон бензол хүлцэх хэмжээнээс 1.03-22.7 дахин их хэмжээгээр илэрч байна.

3.69. Формальдегид нь дотор заслын материалаас ялгарч хүүхдийн нүд, хамар, хоолой, амьсгалын замд цочрол үүсгэх, удаан хугацааны өндөр өртөлтөд хорт хавдрын эрсдэлийг нэмэгдүүлдэг хорт бодис бөгөөд түүврийн 13 барилгаас 3 барилгад илэрч байна.

Хүснэгт 17. Формальдегид /НСНО/ нэгдлийн хүлцэх хэмжээ болон илэрсэн хэмжээ

№	Байршил	Хэмжих нэгж	Хүлцэх дээд хэмжээ	НСНО, мкг/м ³	Хэтрэлтийн хувь
1	ЧД, 16-р хороо, 359-р цэцэрлэг	мкг/м ³	50	54.5 (1.09×)	8.9%
2	БЗД, 27-р хороо, 45-р цэцэрлэг	мкг/м ³	50	75.7 (1.51×)	51.4%
3	БЗД, 24-р хороо, 364-р цэцэрлэг	мкг/м ³	50	51.7 (1.03×)	3.5%

Эх сурвалж: Шинжээчийн лабораторийн шинжилгээний дүгнэлт

⁸³ 37.1.5. “Захиалагч барилгын ажлын үе шат бүрд зохиогчийн хяналт хийлгэж, хөндлөнгийн лабораторийн шинжилгээгээр материал, хийц, бүтээц, эдлэхүүний чанар, аюулгүй байдлын техникийн үзүүлэлтүүдийг тодорхойлуулж, холбогдох зардлыг хариуцах”

3.70. Бензол нь олон улсын стандартад заасан нэгдүгээр ангиллын хорт хавдар үүсгэгч бодист хамаардаг бөгөөд 13 барилгаас 6 барилгад бензол хүлцэх хэмжээнээс өндөр хэмжээтэй илэрсэн.

Хүснэгт 18. Бензолын концентраци хүлцэх хэмжээ болон илэрсэн хэмжээ

№	Сургууль, цэцэрлэг	Байршил	Хэмжих нэгж	Хүлцэх хэмжээ	Бензол	Хэтрэлт
1	СХД-ийн 352-р цэцэрлэг	1-р давхар баруун хойд анги	мкг/м ³	1	1.01	1.01х
2	СХД-ийн 21-р хороо, цогцолбор бага сургууль	2-р давхар урд анги	мкг/м ³	1	17.04	17х
		Багш нарын өрөө	мкг/м ³	1	22.69	22.69х
3	СХД-ийн 21-р хороо, цогцолбор цэцэрлэг	2-р давхар урд анги	мкг/м ³	1	16.08	16.08х
		2-р давхар баруун анги	мкг/м ³	1	22.69	22.69х
4	ХУД-ийн 1-р хороо, 348-р цэцэрлэг	1-р давхар 5 тоот анги	мкг/м ³	1	1.77	1.77х
		2-р давхар 21 тоот анги	мкг/м ³	1	1.31	1.31х
5	ЧД-ийн 6-р хороо, 108-р цэцэрлэг	Урлаг заал 209 тоот	мкг/м ³	1	25.88	25.88х
6	ЧД-ийн 16-р хороо, 359-р цэцэрлэг	2-р давхар урд анги	мкг/м ³	1	25.88	25.88х
		2-р давхар урлаг заал	мкг/м ³	1	18.27	18.27х

Эх сурвалж: Шинжээчийн лабораторийн шинжилгээний дүгнэлт

3.71. Цаашид барилгын материалын чанарт тавих хяналтыг сайжруулж УТХО-аар хэрэгжүүлсэн барилга байгууламж, их засварын ажлыг ашиглалтад хүлээн авахдаа эрүүл мэндэд сөрөг нөлөө бүхий дэгдэмхий органик нэгдэл, хорт бодис ялгарч байгаа эсэхийг хянах, хүлцэх хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд авч хэрэгжүүлэх арга хэмжээтэй холбоотой зохицуулалтыг захиалагчийн хяналтын дүрэм, комисс ажиллах дүрэмд тусгах шаардлагатай байна.

3.72. Барилгын тухай хуулийн 40 дүгээр зүйл 40.1.12⁸⁴-т заасны дагуу гүйцэтгэгч нь ажлын үе шат бүрд бетоны бат бэхэд шинжилгээ хийлгэж, дүгнэлт гаргуулах үүрэгтэй, мөн хуулийн 37 дугаар зүйл 37.1.5⁸⁵-д заасны дагуу захиалагчаас материал, хийц, бүтээц, эдлэхүүний чанарыг хөндлөнгийн лабораторт шинжлүүлж хяналт тавих үүрэгтэй бөгөөд энэ зохицуулалтын хүрээнд бетоны бат бэхийн сорьцыг үе шатны ажил дуусах бүрд 7, 14, 28 хоногт лабораторийн шинжилгээнд хамруулдаг.

3.73. Бетоны бат бэхийн шинжилгээ хийх явцад тавих захиалагчийн хяналт хангалтгүй, шинжилгээний үр дүнгийн нэгдсэн цахим систем, архивын бүртгэл бүрдээгүйгээс сорьцын үр дүнгийн мөрдөлт, баталгаажуулалт сул, чанарын хяналтын тогтолцоо үр нөлөөтэй хэрэгжихгүй байна.

3.74. Барилга хөгжлийн төвийн барилгын материалын чанар сорилт, шинжилгээний лабораторийн 2025 онд хийж гүйцэтгэсэн бетоны бат бэхийн сорилт шинжилгээний үр дүнд судалгаа хийхэд улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй 7 барилгад ашигласан бетоны 79 сорьц нь зураг төсөлд заасан бат бэхийн маркийн шаардлагыг хангаагүй дүгнэлтийг тус лабораторийн тайланд дурдсан байна. Үүнд:

- Сургуулийн барилга, 640 суудал (Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 12 дугаар хороо) – М250 маркийн 9 сорьц - 2025 оны 4 дүгээр сар, М250 маркийн 6 сорьц - 2025 оны 5 дугаар сар;
- Сургуулийн барилга, 1500 суудал /Дархан-Уул, Дархан сум/ - М350 маркийн 6 сорьц, 2025 оны 5 дугаар сар, М350 маркийн 6 сорьц - 2025 оны 6 дугаар сар
- Сургуулийн барилга, 640 суудал (Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 12 дугаар хороо) – М250 маркийн 6 сорьц, 2025 оны 5 дугаар сар
- Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Дархан-Уул аймаг дахь салбар Анагаах ухааны сургуулийн эмнэлгийн өргөтгөлийн барилга /Дархан-Уул, Дархан сум/ - М350 маркийн 21 сорьц, 2025 оны 7 дугаар сар;

⁸⁴ 40.1.12.барилга байгууламжийн хийц, бүтээцийн даацын бат бэхийг барилгын ажлын үе шат бүрд лабораторийн шинжилгээ хийлгэж дүгнэлт гаргуулан баталгаажуулах;

⁸⁵ 37.1.5.барилгын ажлын үе шат бүрд зохиогчийн хяналт хийлгэж, хөндлөнгийн лабораторийн шинжилгээгээр материал, хийц, бүтээц, эдлэхүүний чанар, аюулгүй байдлын техникийн үзүүлэлтүүдийг тодорхойлуулж, холбогдох зардлыг хариуцах;

- Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах төв /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/ - М350 маркийн 3 сорьц - 2025 оны 8 дугаар сар, 6 сорьц - 2025 оны 9 дүгээр сар, М400 маркийн 3 сорьц - 2025 оны 10 дугаар сар, М350 маркийн 24 сорьц - 2025 оны 10 дугаар сар;
- Шүүхүүдийн нэгдсэн барилга /Хан-Уул дүүрэг 21 дүгээр хороо/ - М350 маркийн 6 сорьц, 2025 оны 8 дугаар сар;
- ССАЖЗС-ын багцын 1.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй “Аялал жуулчлалын гол чиглэл, улсын чанартай хатуу хучилттай авто зам дагуу үйлчилгээний цогцолборын барилга” /Увс/ ТАХ-ний барилгын бетоны сорьц шахалтын бат бэхийн шаардлагыг хангаагүй;
- ЭХЭМҮТ-ийн Эх барих, эмзэгтэйчүүдийн эмнэлгийн барилгын хүчитгэл гадна ариутгах татуургын шугам зөөх ажил Багц-5 – М350 маркийн 18 сорьц, 2025 оны 11 дүгээр сарын лабораторийн дүгнэлтүүдээр шаардлага хангаагүй гарсан байна.

3.75. Сорьцын дээрх дүгнэлтүүд нь захиалагч талд биетээр хадгалагдаагүй, мэдээлэл зөрүүтэй байсан тул 2026 оны 5 дугаар сарын 7-ны өдөр төслийн талбайд бетоны бат бэхийг үл эвдэх аргаар туршиж шалгахад бетон нь зураг төсөлд заасан бат бэхийн маркийн шаардлагыг хангасан байв.

3.76. Мөн Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Дархан-Уул аймаг дахь салбар Анагаах ухааны сургуулийн эмнэлгийн өргөтгөлийн барилга /Дархан-Уул, Дархан сум/ ТАХ-ний В блокийн суурийн бетоны бат бэхийн шинжилгээ нь БХТ-ийн Барилгын материалын чанар сорилт, шинжилгээний лабораторийн дүгнэлтээр шаардлага хангаагүй орбол мөн тухайн өдөр хийгдсэн “Барилга архитектур корпораци” ХХК-ийн шинжилгээний дүгнэлтээр бат бэхийн шаардлагад нийцсэн гэсэн 2 өөр дүгнэлт гарсан байна.

3.77. Барилгын материалын чанарын сорилт, шинжилгээний лабораториудын шинжилгээний үр дүнгийн нэгдсэн мэдээллийн системгүйгээс шалтгаалан улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж буй барилга байгууламжийн материалын сорилт, шинжилгээний үр дүнг ангилсан нэгдсэн бүртгэл, мэдээлэл хангалтгүй, шинжилгээний дүн шаардлага хангаагүй тохиолдолд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлэгч байгууллага, албан тушаалтан хэрхэн мэдээлэл солилцож хяналт хэрэгжүүлэхэд ашиглаж байгаа зэрэг нь тодорхойгүй байна.

3.78. Эдгээр нь Барилгын тухай хуулийн 40 дүгээр зүйл 40.1.12-т заасан “Барилгын ажил гүйцэтгэгч ... барилга байгууламжийн хийц, бүтээцийн даацын бат бэхийг барилгын ажлын үе шат бүрд лабораторийн шинжилгээ хийлгэж дүгнэлт гаргуулан баталгаажуулах” чиг үүргийн хэрэгжилтэд захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч байгууллагаас тавих хяналт хангалтгүйг харуулж байна.

3.79. Барилга байгууламжийн ажлын захиалагч нь лабораторийн шинжилгээний үр дүнг үнэн зөв хянах, баримтжуулах үйл ажиллагааг хангалттай хэрэгжүүлэхгүй байгаа нь Барилгын тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан “барилга байгууламжийн материал, хийц, бүтээц, эдлэхүүн нь эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд аюул учруулахгүй, бат бэх тогтвортой байх” зарчим алдагдах эрсдэлийг үүсгэж байна.

Хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээг зураг төсөв, техникийн тодорхойлолтын дагуу гүйцэтгээгүй байхад ашиглалтад хүлээн авсан байна

3.80. УТХО-аар 2025 онд хэрэгжиж дууссан 1,447.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 304 барилга байгууламж, их засварын ажлыг байнгын ашиглалтад хүлээн авчээ.

3.81. Барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах комисс зарим ажлыг зураг төсөв, техникийн тодорхойлолтын дагуу гүйцэтгээгүй, комиссын гишүүдийн өгсөн үүрэг даалгаврыг гүйцэтгэгч хэрэгжүүлээгүй байхад улсын комиссын актыг баталгаажуулан барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авсан зөрчлүүд илэрч байна. Тухайлбал:

- ЗТС-ын багцын 71.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Мянганы замын хэвтээ тэнхлэгийн Орхон гол-Их тамир чиглэлийн гүүр, авто замын ажлын эхлэл, 63 км /Архангай, Батцэнгэл сум/ ТАХ-ний гүйцэтгэгч Замын байгууламжийн ашиглалт, улсын комиссын үүрэг даалгавар болох нийт 9.5 га чулуун болон шороон ордуудыг дарж хэлбэршүүлэх нөхөн сэргээлтийн ажил, замын даланг болон ухмалын хажуу талыг 45 градусын налуутай тэгшлэх ажлыг хийж гүйцэтгээгүй;
- БОУАӨС-ын багцын 0.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Цаг уурын өртөөний барилга /Хөвсгөл, Тариалан сум/ ТАХ-г ашиглалтад хүлээн авах комиссын бүрэлдэхүүнд зураг төслийн

зохиогчийг оролцуулаагүй, агааржуулалтын ажлыг зургийн дагуу хийгээгүй, шатны чулуун өнгөлөө, газардуулгын ажлыг гүйцэтгээгүй;

- Боловсролын сайдын багцын 2.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Дотуур байрны барилга, 75 ор /Баянхонгор, Баянбулаг сум/ ТАХ-ний комиссын гишүүдийн өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй, зураг төсөвт тусгасан ажлуудыг бүрэн гүйцэтгээгүй;
- ХББОСС-ын багцын 10.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй "Сумын төвийн шинэчлэл" хөтөлбөр /Баянхонгор, Галуут сум/ ТАХ-ний комиссын гишүүдийн өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй, зураг төсөвт тусгасан ажлуудыг бүрэн гүйцэтгээгүй;
- Боловсролын сайдын багцын 13.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Сургуулийн барилга, 640 суудал /Баянхонгор, Баянхонгор сум/ ТАХ-ний комиссын гишүүдийн өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй, зураг төсөвт тусгасан ажлуудыг гүйцэтгээгүй;
- Боловсролын сайдын багцын 4.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Сургуулийн барилга, 160 суудал /Баянхонгор, Заг сум/ ТАХ-ний комиссын гишүүдийн өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй, зураг төсөвт тусгасан ажлуудыг гүйцэтгээгүй;
- ХББОСС-ын багцын "Цэвэр хот" ОНӨААТҮГ-ын ажилчдын байр, халуун усны байр /Баянхонгор, Баянхонгор сум/ ТАХ-ний гүйцэтгэгч компани нь 124.9 сая төгрөгийн гадна тохижилтын ажлыг дуусгаагүй, барилгын гаднах хаяачны цутгалт бүрэн хийгдээгүй, цутгасан бетон хөлдөж хагарсан, комиссын гишүүдийн өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлээгүй;
- Боловсролын сайдын багцын 3.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Цэцэрлэгийн барилга, 150 ор /Дорноговь, Сайншанд сум/ ТАХ-г ашиглалтад хүлээн авах комиссын гишүүдийн өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй;
- Боловсролын сайдын багцын 9.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Сургуулийн барилга, 640 суудал /Дорноговь, Замын-Үүд сум/ ТАХ-г ашиглалтад хүлээн авах комиссын гишүүдийн өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй;
- ССАЖЗС-ын багцын 8.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Соёл, урлагийн ордон, 500 суудал /Дорноговь, Замын-Үүд сум, 3 дугаар баг/ ТАХ-г ашиглалтад хүлээн авах комиссын гишүүдийн өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй байхад тус тус ашиглалтад хүлээн авсан.

3.82. Эдгээр нь ТАХ-ний хэрэгжилт гүйцэтгэлд тавих үе шатны хяналт хангалтгүй, барилга байгууламжийг хүлээн авах комисс холбогдох хууль дүрмийн дагуу хянаж хүлээн авах үүргээ хэрэгжүүлэхгүй байгаатай холбоотой байх тул холбогдох ТЕЗ нарт албан шаардлага хүргүүлэв.

3.83. ТАХ-ний хэрэгжилтэд тавих захиалагчийн хяналт, улсын комиссын үүрэг даалгавар хэрэгжихгүй байгаагаас барилга байгууламж нь зураг төсөл, төсөв, техникийн тодорхойлолтоос зөрүүтэй байх, шаардлага хангаагүй барилгыг ашиглалтад хүлээн авах зөрчил давтагдаж байна.

3.84. Мөн захиалагчийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагуудын чиг үүрэг, хариуцлага, хяналтын хэрэгжилт харилцан адилгүй байгаа нь хөрөнгө оруулалтын төслийн чанар, хэрэгжилтийн үр дүн, хариуцлагын тогтолцоонд сөргөөр нөлөөлж байна.

3.85. УТХО-аар хэрэгжүүлж улсын комиссын дүгнэлтээр байнгын ашиглалтад хүлээн авсан барилга байгууламжийг ашиглах явцад ТАХ-ний чанартай холбоотой алдаа, зөрчил илэрч байна. Тухайлбал ЗТС-ын багцын Аймгийн төвийн доторх хатуу хучилттай авто замын 2 дугаар үе шат /Дархан-Уул, Дархан сум/ 4 дүгээр багц ажлын хүрээнд хийгдсэн авто замын 550 ширхэг бетон хашлага эвдэрсэн, Боловсролын сайдын багцын 3.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй "Цэцэрлэгийн барилга, 240 ор" /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/ ТАХ-ний барилгын хананд цууралт, хаалгануудад мөөгөнцөр үүссэн, зарим өрөөнд агааржуулалт хийгдээгүй, гадна усны хаялгыг зураг төслийн дагуу хийж гүйцэтгээгүйгээс шалтгаалан барилгын суурьт ус нэвчих нөхцөл бүрдсэн байна.

3.86. Улсын комисс ажиллан барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авсан ч ашиглалтын явцад чанарын доголдол, эвдрэл гарч байгаа нь "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийн 5⁸⁶ дугаар зүйлд заасан улсын комиссын чиг үүрэг хэрэгжихгүй байгааг харуулж байна.

3.87. Боловсролын сайд болон ССАЖЗС-ын багцад хэрэгжин 2025 онд ашиглалтад хүлээн авсан 82 барилгын улсын комиссын үүрэг даалгаврын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийхэд

⁸⁶ Тав. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын чиг үүрэг

тухайн жилийн сүүлийн саруудад улсын комисст хүлээлгэн өгсөн тохиолдолд гадна тохижилтын ажлыг дараа онд үргэлжлүүлэн гүйцэтгүүлэхээр захиалагч, гүйцэтгэгч талууд хоорондоо тохиролцон 16 барилга угсралтын ажлыг ашиглалтад хүлээн авсан байна.

3.88. Энэ нь “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.8.38.3⁸⁷-т заасныг зөрчсөн ба гүйцэтгэл бүрэн дуусаагүй барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авснаар тохижилтын ажил бүрэн хийгдэхгүй орхигдох эрсдэлтэй байна.


Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн зарим барилга байгууламжид мэдээллийн самбарын байршуулаагүйгээс мэдээллийн ил тод байдал бүрэн хангагдаагүй байна

3.89. Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2023 оны 49 дугаар тушаалаар улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр санхүүжих бүтээн байгуулалтын ажлын мэдээллийн самбарт тавих шаардлага, стандартыг баталж 2024 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөхөөр тусгажээ.

3.90. Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системд мэдээллийн самбарын зураг оруулах дэд цэс шинээр үүсгэснээр барилга байгууламжийн гүйцэтгэгч нар мэдээллийн самбарын зургийг 2025 оны 4 дүгээр сараас эхлэн системд оруулж баримтжуулснаар Сангийн яам хяналт тавих нөхцөл боломж бүрдсэн байна.

3.91. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 оноос эхлэн шинээр хэрэгжиж буй 122 барилга байгууламж, их засварын ажлын мэдээллийн самбарын байршуулалт, цахим баримтжуулалтыг хянахад 44 хувь буюу 54 ТАХ-ний мэдээллийн самбарыг байршуулаагүй, цахим системд бүртгээгүй, хэрэгжилт хангалтгүй байна.

Дүрслэл 9. Цахим системд баримтжуулсан мэдээллийн самбар



3.92. Бүтээн байгуулалтын ажлын мэдээллийн самбарын стандартыг бүх ТАХ-ний хувьд 2024 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр зохицуулсан боловч төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системд зөвхөн 2025 оноос шинээр хэрэгжиж, санхүүжилт авсан ТАХ-г бүртгэсэн байна.

3.93. Мөн өмнөх оноос шилжин хэрэгжиж байгаа ТАХ-ний мэдээллийн самбарыг стандартын дагуу шинэчлээгүй, хэрхэн хяналт тавих талаарх зохицуулалтгүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон зарим хөрөнгийг бүртгэлд тусгаагүй, хөрөнгийн бүртгэлд тавих хяналт сул байна

3.94. УТХО-аар 2025 онд хэрэгжүүлж, ашиглалтад хүлээн авсан нийт 1,902.4 тэрбум төгрөгийн 668 төсөл, арга хэмжээнээс зарим төсөл, арга хэмжээг хөрөнгөд бүртгээгүй байна. Тухайлбал:

- Дархан-Уул аймагт 12.3 тэрбум төгрөгийн барилга байгууламж, 61.3 тэрбум төгрөгийн автозам, 1.9 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмж нийт 25 ТАХ-ний 75.5 тэрбум төгрөгийг;
- ЗТС-ын багцын 9.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Чойбалсан хот доторх авто замын шинэчлэл, сайжруулалт /Дорнод, Хэрлэн сум/ ТАХ-ний Багц-3 ажлын нийт 4.6 тэрбум төгрөгийг;
- ССАЖЗС-ын багцын 5.4 тэрбум төсөвт өртөгтэй Кино театрын барилга /Ховд, Жаргалант сум/ ТАХ-г;

⁸⁷ 4.8.38.3.санхүүжилтийн зохицуулалтыг тухайн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, гүйцэтгэлд үндэслэх;

- ССАЖЗС-ын багцын 2.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Төв номын сангийн барилга /Булган, Булган сум/ ТАХ-г;
- ССАЖЗС-ын багцын 3.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Соёлын төвийн барилга, 400 суудал /Өвөрхангай, Хужирт сум/ ТАХ-г;
- ЗТС-ын багцын 5.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Ногоон байгууламж бүхий орчны тохижилт /Ховд, Зэрэг, Мянгад, Буянт, Ховд, Чандмань, Дарви, Эрдэнэбүрэн, Манхан, Дөргөн, Цэцэг сум, Архангай, Өгийнуур сум/ ТАХ-ний хүрээнд Зэрэг, Мянгад, Буянт, Чандмань сумдын ногоон байгууламж орчны тохижилтыг;
- ЗТС-ын багцын 4.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Сумын төвийн авто замын шинэчлэл, 2.15 км /Дорноговь, Замын-Үүд сум/ ТАХ-г;
- ЭХС-ын багцын 6.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Дорноговь аймгийн дулааны станцын өргөтгөл /Дорноговь, Сайншанд сум/ ТАХ-г;
- НЗД бөгөөд Улаанбаатар хотын Захирагчид эрх шилжсэн ТАХ-ээс "Хөрөнгөд бүртгээгүй 23.8 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй 10 ТАХ-ний ажлын эцсийн гүйцэтгэл тухайн ондоо багтаж гараагүй, ажил дууссан ч хүсэлт хүргүүлээгүйгээс өмчид бүртгээгдээгүй;
- ЗТС-ын багцын 2.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Улсын чанартай авто замтай холбох хатуу хучилттай авто замын эхлэл /Сэлэнгэ, Хушаат сум/ ТАХ-г;
- ЗТС-ын багцын 41.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Ховд-Алтай чиглэлийн авто замаас Чандмань сум хүртэлх хатуу хучилттай авто зам, 56.9 км /Ховд/ ТАХ-г;
- ЗТС-ын багцын 23.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй "Өндөрхаан-Норовлин чиглэлийн хатуу хучилттай авто замын үргэлжлэл" ТАХ-ний 1 дүгээр багцын хүрээнд хэрэгжүүлсэн 68.6 км авто замын хоёр дахь хэсэг;
- ЗТС-ын багцын 2.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Түйн голын төмөр бетон гүүр, 64.75 у/м /Баянхонгор, Богд сум/ тус тус бүртгэлд тусгаагүй байна.

3.95. ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор төрийн болон орон нутгийн өмчид хөрөнгө олж авах, бүртгэх, шилжүүлэх үйл ажиллагааг зохицуулсан боловч ашиглалтад хүлээн авсны дараа хөрөнгөд бүртгэх холбоотой хугацааны зохицуулалт тодорхойгүй байгаа нь хэрэгжилтэд нөлөөлж байна.

3.96. УТХО-аар бэлтгэсэн тоног төхөөрөмжийг дутуу нийлүүлсэн, ашиглалтгүй байгаа нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, ашиглагдаагүй байхад чанарын баталгаат хугацаа дуусах эрсдэлтэй байна. Тухайлбал:

- БОУАӨС-ын багцын Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/ ТАХ-ний "Байгаль хамгаалагч, цаг уурын мэдээлэл авах ажилтны мотоцикл" багцын хүрээнд худалдан авч хуваарилсан Everest cross маркийн 310 ширхэг мотоциклын тоо ширхэг, дүн зөрүүтэй, арлын дугаар давхардсан бөгөөд Авто тээврийн үндэсний төвийн тээврийн хэрэгслийн бүртгэлийг 2026 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн байдлаар хянахад 927.5 сая төгрөгийн 240 ширхэг мотоциклыг ашиглагч байгууллагын эзэмшилд бүртгээгүй;
- ССАЖЗС-ын багцын Орон нутгийн музейн соёлын өвийн тоног төхөөрөмж /Говь-Алтай, Есөнбулаг/ ТАХ-ний хүрээнд нийлүүлэх үзмэрийн хаяг тайлбар 3.0 сая, 13 ширхэг танилцуулга самбар 2.8 сая, 1 ширхэг түүхэн бичээс бичиг 1.0 сая, нийт 6.2 сая төгрөгийн хөрөнгийг нийлүүлээгүйгээс бүртгэлд тусгаагүй;
- ЭЗХС-ын багцын 1.3 тэрбум төгрөгийн гүүр, гүүрэн байгууламж, авто замын 4 ТЭЗҮ, зураг төсвийг хүлээн авсан ч ашиглагч байгууллагад шилжүүлж, бүртгүүлэх хүсэлтээ ТӨБЗГ-т хүргүүлээгүйгээс бүртгэлд тусгаагдаагүй;
- ХББОСС-ын багцад 2022-2025 онуудад хэрэгжиж дууссан 68.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 24 ТАХ-ний үр дүн бий болсон хөрөнгийг бүртгэлд тусгаагүй байна.

3.97. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.2, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4.8.30 дахь заалтыг зөрчсөн байна.

3.98. УТХО-ын ТАХ-ний үр дүнд бий болсон хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаагүй, хүлээн авагч тодорхойгүй, ашиглалтгүй хадгалсан, түрээсийн болон ашиглалтын орлогыг бүрэн төвлөрүүлээгүй зэрэг дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- ХХААХҮС-ын багцын 2.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилга /Говьсүмбэр, Сүмбэр сум/ ТАХ-г ашиглалтад хүлээн авсан боловч бүртгэлд тусгаагүй, анхны зориулалт, хүчин чадлаар нь бүрэн ашиглаагүй;

- ХХААХҮС-ын багцын 4.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Орон нутгийн хөгжлийг дэмжих шинэ хөдөө" ТАХ-ний 2 дугаар багцын хүрээнд нийлүүлэгдсэн 200 ширхэг оёдлын машинаас 47 ширхгийг хэнд олгосон нь тодорхойгүй;
- ХХААХҮС-ын багцын 0.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй "Шинэ хөдөө" төсөл /Ховд/-ийн хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн тоног төхөөрөмжийн ашиглалтын болон түрээсийн төлбөрийн орлогыг төсөвт бүрэн төвлөрүүлээгүй;
- ХХААХҮС-ын багцын 4.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Орон нутгийн хөгжлийг "Шинэ хөдөө 2" төслийн багц 2-ийн хүрээнд нийлүүлсэн 10 ширхэг хөргүүрийн 6 нь холбогдох сумууд аваагүйгээс хадгалагдаж, багц 8-ийн хүрээнд нийлүүлсэн 16 ширхэг тэжээлийн үйлдвэр ашиглалтгүй, багц 10-ын хүрээнд нийлүүлсэн 10 сумын захиалгат үйлдвэр, тоног төхөөрөмжүүдээс 9 сум нь хүлээн аваагүй, ашиглалтгүй;
- ХХААХҮС-ын багцын 4.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Ховд/ ТАХ-ний багц 4-ийн хүрээнд нийлүүлсэн хүлэмжээс Дарви, Зэрэг суманд олгосон 10 ширхэг хүлэмж ашиглалтгүй;
- ХХААХҮС-ын багцын 4.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Ховд/ ТАХ-ний багц 2-ын "Малын гаралтай түүхий эдийн тоног төхөөрөмж" нийлүүлэх ажлаар хүлээн авсан ноосны пресс, ноосны пүү, хонь хяргадаг хайчийг авсан 15 суманд ашиглалтгүй байгаа, арьс шир элдэх 5 ширхэг багц, Ноос нарийвчлан самнах 2 ширхэг, эсгий үйлдвэрлэх иж бүрэн 7 ширхэг тоног төхөөрөмжүүд нь үйлдвэрлэлд ашиглах боломжгүй;
- ЗТС-ын багцын 5.0 тэрбум төгрөгийн Ногоон байгууламж бүхий орчны тохижилт /Ховд, Зэрэг, Мянгад, Буянт, Ховд, Чандмань, Дарви, Эрдэнэбүрэн, Манхан, Дөргөн, Цэцэг сум, Архангай, Өгийнуур сум/ ТАХ-ний хүрээнд нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийн ашиглалт хангалтгүй;
- ХББОСС-ын багцын 56.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах цогц хөтөлбөр, 1-р үе шатыг аймаг, сумдад хэрэгжүүлэхэд шаардагдах УТХО /Бүсүүд/ ТАХ-ний хүрээнд 900.2 сая төгрөгийн гэрээний дүнтэй "Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах төсөл" /Архангай, Эрдэнэмандал/ ТАХ хэрэгжиж 2025 оны 12-р сард ашиглалтад хүлээн авсан ч 1 орон сууцыг төрийн албан хаагчид түрээсийн гэрээгээр ашиглуулсан, 7 орон сууц түрээслэгчгүй буюу ашиглалтгүй байна.

3.99. ХХААХҮС-ын багцад хэрэгжүүлсэн ТАХ-ний хүрээнд нийлүүлсэн тоног төхөөрөмжийг бүртгэлд тусгаагүй, зориулалтын дагуу ашиглаагүй, ашиглалт хангалтгүй дээрх зөрчлүүдийг арилгуулахаар албан шаардлага хүргүүлэв.

3.100. Боловсролын сайдын багцын 4.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Тусгай хэрэгцээт хүүхдийн цэцэрлэгийн барилга, 150 ор /Өвөрхангай, Арвайхээр сум, 13 дугаар баг/ ТАХ-ний барилгыг бүрэн дуусаагүй, улсын комисс хүлээн аваагүй, ашиглах шийдвэр гаргаагүй барилгад хүүхдийн цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байна.

3.101. ХББОСС-ын багцад Хэнтий аймгийн Хэрлэн сумын айл өрхийг цэвэр, бохир ус, дулааны шугам сүлжээнд холбох зорилгоор 2021 оноос эхлэн нийт 135.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ-г хэрэгжүүлсэн ба үүнээс 61.2 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй 4 багц ТАХ-г 2024, 2025 онд ашиглалтад хүлээн авч санхүүжилтийг олгосон боловч туршилт тохируулга хийгдээгүй, айл өрх, хэрэглэгчид холбогдоогүй, ашиглаж эхлээгүй байгаа бөгөөд 2026 оны 5 дугаар сарын байдлаар Хэрлэн сумын хэмжээнд 5 өрх хүсэлт өгч техникийн нөхцөл авсан байна.

3.102. Эдгээр багц ажлуудаас Чингис хотын бохир усны төв коллекторын 1,2,3,4 дүгээр шугамын шинэчлэл, даралтат шугам /Хэнтий аймаг Хэрлэн сум/, Инженерийн шугам сүлжээ /Хэрлэн сум 1, 2 дугаар баг/ ТАХ-г түүвэрлэн аудитад хамруулахад дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

- Цэвэр усны шугамыг шуудуунд угсрахдаа дулааны шугамтай зэрэгцээ байрлалтайгаар угсрагдахаар төлөвлөсөн боловч захиалагч, зохиогчийн шийдвэрээр гүйцэтгэгч дулааны өгөх буцах шугамын дундуур угсарсан нь БНБД 40-02-16 "Ус хангамж, гадна сүлжээ ба байгууламжийн норм" болон ажлын зураг төслийн дагуу хийгдээгүй, зөрүүтэй;
- Зохиогчоос ажлын гүйцэтгэлийн явцад гүйцэтгэгч байгууллагад өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг гаргуулаагүй, баримтжуулаагүй, батлагдсан ажлын зураг төслийн дагуу хийгээгүй болон норм стандартын дагуу хийгээгүй ажлуудыг засаагүй,
- Захиалагчаас нэмэлт болон зургаас өөрчлөгдөн хийгдсэн ажлуудын тоо хэмжээ, зураг төсвийг зөрүүтэй хянасан, бичиг баримтын бүрдлийг хангаж ажиллаагүй байна.

3.103. Иймд ХББОСС-д Хэнтий аймгийн Хэрлэн суманд хэрэгжүүлсэн гэр хорооллын инженерийн шугам сүлжээний ажлын гүйцэтгэл, захиалагчийн хяналт гүйцэтгэгч болон зураг төслийн байгууллагын үйл ажиллагаанд салбарын дотоодын хяналт шалгалт хэрэгжүүлж, зөрчлүүдийг арилгуулах албан шаардлага хүргүүлэв.

3.104. Захиалагч байгууллагуудын хэрэгцээ шаардлагад үндэслэн тоног төхөөрөмжийн ТАХ-г төлөвлөж батлах шаардлагатай байгаа бөгөөд бэлтгэн нийлүүлсэн хөрөнгийг хуваарилсан байгууллага, нэгжид бодитоор бүрэн хүлээлгэн өгсөн эсэх, бүртгэлд тусгасан эсэхэд ТЕЗ-ийн тавих хяналт сул, зарим салбарын тоног төхөөрөмжийн хуваарилалт, олголт огт хяналтгүй хэрэгжиж байгаа нь хөрөнгө эзэнгүйдэх, алдагдах эрсдэл дагуулж байна.

3.105. Цаашид улсын төсвийн хөрөнгөөр нийлүүлж буй өмч хөрөнгийг хүлээлгэн өгөх, хүлээн авах, нягтлан бодох бүртгэлд бүртгэх үе шат бүрд ТЕЗ нар дотоод хяналтыг холбогдох хууль, журамд заасны дагуу хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээний төлөвлөлт оновчгүй, үр ашиг багатай байна

3.106. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020–2025 онд хэрэгжүүлсэн ТАХ-ний үр ашгийг үнэлэх зорилгоор аудитын баг иргэний нийгмийн байгууллагын санхүүжилтээр судалгааны багтай хамтран боловсрол, эрүүл мэнд, соёл, авто зам, инженерийн дэд бүтэц зэрэг голлох салбаруудад хэрэгжүүлсэн ТАХ-ээс түүвэрлэн авч боломжит мэдээлэл, өгөгдөлд тулгуурлан зардал үр ашгийн шинжилгээг хийж гүйцэтгэсэн.

Ерөнхий боловсролын сургууль барих төсөл, арга хэмжээ:

3.107. Ерөнхий боловсролын сургууль барих, өргөтгөх ТАХ-ний үр дүнг шинээр бий болгосон суудлын тоо, зарцуулсан хөрөнгө, байршлын тархалтаас гадна хоёроос дээш ээлжээр хичээллэж буй суралцагчийн ачаалал ихтэй байршилд төлөвлөсөн эсэхийг голлох шалгуур үзүүлэлт болгож үр дүнгийн үнэлгээнд авч үзсэн.

3.108. Ерөнхий боловсролын сургуулийн ачааллыг Боловсролын яамны ээлжийн коэффициентын үзүүлэлтэд тулгуурлан үнэлэхэд 2020–2025 онд ашиглалтад орсон 43 сургуулийн 44.2 хувь нь ээлжийн коэффициент 2-оос их буюу ачаалал ихтэй байршилд хэрэгжсэн бол үлдэх 55.8 хувь нь 2-оос бага буюу сурагчийн ачаалал харьцангуй бага байршилд төлөвлөгдөж хэрэгжсэн байна.

3.109. УТХО-аар хэрэгжиж ашиглалтад орсон 43 сургуулиас 83.7 хувь буюу 36 нь орон нутагт хэрэгжиж, нийт өртгийн 76.3 хувь, суудлын тоогоорх нийт хүчин чадлын 74.5 хувийг эзэлж байна. Энэ нь сургууль барих, өргөтгөх ТАХ тоо болон хүчин чадлын хувьд орон нутагт илүү чиглэснийг харуулж байна.

3.110. Ерөнхий боловсролын сургуулийн ачааллыг илэрхийлэх жинлэсэн ээлжийн коэффициент аймгийн төвд 1.87, сумд 1.28 буюу харьцангуй зөрүүтэй байна. Харин Улаанбаатар хотод ачаалал харьцангуй их буюу жинлэсэн ээлжийн коэффициент 1.91 байхад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төлөвлөж хэрэгжүүлэн ашиглалтад орсон сургуулийн бага хувь нь нийслэлд ногдож байна.

3.111. Энэ нь орон нутагт хэрэгжсэн сургууль барих зарим ТАХ нь сургуулийн ачаалал, ээлжийн коэффициентын үзүүлэлттэй уялдаагүйгээс тэргүүн эрэмбэд хамаарахгүй тул зарим ТАХ-ний төлөвлөлт оновчгүй байгааг харуулж байна.

3.112. Насны бүлгээрх хүн амын статистик мэдээллээр ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын өсөлтийн хурд ойрын жилүүдэд саарч 2028 оноос буурах төлөвтэй байгаа боловч байршлаас хамааран ялгаатай буюу нийслэл, аймгийн төвүүдэд ачаалал өндөр хэвээр байх хандлагатай байна.

3.113. Иймд ерөнхий боловсролын сургууль барих ТАХ-г сургуулийн насны хүүхдийн бүлгийн хэтийн төлөв, байршил, шилжилт хөдөлгөөн, сурагчдын төвлөрөлтэй уялдуулан хэрэгцээг тооцож төлөвлөх нь зүйтэй.

3.114. Цаашид боловсролын салбарт төлөвлөж хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын зорилтот үр дүн, хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг шинээр баригдсан, ашиглалтад оруулсан сургуулийн барилгын тоо, суудлын тоогоорх хүчин чадлаар бус, ээлжийн коэффициент өндөртэй байршил

хэсгийн сургуулийн ачааллыг бууруулах түвшнээр үнэлж хэмжин төлөвлөж тайлагнаж хэвших шаардлагатай байна.

Иргэдэд үйлчлэх төв болон хөгжлийн төвийн барилгууд:

3.115. Иргэдэд үйлчлэх төвөөр хэдэн иргэн тогтмол үйлчилгээ авч байгаа эсэх талаар нэгдсэн судалгаа мэдээлэл дутмаг буюу үйлчилгээ үзүүлсэн иргэний тоо мэдээлэл судалгааг авахад мэдээлэл бүрэн бус, бодитой үндэслэлтэй нь тодорхойгүй байна.

3.116. Судалгаа тоон мэдээлэл ирүүлсэн иргэдэд үйлчлэх 14 төвөөр жилд нийт 162.6 мянган иргэн үйлчлүүлсэн байгаа бөгөөд нэг төвд ногдох жилийн дундаж үйлчлүүлэгч 11.6 мянга, медиан үзүүлэлт 5.1 мянга байна.

3.117. Иргэдэд үйлчлэх төвүүдийг дэд ангиллаар авч үзвэл хорооны төвүүд хамгийн өндөр ашиглалттай буюу үр ашигтай байна. Үйлчилгээ үзүүлсэн иргэдийн судалгаа мэдээллийг ирүүлсэн 4 хорооны төвөөр жилд нийт 111.0 мянган иргэн үйлчлүүлсэн нь иргэдэд үйлчлэх төвүүдийн нийт бүртгэгдсэн үйлчлүүлэгчийн 68.3 хувийг эзэлж байна.

3.118. Үзүүлсэн үйлчилгээ, хамрагдсан иргэний судалгаа мэдээллийг ирүүлсэн 7 хөгжлийн төв, ахмадын төвд нийт 144 арга хэмжээ зохион байгуулагдаж, давхардсан тоогоор 8155 хүн хамрагджээ. Нэг төвд ногдох жилийн дундаж арга хэмжээний тоо 20.6, медиан 11 байгаа бөгөөд нэг арга хэмжээнд ногдох оролцогчийн тооны дундаж 56.6 хүн, медиан 70.6 хүн байгаа нь харьцангуй үр ашиг багатай байна.

3.119. Иргэдэд үйлчлэх барилгын нэг үйлчлүүлэгчид ногдох анхны хөрөнгө оруулалтын медиан өртөг 233.1 мянган төгрөг байгаа бол хөгжлийн төвүүдийн нэг үйлчлүүлэгчид ногдох өртөг 1.26 сая төгрөг байгаа бөгөөд энэ нь тухайн төвүүдийн ашиглалт, зохион байгуулж буй үйл ажиллагаа, тэдгээрийн давтамж, хамрагдаж буй үйлчлүүлэгчдийн тооноос хамаарч байна.

3.120. Төсвийн хөрөнгөөр байгуулагдсан хөгжлийн төвүүдийн хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэхийн тулд зохион байгуулах арга хэмжээний давтамжийг нэмэгдүүлэх, зорилтот бүлэгт болон тодорхой үр дүнд чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээг тогтмол зохион байгуулах, үр дүнг үнэлж бүртгэх шаардлагатай байна.

3.121. Иргэдэд үйлчлэх төв, хөгжлийн төвүүдийн ашиглалт харилцан адилгүй, ихээхэн ялгаатай байгаа нь эдгээр барилгуудын газар зүйн байрлалаас илүү иргэдийн бодит урсгал, үйлчилгээний давтамж, төрөл, хүн амын төвлөрлөөс шалтгаалсан байна.

3.122. Иймд тухайн чиглэлийн хөрөнгө оруулалтыг анх төлөвлөхдөө үзүүлэх үйлчилгээний төрөл, хэрэгцээ, шаардлагыг хүн амын төвлөрөлтэй уялдуулж төлөвлөх, хувийн хэвшил хэрэгжүүлэх боломжтой эсэхийг харгалзан үзэх зэргээр ашиглалт багатай, байнгын тогтмол зардалтай барилга байгууламжууд нэмэгдэх эрсдэлээс зайлсхийх шаардлагатай байна.

Эрүүл мэндийн салбарын барилгууд:

3.123. Эрүүл мэндийн салбар дахь улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр ашиг, байршлын оновчтой байдал болон бодит хэрэгцээтэй уялдсан байдлыг үнэлэх зорилгоор нийт 39 барилгын өртөг зардал, орны хүчин чадал, жилийн үзлэг болон ашиглагдсан ор хоногийн мэдээллийг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт (Key Performance Indicators) болгон ашиглаж үр ашгийн шинжилгээг хийсэн.

3.124. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 39 эмнэлгийн барилгын жинлэсэн дундаж ор ашиглалт 61.5 хувь, нэг оронд ногдох дундаж өртөг 67.1 сая төгрөг, нэг үзлэгт 113.5 мянган төгрөг, нэг ор хоногт 298.7 мянган төгрөг байна.

3.125. Эмнэлгүүдийн ор хоногийн ашиглалтыг харьцуулж үзэхэд 3 ТАХ 70-аас дээш хувийн ашиглалттай, хамгийн өндөр үр ашигтай байгаа бөгөөд нийт хөрөнгө оруулалтын 83.3 хувийг эзэлж буй 25 эмнэлгийн ор хоногийн ашиглалт 40-70 хувьтай дундаж орчимд байна.

3.126. Харин 19.2 тэрбум төгрөг зарцуулж баригдсан 11 эмнэлгийн ор хоногийн ашиглалт 40 хувиас бага бөгөөд дунджаар 29.9 хувьтай байгаа нь үр ашиг багатай, төлөвлөлт оновчгүй байгааг харуулж байна.

Хүснэгт 19. Эмнэлгүүдийн ор хоногийн ашиглалт

Ор ашиглалтын бүлэг	Тоо	Зардал, тэрбум ₮	Ор	Үзлэг	Ор хоног	Жигнэсэн ашиглалт
40< хувь	11	19.2	170	56,974	18,108	45.2%
40-70 хувь	25	127.3	2,076	1,259,549	483,439	63.8%
70> хувь	3	6.3	32	29,234	10,026	85.8%

Эх сурвалж: Судалгааны багийн тайлан

3.127. Эмнэлгийн барилгын ангиллаар авч үзвэл нэгдсэн эмнэлэг, хүүхдийн эмнэлэг 61-67 хувьтай байгаа бол сумын эрүүл мэндийн төв 45.7 хувь, багийн эрүүл мэндийн төв 26.3 хувьтай хүчин чадлын ашиглалт харьцангуй бага байна. Энэхүү ялгаа нь хүн амын төвлөрөл, эмч, мэргэжилтний хүртээмж зэрэг хүчин зүйлээс шалтгаалан шалтгаалан гарч байна.

Соёлын салбарын барилгууд:

3.128. Сүүлийн 5 жилд ашиглалтад орсон 71 соёлын төвийн барилгын хэрэгцээг үнэлэхдээ тухайн бүсэд барилга баригдахаас өмнөх үеийн нөхцөл байдал буюу тухайн байршлын эрэлт, иргэдийн оролцоо, суудлын ашиглалт, нэг арга хэмжээнд ногдох үзэгчийн түвшнийг суурь болгосон. Соёлын төвүүдийг “өндөр хэрэгцээтэй”, “Дунд зэргийн хэрэгцээтэй”, “хэрэгцээтэй эсэх нь тодорхойгүй” гэсэн 3 ангилалд хуваан авч үзсэн. Үүнд:

- 24.0 хувь буюу 18 соёлын төв “өндөр хэрэгцээтэй” ангилалд багтсан ба нийт төсөвт өртөг нь 33.3 тэрбум төгрөг, дундаж KPI 65.3;
- 41.3 хувь буюу 31 соёлын төв “дунд зэргийн хэрэгцээтэй” ангилалд багтсан ба нийт төсөвт өртөг нь 43.7 тэрбум төгрөг, дундаж KPI 52.4;
- 29.3 хувь буюу 22 соёлын төв нь “хэрэгцээтэй эсэх нь тодорхойгүй” ангилалд багтсан ба нийт төсөвт өртөг 47.8 тэрбум төгрөг байна.

3.129. Өндөр хэрэгцээтэй, нөхцөлт хэрэгцээтэй гэсэн эхний 2 ангилалд нийт ТАХ-ний 65.3 хувь, төсөвт өртгийн 60.7 хувь нь хамаарч, улсын төсвийн хөрөнгө оруулалтын соёлын төв барих ТАХ тодорхой хэмжээнд үр дүнтэй хэрэгжсэн байна.

3.130. Харин нийт ТАХ-ний 29.3 хувийг эзэлж буй “хэрэгцээтэй эсэх нь тодорхойгүй” ангилалд багтсан 22 ТАХ-нд 47.8 тэрбум төгрөг зарцуулсан нь тэргүүлэх хэрэгцээ, шаардлагатай эсэх нь тодорхойгүй байршлуудад харьцангуй өндөр өртөгтэй хөрөнгө оруулалт хийгдсэн байх эрсдэлтэйг харуулж байна.

Авто замын салбарын хөрөнгө оруулалт:

3.131. Авто замын салбарын хувьд улсын төсвийн хөрөнгө оруулалт нь хөдөлгөөний эрчим өндөр, ачаа тээврийн эргэлт ихтэй, эдийн засгийн ач холбогдол бүхий, хэрэгцээ өндөр авто зам барихад чиглэсэн байх шаардлагыг шалгуур болгон авч үзсэн.

3.132. Зардал үр дүнгийн шинжилгээнд 2025 оноос өмнө ашиглалтад орсон авто замын төслүүдээс түүвэрлэн сумын төвийн нийт 10,395.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9.8 км урт хатуу хучилттай авто замын 4 ТАХ, мөн аймаг хоорондын нийт 60,974.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 77 км урт хатуу хучилттай авто замын 4 ТАХ-г сонгон шинжилгээ хийсэн.

3.133. Сонгосон төслүүдийн нэг км авто замд ногдох дундаж өртөг сумын төвийн замын хувьд 1,060.7 сая төгрөг, аймаг хоорондын замын хувьд 791.9 сая төгрөг байна.

3.134. Хөдөлгөөний эрчмийн судалгаа болон ашиглалтад орсон 8 авто замын төслийн хөрөнгө оруулалтын үр ашгийг үнэлэхэд аймгийн төвүүдийг холбосон авто замын төслүүдийн эдийн засгийн үр ашиг өндөр, харин сумын төвийн авто замын төслүүд хөдөлгөөний эрчим багатайгаас зардал үр дүнгийн шинжилгээгээр үр ашиг багатай гарсан.

3.135. Иймд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх авто замын ТАХ-ний үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг замын урт, төсөвт өртгөөс илүүтэйгээр хөдөлгөөний бодит эрчим, ачаа тээврийн эргэлт, эдийн засгийн үр өгөөж, бүс нутгийн холболт болон ашиглалтын дараах цаг хугацаа, зардлын хэмнэлт зэрэг үзүүлэлтүүдэд тулгуурлан оновчтой төлөвлөж хэрэгжүүлэх шаардлагатай байна.

3.136. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-г төлөвлөхдөө салбарын бодлогын зорилтот шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлж, үүнтэй уялдуулан төслүүдийг эрэмбэлж сонгох зарчмыг мөрдөх шаардлагатай байна.

3.137. Энэхүү зарчмыг хэрэгжүүлснээр нэн тэргүүний шаардлагатай байршилд, хамгийн бага өртөгтэй, оновчтой төслийг төлөвлөх, үр дүнг бодитоор үнэлж хянах тогтолцоо бүрдэнэ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнг баригдсан барилга байгууламжийн тоо, зам гүүр, инженерийн шугам сүлжээний урт, барилгын ажлын явцын хувиар тодорхойлох нь оновчгүй байна

3.138. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 611 ТАХ-ний 80 хувь буюу 6,981.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 415 төсөл нь боловсрол, зам тээвэр, хот байгуулалт, эрүүл мэнд, эрчим хүч зэрэг тэргүүлэх 5 чиглэлд төвлөрсөн нь суурь дэд бүтэц, нийгмийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх бодлогын зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн байна.

3.139. Үлдэх 20 хувь буюу 1,735.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 189 ТАХ нь 24 ТЕЗ-ийн төсвийн багцад хамаарч байна.

Дүрслэл 10. УТХО-ын төсөвт өртөгийн 80 хувийг эзэлж буй голлох салбарууд

8,735.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 611 төсөл, арга хэмжээ



3.140. Боловсролын салбар нь сургууль, цэцэрлэгийн орчны стандартыг сайжруулах зорилтын хүрээнд ашиглалтад оруулах цэцэрлэг, сургууль, дотуур байр, спорт заалны барилгын тоог, мөн дараа онд шилжин хэрэгжих барилга байгууламжийн тоог зорилтот түвшний шалгуур үзүүлэлтээр төлөвлөжээ.

3.141. Боловсролын салбарын төлөвлөсөн ТАХ-ний зорилтот түвшин дунджаар 81 хувьтай хэрэгжсэн ба үүнд дараа онд шилжин хэрэгжих барилга байгууламжийн тоо болон ашиглалтад оруулахаар төлөвлөсөн дотуур байр, спорт заалны тоо төлөвлөсөн зорилтот түвшинд бүрэн хүрч хэрэгжсэн нь нөлөөлсөн байна.

3.142. Харин ерөнхий боловсролын 42 сургууль ашиглалтад оруулахаар төлөвлөснөөс 52 хувь буюу 22 сургууль, 36 цэцэрлэг ашиглалтад оруулахаар төлөвлөснөөс 75 хувь буюу 27 цэцэрлэг ашиглалтад орсон зэргээр дараах 4 шалгуур үзүүлэлтийн хувьд төлөвлөсөн зорилтот түвшиндээ хүрээгүй, хэрэгжилт хангалтгүй байна.

Хүснэгт 20. Боловсролын салбарын зорилтот түвшин, түүний хэрэгжилт

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Хэрэгжилт
Ашиглалтад оруулах					
1	Ашиглалтад орох цэцэрлэг	Тоо	36	27	75
2	Ашиглалтад орох сургууль	Тоо	42	22	52
3	Ашиглалтад орох байгалийн ухааны лаборатори	Тоо	30	20	67
4	Тохируулгат орчин бүхий цэцэрлэг	Тоо	3	1	33

Эх сурвалж: Улсын хөгжлийн 2025 оны жилийн төлөвлөгөөний хэрэгжилт аудитын тайлан

3.143. Боловсролын салбарын төсвийн хөрөнгө оруулалтын ТАХ-ний зорилтот түвшин, шалгуур үзүүлэлтийг барих, ашиглалтад оруулах барилга байгууламжийн тоогоор төлөвлөж байгаа нь оновчгүй, бодлогын зорилт руу чиглүүлэх байдлаар суралцагчийн ачаалал, нэг анги, багшид ногдох хүүхдийн тоог бууруулах зэрэг сургалтын чанарт нөлөөлөх үзүүлэлтээр төлөвлөж тайлагнах шаардлагатай байна.

3.144. Зам тээврийн салбар нь авто замын сүлжээг өргөтгөх болон аялал жуулчлалын бүс нутгийн авто замын дэд бүтэц, агаарын тээврээр зорчих жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилтын хүрээнд 31 ТАХ-г хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нь дунджаар 68.1 хувьтай хэрэгжжээ.

3.145. Зарим ТАХ-ний санхүүжилтийг шийдвэрлээгүй, ХАА амжилтгүй болсон, захиалагч, гүйцэтгэгчийн зохион байгуулалт зэргээс шалтгаалан бодлогын зорилтот үр дүнд бүрэн хүрээгүй байна.

Хүснэгт 21. Зам, тээврийн салбарын зорилтот түвшин, түүний хэрэгжилт

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Хэрэгжилт /хувиар/
1	Дархан-Алтанбулаг чиглэлийн 113.1 км, 4 эгнээ хатуу хучилттай авто замын өргөтгөл, 885.6 у/м гүүрэн байгууламжийн ажлыг эхлүүлэх	Хувь	20	0	0
2	Дорнод аймгийн Хэрлэн сумаас Хавиргын боомт чиглэлийн 124.5 км хатуу хучилттай авто зам барих	Хувь	55	34.5	57
3	Улаанбаатар-Шар хөтөл-Эрдэнэт чиглэлийн хатуу хучилттай авто замын эхлэл, 92.13 км авто зам барих	Хувь	50	0	0
4	Баяндалай-Гурвантэс чиглэлийн 80 км хатуу хучилттай авто замын дуусгал, 74.2 км авто замын төслийг хэрэгжүүлэх	Хувь	30	0	0
5	Дорнод аймгийн Буйр нуур орчимд 4С нисэх буудал байгуулах	Хувь	10	0	0
6	Хэрлэн-Тосон-Уул-Халх гол чиглэлийн хатуу хучилттай 256 км авто зам барих	Хувь	20	0	0

Эх сурвалж: Улсын хөгжлийн 2025 оны жилийн төлөвлөгөөний хэрэгжилт аудитын тайлан

3.146. Хот байгуулалтын салбар инженерийн бүрэн хангамжтай сууцанд амьдрах өрхийн тоог нэмэх, инженерийн дэд бүтцийн хүртээмжийг нэмэх зорилтын хүрээнд 7 ТАХ-г дэд бүтцийн бүтээн байгуулалтыг шалгуур үзүүлэлт болгон тусгаж гүйцэтгэлийн дундаж 74.2 хувьтай байна.

3.147. Инженерийн шугам сүлжээний хөрөнгө оруулалтыг шугам сүлжээний урт, ажлын гүйцэтгэлийн хувиар бус холбогдох боломжтой хэрэглэгчийн тоо, хүртээмж, үйлчилгээний чанар, шинэ суурьшлын бүсийн хөгжилд үзүүлэх нөлөө зэргээр үнэлэх шаардлагатай байна.

3.148. Эрүүл мэндийн салбарт тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд дараах 6 ТАХ-г тусгаж төлөвлөн хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Сэргээн засах эмнэлгийн барилга, 40 ор /Өмнөговь, Даланзадгад сум, 6 дугаар баг/;
- Эрт илрүүлэг, оношилгооны төвийн барилга /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/;
- Өрхийн эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл /Дархан-Уул, Дархан сум, Гэрэлтэй өрхийн эмнэлэг/;
- Эрүүл мэндийн төвийн барилга /Сэлэнгэ, Ерөө сум/;
- Улсын Нэгдүгээр Төв Эмнэлгийн эм савлалтын автомат тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/;
- Хавдар судлалын үндэсний төвийн робот мэс заслын тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/

3.149. Эрүүл мэндийн сайдын багцад хэрэгжүүлж буй “Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/” ТАХ-ний хүрээнд Хавдар судлалын үндэсний төвд робот мэс заслын тоног төхөөрөмж бэлтгэн нийлүүлж ашиглаж эхэлсэн нь Монгол Улсад өндөр технологид суурилсан хавдрын мэс заслын эмчилгээг хөгжүүлэхэд ач холбогдолтой ажил болсон байна.

Зураг 1. Робот мэс заслын тоног төхөөрөмж



3.150. ГБХНХС-ын багцын “Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалт хөгжлийн төв”-ийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянгол дүүрэг/ ТАХ-ний хүрээнд ариун цэврийн цаас, хүнсний цаасан уут, нэг удаагийн аяга, офсет болон даавуун хэвлэл, оёдлын цехийн шинэ техникүүд, төрөл бүрийн гадаргуу дээр байгууллагын хаяг, нэрийн хуудсыг брайль үсгээр хэвлэх тоног төхөөрөмжийг нийлүүлж үйлдвэрлэлийн үйл ажиллагааг эхлүүлсэн нь хараагүй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн оролцоог дэмжих нөхцөлийг бүрдүүлжээ.

Кофены аяга үйлдвэрлэх эсгүүрийн машин



Огтолгооны болон хэв гаргах машин



Цаасан уут, стикер хэвлэх машин



3.151. Эрчим хүчний салбарт шинэ суурьшлын бүсийн инженерийн дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэх, орон нутгийн бие даасан байдлыг нэмэгдүүлэх болон эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр хангах зорилтын хүрээнд 7 ТАХ-г төлөвлөж, үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлт, зорилтот түвшнийг хөрөнгө оруулалтын ТАХ-ний ажлын явц, гүйцэтгэлийн хувиар тодорхойлж төлөвлөжээ.

3.152. Эрчим хүчний салбарт төлөвлөсөн хөрөнгө оруулалтын ТАХ-ний зорилтот түвшний хэрэгжилт дунджаар 62.2 хувьтай хангалтгүй байгаа бөгөөд үүнд дараах 3 ТАХ-ний ажлын явц 2025 онд төлөвлөсөн хувьд хүрээгүй нь голлон нөлөөлжээ.

Хүснэгт 22. Эрчим хүчний салбарын зорилтот түвшин, түүний хэрэгжилт

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Хэрэгжилт
1	Налайхын 185 МВт-ын дулааны станцын хүчин чадлын өргөтгөлийн төслийг хэрэгжүүлэх	Хувь	20	0	
2	Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн системийн оргил ачаалалд ажиллах тархмал дулааны эх үүсвэр 5 байршилд барих төслийн 1 дүгээр ээлжийг хэрэгжүүлэх	Хувь	60	9	15
3	Аймгийн төвд баригдах дулааны станцын дэд бүтцийг байгуулах, дулаан түгээх сүлжээг шинэчлэх, шинээр барих	Хувь	100	29	21

Эх сурвалж: Улсын хөгжлийн 2025 оны жилийн төлөвлөгөөний хэрэгжилт аудитын тайлан

3.153. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын ТАХ-ний төсөвт өртгийн 80 хувийг эзэлж буй гол 5 салбарын төлөвлөсөн зорилтот түвшний үзүүлэлтүүдийн хэрэгжилт дунджаар 77.1 хувьтай буюу зорилтот үр дүнд бүрэн хүрээгүй байгаа нь ХАА-г хуулийн хугацаанд амжиж зохион байгуулаагүй, санхүүжилт бүрэн шийдвэрлэгдээгүй, төслийн бэлтгэл ажил хангалтгүй зэрэг хүчин зүйлсээс голлон шалтгаалсан байна.

3.154. Эдийн засаг, нийгмийн үр өгөөж, хэрэгцээ шаардлагын эрэмбэ, төсөл хэрэгжих бэлтгэл хангалт, ашиглалтад орох хугацаа зэрэг шалгуурыг бүрэн хангаагүй төслүүдийг төлөвлөж байгаа нь хөрөнгө оруулалтын үр дүн сөргөөр нөлөөлж байна.

3.155. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-ний хэрэгжилт, үр дүнг сургуулийн ээлжийн коэффициент, нэг анги, багшид ногдох суралцагчийн тоо, эрүүл мэндийн тусламжийн чанар, авто замын хөдөлгөөний эрчим, ачаа тээврийн эргэлтийн хурд, дэд бүтцийн хүртээмж зэрэг үзүүлэлтээр хэмжиж оновчтой төлөвлөх, үр дүнг харьцуулан тайлагнадаг тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай байна.

3.156. Монгол Улсын 2020-2025 онд УТХО-ын бодлого нь боловсрол, эрүүл мэнд, авто зам, инженерийн дэд бүтэц зэрэг олон салбарыг зэрэг тэргүүлэх чиглэлд хамруулан хэрэгжүүлсэн боловч салбар хоорондын эрэмбэ, бодит хэрэгцээ, эдийн засаг-нийгмийн өгөөжид суурилсан сонголтын тогтолцоо хангалтгүй байна.

3.157. Салбарын түвшинд авч үзвэл боловсрол, эрүүл мэнд, соёл, иргэдэд үйлчлэх төв, инженерийн шугам сүлжээ, авто замын хөрөнгө оруулалтууд нь тодорхой хэмжээнд хэрэгцээтэй чиглэлд төвлөрсөн боловч хөрөнгө оруулалтын үр дүнг бодит ачаалал, ашиглалт, үйлчилгээний хүртээмж, иргэдийн оролцоо, хөдөлгөөний эрчим зэрэг үр дүнгийн үзүүлэлттэй бүрэн уялдуулан төлөвлөж хэрэгжүүлээгүй байна.

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу шаардлагатай зохицуулалтуудыг Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийн төсөлд тусгасан боловч хэлэлцэж батлагдаагүй нь зөвлөмжийн хэрэгжилтэд нөлөөлж байна

3.158. “Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар Ерөнхий сайдад 3, Сангийн сайдад 4, ТЭЗ нарт 2 нийт 9 зөвлөмж хүргүүлснээс 1 зөвлөмжийн биелэлт 90 хувьтай хэрэгжсэн, 3 зөвлөмжийн биелэлт 60 хувьтай хэрэгжих шатандаа, 5 зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна. Үүнд:

- Сангийн сайдад өгсөн “УТХО-аар өмнөх онуудад эхлүүлсэн боловч хэрэгжиж дуусаагүй зогссон барилга байгууламжийн дэлгэрэнгүй мэдээлэл, судалгааг Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системд бүртгэн хэрэгжилтийг хангуулах тогтолцоог бүрдүүлэх” зөвлөмжийн дагуу цахим системд “Бүрэн дуусаагүй төслийн жагсаалт” цэс шинээр нэмж зогссон ТАХ-ний судалгаа, мэдээллийг цахимаар авч эхэлсэн боловч бүртгэсэн мэдээлэл үнэн зөв, бодитой эсэхэд тавих хяналт дутмаг, тухайн зөвлөмжийн хэрэгжилт 90 хувьтай байна.
- Сангийн сайдад өгсөн “УТХО-ын төсөл, арга хэмжээний ХАА-д нэгдсэн удирдамжаар дотоод аудит хийж хяналт хариуцлагыг сайжруулах арга хэмжээ авч үр дүнг тайлагнах”, “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөх, зарцуулах зарчмыг баримталж, хөрөнгө оруулалтаар худалдан авах тоног төхөөрөмжийн хэрэгцээ шаардлагыг тооцож төлөвлөх, төсөвт өртгийн урьдчилсан судалгаа хийх, тендер шалгаруулалтад үнэ өртгийн судалгааг ашиглах заавар, журмыг боловсруулах, батлуулах”, ТЭЗ нарт өгсөн “Төсвийн багцын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, худалдан авах ажиллагаа, хэрэгжилт, гүйцэтгэл, бүртгэлд тусгасан эсэх бүрээр нэгдсэн судалгаа мэдээллийг бэлтгэж баталгаажуулдаг тогтолцоог бүрдүүлэх” зөвлөмж өгсөн нь тус бүр 60 хувьтай буюу хэрэгжих шатандаа байна.
- Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай анхдагч хуулийн төслийг боловсруулж аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу холбогдох эрх зүйн зохицуулалтуудыг хуулийн төсөлд тусган 2026 оны 2 дугаар сарын 12-нд Засгийн газарт танилцуулж хуулийн үзэл баримтлалыг батлуулсан байна. Тухайн хуулийн төслийг боловсруулсан ч УИХ-аар хэлэлцэгдэж батлагдаагүй байгаа нь дараах Ерөнхий сайдад өгсөн 3, Сангийн сайдад өгсөн 1 зөвлөмжийн хэрэгжилтэд нөлөөлж байна. Үүнд:
 - Улсын төсвийн хөрөнгө оруулалт болон урсгал зардал, тусгай сан, орон нутгийн төсөв, хөгжлийн сангийн хөрөнгөөр хийх төсөл, арга хэмжээг төсөвт өртөг, зориулалт, нэр төрөл, хамрах хүрээ зэргээр нарийвчлан тодорхойлж зааглах эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлж хэрэгжүүлэх;
 - Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх, хүлээн авах үе шат бүрд хийх хяналтын давтамж, шалгуурыг тодорхойлж, хяналт хариуцлагын системийн эрх зүйн зохицуулалтыг бий болгох;
 - ТЭЗ нараас эрх шилжүүлэн хэрэгжүүлэх, багцад задлах төсөл, арга хэмжээний цар хүрээ, нэр төрөл, зориулалтын шалгуурыг бий болгож эрх зүйн зохицуулалтаар хангах;
 - Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх журам, холбогдох аргачлалуудад өөрчлөлт оруулах, их засвар, тоног төхөөрөмж, ТЭЗУ ангиллын төсөл, арга хэмжээг үнэлэх, эрэмбэлэх заавар журам боловсруулж, батлуулах зөвлөмж бүрэн хэрэгжээгүй байна.
- ТЭЗ нарт “УТХО-аар ирэх онуудад хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг дунд хугацаагаар төлөвлөж, тухайн жилд хэрэгжүүлэх арга хэмжээний төсөвлөлтийн шаардлагыг өмнөх онд хангуулахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх” зөвлөмж өгсөн нь мөн бүрэн хэрэгжээгүй байна.

3.159. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжөөс хэрэгжсэн 1, бусад зөвлөмж хэрэгжих шатандаа болон хэрэгжилт хангалтгүй түвшинд байгаа бөгөөд Төсвийн хөрөнгө оруулалтын тухайн хуулийн төсөлд зарим зохицуулалтуудыг тусгасан ч хуулийн төслийг УИХ-т өргөн мэдүүлээгүй, Засгийн газраас үзэл баримтлалыг баталсан, төслийг боловсруулах, хэлэлцэх түвшинд байна.

3.160. Өмнөх аудитаар тогтоосон акт, албан шаардлагын хэрэгжилт дунджаар 48.7 хувьтай, ТЕЗ-дын хувьд хэрэгжилт харилцан адилгүй байгаа бөгөөд нийт 37 зөрчлийг арилгуулахаар 16 албан шаардлага хүргүүлснээс 6 нь бүрэн хэрэгжиж, 4 нь хэрэгжих шатандаа, 6 нь огт хэрэгжээгүй байна.

3.161. ГБХНХЯ, ЗТЯ болон ОБЕГ нь аудитын мөрөөр авах арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, илэрсэн алдаа, зөрчлийг арилгах чиглэлд тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна. Тухайлбал ЗТЯ нь улсын төсөвт төвлөрүүлэхээр тогтоосон 18.0 тэрбум төгрөгийг бүрэн барагдуулсан бол ГБХНХЯ тендер шалгаруулалттай холбоотой зөрчлийг арилгаж хэрэгжилтийг бүрэн хангасан байна.

3.162. ХББОСЯ хөгжлийн төлөвлөгөө болон хөрөнгө оруулалтын хөтөлбөртэй уялдаагүй, төлөвлөлттэй холбоотой албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлсэн боловч ХАА, үнийн судалгаа, барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах ажиллагаа, бодит гүйцэтгэлийн санхүүжилттэй холбоотой зөрчлүүдийг бүрэн арилгаагүй байна.

3.163. ЗГХЭГ, ССАЖЗЯ, ЭМЯ, Боловсролын яам нь акт, албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй, хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг хөгжлийн бодлоготой уялдуулаагүй, төсөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ-г төлөвлөсөн, бодит гүйцэтгэлээр илүү дүнгээр санхүүжилт олгосон, төсөл арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналт сул байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээний үр дүнд 23 сургууль ашиглалтад орж суралцагчийн суудлын тоо 10.6 мянгаар, 20 цэцэрлэг нэмэгдэж хамрагдах хүүхдийн тоо 3.0 мянгаар, 2 дотуур байр ашиглалтад орсноор орны тоо 280-аар, соёлын төв, театрын 8 барилга баригдаж суудлын тоо 2.3 мянгаар, 10 эмнэлгийн барилга ашиглалтад орсноор эмчлүүлэгчдийн орны тоо 154-өөр тус тус нэмэгдсэн байна. Мөн инженерийн дэд бүтцийн 36, дэд станц болон цахилгаан хангамжийг сайжруулах 30 байгууламж ашиглалтад орж хатуу хучилттай авто зам 330.3 км-ээр, гүүрний хүчин чадал 282 метрээр нэмэгджээ.

Төлөвлөлт:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцох, үнэлж эрэмбэлэх салбар бүрийн шалгуур үзүүлэлт тодорхойгүй, тэдгээрийг хэмжих нэгдсэн өгөгдөл мэдээлэл дутмаг байгаа нь хөрөнгө оруулалтын нэн тэргүүний хэрэгцээ шаардлагыг бодитой, үндэслэлтэй тодорхойлох, хөгжлийн бодлого, зорилттой уялдуулан оновчтой төлөвлөхөд тулгарч буй гол бэрхшээл болж байна.
2. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг дунд хугацаагаар төлөвлөж хэрэгжүүлэхгүйгээс шалтгаалан шинээр эхлүүлэх барилга байгууламж, их засварын ажлын зураг төслийг өмнөх онд боловсруулах бэлтгэл ажил бүрэн хийгдэхгүй орхигдож байна. Энэ нь төсөвлөлтийн шаардлага хангаагүй, магадлалаар баталгаажсан зураг төсөвгүй барилга байгууламжийг төлөвлөх, төсөвт өртөг нэмэгдэх, хугацаандаа хэрэгжихгүй удаашрах суурь шалтгаан болж байна.
3. Тоног төхөөрөмжийн төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө хөрөнгийн бүртгэл, ашиглалтын хугацаа, норм хэмжээ, стандарт, жишиг үнэ зэрэгт тулгуурлаагүй, нэн тэргүүний хэрэгцээ шаардлагыг тодорхойлоогүй, хяналтгүй, ерөнхий, нийт үнийн дүнгээр төлөвлөж баталж байгаа нь тэргүүн эрэмбэд хамаарахгүй, өөр эх үүсвэрээс санхүүжүүлэх боломжтой хөрөнгө бэлтгэх, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах нөхцөлийг бий болгож байна.
4. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөвт өртгөөс тухайн жилд ногдох санхүүжилтийг жил бүр дутуу төлөвлөж байгаа нь хэрэгжилт удаашрах, өртөг нэмэгдэх эрсдэлийг дагуулахаас гадна дараагийн жилүүдийн төсвийн уян хатан байдлыг бууруулж, шинэ төсөл, арга хэмжээг эхлүүлэх хөрөнгө оруулалтын боломжийг хязгаарлах үр дагавар үүсгэж байна.
5. Техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах төсөл, арга хэмжээний саналыг хүргүүлэхдээ төсөл, арга хэмжээний нэр, байршил, зориулалт бүрээр төлөвлөөгүй, яам агентлаг, аймаг, нийслэлээс санал авч, эрэмбэлж сонгох төлөвлөлтийн үе шатны ажлыг төсөв батлагдсаны дараа хэрэгжүүлэн хугацаа алдсанаас шалтгаалж 50 хувьд нь гэрээ байгуулаагүй, төлөвлөсөн ажлын хэрэгжилт 15 хувьтай, үр дүн багатай байна.
6. Сангийн яамнаас Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системийг хөгжүүлснээр төлөвлөлтийн үйл ажиллагааг цахимжуулах чиглэлд тодорхой ахиц гарч, төлөвлөлтийн баримт бичгийн бүрдүүлбэр, төсөл, арга хэмжээний үнэлгээ, эрэмбэ, тайлбар мэдээллийг нэгдсэн байдлаар бүртгэх, хянах нөхцөл бүрджээ. Харин цахим системд бүртгэж буй мэдээллийн үнэн зөв, бодитой, үндэслэлтэй эсэхийг хянаж баталгаажуулах шаардлагатай байна.

Худалдан авах ажиллагаа:

7. Төсвийн ерөнхийлөн захирагч нар ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг боловсруулж худалдан авах ажиллагааны нэгжид хугацаанд нь хүргүүлээгүйгээс тендер шалгаруулалтын 52 хувийг 4 дүгээр сараас хойш зарласан бөгөөд түүнээс 39 хувьд гэрээ байгуулаагүй, 525.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцжээ.
8. Төсөвт өртөг ойролцоо нэг төрлийн тендер шалгаруулалтад оролцогчдод тавигдах шаардлага харилцан адилгүй, зарим төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтын

баримт бичигт заасан шаардлагад нийцээгүй оролцогчийг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулсан байна.

9. Сангийн яамны хүлээн авч хянан шийдвэрлэсэн гомдлын 75 хувь нь үндэслэлтэй байхад гомдлын мэдээлэлд дүн шинжилгээ хийгээгүй, алдаа зөрчлийн шалтгаан нөхцөлийг судалж тодорхойлох, бууруулахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй, гомдлын шийдвэрлэлтэд тавих хяналт, хариуцлага сул байна.
10. Худалдан авах ажиллагааны цахим системд тендер шалгаруулалт зарлах, үнэлэх, үр дүнг нийтлэх, мэдэгдэх зарим үйл ажиллагааг цаасаар болон цахим системээр зохион байгуулж давхардал үүсгэж байгаа үе шат дамжлага, процессыг хялбаршуулах, хүний оролцоог бууруулах, цахим хэлбэрт бүрэн шилжих үйл явц хангалтгүй байна.

Хэрэгжилт, үр дүн:

11. Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын тухайн жилийн санхүүжилтийн гүйцэтгэл 72.9 хувь, тухайн онд хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээний хэрэгжилт 75.1 хувьтай байгаа бөгөөд барилга байгууламжийн 2 ажил тутмын нэг нь, ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах 5 ажил тутмын 4 нь тухайн онд хэрэгжиж дуусаагүй дараагийн онд шилжжээ.
12. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжүүлсэн 611 төсөл, арга хэмжээний 80 хувь буюу 6,981.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 415 төсөл нь боловсрол, зам тээвэр, хот байгуулалт, эрүүл мэнд, эрчим хүч зэрэг тэргүүлэх 5 чиглэлд төвлөрсөн нь суурь дэд бүтэц, нийгмийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх бодлогын зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн байна.
13. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөвт өртгийн 80 хувийг эзэлж буй голлох 5 салбарын Төсвийн ерөнхийлөн захирагчдын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх зорилт арга хэмжээг төлөвлөсөн шалгуур үзүүлэлтээр авч үзэхэд дунджаар 77.1 хувьтай байгаа ч Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд хөрөнгө оруулалтын үр дүнг баригдсан барилга байгууламжийн тоо, зам гүүр, инженерийн шугам сүлжээний урт, барилгын ажлын явцын хувиар тодорхойлж байгаа нь оновчгүй байна.
14. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг сургуулийн ээлжийн коэффициент, нэг анги, багшид ногдох суралцагчийн тоо, эрүүл мэндийн тусламжийн чанар, авто замын хөдөлгөөний эрчим, ачаа тээврийн эргэлтийн хурд, дэд бүтцийн хүртээмж зэрэг үзүүлэлтээр хэмжиж оновчтой төлөвлөх, үр дүнг харьцуулан тайлагнадаг тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай байна.
15. Барилга байгууламжийн төсөл, арга хэмжээнд тавьж буй захиалагчийн хяналт харилцан адилгүй, зарим төсөл, арга хэмжээг зураг төслийн дагуу гүйцэтгээгүй, комиссын үүрэг даалгаврыг хэрэгжүүлээгүй байхад ашиглалтад хүлээн авсан, хийгдээгүй ажлын гүйцэтгэлийг хянаж баталгаажуулсан зөрчлүүд давтагдаж байгаа бөгөөд захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч байгууллагын хариуцлага, үе шатны хяналтын үр нөлөөг сайжруулах шаардлагатай байна.
16. Барилгад ашигласан материалаас ялгарах хорт бодисын агууламж хүлцэх хэмжээнд байгаа эсэхийг хянах, бүртгэх, баталгаажуулах тогтолцоо бүрдээгүй, 2025 онд ашиглалтад хүлээн авсан 13 сургууль, цэцэрлэгийг түүвэрлэн дотоод орчны агаарт шинжилгээ хийхэд 8 барилгад формальдегид болон бензолын агууламж хүлцэх хэмжээнээс өндөр байгаа нь суралцагчдын эрүүл мэндэд хортой нөлөө үзүүлэх эрсдэлтэй байна.
17. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, ашиглалтад хүлээн авах, хөрөнгөд бүртгэх үе шат бүрд захиалагч, хяналт хэрэгжүүлэгч, хүлээн авах комисс зэрэг холбогдох байгууллага, албан тушаалтнуудын хяналт, хариуцлага сул байгаагаас шалтгаалан зураг төсөл, техникийн тодорхойлолт, ажлын даалгаврын дагуу хэрэгжихгүй байх, хугацаа хоцрох, дутуу хийгдэх, шаардлагад нийцээгүй төсөл, арга хэмжээг хүлээн авах, санхүүжүүлэх, бүртгэхгүй орхих зэрэг алдаа, зөрчлүүд буурахгүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлт, нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛД ТОЛИЛУУЛАХ НЬ:

1. Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж батлах зөрчил давтагдан гарч байгаад анхаарал хандуулж, төсвийн төслийг хэлэлцэх, батлах явцад зарчмын зөрүүтэй санал гарч хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг нэмж тусгах, хэлэлцүүлэх тохиолдолд төсөвлөлтийн шаардлага хангасан эсэхийг хэн хэрхэн хянах талаарх зохицуулалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд тусгах шаардлага тулгарч байгааг толилуулж байна;
2. Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, хянах, ашиглалтад хүлээн авах, хөрөнгөд бүртгэх үе шат бүрд захиалагч, хяналт хэрэгжүүлэгч, хүлээн авах комисс зэрэг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад хүлээлгэх хариуцлага тодорхойгүй, хэрэгжүүлэх дотоодын хяналт сул байгааг хууль тогтоомжид нарийвчлан зохицуулах шаардлагатай байгааг толилуулж байна.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД-д:

1. Барилгын материалыг импортлох, нийлүүлэх, ашиглах үе шат бүрд хийх чанарын хяналтын давтамж, чиг үүргийг тодорхойлох, чанарын шаардлага хангахгүй материалыг импортоор оруулж ирсэн, зах зээлд нийлүүлсэн, барилгад ашигласан зөрчилд авах арга хэмжээний зохицуулалтыг бий болгох, барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авах үед дотор агаарын чанарт шинжилгээ хийх зохицуулалтыг заавар, журамд тусгах.

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД-д:

1. Захиалагч хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, зураг төсвийг Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэх хугацааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд тусгах.

САНГИЙН САЙД-д:

1. Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системд дэд цэс үүсгэн төлөвлөлтийн болон гэрээний хэрэгжилтийн үе шатанд тоног төхөөрөмжийг нэр төрөл, голлох техникийн үзүүлэлтүүд, тоо ширхэг, нэгжийн үнэ, нийт үнийн дүнг төлөвлөх, хөрөнгийн ашиглалтын хугацаа, батлагдсан норм хэмжээ зэрэгт тулгуурлан хэрэгцээ шаардлагыг үнэлж эрэмбэлэх, үнийн судалгаа мэдээлэл, холбогдох тооцооллыг хавсаргах, хянах боломжтой байдлаар хөгжүүлэлт хийх;
2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журамд тендер шалгаруулалтад гарсан гомдлыг шийдвэрлэсэн шийдвэрийн биелэлтийг захиалагч улирал тутамд тайлагнах зохицуулалтыг тусгах;
3. Тендер шалгаруулалтад гаргасан гомдлын мэдээлэлд судалгаа, дүн шинжилгээ хийж илэрч буй алдаа зөрчлийн шалтгаан нөхцөлийг тодорхойлж, бууруулахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД-д:

1. Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах төсөл арга хэмжээг төсвийн төсөлд хүргүүлэхдээ Төсвийн ерөнхийлөн захирагч нараас саналыг авч нэгтгэн, төсөл, арга хэмжээний нэр, байршил, зориулалт бүрээр төлөвлөн боловсруулж, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан цагалбарт хугацаанд багтаан Сангийн яаманд хүргүүлэх;
2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлтийг барих барилга байгууламжийн тоо, зам гүүр, инженерийн шугам сүлжээний ажлын урт, хөрөнгө оруулалтын ажлын явц, гүйцэтгэлийн хувиар бус салбарын онцлогт тохирсон, бодлогын зорилт, үр дүнд чиглэсэн оновчтой шалгуур үзүүлэлтээр тодорхойлж Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлтэд тусгах.

**ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН САЙД, ЗАМ ТЭЭВРИЙН САЙД
НАР-Т:**

1. Барилга байгууламжийн төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч байгууллага, нэгжүүдийн болон ашиглалтад хүлээн авах комиссын үйл ажиллагаанд салбарын хэмжээнд дотоод хяналт, шинжилгээ хийх, тодорхой давтамжтайгаар тогтмол хяналт хэрэгжүүлэх зохицуулалтыг холбогдох заавар, журамд тусгах;
2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын барилга, зам гүүрийн ажлыг хэрэгжүүлэхдээ зураг төслийн дагуу гүйцэтгээгүй, хийгдээгүй ажлын гүйцэтгэлийг баталгаажуулсан, комиссын үүрэг даалгаврыг зохих журмын дагуу хэрэгжүүлээгүй, зураг төсөвт тусгагдсан ажлыг бүрэн гүйцэтгээгүй байхад ашиглалтад хүлээн авсан зэрэг аудитаар илэрсэн зөрчлүүдэд дүн шинжилгээ хийж, холбогдох байгууллага, албан тушаалтанд хариуцлага тооцох.

ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР-Т:

1. Төсвийн ерөнхийлөн захирагч нараас ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, зураг төсвийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр хүлээн авах, бүртгэх нөхцөлийг бүрдүүлэх;
2. Тендер шалгаруулалтын бэлтгэл ажлыг хангах, тендерийн баримт бичгийг боловсруулах, оролцогчдод тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтийг сонгох, оролцогчийн тендерт ирүүлэх маягтуудыг бөглөх, үнэлгээний хорооны гишүүн бүр тендерийг үнэлэх, үр дүнг нэгтгэх, шалгарсан оролцогчид урилга хүргүүлэх зэрэг үе шатыг цахимжуулж, дэвшилтэд технологи ашиглан хүний оролцоог багасгах ажлыг зохион байгуулах.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛ



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: <http://www.mof.gov.mn>

2026.06.05 № 03/6838

танай _____-ны № _____-т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Д.ЭНХБОЛД ТАНАА

“Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д аудит хийж, тайлангийн төсөлд санал авах тухай Таны 07/1378 тоот албан бичигтэй танилцаа.

Тайлангийн төсөлд холбогдох саналыг хавсралтаар хүргүүлж байна.

Хүндэтгэсэн,

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.АНАР

9765001828



"Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд" аудитын тайлангийн төсөлд хүргүүлэх санал

№	Тайлангийн төслийн дугаар	Санал	Тайлбар
1	1.12. Эдгээр нь тухайн жилийн УТХО хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгасан зорилт, арга хэмжээг санхүүжүүлэхэд бүрэн чиглээгүй, төлөвлөлтөд суурилсан төсөвлөлтийн зарчим алдагдах эрсдэлийг дагуулж байна.	Өөрчлөн найруулах	1. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг Засгийн газраас анх өргөн мэдүүлэхэд буюу 2024 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлагдаагүй байсан тул Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн бодлого болон "Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн зорилго, зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх, 2025 онд төсвийн хөрөнгө оруулалтыг бүсүүдийн авто зам, эрчим хүч, дэд бүтцийг бүрдүүлэх зорилгоор хөгжлийн бүтээн байгуулалтуудыг санхүүжүүлэхэд хөрөнгө оруулалтыг чиглүүлж төлөвлөсөн бөгөөд тайлангийн төсөлд дурдсан улсын төсвийн хөрөнгө оруулалт нь улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдаагүй, зарим зорилт, арга хэмжээ, үр дүнд хангагдаагүй гэж дүгнэх нь зөрүүтэй ойлголт үүсгэхээр байгааг анхаарах;

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГӨХ ХАРИУ ТАЙЛБАР

Сангийн яамнаас ирүүлсэн саналд дараах тайлбарыг өгч байна. Үүнд:

Монгол Улсын 2025 оны төсвийн төслийг 2024 оны 9 дүгээр сард УИХ-д өргөн мэдүүлэх үед Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлагдаагүй ч төсвийн төслийг хэлэлцэх, дахин өргөн мэдүүлэх үед батлагдсан талаар аудитын тайланд тусгагдсан.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь тухайн жилийн улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх шаардлагатай тул аудитын тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзэв.



ХАВСРАЛТ ТАЙЛАН

2. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2025 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АГУУЛГА

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	152
ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ	154
БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗАРИМ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ХОЛБОГДОХ ХУУЛЬД НИЙЦҮҮЛЭН ТӨЛӨВЛӨӨГҮЙ БАЙНА.	155
БҮЛЭГ 2. ЗАРИМ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНД ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ МӨРДӨӨГҮЙ, ШААРДЛАГА ХАНГААГҮЙ ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛСАН ЗӨРЧИЛ ДАВТАГДСАН БАЙНА.....	158
БҮЛЭГ 3. ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛД ТАВИХ ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙГЭЭС ТӨЛӨВЛӨСӨН ХУГАЦААНДАА ЧАНАРТАЙ, ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖИХГҮЙ БАЙХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЖ БАЙНА.	161
БҮЛЭГ 4. ЗАРИМ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ САНХҮҮЖИЛТИЙГ ХУУЛЬ, ЖУРАМД НИЙЦҮҮЛЭН ОЛГООГҮЙ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮР ДҮНД БИЙ БОЛСОН ХӨРӨНГИЙН 18.2 ХУВИЙГ ДАНС БҮРТГЭЛД ТУСГААГҮЙ БАЙНА.	165

Товчилсон үгийн тайлбар

ААН	Аж ахуй нэгж
ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АНТАГ	Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газар
БГД	Баянгол дүүрэг
БЗД	Баянзүрх дүүрэг
БХД	Багахангай дүүрэг
ЕБ	Ерөнхий боловсрол
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗГ	Засгийн Газар
ЗД	Засаг Дарга
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
КВТ	Киловатт
МУИС	Монгол Улсын их сургууль
НА	Нийцлийн аудит
НББ	Нягтлан бодох бүртгэл
НДХ	Нийгмийн даатгалын хэлтэс
НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
ШТА	Шууд тайлагнах аудит
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНТХО	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
СБД	Сүхбаатар дүүрэг
СС	Сангийн сайд
СЯ	Сангийн яам
СХД	Сонгинохайрхан дүүрэг
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТББ	Тендерийн баримт бичиг
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТХТХ	Төрийн хэмнэлтийн тухай хууль
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
УБ	Улаанбаатар
УС-ДУ	Ус дулаан
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХААА	Худалдан авах ажиллагааны алба
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЦДАШ	Цахилгаан дамжуулах агаарын шугам

ЧД
ЭМТЧингэлтэй дүүрэг
Эрүүл мэндийн төв**Хүснэгтийн жагсаалт**

Дугаар

Гарчиг

Хүснэгт 1

Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалт

Хүснэгт 2

Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын ТАХ-ний
хэрэгжилт

Хүснэгт 3

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн ТАХ

Хүснэгт 4

НББ тайланд тусгасан ТАХ

Дүрслэлийн жагсаалт

Дугаар

Гарчиг

Дүрслэл 1

Шинээр хэрэгжүүлэх ТАХ-ний ангилал

Дүрслэл 2

Төсөвлөлтийн шаардлага хангаагүй батлагдсан ТАХ

Дүрслэл 3

ТАХ-ний ангилал

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2025 оны “Төрийн аудитын байгууллагын 2026 онд гүйцэтгэх аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/179, “Тушаалын хавсралтад нэмэлт оруулах тухай” А/33 дугаар тушаалд тус тус үндэслэн Төрийн аудитын байгууллагын хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд аудитыг хийж гүйцэтгэв.

Аудитын зорилго, зорилт

Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газраас хийсэн нийцлийн аудитын тайланг нэгтгэн боловсруулж Үндэсний аудитын газарт танилцуулахад аудитын зорилго чиглэгдсэн. Уг зорилгын хүрээнд дараах дэд асуудлуудад аудитыг чиглүүлэн нэгтгэсэн. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг холбогдох хуульд нийцүүлэн төлөвлөсөн эсэх;
- Хөрөнгө оруулалтаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан эсэх;
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь чанартай гүйцэтгүүлсэн эсэх;
- Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний санхүүжилтийг шийдвэрлэж, хөрөнгө бүртгэлд тусгасан эсэх.

Аудитын хамарсан хүрээ

Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын аудитын тайланг хамруулсан.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, дүн шинжилгээ хийх, харьцуулах, тулган баталгаажуулах, түүвэрлэн хянах зэрэг судалгааны арга зүйг ашигласан байна.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт

Аудитад дараах шалгуур үзүүлэлтийг ашиглав. Үүнд:

- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Барилгын тухай хууль;
- Авто замын тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор баталсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах дүрэм”;
- Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах тайлагнах журам”;
- Засгийн газрын 2024 оны 91 дүгээр тогтоолоор баталсан “Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх журам”;
- Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам болон холбогдох аргачлалууд”;

- Сангийн сайдын 2023 оны 250 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”;
- Барилга байгууламж үнэ бүрдэл, төсөв зохион норм ба дүрэм, стандарт;
- Аймаг, Нийслэл, Сум, Дүүргийн ИТХ-ын 2024, 2025 оны төсөв баталсан тогтоолууд;
- Аймаг, Нийслэл, сум, дүүргийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл;
- Батлагдсан төсөвт зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, ажил гүйцэтгэх гэрээ болон бусад холбогдох эрх зүйн баримтууд.

Аудитыг аймаг, Нийслэл дэх Төрийн аудитын газрууд өөрийн баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, тайланг Нийслэл дэх Төрийн аудитын газар нэгтгэлээ.

Аудитад учирсан хүндрэл, бэрхшээл

ТАХ-ний хэрэгжилтийн бодит байдалд аудит хийхэд аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газруудын хүний нөөц хүрэлцэхгүйн улмаас эрсдэлд суурилан түүвэрлэн хянасан байна.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих 6,532.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 2570 ТАХ, шилжин хэрэгжих 11,793.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1634 ТАХ, нийт 18,326.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 4204 ТАХ-г хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

Хүснэгт 1. Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө

(тэрбум.төгрөг)

№	Аймаг, хот	Шинэ ТАХ		Шилжих ТАХ		Нийт ТАХ	
		ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Тоо	Төсөвт өртөг	Тоо	Төсөвт өртөг
1	Архангай	49	6.9	2	1.2	51	8.1
2	Баян-Өлгий	86	9.1	11	2.5	97	11.6
3	Баянхонгор	24	2.9	24	5.5	48	8.4
4	Булган	30	7.1	10	1.2	40	8.3
5	Говь-Алтай	5	0.5	5	0.5	10	1.0
6	Говь-сүмбэр	25	5.7	8	0.5	33	6.2
7	Дархан	50	12.5	142	33.2	192	45.7
8	Дорноговь	111	34.4	61	69.1	172	103.5
9	Дорнод	27	1.2	9	6	36	7.2
10	Дундговь	54	23.9	13	5.6	67	29.5
11	Завхан	64	7.4	10	1.8	74	9.2
12	Орхон	195	97.0	103	76.9	298	173.9
13	Өвөрхангай	19	4.3	10	2.2	29	6.5
14	Өмнөговь	379	311.7	176	361.8	555	673.5
15	Сүхбаатар	29	11.1	21	16.9	50	28.0
16	Сэлэнгэ	133	14.5	62	9.7	195	24.2
17	Төв	62	11.5	0	0	62	11.5
18	Увс	19	5.3	2	0.8	21	6.1
19	Ховд	128	15.4	54	14	182	29.4
20	Хөвсгөл	116	31.9	12	3.7	128	35.6
21	Хэнтий	62	8.3	14	4.2	76	12.5
22	Нийслэл	903	5,910.2	885	11,176.4	1,788	17,086.6
Нийт		2570	6,532.7	1634	11,793.7	4204	18,326.4

Эх сурвалж: АНТАГ-ын аудитын тайлан, судалгаа

Тайлант онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих ТАХ 2750 болж, өмнөх оноос 28.1 хувь, санхүүжилт 6,532.7 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 18.6 хувиар буурсан байна.

Тайлант онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ-ний 72.5 хувь нь бүрэн хэрэгжиж, 18.9 хувь нь хэрэгжих шатанд, 8.6 хувь нь хэрэгжээгүй байна.

Дүрслэл 1. Шинээр хэрэгжүүлэх ТАХ-ний ангилал



Шинээр хэрэгжүүлэх ТАХ-ний 32.3 хувийг их засвар, 29.9 хувийг тоног төхөөрөмж, 18.2 хувийг ТЭЗҮ, зураг төсөл, зөвлөх үйлчилгээ, 14.2 хувийг барилга байгууламж, 5.4 хувийг авто зам болон бусад ангилалд хамаарах ТАХ эзэлж байна.

БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗАРИМ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ХОЛБОГДОХ ХУУЛЬД НИЙЦҮҮЛЭН ТӨЛӨВЛӨӨГҮЙ БАЙНА.

1.1. Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх зарим ТАХ-г Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан зарчимд нийцээгүй байна. Тухайлбал:

- *Өмнөговь аймгийн ИТХ-ын 2024 оны “Орон нутгийн төсөв батлах тухай” 03/14 дүгээр тогтоолоор шинээр хэрэгжих зарим ТАХ-г төлөвлөж батлуулахдаа төсөвт өртөггүй тусгаж батлуулсан нь төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх, санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх, ил тод, хариуцлагатай байх зарчим;*
- *Нийслэл, БНД, БХД, ЧД, СХД, ХУД-үүд, 2025 оны хөрөнгө оруулалтын төсвийг батлахдаа төсвийн тодотголоор шинэ хэрэгжих, он дамжин хэрэгжиж буй ТАХ-г төсөвт тусгаагүй, төсөвт өртгийг давхардуулан тусгасан, орон нутгийн хөгжлийн сангийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-г баталсан нь Төсвийн тухай хуульд заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх, ил тод, хариуцлагатай байх зарчмуудыг баримтлаагүй байна./Хавсралт 1/*

1.2. Шинээр хэрэгжих ТАХ-г “Аймаг, нийслэл, сум, дүүргийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр”, “Хөгжлийн жилийн төлөвлөгөө” зэрэг бодлогын баримт бичгүүдтэй 17.3 хувийг нийцүүлэн төлөвлөөгүй байна. Тухайлбал:

- *УБ, БЗД, 11.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 15 ТАХ;*
- *Завхан аймаг, 8.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 21 ТАХ;*
- *УБ, ХУД, 7.5 тэрбум төгрөгийн 16 ТАХ;*
- *УБ, ЧД, 5.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 17 ТАХ;*
- *Ховд аймаг, 4.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 17 ТАХ;*
- *Нийслэл, 2.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 154 ТАХ;*
- *Булган аймаг, 1.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 13 ТАХ;*
- *Архангай аймаг, 0.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 13 ТАХ. /Хавсралт 2/*

1.3. Шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн ангилалд хамаарах 145 ТАХ-ний 23.5 хувьд нь үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлт, тооцооллыг хийгээгүй нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2⁸⁸, ЗГ-ын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах тайлагнах журам”-ын 2.2.4⁸⁹-д заасантай тус тус нийцээгүй байна. /Хавсралт 3/

1.4. Нийслэлд шинээр хэрэгжүүлэхээр багцлан баталсан 28 ТАХ-ний ажлын тоо хэмжээ, төсвийн тооцоолол тодорхойгүй байна.

- *Ухаалаг УБ “Смарт сити” төсөл, 20.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 5 ТАХ;*
- *Алсын зайн дамжуулагчтай угаарын болон хийн түлшний мэдрэгч (УБ), 15.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 2 ТАХ;*
- *Шинэ Зуун модын бүтээн байгуулалтын ажлын зураг төсөв, 9.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 4 ТАХ;*
- *Эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн барилгын хөрөнгө оруулалт, их засварын ажил (УБ), 8.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 9 ТАХ. /Хавсралт 4/*

1.5. Шинээр хэрэгжих 1.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 58 ТАХ-г төлөвлөж, батлахдаа иргэд, олон нийтийн саналыг төсвийн цаглаварт хугацаанд аваагүй, тусгаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.2⁹⁰, 67 дугаар зүйлийн 67.3⁹¹-т заасантай тус тус нийцээгүй байна. /Хавсралт 5/

⁸⁸ 29.2.Хөрөнгө оруулалтын төслийн саналд үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог хавсаргаж, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлтийг гаргасан байна.

⁸⁹ 2.2.4.Төсөл, арга хэмжээний саналд үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог хавсаргаж, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлтийг гаргасан байх;

⁹⁰ 6.5.2.төсвийг төлөвлөх, бүрдүүлэх, хуваарилах, тайлагнах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах;

⁹¹ 67.3.Энэ хуулийн 67.1-д заасан төсвийн төслийг боловсруулах явцдаа төслийг тухайн шатны Засаг дарга болон хот, тосгоны Захирагч олон нийтэд танилцуулж, тухайн засаг захиргааны нэгжид амьдарч байгаа иргэдийн санал, хүсэлтийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Зөвлөлд танилцуулна.

1.6. Хөрөнгө оруулалтын бус шинж чанартай, өмчид бүртгэх боломжгүй 133.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 220 ТАХ-г хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24⁹²-т заасантай нийцээгүй байна. Тухайлбал:

- УБ, нийтийн зориулалттай орон сууцны цахилгаан шат шинэчлэх, дээвэр фасад засвар, угсармал орон сууцны дулаан алдагдлыг бууруулах зэрэг 62.3 тэрбум сая төгрөгийн төсөвт өртөгтэй 38 ТАХ;
- УБ, СБД, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ, нийтийн зориулалттай орон сууцны гадна фасад, дээвэр засвар, цахилгаан шатны шинэчлэлт зэрэг 11.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 19 ТАХ;
- УБ, ЧД, Орчны аюулгүй байдал, дэд бүтцийн судалгаа, нийтийн орон сууцнуудын гадна фасад, дээвэр засвар зэрэг 1.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 19 ТАХ;
- Дорноговь аймаг, фасад, дээвэр засварын 0.5 тэрбум төгрөгийн 3 ТАХ;
- Төв аймаг, нэгдсэн эмнэлгийн дээвэр засварын 0.3 тэрбум төгрөгийн 2 ТАХ. /Хавсралт 6/

1.7. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар аймгуудад төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, баяр наадмын бэлтгэл ажил, худаг гаргах, орон гэргүй иргэдэд гэр болон улсын төсвийн байгууллагуудад тоног төхөөрөмж, бараа материал худалдан авах, үйлчилгээ үзүүлэх, судалгаа хийх зэрэг ТАХ-г хэрэгжүүлэхээр төлөвлөж, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна. Үүнд:

- Хөвсгөл аймаг, 16.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 12 ТАХ.
- Орхон аймаг, 12.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 29 ТАХ;
- Ховд аймаг, 4.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 17 ТАХ;
- Дундговь аймаг, 2.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 10 ТАХ;
- Өвөрхангай аймаг, 1.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 9 ТАХ;
- Увс аймаг, 0.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 5 ТАХ;
- Дорноговь аймаг, 0.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 8 ТАХ;
- Сэлэнгэ аймаг, 0.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 12 ТАХ;
- Завхан аймаг, 0.05 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1 ТАХ.

1.8. Шинээр хэрэгжүүлэх 720.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 50 ТАХ-г ерөнхий нэршлээр баталж, хэрэгжүүлэх явцад тухайн шатны ЗД-ын захирамжаар 347 багцад задалж төсөвт өртөг, хэрэгжүүлэх байршлыг тодорхойлсон нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.4⁹³-д “санхүүжүүлэх эх үүсвэрээс үл хамааран төсөл арга хэмжээг нэг бүрийг бүрэн хэмжээгээр тусгана” гэж заасантай нийцээгүй байна. Тухайлбал:

- УБ, БГД, Боловсролын байгууллагад шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах ТАХ-г 5 багцад;
- УБ, БЗД, УБ зам засвар, арчлалт ОНӨААТҮГ-ын асфальт бетоны үйлдвэрийн барилга, тоног төхөөрөмж нийлүүлэлтийн ажил, ТАХ-г 3 багцад;
- УБ, СБД, Сургууль, цэцэрлэгийн материаллаг бааз бэхжүүлэх, ТАХ-г 7 багцад;
- УБ, Нийтийн зориулалттай орон сууцны дээвэр, фасадын зураг төсөв, засварын ажил хийх ТАХ-г 27 багцад хуваажээ. /Хавсралт 7/


1.9. Шинээр хэрэгжүүлэх 5.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 428 ТАХ-г нэн тэргүүнд хэрэгжүүлэх, хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, эрэмбэлээгүй нь ЗГ-ын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан журмын 2.3.2.1-д заасантай нийцээгүй байна. /Хавсралт 8/

1.10. Шинээр хэрэгжүүлэх 890.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 596 ТАХ төсөвлөлтийн шаардлага хангаагүй, төсөв батлагдсаны дараа холбогдох шийдвэрүүд нь гарсан нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т заасантай нийцээгүй байна. Тухайлбал:

⁹² 4.1.24. "хөрөнгө оруулалт" гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг;

⁹³ 29.3.4. санхүүжүүлэх эх үүсвэрээс үл хамааран төсөл нэг бүрийг бүрэн хэмжээгээр тусгах;

Дүрслэл 2. Төсөвлөлтийн шаардлага хангаагүй батлагдсан ТАХ

**Ажлын даалгаваргүй:**

- Дундговь аймаг, Төрийн үйлчилгээний авто бааз байгуулах, Дундговь аймаг-Бүгд найрамдах Киргиз улсын Баткөн хот хоорондын санамж бичгийн хүрээнд хэрэгжүүлэх Ногоон байгууламж нэмэгдүүлэх;
- УБ, БЗД дүүрэг, Тохижилтын ажил, дүүргийн 27 дугаар хорооны ӨЭМТ-ийн засварын ажил;
- УБ, БГД, суралцагчдын дотуур байр, Төрийн архив, Улсын бүртгэлийн барилга, Оюуны эрин сургуулийн өргөтгөл, гадна тохижилт зэрэг ажлын зураг төсөв боловсруулах;
- УБ, ХУД, Авто зам, авто замын засвар шинэчлэлт, Барилга, байгууламж, дэд бүтэц, Тохижилт, бүтээн байгуулалт зэрэг ажлын зураг төсөв боловсруулах;
- УБ, ЧД, Тусгаар тогтнолын талбайн тохижилт, Хүүхдийн зуслан, Хайлааст Чингэлтэйг холбосон авто замаас 37 дугаар сургууль хүртэлх авто зам зэрэг ажлын зураг төсөв боловсруулах.

Зураг төсөвгүй:

- Завхан аймаг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын засвар, Нөмрөг сумын спорт заал, Тосонцэнгэл сумын хүүхэд хамгааллын төвийн засвар;
- Өмнөговь аймаг, Цогтцэций суманд 320 хүүхдийн хүчин чадал бүхий сургуулийн барилга, Сэврэй сумын Цагдаагийн хэсгийн барилга, 1200 хүүхдийн сургуулийн барилга;
- Орхон аймаг, Спорт заалны барилга, Хот тохижуулах газарт нийтийн тээврийн авто гарааш барих;
- Өвөрхангай аймаг, Арвайхээр сумын хүүхэд залуучуудын парк, Хужирт сумын ерөнхий боловсролын 1, 2 дугаар сургуулийн дотуур байрны засвар;
- Нийслэл, "Үндэсний цэцэрлэгт хүрээлэн"-ийн бүтээн байгуулалтын ажил, Гандантээглэн хийдийн гадна зам, талбайн борооны ус зайлуулах шугамын ажил, Бэлхийн амны Хүннүгийн язгууртны цогцолборын тохижилтын ажил.

Магадлалын дүгнэлтгүй:

- Өмнөговь аймаг, Даланзадгад сумын Нисэх хорооллын үерийн сувгийн автомашины гүүрэн гарц байгуулах, 2-р баг Хан-Уул гэр хорооллын чулуун зам барих, Аймгийн нутгийн удирдлагын ордны өргөтгөлийн барилгыг барьж, ашиглалтад оруулах;
- Сэлэнгэ аймаг, Хүнсний агуулахын барилга барих;
- Нийслэл, СХД Гал түймэр унтраах аврах анги, Жаргалант тосгоны эрүүл мэндийн төвийн барилга угсралтын ажил, Нийтийн эзэмшлийн явган хүний замыг шинээр болон шинэчлэн засвар;
- УБ, БГД Нийтийн зориулалттай орон сууцны гадна фасад засвар;
- УБ, БЗД-ийн Онцгой байдлын хэлтсийн гал түймэр унтраах, аврах 35 дугаар ангийн их засварын ажил, 27 дугаар, 6 дугаар хорооны ӨЭМТ-ийн их засвар;
- УБ, ХУД, Зайсангийн эцсийн автобусны буудлын тохижилтын ажил, 7 дугаар хэсгийн авто замын ажил.

Техникийн тодорхойлолтгүй:

- Төв аймаг, Аймгийн төвийн орон сууцны шугам сүлжээнд ус цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулах;
- Хөвсгөл аймаг, "Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих" тоног төхөөрөмж, Дулааны станцад зөөврийн дизель генератор, Цагдаагийн эргүүлийн автомашин худалдан авах;
- Хэнтий аймаг, газар ухагч машин, иргэний бүртгэлд 4G сүлжээний төхөөрөмж, компьютер авах, Цэнхэрмандал суманд орон нутаг сурталчлах танхим байгуулах;
- Нийслэл, Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн тусгай хэрэгсэл, тоног төхөөрөмж, Дата төвийн үндсэн болон цахилгааны тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх ажил, дунд оврын автобус худалдан авах;
- УБ, ХУД-ийн Онцгой байдлын хэлтэст шаардлагатай гал унтраах, эрэн хайх тоног төхөөрөмж, 130 дугаар сургуулийн тоног төхөөрөмж худалдан авах;
- УБ, СБД, Төрийн албаны болон сургууль, цэцэрлэгийн материаллаг бааз бэхжүүлэх;
- УБ, БЗД, халуун сүү хөтөлбөрийн хүрээнд шаардлагатай тоног төхөөрөмж, цэвэр усны станцын 5 байрыг шинээр барихад шаардлагатай материал худалдан авах.
- Холбогдох зөвшөөрөлгүй /газрын зөвшөөрөлгүй/;
- Говь-сүмбэр аймгийн шинээр баригдах Найрамдал хотхоны гадна цахилгаан хангамжийн ажил;
- Нийслэл, СХД бейсболын талбай шинээр байгуулах;
- Нийслэл, Гал түймэр унтраах аврах анги барих ажил. /Хавсралт 9/

Шийдвэрлэлт: Аудитаар илэрсэн 4,225.7 тэрбум төгрөгийн зөрчилд 1,114.6 тэрбум төгрөгийн зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй 59 албан шаардлага, 3,111.1 тэрбум төгрөгийн 31 зөвлөмж хүргүүлсэн байна.

БҮЛЭГ 2. ЗАРИМ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНД ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ МӨРДӨӨГҮЙ, ШААРДЛАГА ХАНГААГҮЙ ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛСАН ЗӨРЧИЛ ДАВТАГДСАН БАЙНА.

2.1. Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар 12,878.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 2671 ТАХ-ний ХАА-ны эрхийг холбогдох газруудад шилжүүлсэн байна.

2.2. Тайлант онд 3,945.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 2315 ТАХ-ний ХАА-г амжилттай зохион байгуулж, 164.0 тэрбум төгрөгийг хэмнэж, 8,538.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 163 ТАХ-ний ХАА амжилтгүй болжээ.

2.3. Төсөвлөлтийн шаардлага хангаагүй, хугацаа алдаж эрх шилжүүлсэн, хөрөнгө татагдсан, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн үйлчлэлд хамаарсан зэрэг шалтгаанаар 225.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 193 ТАХ-ний ХАА-г зарлаагүй байна.

2.4. Нийслэлд ажлын даалгавраар тендер зарласантай холбоотойгоор 2025 онд шинээр хэрэгжүүлэх 1,301.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 34 ТАХ-ний зураг төсвийг гүйцэтгэлийн шатанд боловсруулж, зарим ТАХ-ний газрын зөвшөөрөл бүрэн шийдвэрлэгдээгүйгээс гэрээт ажлын хэрэгжилт удаашрах, төсөвт өртөг нэмэгдэх эрсдэл үүссэн байна. Тухайлбал:

Нийслэл:

- БГД 25-р хороо, 960 суудалтай сургуулийн барилга барих 18.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ;
- СХД гал түймэр унтраах аврах анги барих 6.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ;
- СХД 8 дугаар хорооны өрхийн эмнэлэг, цагдаагийн хэсгийн цогцолбор барилга барих 3.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ;
- СБД 7 дугаар хороо, ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн өргөтгөлийн барилга угсралтын ажил 1.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ;
- Өмчийн харилцааны газрын агуулахын барилга барих 0.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ.

2.5. Нийт ТАХ-ний 54.3 хувь нь нээлттэй тендер шалгаруулалт, 26.3 хувь нь харьцуулалт, 15.6 хувь нь шууд худалдан авалт, 3.8 хувь нь бусад аргаар зохион байгуулсан байна.

2.6. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 379.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 308 ТАХ-ний худалдан авах ажиллагааг 2025 оны 5 дугаар сарын 31-ний өдрөөс хойш зохион байгуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-д заасантай нийцэхгүй байна. /Хавсралт 10/

2.7. Нийслэлд 184 ТАХ-ний худалдан авах ажиллагаа зохион байгуулахаар төлөвлөсөн боловч гүйцэтгэлийн шатанд 160 ТАХ-ээр нэмэгдэж, төсөвт өртөг нь 11,739.6 тэрбум төгрөг буюу 43.7 дахин өссөн байна.

2.8. Дундговь аймгийн Дэрэн, Дэлгэрцогт сумд 0.07 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 10 ТАХ-г худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй байна.

2.9. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 82.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 110 ТАХ-ний ХАА-г зохион байгуулахдаа шаардлага хангаагүй гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 27 дугаар зүйлийн 27.3-д заасантай нийцэхгүй байна. Тухайлбал:

Нийслэл:

- Нийтийн зориулалттай орон сууцны дээвэр, фасадны зураг төсөө, засварын ажлын гүйцэтгэгчээр шалгарсан компани нь ижил төстэй ажил, хүний нөөц, техникийн чадавхийн шаардлага хангаагүй;
- Бейсболын талбай шинээр байгуулах ажлын гүйцэтгэгчээр шалгарсан компани нь санхүү, хүний нөөц, техникийн чадавхийн шаардлага хангаагүй.

Дүүрэг:

- ЧД, 1, 3, 4, 5, 6, 10 дугаар хороодод ухаалаг хогийн сав байрлуулах ажлын гүйцэтгэгчээр шалгарсан компани нь ижил төстэй ажил, хүний нөөцийн чадавхийн шаардлага хангаагүй;
- СХД, Хог тээврийн тусгай зориулалтын техник хэрэгсэл худалдан авах ажлын гүйцэтгэгчээр шалгарсан компани нь техникийн чадавхийн шаардлага хангаагүй;
- БХД, Хог төвлөрүүлэх цэгийн өргөж буулгадаг хогийн сав, хог буулгаж ачих крантай автомашин худалдаж авах ажлын гүйцэтгэгчээр шалгарсан компани нь ижил төстэй ажил, техникийн чадавхийн шаардлага хангаагүй;
- БЗД, УБ зам засвар, арчлалт ОНӨААТҮГ-ын асфальт бетоны үйлдвэрийн тоног төхөөрөмж нийлүүлэлтийн ажлын гүйцэтгэгчээр шалгарсан компани нь санхүүгийн чадавхийн шаардлага хангаагүй;

- ЧД, Дүүргийн 30 дугаар байрны фасад засварын ажлын гүйцэтгэгчээр шалгарсан компани нь ерөнхий шаардлага хангаагүй.

Ховд аймаг:

- Хөгжил политехник коллежийн барилгын сантехникийн засварын ажлын гүйцэтгэгчээр шалгарсан компани нь санхүүгийн болон ижил төстэй ажил шаардлага хангаагүй;
- Жаргалант станцаас Ховд сумыг холбох цахилгаан дамжуулах агаарын шугамын угсралтын ажлын гүйцэтгэгчээр шалгарсан компани нь ижил төстэй ажил, техникийн чадавхийн шаардлага хангаагүй;
- МУИС Оюутны II байрны их засварын ажлын гүйцэтгэгчээр шалгарсан компани нь санхүү, ижил төстэй ажил, хүний нөөц, техникийн чадавхийн шаардлагыг тус тус хангаагүй. /Хавсралт 11/

2.10. Тайлант онд тендер сонгон шалгаруулах үйл ажиллагаатай холбоотой нийт 2,674.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 138 ТАХ-нд гомдол гарч СЯ болон Монополын эсрэг газарт хянагдаж 35 ТАХ-ний тендертэй холбоотой гомдлыг үндэслэлтэй гэж үзсэн байна. **Хавсралт**

2.11. СЯ гомдлыг үндэслэлтэй гэж үзэн дахин үнэлгээ хийхийг даалгасан боловч дараах үнэлгээний хороод хэрэгжүүлээгүй байна. Үүнд:

Завхан: Аймгийн ИТХ болон Их-Уул сумын Соёлын төвд тоног төхөөрөмж худалдан авах ТАХ-ний үнэлгээний хороо.

Өмнөговь: Ханбогд сумын 1 дүгээр сургуулийн Б байрны камержуулалт, 2 дугаар сургуулийн дотор камержуулалт, Хөнгөн үйлдвэрийн бүсийг цэвэр, бохир, цахилгаан, дулаан, холбоо дохиоллын магистрал шугамд холбох ТАХ-ний үнэлгээний хороо.

2.12. ХАА зохион байгуулахтай холбоотой 17.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 60 ТАХ-ний ТББ-г хууль, журмын дагуу боловсруулж, батлуулаагүй байна. Тухайлбал:

Говьсүмбэр аймгийн ТЕЗ-аас зохион байгуулсан:

- УСДУ ОНӨААТҮГ-ын экскаватор худалдан авах ТАХ;
- Усан спорт сургалтын төвийн засварын ажил ТАХ;
- Өгөөж захын уулзвараас 2 дугаар сургуулийн уулзвар хүртэлх авто зам барих ТАХ;

Дорноговь аймгийн ТЕЗ-аас зохион байгуулсан: Жаргалант багийн 0.4 кВ-ын ЦДАШ, 250 кВА дэд өртөө барих ТАХ;

Завхан аймгийн ТЕЗ-аас зохион байгуулсан:

- Шилүүстэй, Их-Уул сумдын хогны автомашин худалдан авах ТАХ;
- Завханмандал сумын хүнсний ногоо тариалах тоног төхөөрөмж, трактор худалдан авах ТАХ;

Сүхбаатар аймгийн ТЕЗ-аас зохион байгуулсан:

- Баруун-Урт сумын Нэгдүгээр сургуулийн их засвар ТАХ;
- НДХ-ийн зүүн урд уулзвараас Асгат сумын чиглэлд гарах зам засварын ажил ТАХ;
- Боловсрол хорооллын хойд хэсгийн авто зогсоолын ажил ТАХ;

БЗД-ийн ХААА-аас зохион байгуулсан:

- 12.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 15 ТАХ;
- БЗД-ийн цагдаагийн хэлтэст шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэх ажил ТАХ;

СХД-ийн ХААА-аас зохион байгуулсан:

- Хот тохижилтын техник хэрэгсэл худалдаж авах ТАХ;
- Автобусны зогсоол 6 байршилд шинээр байгуулах ажил ТАХ;
- Захиалагчийн алба ОНӨААТҮГ-д техник хэрэгсэл худалдаж авах ТАХ;
- Усан сан барих ажил ТАХ;

БГД-ийн ХААА-аас зохион байгуулсан:

- Гэр хороолол дахь автомашины гүүр шинэчлэх ажил ТАХ;
- Тусгай зориулалтын техник тоног төхөөрөмж хэрэгсэл худалдан авах ТАХ;

ЧД-ийн ХААА-аас зохион байгуулсан: 1.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 9 ТАХ.

2.13. Зарим аймгийн ХАА-ны газар нь тендерийн нээлттэй болон харьцуулалтын аргыг хэрэглэхээс зайлсхийж 3.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 93 ТАХ-ний төсвийг багцад хувааж, ажлын тоо хэмжээг багасгаж, шууд худалдан авалт хийсэн нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 10 дугаар зүйлийн 10.3⁹⁴, 44 дүгээр зүйлийн 44.1⁹⁵-д заасантай тус тус нийцэхгүй байна. Тухайлбал:

Архангай: Хашаат сумын ЗДТГ-ын цэвэр бохир шугамын холболт хийх 2 ТАХ;

Баян-Өлгий: Өлгий сумын 17, 29, 30, 7 дугаар багийн цэцэрлэг, Цэнгэл сумын 5 дугаар цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль зэрэг 6 байгууллагад гал тогооны тоног төхөөрөмж нийлүүлэх ТАХ;

Дорноговь:

⁹⁴ 10.3.Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно.

⁹⁵ 44.1.Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална.

- Төрийн болон тусгай чиг үүргийн байгууллагуудын парк шинэчлэл 2 ТАХ;
- Замын-Үүд сумын 4, 6, Алтан харгана цэцэрлэгт сургалтын хэрэглэгдэхүүн худалдан авах ТАХ;
- ЕБ-ийн 2, 3 дугаар сургуулийн засвар, ундны ус цэвэршүүлэгч худалдан авах ажил ТАХ;

Завхан: Онцгой байдлын газар гамшгийн эрсдэлийг даван туулах ажлын хүрээнд иргэдэд гэр олгох ТАХ;

Орхон: Ус дулаан хуваарилах төвүүдийг үл хамаарах схемд шилжүүлэх иж бүрэн ялтсан бойлер суурилуулах, Өвлийн спортыг дэмжих, Жаргалант сумын саравч барих ТАХ;

Өмнөговь: Ханбогд сумын 2 дугаар сургуулийн багш ажилчдын 60 айлын орон сууцны зураг төсөв боловсруулах ТАХ.

2.14. ТБОНӨХБАҮХАТХ, тендер үнэлэх болон давуу эрх олгох аргачлал, үнэлгээний хорооны үйл ажиллагааны журмыг зөрчиж ТББ-т тусгагдаагүй шалгуураар үнэлгээ хийж, шаардлага хангаагүй гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан зөрчил илэрсэн байна. Үүнд:

Завхан:

- Эрдэнэхайрхан сумын усалгааны систем худалдан авах ТАХ;
- Шилүүстэй сумын соёлын төвийн лед дэлгэц худалдан авах ТАХ;
- Завханмандал сумын хүнсний ногооны тоног төхөөрөмж, трактор худалдан авах ТАХ.

Шийдвэрлэлт: Дээрх илэрсэн зөрчилд АНТАГ-аас 55 зөвлөмж, 147.4 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 78 албан шаардлага, сахилгын хариуцлага тооцуулах 1 албан шаардлага, 3.0 сая төгрөгийн 2 төлбөрийн акт, 16.3 тэрбум төгрөгийн 3 ТАХ-г хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн байна.

БҮЛЭГ 3. ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛД ТАВИХ ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙГЭЭС ТӨЛӨВЛӨСӨН ХУГАЦААНДАА ЧАНАРТАЙ, ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖИХГҮЙ БАЙХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЖ БАЙНА.

3.1. Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар 9,408.4 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 4650 ТАХ хэрэгжихээс 72.5 хувь буюу 3369 ТАХ бүрэн хэрэгжсэн, 18.9 хувь буюу 879 ТАХ хэрэгжих шатанд, 8.6 хувь буюу 402 ТАХ хэрэгжээгүй байна.

Хүснэгт 2. Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын ТАХ-ний хэрэгжилт

(тэрбум.төгрөг)

№	Аймаг, нийслэлийн нэр	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Гэрээний дүн	Хэрэгжиж дууссан ажил		Он дамжин хэрэгжиж байгаа		Хэрэгжээгүй	
					тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	Архангай	51	8.0	7.8	30	4.7	4	3.1	17	0.1
2	Баян-Өлгий	99	11.6	10.4	92	7.6	2	2.8	5	-
3	Баянхонгор	43	10.2	10.3	39	7.3	4	3.0	-	-
4	Булган	88	8.7	7.5	74	5.4	4	2.0	10	0.0
5	Говь-Алтай	12	3.0	2.9	9	1.2	2	1.7	1	-
6	Говь-Сүмбэр	33	6.3	5.9	22	5.1	6	0.7	5	0.2
7	Дархан-Уул	152	44.6	39.3	118	30.5	10	3.9	24	5.0
8	Дорноговь	172	103.5	96.2	136	80.2	23	16.0	13	-
9	Дорнод	22	7.3	7.2	17	4.9	5	2.3	-	-
10	Дундговь	67	33.6	30.5	56	17.0	8	13.5	3	-
11	Завхан	75	9.1	12.2	65	8.3	8	3.4	2	0.4
12	Орхон	724	222.7	195.9	609	111.1	48	84.6	67	0.1
13	Өвөрхангай	24	5.1	3.1	24	3.1	-	-	-	-
14	Өмнөговь	589	594.1	546.0	480	332.4	84	182.0	25	31.6
15	Сүхбаатар	51	28.0	24.9	47	22.5	3	2.4	1	-
16	Сэлэнгэ	195	24.2	20.7	148	13.7	14	6.8	33	0.2
17	Төв	60	10.2	14.1	45	9.5	15	4.6	-	-
18	Увс	21	6.0	6.0	20	5.4	1	0.6	-	-
19	Ховд	191	29.3	21.7	146	16.6	13	4.9	32	0.2
20	Хөвсгөл	163	34.9	30.5	107	10.0	18	20.5	38	0.0
21	Хэнтий	76	14.0	13.1	65	12.5	5	0.6	6	-
22	Нийслэл	1,742	9,015.0	8,302.2	1,020	1,774.2	602	6,382.5	120	145.5
НИЙТ		4650	10,229.6	9,408.4	3369	2,483.3	879	6,741.8	402	183.2

3.2. Зарим ТАХ-ний зураг төсөв боловсруулах болон гүйцэтгэгч сонгон шалгаруулалт удааширсан, технологийн зогсолт хийсэн, захиалагч гэрээг тухай бүр дүгнээгүй зэрэг шалтгаанаар он дамжин хэрэгжихээр байна.

3.3. Ажлын даалгавар, техникийн тодорхойлолтгүй, магадлалын дүгнэлтгүй, худалдан авах ажиллагаанд оролцогчгүй, төсвийн тодотголоор санхүүжилт хасагдсан зэрэг шалтгаанаар зарим ТАХ хэрэгжээгүй байна.

Дүрслэл 3 ТАХ-ний ангилал



3.4. ТАХ-г ангилбал, орчны тохижилт, ногоон байгууламжийн 1401 ТАХ буюу 30.1 хувь, техник, тоног төхөөрөмж, машин механизм авах 1219 ТАХ буюу 22.0 хувь, барилга байгууламжийн 748 ТАХ буюу 16.1 хувь, дэд бүтцийг сайжруулах, зам, гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээний 463 ТАХ буюу 10.0 хувь, ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах болон бусад 1013 ТАХ буюу 21.8 хувийг эзэлж байна.

Нийслэлийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй 813 ТАХ-ний 7,739.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий гүйцэтгэлд Нийслэлийн харьяа 19 байгууллага захиалагчийн хяналт хэрэгжүүлснээс Нийслэлийн Замын хөгжлийн газар, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын

газар болон СХД-ийн барилга Захиалагчийн алба ОНӨААТҮГ-уудад дараах зөрчил илэрсэн байна. Тухайлбал:

- Газар чөлөөлөлт бүрэн дуусаагүй, ажлын зураг төсөвт өөрчлөлт оруулсан, магадлалын дүгнэлтгүй ажил эхлүүлсэн, гүйцэтгэгч гэрээнд заасан хугацаанд ажлаа гүйцэтгээгүй, ажлаа орхигдуулсан, гэрээ дүгнэж алданги тооцоогүй, гүйцэтгэлд үндэслэн санхүүжилт олгоогүй.
- **Сэлбэ хорин минутын хот корпорац ХХК:**
- Газар чөлөөлөлт бүрэн дуусаагүй, иргэдтэй тохиролцоо хийгдээгүй байхад барилга угсралтын ажлыг эхлүүлсэн, зураг төсөв магадлалаар баталгаажаагүй байхад барилга угсралтын ажлын гэрээ байгуулж эхлүүлсэн, захиалагч үе шатны хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй, гэрээт ажлын хугацаа хэтэрсэн гүйцэтгэгчээс алданги тооцоогүй.
- **Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба:**
- Нөхөн олговортойгоор газар чөлөөлөлтийн явцад зохих зөвшөөрөлгүй баригдсан барилгын нөхөн олговорт 1.4 тэрбум төгрөг, газар чөлөөлөх явцад газар өмчлөх эрхийг баталгаажуулснаас 1.2 тэрбум төгрөгийг тус тус олгосон байна.

3.6. Нийслэлд төсөвлөлтийн шаардлага хангаагүй 1,491.0 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй 75 ТАХ-г эхлүүлснээс шалтгаалан гүйцэтгэлийн үе шатанд зураг, төсөв боловсруулах, газар чөлөөлөх ажил хийгдэж, ажлын явц удааширч, төсөвт өртөг нэмэгдэх эрсдэл үүссэн байна. Тухайлбал:

- Эмээлт эко аж үйлдвэрийн паркийн дулааны цахилгаан станц, бохир ус цэвэрлэх байгууламж, гэрээний дүн 224.6 тэрбум төгрөг, ажлын явц 20.0 хувь;
- БЗД-ийн 2, 4 дүгээр хорооны инженерийн шугам сүлжээний ажил, гэрээний дүн 6.5 тэрбум төгрөг, ажлын явц 10.0 хувь;
- Нийслэлийн Өмчийн харилцааны газрын агуулахын барилга, гэрээний дүн 0.8 тэрбум төгрөг, ажлын явц 5.0 хувь;
- Шалган нэвтрүүлэх товчооны байр, гэрээний дүн 0.9 тэрбум төгрөг, ажлын явц 5.0 хувь;
- БГД-ийн 25 дугаар хорооны 960 суудлын сургуулийн барилга, гэрээний дүн 16.6 тэрбум төгрөг, ажлын явц 5.0 хувь;
- Хан-Уул дүүргийн 18 дугаар хорооны 640 суудлын сургуулийн барилга, гэрээний дүн 9.3 тэрбум төгрөг, ажлын явц 5.0 хувь;
- СХД-ийн 8 дугаар хорооны цогцолбор барилга, гэрээний дүн 3.0 тэрбум төгрөг, ажлын явц 5.0 хувь;
- Эсгийлэх дэд станцын зураг төсөв, гэрээний дүн 0.2 тэрбум төгрөг, ажлын явц 5.0 хувь.

3.7. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн зарим барилга байгууламжийн зураг төсөвт тусгагдсан ажлыг бүрэн хийгээгүй, чанартай гүйцэтгээгүй, захиалагчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй зэрэг зөрчил илэрсэн байна. Тухайлбал:

Архангай:

- Хашаат сумын “Спорт заал, дотуур байрны их засвар” ажлын дээвэр хэсэгт зай, завсар үүссэн, дусаал дусаж, хана таазанд нэвчилт үүссэн.

Баянхонгор:

- Хүрээмарал сумын цэцэрлэгийн барилгын засварын ажлын паркетын шалны ам даралт бүрэн хийгдээгүй, шал хөндийрч, ховхорсон;
- Галуут сумын цэцэрлэгийн их засварын ажлын шилэн хаалганы ханын доторлогоо, өнгөлгөө бүрэн хийгдээгүй, дээд, доод булангуудын дулаалга дутуу хийгдсэн;
- Баянхонгор сумын 6 дугаар цэцэрлэгийн барилгын их засварын ажлын агуулахын өрөөний дээврийн хэсгээс ус гоожсон.

Говь-Алтай:

- Есөнбулаг сумын гэр хорооллын багт ус түгээх цэг байгуулах ажлыг дутуу болон чанаргүй гүйцэтгэсэн.

Говь-Сүмбэр:

- Шивээговь суманд хүүхдийн тоглоомын талбай барих ажлын хашаа, сүүдрэвч эвдэрсэн;
- Халдвартын эмнэлгийн их засварын ажлын хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан налуу зам, бариул бүрэн хийгдээгүй.

Дархан-Уул:

- Дархан сумын 18 дугаар сургуулийн спорт заалны засварын ажлын агааржуулалтын систем эвдэрсэн;
- Дархан сумын 4 дүгээр сургуулийн спорт заалны засварын ажлыг чанаргүй гүйцэтгэсэн.

Дорноговь:

- Ханги боомтод Төрийн албан хаагчийн 8 айлын орон сууц барих ажлын гадна талбайн саравч эвдэрсэн;
- Сайншанд сумын 8 дугаар цэцэрлэгийн гадна фасад, дээвэр, цонх, хаалга, дотор засварын ажлыг чанаргүй гүйцэтгэсэн.

Дундговь: Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газарт "Unitel Hub" өрөө байгуулах ажлын паркетэн шал, халуун хүйтнээр үлээдэг кондейшн хийгдээгүй.

Өмнөговь:

- Сэврэй суманд 10 айлын орон сууц барьж, ашиглалтад оруулах ажлын гадна тохижилт хийгдээгүй;

- Ханбогд сумын Онцгой байдлын хэлтсийн сургалтын төвийн барилгыг барьж ашиглалтад оруулах ажлыг чанаргүй гүйцэтгэсэн;
- Цогтцэций сумын Тээшдүүрэн тохижилт ОНӨААТҮГ-ын барилгын ажлын галын дохиоллын холболт хийгдээгүй, цементэн талбайн хайрга бутарсан;
- Ханбогд сумын 2 дугаар сургууль, 29 дүгээр цэцэрлэгийн барилгын хаалга, цонхны засварын ажлын даалгаварт тусгагдсан 603м² вакум цонхонд хамгаалалтын тор хийгдээгүй;
- Даланзадгад сумын 3-р сургуулийн барилгын их засварын ажлыг батлагдсан зураг төслийн дагуу гүйцэтгээгүй.

Сүхбаатар:

- Аймгийн нэгдсэн эмнэлгийн барилгын их засварын ажлын гэрэлтүүлэг, цахилгааны засварын ажлыг чанаргүй гүйцэтгэсэн;

Сэлэнгэ:

- Аймгийн музейн барилгын дотор засварын ажлын даалгаварт тусгагдсан ажлыг дутуу гүйцэтгэсэн;
- Түшиг сумын нийтийн эзэмшлийн талбайн тохижилт, гэрэлтүүлгийн ажлыг чанаргүй гүйцэтгэсэн.

Ховд:

- Жаргалант сумын цэцэрлэгийн засварын ажлын гадна фасадыг чанаргүй гүйцэтгэсэн;
- Жаргалант сумын Цамбагараев баг Олзвойн 3-р гудамж гадна зогсоол, тохижилтын ажлын даалгаварт тусгагдсан 511 м² зүлэжүүлэлтийн ажил хийгдээгүй;
- Дарви сумын дотуур байрны барилгын засварын ажлын угаалгын өрөөний таазнаас ус алдсан, замаск ховхорсон.

Хөвсгөл:

- Ус дулаан дамжуулах төв №11, 12, 13 хэрэглэгчийг төвлөрсөн дулааны шугам сүлжээнд нэмж холбох ажлуудыг батлагдсан зураг төслийн дагуу гүйцэтгээгүй.

Төв:

- Авто зам засвар, арчлалтын нэгтгэл нь Зуунмод сумын өвөл, зуны арчлалтын ТАХ-нд захиалагчийн хяналтыг хангалтгүй хэрэгжүүлснээс гэрээнд тусгагдаагүй ажлыг гүйцэтгүүлсэн.

Нийслэл:

- СХД-ийн ӨЭМТ-ийн барилгын 1, 2 дугаар давхрын зарим өрөөний хана цуурсан, орчны ногоон байгууламж, замын бродюрын чигжээс бүрэн хийгдээгүй;
- СБД-ийн 10-р хороо, 13, 15, 30, 30б, 36-р байрны гадна талын авто зогсоол, явган зам талбайн тохижилтын ажлуудыг чанаргүй гүйцэтгэсэн.

3.8. Барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах комиссоос өгсөн үүрэг даалгаврыг бүрэн хэрэгжүүлээгүй, техникийн тодорхойлолт, ажлын даалгаварт тусгагдсан ажлын тоо хэмжээ зөрүүтэй байхад хүлээн авсан, захиалагчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй дараах ТАХ байна. Үүнд:

Баян-Өлгий:

- Баяннуур сумын ахуйн үйлчилгээний барилгыг цэцэрлэгийн зориулалттай болгон засварлах ТАХ;
- Ногооннуур сумын Ховд багийн салбар цэцэрлэгийн засвар ТАХ.

Баянхонгор: Гурванбулаг сумын ЕБС-ийн дотуур байрны засвар ТАХ.

Завхан аймаг:

- Эрдэнэхайрхан, Яруу сумдад газар тариалангийн усалгааны систем нийлүүлэх ТАХ;
- Хүүхэд хамгааллын үйлчилгээг түргэн шуурхай хүргэх автомашин нийлүүлэх ТАХ.

Өмнөговь:

- Гурвантэс сумын ЕБС-ийн спорт заалны засвар ТАХ;
- Сэврэй сумын засмал зам дагуух сумын хилийн цэс газарт тохижилт хийх ТАХ;
- Сэврэй сумын төрийн үйлчилгээний авто машины гарааш барих ТАХ;
- Даланзадгад сумын Цагаанбулаг 8 дугаар багийн мод үржүүлэг хорооллын баруун талын үерийн даланг засварлаж, тохижуулах ТАХ;
- Даланзадгад сумын Дунд сайхны 4 дүгээр багт тоглоомын талбай байгуулах ТАХ;
- Даланзадгад сумын Гурвансайхан хорооллын шинээр баригдаж буй автозам дагуух үерийн усны сувагчлал ТАХ;
- Даланзадгад сумын ЕБС-ийн ариун цэврийн өрөөний засвар ТАХ.

Сүхбаатар: Боловсрол хорооллын хойд хэсгийн авто зам, зогсоол барих ажил ТАХ.

Ховд:

- Спортын ордны засвар ТАХ;
- Үенч сумын дотуур байрны засвар ТАХ.

Нийслэл:

- ХУД-ийн цэцэрлэгт хүрээлэн, спорт талбай, зам талбайн тохижилтын ажил ТАХ;
- БНД-ийн төрийн байгууллагуудад шаардлагатай компьютер, тоног төхөөрөмж худалдан авах ТАХ;
- БЗД-ийн Прокурорын газарт шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэлтийн ажил ТАХ;
- НД-ийн усны машин худалдан авах ажил ТАХ.

3.9. Дээрх зөрчлүүд нь Барилгын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5⁹⁶, ЗГ-ын 2017 оны 170 дугаар тогтоолоор баталсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 3.11⁹⁷, 2021 оны 212 дугаар тогтоолоор баталсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн 5.1.3⁹⁸, 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.4.1⁹⁹, Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны А/178 дугаар тушаалаар баталсан “Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт тавих дүрэм”-ийн 3.1¹⁰⁰-д заасан хяналт тавих үүрэг бүхий байгууллагууд болон ИТХ, ЗД нар бүрэн хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.

Шийдвэрлэлт: Дээрх илэрсэн 54.4 тэрбум төгрөгийн зөрчилд АНТАГ-аас 0.6 тэрбум төгрөгийн 25 зөвлөмж, 53.7 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 64 албан шаардлага, сахилгын хариуцлага тооцуулах 6 албан шаардлага, 0.06 тэрбум төгрөгийн 4 төлбөрийн актыг тогтоож шалгагдагч байгууллагад хүргүүлсэн байна.

⁹⁶ Барилгын асуудал эрхэлсэн төрийн болон нутгийн захиргааны байгууллага нь барилгын үйл ажиллагаанд холбогдох норм, нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих замаар хувийн, нийтийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхлыг хамгаалах үүрэг хүлээнэ

⁹⁷ Захиалагч барилга байгууламжийн техникийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагаас хийх үзлэг, шалгалтын ажилд оролцож, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах ажлыг зохион байгуулах үүрэгтэй.

⁹⁸ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: барилгын ажлыг зураг төсөл, норм, нормативын баримт бичигт заасан техникийн үзүүлэлт, шаардлагын дагуу гүйцэтгэсэн эсэх;

⁹⁹ 4.4.1.Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний захиалагчийн техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэгч байгууллага нь холбогдох хууль тогтоомжид заасны дагуу техник, технологийн захиалагчийн хяналт хэрэгжүүлэх зөвшөөрлийг авсан байх бөгөөд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

¹⁰⁰ Зураг төсөл зохиогч барилгын ажлын захиалагчтай / цаашид захиалагч гэх/ гэрээ байгуулан барилгын ажилд зохиогчийн хяналт тавина.

БҮЛЭГ 4. ЗАРИМ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ САНХҮҮЖИЛТИЙГ ХУУЛЬ, ЖУРАМД НИЙЦҮҮЛЭН ОЛГООГҮЙ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮР ДҮНД БИЙ БОЛСОН ХӨРӨНГИЙН 18.2 ХУВИЙГ ДАНС БҮРТГЭЛД ТУСГААГҮЙ БАЙНА.

4.1 Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар 4204 ТАХ-нд 4,077.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгохоор баталж, гүйцэтгэлээр 3158 ТАХ-нд 2,793.6 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосноос шилжих ТАХ-нд 1,398.3 тэрбум төгрөг, шинээр хэрэгжих ТАХ-нд 1,395.3 тэрбум төгрөгийг тус тус олгожээ.

Хүснэгт 3. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн ТАХ

(тэрбум.төгрөг)

№	Аймаг, нийслэл	Тайлант онд олгосон санхүүжилт					
		Шинэ ТАХ		Шилжих ТАХ		Нийт	
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн
1	Архангай	32	5.5	2	0.5	34	6.0
2	Баянхонгор	20	2.5	17	2.6	37	5.1
3	Баян-Өлгий	61	4.7	37	1.7	98	6.4
4	Булган	60	4.9	13	1.1	73	6.0
5	Говь-Алтай	5	0.4	6	1.9	11	2.2
6	Говь-Сүмбэр	19	3.7	3	0.4	22	4.0
7	Дархан-Уул	31	5.4	64	6.8	95	12.3
8	Дорноговь	81	19.6	31	13.9	112	33.4
9	Дорнод	10	1.1	2	2.2	12	3.3
10	Дундговь	43	14.1	11	4.8	54	18.9
11	Завхан	62	5.8	8	1.0	70	6.8
12	Орхон	189	59.9	67	19.4	256	79.2
13	Өвөрхангай	15	2.3	10	0.8	25	3.1
14	Өмнөговь	360	160.1	185	116.4	545	276.6
15	Сүхбаатар	30	7.3	9	1.6	39	8.9
16	Сэлэнгэ	104	8.5	48	3.6	152	12.1
17	Төв	36	6.5	1	0.0	37	6.5
18	Увс	18	4.4	2	0.5	20	4.9
19	Ховд	108	8.6	48	4.7	156	13.4
20	Хөвсгөл	107	10.1	4	0.9	111	11.0
21	Хэнтий	56	8.4	15	1.6	71	10.0
22	Нийслэл	475	1051.3	653	1,121.1	1128	2,263.4
Нийт дүн		1922	1,395.3	1236	1,398.3	3158	2,793.6

4.2. Нийт олгосон санхүүжилтийн 0.8 хувь буюу 22.1 тэрбум төгрөгийг техник хяналтын болон зохиогчийн хяналтын зардал эзэлж байна.

4.3. Төрийн сангийн барьцаа хөрөнгийн дансанд хэрэгжиж дууссан 1259 ТАХ-ний 53.3 тэрбум төгрөгийг төвлөрүүлжээ.

4.4. Гэрээний үүргээ зөрчсөн 179 гүйцэтгэгчид 0.4 тэрбум төгрөгийн алдангийг захиалагч байгууллагуудаас тооцсон байна.

4.5. Аудитаар ТАХ-ний санхүүжилттэй холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна. Тухайлбал:

Алданги суутгалгүйгээр санхүүжилт олгосон:

- Орхон аймаг 130.8 сая төгрөг, Дорноговь аймаг 29.5 сая төгрөг, Өмнөговь аймаг 3.0 сая төгрөг, Хөвсгөл аймаг 3.0 сая төгрөг, Завхан аймаг 2.2 сая төгрөг.

Анхан шатны баримтын бүрдэлгүй зарцуулсан:

- Орхон аймаг 29.1 сая төгрөг.

Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан:

- Өмнөговь аймаг өмнөх онуудад хөрөнгө оруулалтын зардлаас 4.4 тэрбум төгрөгийг төсөөт төвлөрүүлээгүй.

Гүйцэтгэлд үндэслээгүй санхүүжилт олгосон:

- Архангай аймаг 1.5 сая төгрөг, Баян-Өлгий аймаг 8.5 сая төгрөг, Завхан аймаг 5.4 сая төгрөг, Орхон аймаг 526.1 сая төгрөг, Ховд аймаг 3.7 сая төгрөг; Увс аймаг 25.3 сая төгрөг, Төв аймаг 24.9 сая төгрөг, СХД 1.5 сая төгрөг, Хан-Уул дүүрэг 10.8 сая төгрөг, БГД 16.3 сая төгрөг, Чингэлтэй дүүрэг 8.9 сая төгрөг;
- Өмнөговь аймаг 4.2 тэрбум төгрөгийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгоогүй, төлөвлөгөөнд тусгаадаагүй ажилд 414.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон, 12.5 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулаагүй, 2.7 сая төгрөгийн үнийн хөнгөлөлтийг тооцоогүй санхүүжилт олгосон;
- Төв аймаг түрээсийн орон сууц хөтөлбөрийн хүрээнд орон сууц хүлээж аваагүй байхад 450.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон;

- Сүхбаатар аймаг малжуулах хөтөлбөр ТАХ-ний 710 бог малыг нийлүүлээгүй бөгөөд 117.2 сая төгрөгийн санхүүжилтийг бодит гүйцэтгэлээс илүү олгосон.

Зориулалт бусаар зарцуулсан:

- Завхан аймаг 9 ТАХ-нд 941.0 сая төгрөгийн санхүүжилт олгож, зориулалт бусаар зарцуулсан;
- Орхон аймаг худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон 3.8 тэрбум төгрөгийн хэмнэлтийг аймгийн болзошгүй аваарын зардалд зарцуулсан.

Эх үүсвэрийг данс хооронд гүйлгэн зарцуулсан:

- Завхан аймгийн Сантмаргаз болон Завханмандал сумд 243.9 сая төгрөг;
- Орхон аймаг 49.8 сая төгрөгийг Засаг даргын захирамжаар болзошгүй аваарын зардлаас гаргаж, зарцуулсан;
- Сэлэнгэ аймаг 103.8 сая төгрөгийг зардлын эх үүсвэр хооронд гүйлгэн санхүүжүүлсэн байна.

4.6. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-ний санхүүжилтэд 2025 онд 2,926.1 тэрбум төгрөгийг төлөвлөж, гүйцэтгэлээр 69.5 хувийн санхүүжилт олгосон байна.

4.7. Хөрөнгө оруулалтын ТАХ-г төсөвт тусгахдаа шилжих, их засвар, арчлалт болон шинээр хэрэгжүүлэх гэсэн дарааллаар эрэмбэлэхээр журамласан боловч Нийслэлийн 2025 оны төсвийг батлахдаа шилжих ТАХ-г он дамжих болон шилжих гэж ангилж, санхүүжилтийг хоёр төсвийн жил дамжуулан хэрэгжүүлэхээр баталсан байна.

4.8. Он дамжин хэрэгжихээр төлөвлөсөн 235 ТАХ-нд олгох санхүүжилтийн 49.8 хувийг олгож, хоёр төсвийн жил дамжуулсан нь Төсвийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.5¹⁰¹, ЗГ-ын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан журмын 3.3.1¹⁰²-д заасантай нийцэхгүй байна.

4.9. Дараах байгууллагууд гэрээний үүргийн хэрэгжилтэд тавих хяналтыг хангалтгүй хэрэгжүүлж, гэрээ сунгах хүсэлтийг тогтоосон хугацаанд ирүүлээгүй 14 ТАХ-ний гүйцэтгэгчээс 290.6 сая төгрөгийн алданги тооцож, төлүүлэх арга хэмжээг авч ажиллаагүй байна. Үүнд:

- Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ нь 11 ТАХ-ний гүйцэтгэгчээс 203.1 сая төгрөг;
- Сэлбэ хорин минутын хот корпорац ХХК нь 1 ТАХ-ний гүйцэтгэгчээс 60.2 сая төгрөг;
- СХД-ийн Захиалагчийн алба ОНӨААТҮГ нь 2 ТАХ-ний гүйцэтгэгчээс 27.3 сая төгрөг.

4.10. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн ТАХ-нд дараах алдаа, зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

Төсөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ-нд санхүүжилт олгосон:

- Захиалагчийн хяналт хэрэгжиж буй 34 ТАХ-ний төсөвлөлтийн шаардлага хангаагүй гүйцэтгэгчид 380.3 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосноос 84.5 хувь буюу 321.3 тэрбум төгрөгийг урьдчилгаа төлбөр хэлбэрээр олгосон.

Үр ашиггүй зарцуулалт:

5 ТАХ-нд бодит ажил хийгдээгүй байхад гүйцэтгэгчид 2.9 тэрбум төгрөгийн явцын санхүүжилт олгож, төсвийн хөрөнгийг үргүй зарцуулсан байна. Үүнд:

- УБ хотын бохир усны "Туул-1" коллекторын барилга угсралт: Гэрээний дүн 6.2 тэрбум төгрөг, бодит ажил хийгдээгүй байхад 1.9 тэрбум төгрөг;
- БЗД-ийн 12 дугаар хорооны инженерийн шугам сүлжээний зураг төсөл: Гэрээний дүн 0.1 тэрбум төгрөг, бодит ажил хийгдээгүй байхад 0.03 тэрбум төгрөг;
- Гэр хорооллын дахин зохион байгуулалтын зураг төсөл: Гэрээний дүн 0.1 тэрбум төгрөг, бодит ажил хийгдээгүй байхад 0.03 тэрбум төгрөг;
- Гандантэгчилэн хийд орчмын инженерийн дэд бүтцийн ажил: Гэрээний дүн 0.7 тэрбум төгрөг, бодит ажил хийгдээгүй байхад 0.6 тэрбум төгрөг;
- "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын автобус паркийн барилга: Гэрээний дүн 4.3 тэрбум төгрөг, бодит ажил хийгдээгүй байхад 0.3 тэрбум төгрөг.
- Хот байгуулалт, хотын стандартын газар нь захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн 3.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Сэлбэ дэд төвийн орон сууцны барилгуудын суурийн холболтын зураг боловсруулах ТАХ-ний санхүүжилтийг бүрэн олгосон боловч зураг төсөвт дахин өөрчлөлт оруулснаар өмнөх зураг ашиглалтгүй болж, төсвийн хөрөнгийг үргүй зарцуулсан байна.

Шийдвэрлэлт: АНТАГ-аас нийт 31.2 тэрбум төгрөгийн зөрчилд 5.0 тэрбум төгрөгийн 20 акт, 25.7 тэрбум төгрөгийн 24 албан шаардлага, 0.5 тэрбум төгрөгийн 7 зөвлөмжийг шалгагдагч байгууллагуудад хүргүүлсэн байна.

4.11. Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон 1,817.5 тэрбум төгрөгийн 2347 ТАХ-ний хөрөнгийг НББ-д тусгахаас 81.8 хувийг бүртгэлд тусгасан байна.

¹⁰¹ 43.5-д заасныг зөрчиж “төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3, 43.1.5-д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй”

¹⁰² 3.3.1. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн төсөлд тусгах төсөл, арга хэмжээг сонгох болон төслийн санхүүжилтийг шийдвэрлэхдээ дараах эрэмбийг баримтална

Хүснэгт 4. НББ тайланд тусгасан ТАХ

(тэрбум.төгрөг)

Д/д	Аймаг, хот	НББ-д тусгавал зохих ТАХ		НББ-д тусгасан ТАХ		НББ-д тусгаагүй ТАХ	
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн
1	Архангай	34	5.0	34	5.0	-	-
2	Баянхонгор	37	6.3	23	5.0	14	1.3
3	Баян-Өлгий	72	6.2	69	6.1	3	0.1
4	Булган	71	5.9	64	5.0	7	0.8
5	Говь-Алтай	9	1.2	9	1.2	-	-
6	Говь-Сүмбэр	20	4.3	14	3.7	6	0.5
7	Дархан-Уул	33	12.7	14	5.3	19	7.3
8	Дорноговь	119	51.0	99	39.4	20	12.6
9	Дорнод	17	4.9	17	4.9	-	-
10	Дундговь	50	16.7	48	15.9	2	0.7
11	Завхан	47	7.9	37	4.3	10	3.6
12	Орхон	232	124.8	232	124.8	-	-
13	Өвөрхангай	24	3.4	24	3.4	-	-
14	Өмнөговь	547	373.7	546	364.4	1	9.4
15	Сүхбаатар	42	20.5	40	16.3	2	4.3
16	Сэлэнгэ	147	14.5	139	13.9	8	0.6
17	Төв	42	7.3	34	4.9	8	2.3
18	Увс	17	4.2	16	4.1	1	0.1
19	Ховд	103	13.1	92	11.5	11	1.7
20	Хөвсгөл	94	8.8	90	7.4	4	1.4
21	Хэнтий	60	12.5	53	12.4	7	0.1
22	Нийслэл	530	1,111.6	323	586.0	207	525.6
Нийт дүн		2347	1,817.5	2017	1,244.9	330	572.5

4.12. Харин 572.5 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 330 ТАХ-г НББ-д тусгаагүй байна. Тухайлбал:

- Баян-Өлгий аймаг 0.1 тэрбум төгрөгийн хөрөнгийг ашиглагч байгууллага НББ-д тусгаагүй;
- Булган аймаг 0.8 тэрбум төгрөгийн 5 ТАХ-г данс бүртгэлд тусгаагүй;
- Говьсүмбэр аймаг 0.5 тэрбум төгрөгийн дүнтэй 6 ТАХ-г данс бүртгэлд тусгаагүй;
- Дорноговь аймаг 9.1 тэрбум төгрөгийн 17 ТАХ-г ашиглагч байгууллагын НББ-д тусгаагүй, 3.5 тэрбум төгрөгийн өртөгтэй 3 ТАХ-г ашиглагч байгууллагын НББ-д тусгаагүй;
- Дундговь аймаг "Мандалын гэгээ" ОНӨААТҮГ-ын дансанд бүртгэгдэх усалгааны системийг орон нутгийн хөрөнгөд бүртгээгүй;
- Завхан аймаг 3.6 тэрбум төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй;
- Дархан аймаг 7.3 тэрбум төгрөгийн 19 ТАХ-ний хөрөнгийг бүртгэлд тусгаагүй;
- Өмнөговь аймаг хатуу хучилттай автозам барих ажлын 9.4 тэрбум төгрөгийн дүнг эргэлтийн хөрөнгөөр бүртгээгүй;
- Хөвсгөл аймаг 1.4 тэрбум төгрөгийн 4 ТАХ-ний хүрээнд бий болсон хөрөнгийг бүртгэлд тусгаагүй;
- Төв аймаг Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн 8 хөрөнгө оруулалтын ажлыг данс бүртгэлд тусгаагүй;
- Сэлэнгэ аймаг 0.6 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй 8 хөрөнгийг холбогдох байгууллагуудын бүртгэл, тайланд тусгаагүй байна;
- Нийслэл, 12.9 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй 19 ТАХ-ний зургийг "барилга угсралтын явцад өөрчлөгддөг" гэх үндэслэлээр өмчийн бүртгэлд тусгаагүй, ТЭЗҮ болон байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ боловсруулах 87.2 тэрбум төгрөгийн өртөг бүхий 35 ТАХ-ний үр дүнд бий болсон баримт бичгийг бүртгэх эрх зүйн зохицуулалт дутмаг байгаагаас шалтгаалан өмчийн бүртгэлд тусгаагүй байна.

4.13. Бусад ТАХ-ний ангиллын хувьд баримт бичгийн бүрдүүлбэр хангуулах, хянах, холбогдох зөвшөөрөл авах зэрэг ажлууд үргэлжилж 2026 онд бүртгэгдэхээр төлөвлөсөн нь төсөвт тодотголд орж зарим ажил цаг хугацааны хувьд оройтож хэрэгжсэн, явц удааширсан зэргээс шалтгаалж байна.

Шийдвэрлэлт: АНТАГ-аас нийт 35.3 тэрбум төгрөгийн зөрчилд 25.8 тэрбум төгрөгийн 12 албан шаардлага, 9.5 тэрбум төгрөгийн 9 зөвлөмжийг шалгагдагч байгууллагуудад хүргүүлсэн байна.